



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

БАГШ НАРЫН МЭРГЭЖЛИЙН ӨСӨЛТӨД АХМАД БАГШ НАРЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ



ЦЭЦЭРЛЭГ, ЕБС-ИЙН БАГШ, УДИРДАХ АЖИЛТНЫ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

Улаанбаатар хот
2022 он

**“БАГШ НАРЫН МЭРГЭЖЛИЙН ӨСӨЛТӨД АХМАД БАГШ
НАРЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ”**

ЦЭЦЭРЛЭГ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАГШ, УДИРДАХ АЖИЛТНЫ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН ЭМХЭТГЭЛ

Улаанбаатар
2022 он

**“БАГШ НАРЫН МЭРГЭЖЛИЙН ӨСӨЛТӨД АХМАД БАГШ НАРЫН
ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ”**

ЦЭЦЭРЛЭГ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАГШ, УДИРДАХ АЖИЛТНЫ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН ЭМХЭТГЭЛ

Эмхэтгэсэн:	Э.Баясгалан
Редактор:	С.Санжаабадам
Хэвлэлийн эх бэлтгэсэн:	Б.Баярмаа
Хавтасны дизайнер:	А. Мөнхмагнай
Цаасны хэмжээ:	70x100/76
Хэвлэлийн хуудас:	20xx

ӨМНӨХ ҮГ

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгээс үндэсний хэмжээнд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтны дунд зохион байгуулдаг эрдэм шинжилгээний хурлыг 55 дахь удаагаа “БАГШ НАРЫН МЭРГЭЖЛИЙН ӨСӨЛТӨД АХМАД БАГШ НАРЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ” сэдвийн дор зохион байгуулав. Нийслэл, аймаг, сумын цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш нарын илтгэлүүдээс шалгаран үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний хуралд хэлэлцсэнийг нь хураангуйлан эмхэтгэн Та бүхэнд хүргэж байна.

Багш нар сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд ахмад багш нартай хамтран ажиллах арга зам, судалгааны ажлын арга зүйг дэмжих, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, эрдэм судлалын ажлын үр дүнг сургалтын үйл ажиллагаатай уялдуулах, хамтын ажиллагааг дэмжих шийдлийг эрэлхийлсэн бүтээлүүдийг хэлэлцүүлсэн юм.

Энэхүү эрдэм шинжилгээний хуралд тухайн сэдвийнхээ хүрээнд судалгаа шинжилгээний ажил хийж бүтээлчээр хандаж сургууль, аймаг, дүүргийн шалгаруулалтад оролцож үндэсний түвшинд илтгэлээ хэлэлцүүлсэн багш нартаа талархал илэрхийлэн цаашдын сургалт, эрдэм судлалын үйлсэд өндөр амжилт хүсэн ерөөе.

Цэцэрлэг, ерөнхий боловсролын багш, удирдах ажилтнуудын эрдэм шинжилгээний үндэсний хурлын удирдлагаар хангаж ажилласан Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга болон зохион байгуулсан Хүний хөгжлийн судалгааны секторын судлаачдад талархал илэрхийлье.

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн
захирлын үүрэг гүйцэтгэгч, доктор М.ИТГЭЛ

Өмнөх үг	4
Бага ангийн “хүн байгаль” хичээлийн багшлах арга зүйг ахмад багш нарын оролцоотой дэмжих нь	7
“Дагалдан суралцах” хөтөлбөрийн хэрэгжилтээр багш ажлын байрандаа хөгжих нь	15
Сурагчдын ном унших, уншаад ойлгох чадварыг нэмэгдүүлэхэд ахмад багшийн арга туршлагыг туршин хэрэгжүүлэх нь	25
Сурагчдын сурлагын хоцрогдлыг ахмад багшийн туршлага, арга зүйгээр нөхөх боломжийг судалсан нь (Нийгэм судлал хичээлийн жишээн дээр).....	35
Хичээл зохион байгуулахдаа ахмад багш нарын туршлагаас суралцаж, хэрэгжүүлсэн үр дүн	42
Багшлахуйн залгамж холбоо.....	51
Ахмад багшийн цифртэй холбоотой бодлого бодох хялбар арга зүйг туршин үр дүнд хүрэх нь.....	61
Залуу багш нарын тасралтгүй хөгжилд мэргэжлийн бүлгийн туршлагатай багш нарын нөлөөлөл.....	70
Хөгжүүлэх төлөвлөгөөгөөр ахмад-залуу багшийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх нь	80
Сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах төлөвлөгөө хийхэд ахмад багш нар нөлөөлөх нь	88
Анги удирдахад ахмад багш нарын үзүүлэх нөлөө	96
Мэргэжлийн багш нарын үр дүнтэй баг бүрдүүлэхэд ахмад багш нарын оролцоо.....	103
Залуу багш нар тулгамдаж буй асуудлаар ахмад багш нараас суралцах нь..	111
Чадваржсан багш хөгжилд хөтөлнө	118
Өвлөхүйн ухаанд хамтдаа	128
Сурагчдын унших чадварыг хөгжүүлэхэд “давтан унших” арга зүйг ашигласан нь.....	135
Мэргэжлийн өсөлтөд туршлагатай багшийн хамтын үйл ажиллагааны нөлөөллийг судалж дэвшүүлсэн хувилбар	142
Залуу багш нарын хөгжилд ахмад багш нарын оролцоо нөлөөлөх нь	149

Залуу багш нарын төлөвшилд ахмад багш нарын оролцоог нэмэгдүүлэх нь	159
Залуу багш нарын заах арга зүйд ахмад багшийн оролцоо нөлөөлсөн нь	166
Мэнтон & Мэнти нар хамтдаа хөгжих нь	174
Ахмад багш нарын үндэсний бичиг заах арга багшийн мэргэжлийн өсөлтөд нөлөөлөх нь.....	181
Ахмад болон залуу багш нар бие биенээсээ суралцаж тасралтгүй хөгжих нь	188
“Багшийн багш” хөтөлбөр нь залуу багшийн мэргэжлийн өсөлтөд нөлөөлөх нь	195
“Хаврута” аргыг хэрэгжүүлсэн нь.....	205
Залуу багш нарын харилцаа хандлагад эерэг нөлөө үзүүлэхэд ахмад багш нарын оролцоог нэмэгдүүлэх нь.....	216
Залуу багш нар PDCA загвараар өөрийгөө хөгжүүлэхэд ахмад багш нарын оролцоо.....	223
Ахмад багшийн арга зүй болон самбар төлөвлөлт	228
Ахмад багшийн дэмжлэгээр туршилтат хичээлийн ажлын хуудсыг сайжруулах боломж	234
Мэргэжлийн багшийн өсөлтөд ахмад багш нарын оролцоо “Харилцан суралцаж, хамтдаа хөгжье ”	242

БАГА АНГИЙН “ХҮН БАЙГАЛЬ” ХИЧЭЭЛИЙН БАГШЛАХ АРГА ЗҮЙГ АХМАД БАГШ НАРЫН ОРОЛЦООТОЙ ДЭМЖИХ НЬ

(I байр)

Думбаагийн БЯМБАСҮРЭН

Орхон аймгийн Баян-Өндөр сумын 7 дугаар сургууль

Byambasuren7school@gmail.com

Хураангуй

Цар тахалтай холбоотой сурагчдад зайнаас суралцах хэрэгцээ бий болсноор багш, сургалтын байгууллагуудаас МХТ-д суурилсан шинэ арга зүй, мэдлэг чадварыг шаардаж байна. Үүнтэй холбоотой сурагчдын хийсвэр дүрслэл их болж, бодит ухагдахуунд тулгуурлан сэтгэн бодох чадвар буурсан нь ажиглагдаж байна. Нөгөө талаар залуу багш нар бүтээлч үйл ажиллагаанд тулгуурласан хичээлээс илүүтэйгээр МХТ ашиглан хичээл сургалт зохион байгуулж байгаа нь шүүмжлэлт сэтгэлгээ, бүтээлч сэтгэлгээ, логик сэтгэлгээ бус хийсвэр сэтгэлгээг улам идэвхжүүлэхэд хүрч байна. Байгалийн ухааны хичээлийн үндэс суурийг тавих бага боловсролын хүн байгалийн хичээлийн багш нарын мэргэжлийн хөгжлийг дэмжих арга зүйг ахмад багштай хамтран хөгжүүлэх хамтын ажиллагааны хэлбэрийг энэ судалгаанд авч үзлээ. Хамтын ажиллагаа нь онолын мэдлэг ойлголтод үндэслэн багшийн арга зүйг сайжруулах чиглэлтэй байх юм.

Түлхүүр үг: багш; багшийн хөгжил; V model; багшийн туслах; гарын авлага; онолын мэдлэг.

Оршил

Тэртээ түүхийн шарласан хуудаснаа БНМАУ-ын хөдөлмөрийн баатар, гавьяат багш Д.Базар “Түмэн бодис” хичээлийн үйл ажиллагаа, сургалтын чанарт нөлөөлөх хүчин зүйлсэд судалгаа хийж “Бодис, үзэгдлийг ажиглалт, туршлага, дадлага хийлгэх, бодит үзүүлэнгээр судлуулах ажил хангалтгүй зөвхөн сурах бичгийг нь уншуулж тайлбарлан ярилцах төдийгөөр хязгаарлах явдал их байгаа нь ажиглагдаж байна. Байгалийн юмс, үзэгдлийг сурагчдаар ажиглуулж, тэмдэглэл хөтлүүлэх, харьцуулан дүгнэж учир шалтгаан, холбоо хамаарлыг сурагчдаар өөрсдөөр нь сэтгүүлэн олуулах ажлыг сонирхолтой хэлбэрээр удирдаж чадахгүй явдал нийтлэг байна. Хичээлийн дэвтэр дээр хичээлийн сэдэв, холбогдох зураг, шинээр нэмэгдэж байгаа нэр томьёог бичүүлэх ёстой байтал, сурах бичгээс нь товчлон хуулуулж бичүүлэх, бүтээлч биш, илүү зүйл хийлгэх гэм нэлээд багш нарын ажилд байна. Энэ байдал юунаас шалтгаалан гарч байгааг ажиглахад зарим багш нар программын тайлбар, агуулга, заах арга зүйн зөвлөмжийг гүнзгий нарийн судлахгүй, сурагчдын сурах бичигт найдаад ямар ч бэлтгэл хийхгүй байгаатай холбоотой гэжээ”. Энэ нь одоо ч боловсролын салбарт тулгамдаж буй гол асуудал хэвээр байна.

Байгалийн ухааны хичээлүүдийн суурь болсон “Хүн байгаль” хичээлээр сурагчид хүрээлэн буй орчны юмс үзэгдлийн ерөнхий зүй тогтол, хөгжил, харилцан хамаарал, учир шалтгааныг судлан өдөр тутмын амьдралд тохиолдох асуудлыг таньж мэдэхэд

мэдлэгээ хэрэглэж сурах хэрэгцээ шаардлага зүй ёсоор урган гардаг. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багшийн мэдлэг чадварт анхаарахаас гадна нийгмийн хурдацтай хөгжилтэй холбоотой сурагчдын сэтгэл зүйд тохирсон сургалтын шинэ арга зүйг судлан хэрэгжүүлэх шаардлага бий болж байна. Сурагчдын фейсбүүкийн хэрэглээ нь тэдний бодол дээгүүр нисэх оюун санааны виртуал ертөнцийг улам хүчтэй болгож, өчигдрийн номтой ажиллаж сурсан нөхцөлөөс өнөөдрийн олон өөр хэв шинжийн оюун санаа бүхий хүүхдийг бий болгож байгаа нь асуудал болж байна уу гэлтэй. Байгалийн ухааны хичээлийн үндэс суурь болсон хүн байгалийн хичээлийн багшийн мэргэжлийн чадварыг *мэргэжлийн багш - ахмад багш - бага боловсролын багшийн* хамтын ажиллагаагаар хөгжүүлж, сургалтын чанарт ахиц гаргах боломж байгааг туршилт, түүний үр дүнгээр харуулахыг зорилоо.

Бага боловсролын “Хүн байгаль хичээл”-ийн багш нарын мэргэжлийн хөгжилд хамгийн их хэрэгцээтэй байгаа онол, арга зүйн мэдлэг чадварыг ахмад багшийн тусламжтайгаар дэмжих зорилго тавьж, судалгааныхаа өгүүллийн хүрээнд байгалийн ухааны хичээлийг заах багшид тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, багшийн мэргэжлийн хөгжлийг ахмад туршлагатай багшийн тусламжтайгаар дээшлүүлэх арга замыг тодорхойлон туршиж үр дүнг улам боловсронгуй болгох зорилт дэвшүүлсэн юм.

Үндсэн хэсэг

Багшийн хөгжлийн хөдөлгөгч хүч нь багш-багшийн, багш-суралцагчийн хамтын ажиллагаа билээ. “Хөгжил” гэдэг нь чухамдаа “чанарын өөрчлөлт” байдаг бөгөөд тэр нь цаанаа ямар нэг сул талаа засахтай холбоотой байх учиртай тул “Багшийн хөгжил” ч тухайн багшийн “өөрийнхөө алдаж доголдож байгаа талаа засахад чиглэсэн үйл ажиллагааны үр дүн байна (Болормаа, 2019). Багш нар бүтээлчээр хамтран ажиллах нь мэргэжлийн асуудлаар харилцан санал солилцож, багшлахуйн арга барилыг судалж, туршлага солилцон сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох боломжийг олгодог.

2019 оны 01 дүгээр сарын 01-ээс “Багшийн хөгжлийг дэмжих тухай” хууль хэрэгжиж эхэлснээс хойш сургууль бүрт өөрийн онцлогт зохицсон, үр дүнтэй, багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих хөтөлбөр хэрэгтэй болсон.

Зураг 1. Багшийн хөгжлийн 3 талт загвар



Орхон аймгийн ерөнхий боловсролын 7 дугаар сургуулийн хувьд “Багш хөгжлийн гурван талт загвар” хөтөлбөр боловсруулан 4 дэх жилдээ туршин хэрэгжүүлж байна.

“Багшийн хөгжлийн гурван талт загвар” хөтөлбөрийн тулгуур боловсрол судлалын онол бол Коелр, Мишра (2013) нарын боловсруулсан багшийн хөгжлийн TRACK мэдлэгийн загварт суурилсан ба энэ нь тухайн судлагдахууны мэдлэг, чадварыг

эзэмшсэн, багшлахуйн болон мэдлэг бүтээлгэх үр дүнтэй арга, арга зүйг эзэмшсэн, МХТ ашиглан суралцагчдынхаа суралцахуйг дэмжих чадвар бүхий багшийг төлөвшүүлэх үйл ажиллагааны нэгдэл юм.

Багш хөгжлийн гурван талт загварын чадваруудыг хөгжүүлэхэд *мэргэжлийн багш - бага ангийн багш - ахмад багш* гэсэн үндсэн бүрэлдэхүүн бүхий хамтын ажиллагааны баг ажиллаж байгаагаас 1. Судлагдахууны мэдлэг чадвар буюу онолын мэдлэг, 2. Багшлахуйн мэдлэг чадвар буюу арга зүйг сайжруулах ажлын хүрээнд хийж гүйцэтгэсэн туршлагыг энд авч үзлээ.

“Хүн байгаль” хичээлийн онцлог. Байгалийн ухааны хичээлүүдийн суурь болсон “Хүн байгаль” хичээлээр сурагчид хүрээлэн буй орчны юмс үзэгдлийн ерөнхий зүй тогтол, хөгжил, харилцан хамаарал, учир шалтгааныг судлан өдөр тутмын амьдралд тохиолдох асуудлыг таньж мэдэхэд багшийн мэргэжлийн чадвар, заах арга барил чухал юм.

Судалгааны хэсэг

Судалгааны ажил нь бага ангийн хүн байгалийн хичээлийн багшлахуйг дэмжих зорилготой тул мэргэжлийн хөгжилд тулгамддаг асуудлыг илрүүлэх, нөлөөлөх хүчин зүйлсийг тодруулах судалгааг бага ангийн хүн байгаль хичээлийг заадаг багш нараас авлаа (Судалгаанд бага боловсролын 68 багш хамрагдав).

Байгалийн ухааны сургалт нь амьдралд ойрхон жишээ баримттай, судлагдахуун нь сонирхол татахуйц байдаг ч бага ангийн багш нарт онолын болон арга зүйн дэмжлэг зайлшгүй хэрэгтэй байгаа нь дараах судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Зураг 2. Бага ангийн “Хүн байгаль”-ийн хичээлийн багш нарт тулгамдаж буй бэрхшээл, 68 багш



Судалгаанд хамрагдсан багш нар монгол хэл, математикийн судлагдахууныг ихэвчлэн ордог бөгөөд энэ 2 судлагдахууны онолын мэдлэгийн хувьд өөртөө итгэлтэй,

мэдлэгтэй гэж үздэг нь харагдаж байна. Харин байгалийн ухааны судлагдахууныг орохоос зайлсхийж өөртөө итгэлгүй байгаа нь онолын мэдлэг дутмаг байгааг илэрхийлж байна.


Зураг 3. “Хүн байгаль”-ийн хичээлийн нэгж, ээлжит хичээл бэлтгэх явцад тулгардаг бэрхшээл, 68 багш



Хүн байгалийн хичээлийн төлөвлөлт хийхэд гол тулгарч байгаа бэрхшээлд онолын мэдлэг ойлголтоос гадна заах арга зүйн санаа, хичээлийн агуулгад тохирсон бичлэг, зураг хомс байгаа нь багшийн хариултаас харагдаж байна.

Бага боловсролын хүн байгалийн хичээлийн тулгамдсан асуудал болох гарын авлага бэлтгэн гаргах хэрэгцээг тодорхойлоход:

Зураг 4. “Хүн байгалийн хичээлийн багшийн туслах” гарын авлага боловсруулах хэрэгцээг илрүүлэх судалгаа, 68 багш



Судалгаанаас харахад хүн байгалийн хичээлийн багш нарт мэргэжлийн дэмжлэг нэн чухал бөгөөд сурах бичиг гол хэрэглэгдэхүүн болж чадахгүй байгааг илэрхийлсэн байна.

“Хүн байгаль хичээлийн багшийн туслах” гарын авлагын онцлог

Энэ гарын авлага нь хүн байгалийн хичээлийг заадаг багш нарт онол, арга зүйн мэдлэг олгохоос гадна сурагчдад хүн байгалийн хичээлийн агуулгыг эзэмшихэд туслан чиглүүлнэ. Хүн байгалийн хичээлийн багшийн туслах нь:

- Бага ангийн багш нарт хамгийн ихээр тулгамдаад байгаа онолын мэдлэгийг өгөх
- Хичээлд ашиглах бичлэг хичээлүүдийг хэрэглэгдэхүүн болгон бэлтгэх
- Онолын тайлбар бүхий зураг оруулах
- Улсын шалгалтад ихэвчлэн ирдэг асуултад хариулт өгөх
- Хүн орчин, хүн байгалийн хичээлийн сурах бичгийн дасгал даалгаврын гүйцэтгэлд чиглүүлэг өгөх зорилготой.

“Багшийн туслах” гарын авлагын онцлог нь хичээлийн агуулгыг ойлгомжтой байдлаар тайлбарласан, хичээлд туслах бичлэг зааврыг QR кодоор нээлттэй оруулснаараа давуу талтай болно.


Зураг 6. “Хүн байгалийн хичээлийн багшийн туслах” – ын цахим хэрэглэгдэхүүн



“Хүн байгаль хичээлийн багшийн туслах” гарын авлагыг урьдчилан хэвлэж хичээл сургалтад ашиглаж үр дүнг тооцсон нь

“Багшийн туслах” гарын авлагыг урьдчилсан байдлаар хэвлэн сургуулийн бага ангийн багш нартаа уншиж судлуулан онолын мэдлэгийн ахицыг тооцлоо.

Зураг 7. Хүн байгалийн хичээлийг заах багшийн онолын мэдлэгийн ахиц, 11 багш




Үнэлгээний дүнгээс харахад “Хүн байгалийн хичээлийн багшийн туслах” нь Бага ангийн багшид мэдлэг ойлголт өгөхүйц хэмжээнд боловсруулагдсан байгаа нь харагдаж байна. Гарын авлагыг Биологийн ахмад нарт уншуулан

мэргэжлийн зөвлөгөө авч сайжруулан бэлтгэж байна.

“Хүн байгаль хичээл”-ийн багшлах арга зүйг ахмад багш нарын оролцоотой дэмжих нь

Амжилттай багшлахуйн хамгийн эхний хүчин зүйл бол хувь багшийн шинжлэх ухааны мэдлэг ойлголт юм. Тухайн судлагдахууны талаар онолын мэдлэг сайтай багш хүүхдэд үнэн зөв мэдээллийг оновчтой өгч чадна. Ингэхдээ арга зүйн чадварыг хичээл зааж байх явцдаа болон бусад туршлагатай багшийн тусламжтайгаар байнга сайжруулан хөгжүүлж явдаг билээ.

Зураг 9. V, VI ангийн сурагчдын “Хүн байгаль” хичээлийн ТТШ-ын гүйцэтгэл



Үүний дүнд 5-р ангийн сурагчдын хүн байгалийн хичээлийн мэдлэг чадвар ахисан нь багшийн заах арга зүйд тодорхой дэвшил гарсныг илтгэж байна.

Ахмад багш - Бага боловсролын багш нартай хамтран ажилласнаар гарсан үр дүн

“Хүн байгаль хичээл”-ийн багшийн мэргэжлийн чадварыг хөгжүүлэх чиглэлээр ахмад багш, дунд ангийн мэргэжлийн багш, бага ангийн багшийн хамтын ажиллагаа нь дараах давуу талуудыг бий болгож байлаа. Үүнд:


1. Хүн байгаль хичээлийн онолын ойлголтыг нэг дороос авах зорилго бүхий гарын авлага хийх явцдаа хамтран хөгжих, цаашид бага боловсролын багш нарын мэргэжлийн хөгжлийг дэмжих зорилгоор ЕБС-иудад туршин хэрэгжүүлэх боломжийг бий болгох
2. Ахмад багшийн сурган хүмүүжүүлэх үнэтэй аргуудыг идэвхтэй сургалтын аргатай хослуулан хэрэглэх, туршлагыг нь өвлөн авч үлдэх, сургалтыг чанартай явуулах залгамж халааг бэлтгэх

3. Бага ангийн хүн байгалийн хичээлд хэрэглэж болохуйц 5 аргыг хичээл сургалтад хөрвүүлэн ашиглах боломжтой, ойлгомжтой байдлаар томъёолон бичиж “Хүн байгалийн хичээлийн багшийн туслах”-тай хослуулан хэрэглэх арга зүйн чиглүүлэг өгөх зэрэг байлаа.

Дүгнэлт

- Багшийн мэргэжлийн өсөлт нь онолын мэдлэг, заах арга зүй, МХТ-ийн мэдлэг чадвараа цогцоор нь дээшлүүлэхэд чиглэсэн бүтээлч үйл ажиллагаанд суурилна. Энэхүү бүтээлч үйл ажиллагааг чиглүүлэх, зөвлөх, сайжруулах дэмжлэгийг ахмад багш нар өгдөг болохыг ойлгож хамтран ажиллах нь чухал юм.
- “Хүн байгаль хичээл”-ийн багшийн мэргэжлийн өсөлтийг дэмжихийн тулд эхлээд онолын мэдлэг ойлголтыг сайжруулах шаардлагатай байна гэж дүгнэлээ.
- Хичээлийн бэлтгэл хийхэд онолын мэдлэг ойлголтоос гадна заах арга зүйн санаа, хичээлийн агуулгад тохирсон бичлэг, зураг хомс байгаа нь багшийн хариултаас харагдаж байна. Иймээс “Хүн байгаль” хичээлийн агуулга, арга зүй,

Зураг 10. Ахмад багштай хамтран боловсруулсан



хэрэглэгдэхүүний санаа, шийдлийг нэг дороос авах арга зүйн чиглүүлгийг сайжруулан боловсруулах хэрэгтэй байна.

- Ахмад багштай тасралтгүй, нягт хамтран ажилласнаар онолын мэдлэг, заах арга зүй, МХТ-ийн чадвар сайжраад зогсохгүй гарын авлага, нэр томъёоны тайлбар толь, эмхэтгэл бичих чадварт суралцах боломж байгаа нь харагдаж байна.
- Амжилттай багшлахуйн үндэс ээлжит хичээлийн үйл явцаар илэрхийлэгддэг. Ээлжит хичээлийг V загварын дагуу бэлтгэн орох, засан сайжруулах нь багшийн заах арга зүй, онолын мэдлэг ойлголт, багшлах эв дүй, харилцааны ур чадварыг хамтад нь хөгжүүлэхэд чухал түлхэц болж байна.

Ном зүй

Базар, Д. (1976). Түмэн бодисын сургалтын судалгаанаас. *Сурган хүмүүжүүлэгч*, хуудас 36.

БМДИ. (2019). *Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын гарын авлага*. Улаанбаатар.

Болормаа, Н. Г. (2019). *Багшийн хөгжил-Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын гарын авлага*. Улаанбаатар: БМДИ, БСШУСЯ.

Ганбат, Х. (2012). *Багшийг ажлын байранд хөгжүүлэх онол арга зүйн асуудал*. Улаанбаатар: ПИТ ПРЕСС ХХК.

Даваасамбуу, Д. (2007). *Багшийн хөгжил, түүнийг үнэлэх дэмжих асуудлууд-2006 оны шилдэг илтгэлүүд*. Улаанбаатар: Боловсролын хүрээлэн.

Долгоржав, Ч. (2016). *Маргаашийн багш байхын тулд*. Улаанбаатар: МУБИС.

Лувсандорж, Ц. О.-Э. (2016). *Багшийн чадамжийн хэмжүүр*. "Лавай" сэтгүүл. Дугаар 17 Улаанбаатар.

Лувсандорж, Ц. О.-Э. (2016). *Багшийн чадамжийн шүтэлцээ*. Улаанбаатар: МУБИС.

Лхагвасүрэн, Ц. Баярмаа, Б. (2017). 6-10 настай Монгол хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийн онцлог. *"Боловсрол судлал" сэтгүүл*. Дугаар 07. Улаанбаатар: Соёмбо принтинг.

Нэргүй, Н. Н. (2013). *Багшлахуйн хөгжил*. Улаанбаатар: БШУЯ.

Одгэрэл, Ц. А. (2021). *Багшийн хөгжлийн гурван талт загвар, түүний дагуу боловсруулсан багшийн мэргэжлийн хөгжлийн хөтөлбөр*. Улаанбаатар: Ерөнхий боловсролын прогресс сургууль.

Санжаабадам, С. (2017). Хичээлийн зохион байгуулалт: туршилтын үр дүн. *Боловсрол судлал сэтгүүл*. Дугаар 9, хуудас 39.

Энхтүвшин, С. (2016). *Багш боловсролын агуулга, багш мэргэжилтний чадамжийн шинэчлэлийн асуудалд*. Улаанбаатар: Багшийн мэргэжил дээшлүүлэх институт.

Энхцэцэг, Б. О. (2013). *Бүтээлч сэтгэлгээ хөгжүүлэх аргын онол, арга зүй, хэрэглээ*. Улаанбаатар: МУБИС.

“ДАГАЛДАН СУРАЛЦАХ” ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭЭР БАГШ АЖЛЫН БАЙРАНДАА ХӨГЖИХ НЬ

(II байр)

Б.Ууганцэцэг¹, Н.Болормаа², Т.Туяа³, Б.Уугангэрэл⁴, Д.Римма⁵

Сэлэнгэ аймгийн Мандал сумын

ерөнхий боловсролын 2 дугаар сургууль

buyandelgeruugantsetseg@gmail.com¹, bdoo0105@gmail.com², tuya1929@gmail.com³,
Uugangerelbayrsaikhan@gmail.com⁴, Rimka5247@gmail.com⁵

Хураангуй

Их, дээд сургуульд эзэмшсэн багшлах ур чадвар, арга барилтай холбоотой онол, арга зүйн мэдлэгийг ажлын байрандаа хэрхэн ашиглах, дадлагажих, чадваржих, хамт олон, орчиндоо дасан зохицох зэрэг асуудлууд шинэ, залуу багш нарт тулгамддаг. Уг асуудлыг шийдвэрлэхийн тулд ахмад, туршлагатай багшийн оролцоо, нөлөөллийг нэмэгдүүлэх зорилгоор сургуулийн хүрээнд тухайн жилийн сургуулийн зорилго, зорилттой уялдуулан “Дагалдан суралцах” хөтөлбөрийг санаачлан 2 жилийн хугацаанд хэрхэн хэрэгжүүлж, үр дүнг тооцсон талаар авч үзсэн болно. Тус хугацаанд нийт 8 залуу, 8 ахмад багш хөтөлбөрт хамрагдсан. “Дагалдан суралцах” хөтөлбөрт эхний жилдээ ажиллаж буй залуу багш нар хамрагдана. Хөтөлбөрийн үргэлжлэх хугацаа 1 жил байх ба хариуцсан ахмад багш нарын удирдлага дор 5 чиглэл бүхий 13 үйл ажиллагааг хэрэгжүүлж, 2 удаа үнэлүүлнэ. Уг хөтөлбөрт хамрагдсан залуу багш нарт багшлах арга барил, ур чадвар, суралцагчидтай харилцах эв дүй сайжирч, хамт олонтойгоо богино хугацаанд танилцан дотносох зэрэг ахиц өөрчлөлт гарсан нь тус хөтөлбөр үр дүнтэй байгааг илтгэж байна.

Түлхүүр үгс: хамтын ажиллагаа (Collaboration); залуу багш; тулгамдаж буй асуудал (Problem) ахиц амжилт.

Оршил

2022 оны Боловсрол Шинжлэх Ухааны Яамны судалгаагаар Ерөнхий боловсролын сургуульд 48.4%-ийг 0-10 жил, 29.2%-ийг 10-20 жил, 17.9%-ийг 21-ээс дээш жил ажилласан багш нар эзэлж байна. Багш ажлын байрандаа хөгжихөд нөлөөлөх хүчин зүйлс юу вэ? гэсэн асуулгад 35.6% нь өөрийн идэвхтэй үйл, 34.5% нь ахмад багш нараас туршлага судлах нь чухал гэж хариулжээ. Тэгвэл “Ахмад багш” гэж хэнийг хэлэх вэ? гэсэн асуулгад судалгаанд оролцогчдын 64% нь “20-иос дээш жил ажилласан, туршлагатай, өөрийн гэсэн заах арга барилтай багшийг хэлнэ” гэж хариулсан. Тиймээс ахмад багш нар залуу багш нартаа зөвлөн хамтран ажиллах нь асуудлуудыг шийдвэрлэх гол арга зам гэж үзлээ. Үүнд тулгуурлан Сэлэнгэ аймгийн Мандал сумын Ерөнхий Боловсролын 2 дугаар сургуулийн залуу багш нарын “Нэмэх цэнэг” клубийн санаачилгаар “Дагалдан суралцах” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэхэд гарсан үр дүн нь уг сэдвийг сонгосон үндэслэл боллоо.

Судалгааны хэрэгцээ шаардлага

Залуу багш нар харилцан биенээсээ суралцаж, хамтдаа хөгжих зорилгоор байгуулагдсан “Нэмэх цэнэг” клуб 2 дахь хурлаараа тулгамдаж буй асуудлаа хэлэлцэхэд бичиг баримт хөтлөх, хичээл төлөвлөн зохион байгуулах, анги удирдах, сурагчид, эцэг эхтэй хамтран ажиллахад бэрхшээл буйг тодорхойлсон. Уг асуудлыг шийдвэрлэхийн тулд сургуулийн менежментэд тулгуурлан “Дагалдан суралцах” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага бий болсон.

Судалгааны зорилго

Ахмад багш нарын оролцоо бүхий “Дагалдан суралцах” хөтөлбөрөөр дамжуулан залуу багш нар ажлын байрандаа хөгжих, ур чадвараа сайжруулах боломж, арга замыг тодорхойлно.

Судалгааны зорилт

1. Залуу багш нар ажлын байрандаа хөгжих боломжийг тодорхойлох
2. Залуу багш нарын ур чадвараа сайжруулах арга замыг тодорхойлох
3. “Дагалдан суралцах” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, үр дүнг тооцох

Судалгааны аргууд

Асуулгын арга, баримт бичгийн судалгааны арга, SWOT шинжилгээ

Судалгааны таамаглал

“Дагалдан суралцах” хөтөлбөрийг хэрэгжүүлснээр залуу багш нарын мэргэжлийн ур чадвар, арга зүй дээшилж, суралцагчдын сурлагын амжилтад ахиц гарна. Судалгааны шинэлэг тал

“Дагалдан суралцах” хөтөлбөрийн үр дүнд залуу багш нарт тулгамдсан асуудлуудыг ахмад багш нарын дэмжлэгтэйгээр шийдвэрлэсэн нь судалгааны ажлын шинэлэг тал болно.

Судлагдсан байдал

2018 онд Оросын Холбооны Улс болон Бүгд Найрамдах Казахстан Улсын 561 сургуулийн 10000 гаруй багшаас авсан судалгааны үр дүнгээр “залуу багш нарыг дэмжин ажиллах, тэдэнд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгдөг ч явц, үр дүнд нь хяналт тавьдаггүй” гэсэн дүгнэлт гарчээ.¹

Мөн Оросын Холбооны Улсад багш нарт явуулсан социологийн судалгаанаас үзэхэд сурган хүмүүжүүлэх их, дээд сургууль төгсөгчдийн 42% нь л мэргэжлээрээ ажилладаг ч нэг, хоёр жилийн дараа тэдний тал хувь нь ажлын байрандаа үлддэг. Үүний гол шалтгаан нь багш ажлын байрандаа дасан зохицох чадваргүй байгаатай холбоотой гэж дүгнэсэн.²

¹ Е. В. Чернобай, Профессиональное развитие учителей в Российской Федерации и Республике Казахстан По результатам исследования, TALIS, 2018

² TALIS, Creating Effective Teaching and Learning Environments, 2009. page 51-52

Манай улсад залуу багш нарт тулгамдсан асуудлуудыг илрүүлэх, шийдвэрлэх талаарх томоохон судалгаа шинжилгээний ажил одоогоор хийгдээгүй байна. Харин 2014 онд Орхон аймгийн Баян-Өндөр сумын 16 дугаар сургуульд жилийн хугацаанд хамтран ажиллаж, харилцан туршлага солилцох, суралцах зорилгоор 18 бүлгийн 36 багшийг хамруулсан “Хос багш” үйл ажиллагааг зохион байгуулсан байдаг.

Үндсэн хэсэг

Онолын үндэс

Сургуулийн менежментийн онолд сургуулийн хөгжлийг макро, мезо, микро гэсэн 3 түвшинд үздэг. Мезо түвшний менежментэд хөтөлбөрийн хэрэгжилт, түгээлтийн явцыг голлон авч үзнэ³. 1980 оноос сургуульд суурилсан Ментор загвар нэвтэрч дэлхийн өнцөг булан бүрт тус загвар хэрэгжиж эхэлсэн. Дэлхий дахинаа багшийн тасралтгүй хөгжил гэдгийг багшийн өдөр тутмын үйл ажиллагаа, ажлын байранд явагдах байнгын оролдлого, хамтын ажиллагааны үр дүн хэмээн тодорхойлжээ. Үүний тулд сургууль өөрөө тасралтгүй суралцагч байгууллага болж суралцахуйн орчин ба суралцахуйн соёлыг бүрдүүлэх ёстой (Ариунбаатар, 2019). Тэрээр дэлхий дахинаа Финлянд, Япон, Сингапур гэсэн үндсэн 3 загвар байна гээд Сингапурын загварын гол онцлог нь дагалдан суралцах буюу *mentorship* гэж үзжээ.

Хүснэгт 1. ОУ-ын багшийн хөгжлийн загвар

Загвар	Гол арга	Онцлог
Сингапур	Менторинг	Ажлын байран дах хөгжил, хамтын ажиллагаа
Финлянд	Эрдмийн зэрэг, их, дээд сургууль	Багшийн бие даасан байдал
Япон	Хичээлийн судалгаа	Практик судалгаа

Эх сурвалж: Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих боломж, арга зам сургалтын материал, БМДИ

Википедиа олон улсын нэвтэрхий тольд “Дагалдан суралцах” гэдэг нь шинэ үеийн мэргэжил, дадлагажигчдыг ажлын байран дээр сургах, ихэвчлэн дагалдах сургалтаар сургах систем гэсэн бол Монгол хэлний их тайлбар тольд ажил мэргэжилд хэн нэгний үлгэр, заавраар суралцагч гэжээ⁴.

Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 3.1.2-т “Багшийн хөгжил гэдэг нь багшийн мэдлэг, ур чадвар, боловсролоо дээшлүүлэх тасралтгүй үйл явц гэж тодорхойлсон байдаг.

Судалгааны хэсэг

Алхам 1. 2015-2018 оны хичээлийн жил

2015-2018 оны хичээлийн жилүүдэд сургуулийн захирлын тушаалаар дадлагажуулагч багш, дагалдан багшийг томилон ажиллуулж ирсэн.

³ Боловсрол судлал, Улаанбаатар, хуудас-41

⁴ [ps://mongoltoli.mn/dictionary/detail/30048?fbclid=IwAR0o-lxHgQJ_gHCnGWhmCBy5z9TrongzDv4HlUVKdCNbLzR-QgQ309ELYE](https://mongoltoli.mn/dictionary/detail/30048?fbclid=IwAR0o-lxHgQJ_gHCnGWhmCBy5z9TrongzDv4HlUVKdCNbLzR-QgQ309ELYE)

Үр дүн: Залуу багш нарт бичиг баримт хөтлөлт, хөтөлбөр төлөвлөгөө боловсруулах, сурагчид, эцэг эхтэй харилцах харилцаанд эерэг өөрчлөлтүүд ажиглагдсан боловч үр дүн нь хэмжигдэхүйц биш байсан.

Алхам 2. 2018-2019 оны хичээлийн жил

Алхам 1-ийн үр дүнд үндэслэн 3 сарын хугацаанд залуу болон ахмад багш хамтран “Туршлага судлах” үйл ажиллагааг хэрэгжүүлж, үр дүнг “Сайн хичээл”-ийн уралдаанаар тооцсон.

Үр дүн: Цаашид уг үйл ажиллагааг сайжруулах, үр дүнг тооцох зорилгоор 15 залуу багшаас авсан асуулгын дүнг дараах байдлаар боловсрууллаа.

Зураг 1. “Туршлага судлах” үйл ажиллагаанд ажиглагдсан сул тал



“Туршлага судлах” үйл ажиллагаа нь мэргэжлийн өсөлтөд нөлөөлсөн гэдэгтэй багш нар 100% санал нийлсэн.

Зураг 2. Ахмад багш нартай хамтран ажилласнаар залуу багшид гарсан эерэг өөрчлөлтүүд




Үйл ажиллагаанд хамрагдсан нийт багш нарын 40% нь сургалтын шинэ арга зүйд суралцаж, хөтөлбөр төлөвлөгөө боловсруулах чадвар ахисан, 20% нь анги удирдах арга зүйд суралцсан гэж дүгнэсэн бол 30% нь 3 сарын хугацаанд суралцах нь хангалтгүй, үр дүнг зөвхөн сайн хичээлийн уралдаанаар дүгнэх нь явцуу байна гэж үзсэн.


Алхам 3. Хэрэгжүүлсэн байдал

Үе шат 1.

Зураг 3. 2019-2020 оны хичээлийн жилд хөтөлбөрт




Зураг 4. 2019-2020 оны хичээлийн жилд хамрагдсан багш нарт гарсан ур чадварын ахиц, амжилт хөтөлбөрт хамрагдсан багш тус бүрийн ахиц, амжилт



Дээрх тоон боловсруулалтаас харахад багш нарын эхний хагас жилийн гүйцэтгэл 50.1%-тай үнэлэгдсэн бол жилийн эцэст 84.9% болж 34.8%-иар өссөн. Мөн 6 залуу багш урилгатай хичээл 30, ээлжит хичээлийн төлөвлөлт 56, ажлын хуудас 91, үнэлгээний даалгавар 29-ийг боловсруулан, идэвхтэй сургалтын арга зүй 12, судалгааны арга зүй 10-ыг тус тус эзэмшиж, 104 цагийн хичээлд суужээ.

Зураг 5. Суралцагчдын сурлагын ахиц, амжилт (2019-2020)



Дээрх 6 багшийн гарааны болон жилийн эцэст хийгдсэн хөндлөнгийн үнэлгээг харьцуулахад дундаж гүйцэтгэл 51%-иас 77.7% болж 26.7%-иар ахисан. Ахицыг багш тус бүрээр авч үзвэл 22.6-30.9%-ийн ахицтай ажиллажээ.


Хүснэгт 2. Суралцагчдаас авсан үнэлгээний даалгаврын тохирц

Багш	Тохирц					
	х.зэрэг		R		Ø	
	гараа	хөндлөн	гараа	хөндлөн	гараа	хөндлөн
Багш 1	0.571	0.652	0.788	0.842	0.40	0.88
Багш 2	0.536	0.636	0.769	0.839	0.28	0.85
Багш 3	0.551	0.637	0.774	0.815	0.3	0.936
Багш 4	0.532	0.643	0.647	0.802	0.4	0.768
Багш 5	0.459	0.627	0.81	0.801	0.108	0.835
Багш 6	0.525	0.611	0.739	0.867	0.3	0.936
Дундаж	0.529	0.634	0.755	0.828	0.30	0.87

Гарааны болон хөндлөнгийн шалгалтын даалгаварт хийсэн шинжилгээнээс харахад гарааны үнэлгээний даалгавар нь ялгах чадвар сул бол хөндлөнгийн үнэлгээний даалгавар нь хүнд хөнгөний зэрэг тохирсон, найдвартай байдлын хувьд суралцагчдыг бодитой үнэлж чадахуйц, ялгах чадвар сайн даалгавар болсон.

Асуулга. Хөтөлбөрт хамрагдсан багш нараас авсан хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх асуулга

Зураг 6. Дагалдан суралцах хөтөлбөрт хамрагдсанаар багшид ур чадварын ахиц гарсан эсэх



Зураг 7. Хөтөлбөрийн дагуу ажилласнаар гарсан ахиц, зэрэг өөрчлөлтүүд



Асуулгын дүнгээс үзэхэд 83% нь мэргэжлийн ур чадварт ахиц гарсан гэж дүгнэсэн. Тэдний 57% нь заах арга зүй дээшилсэн, 29% нь багаар ажиллах чадварт суралцан, хамтын ажиллагаа сайжирсан гэж үзжээ.

Хүснэгт 3. Хөтөлбөрт хийсэн SWOT шинжилгээний үр дүн


Давуу тал (strengths)	Сул тал (weaknesses)
Зорилго, хийгдэх үйл ажиллагаа тодорхой. Төлөвлөгөөний дагуу ажиллах нь цэгцтэй. Үр дүнг тооцоход хялбар. Цаг хугацаа хэмнэсэн. Удирдлагын багтай тогтмол харилцах боломжийг бүрдүүлсэн.	Цар тахлын улмаас хариуцсан ахмад багштай ажиллах боломж хязгаарлагдсан. Хичээл цахимд шилжсэн нь сурагчидтай ажиллах практик дадлага хийх боломж багассан. Зөвхөн нэг ахмад багшаас суралцах нь хангалтгүй
Боломж (opportunities)	Эрсдэл (threats)
Ажлын байрандаа хурдан хугацаанд дасах Хамт олонтойгоо богино хугацаанд дотносох Ажлын байрандаа хөгжих нөхцөл бүрдэх	

Үе шат 2: 2020-2021 оны хичээлийн жилд хөтөлбөрт хамрагдсан багш нарын ажлын үр дүнг графикаар илэрхийлвэл:

Зураг 8. 2020-2021 оны хичээлийн жилд хөтөлбөрт




Зураг 9. 2020-2021 оны хичээлийн жилд хамрагдсан багш нарын үр чадварын ахиц, амжилт хөтөлбөрт хамрагдсан багш тус бүрийн ахиц, амжилт



Дээрх тоон боловсруулалтаас харахад багш нарын эхний хагас жилийн гүйцэтгэл 54.5%-тай үнэлэгдэж байсан бол жилийн эцэст 90.5%-тай болж 36%-иар өссөн. 2 залуу багш урилгатай хичээл 12, ээлжит хичээлийн төлөвлөлт 18, ажлын хуудас 32, үнэлгээний даалгавар 8-ыг боловсруулан, идэвхтэй сургалтын арга зүй 4, судалгааны арга зүй 3-ыг эзэмшиж, 16 цагийн хичээлд сууж, тэмдэглэл хөтөлсөн.

Зураг 10. Суралцагчдын сурлагын ахиц, амжилт (2020-2021)



Гарааны үнэлгээ болон жилийн эцэст хийгдсэн хөндлөнгийн үнэлгээний дүнг харьцуулахад дундаж гүйцэтгэлийн хувь 55.5%-иас 79.4% болж 23.9%-иар ахисан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 4. Суралцагчдаас авсан үнэлгээний даалгаврын тохирц

Багш	Тохирц					
	х.зэрэг		R		Ø	
	гараа	хөндлөн	гараа	хөндлөн	гараа	хөндлөн
Багш 1	0.571	0.652	0.788	0.842	0.501	0.91
Багш 2	0.536	0.636	0.769	0.839	0.485	0.93
Дундаж	0.554	0.644	0.779	0.841	0.493	0.920

Хүснэгтээс харахад гарааны үнэлгээний даалгаврууд нь бага зэрэг хүндэдсэн, ялгах чадвар сул байсан бол хөндлөнгийн үнэлгээний даалгаврууд нь сурагчдын мэдлэгийг хангалттай зөв үнэлж чадахуйц, хүнд хөнгөний зэрэг тохирсон даалгавар

болсон гэж дүгнэсэн.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх асуулга

Хөтөлбөрийн дагуу ажилласнаар мэргэжлийн ур чадварт ахиц гарсан эсэх талаар багш нараас тодруулж асуухад бүгд “Тийм” гэсэн хариулт өгсөн байна.

Зураг 11. Хөтөлбөрийн дагуу ажилласнаар гарсан ахиц, зэрэг өөрчлөлтүүд



Дээрх асуулгын дүнгээс харахад хөтөлбөрт хамрагдсан 2 багшийн мэргэжлийн ур чадварт ахиц гарсан гэж дүгнэсэн. Тэдэнд туршлага судалж, заах арга барил, хөтөлбөр төлөвлөгөө боловсруулах, анги удирдан ажиллах зэрэгт маш их дэмжлэг үзүүлсэн гэж дүгнэжээ.

Хүснэгт 5. Хөтөлбөрт хийсэн SWOT шинжилгээний үр дүн

Даеу мал (strengths)	Сул мал (weaknesses)
- Мэргэжлийн ур чадварт ахиц дэвшил гарсан. - Туршлага судлах боломжийг бүрдүүлсэн. - Хамтран ажиллах, суралцах нөхцөл бүрдсэн. - Үнэлэх, дүгнэх зарчим тодорхой, ойлгомжтой - Цаг хугацаа хэмнэсэн.	- Зөвхөн нэг ахмад багшаас суралцах нь хязгаарлагдмал байна. - Цахимаар хариуцсан багштайгаа холбогдон ажиллах нь хүндрэлтэй байсан. - Ахмад багшийг сонгуулах боломж өгөөгүй.
Боломж (opportunities)	Эрсдэл (threats)
- Ажлын байрандаа хурдан хугацаанд дасан зохицох - Багш нарын залгамж холбоо, хамтын ажиллагаа сайжрах	- Цар тахлын улмаас хөтөлбөрийн хэрэгжилт доголдох, төлөвлөгөөний дагуу зарим үйл ажиллагаа орхигдох

Хүрсэн үр дүн буюу практик ач холбогдол

- 2019-2021 онуудад 8 залуу багш нийт 42 урилгатай хичээл, 5 мэргэжлийн 74 ээлжит хичээлийн төлөвлөлт, 86 ажлын хуудас, 37 үнэлгээний даалгавар боловсруулан зөвлөгөө авч, 120 цагийн хичээлд сууж, тэмдэглэл хөтөлснөөр бичиг баримт хөтлөлт, заах арга зүй, ур чадвар, хүүхэдтэй ажиллах эв дүйд ахиц гарсан.
- Багшийн тасралтгүй хөгжлийн эцсийн үр дүн нь суралцагчийн хөгжил. Суралцагчийн сурлагын амжилт бол багшийн хөгжлийн нэг том шалгуур юм. Багш нарын гарааны үнэлгээ болон жилийн эцэст хийгдсэн хөндлөнгийн үнэлгээний дүнг харьцуулахад тэдний дундаж гүйцэтгэл 53.2-иас 77.7 болж 26.7%-иар ахисан байна. Харин багш тус бүрээр авч үзвэл 22.6-30.9%-ийн ахиц гарсан.

Дүгнэлт

- Судалгааны үр дүнгээс хөтөлбөрт хамрагдсан багш нарын 82%-д нь мэргэжил, заах арга зүй, ур чадварт ахиц гарсан гэж дүгнэсэн нь “Дагалдан суралцах” хөтөлбөр үр дүнтэй байгааг илтгэж байна.
- Залуу багш нарын заах арга зүй, бичиг баримт хөтлөлт, ангитай ажиллах эв дүйд ахиц гарсан нь багш нар ахмад багшийн дэмжлэгтэйгээр ажлын байрандаа хөгжих боломжтойг харуулж байна.
- Ахмад багш нараас дагалдан суралцах нь эдийн засгийн хувьд хэмнэлттэй, дотоод нөөц боломжид тулгуурлан багшийн мэргэжлийн өсөлтөд нөлөөлж болохыг хөтөлбөрийн үр дүн харуулж байна.
- “Дагалдан суралцах” хөтөлбөрийг хэрэгжүүлснээр залуу багш нарын мэргэжлийн ур чадвар, арга зүй дээшилж, суралцагчдын сурлагын амжилтад ахиц гарсан.
- Тус хөтөлбөрт хамрагдсанаар онол арга зүйн мэдлэгээ ахмад багшийн туршлагад тулгуурлан сайжруулж, ажлын байрандаа богино хугацаанд дасан зохицоход ихээхэн түлхэц болж байна.

Дэвшүүлэх санал

- Дагалдан суралцах ахмад багшаа өөрөө сонгох боломжгүй байгаа асуудлыг залуу багш, ахмад багшийн тооноос хамаарч сонгуулах эсвэл шууд оноох эсэхийг шийднэ.
- Зөвхөн нэг багшаас суралцах нь хязгаарлагдмал байна гэсэн сул талыг сайжруулахдаа ахмад багшийн сайн туршлагыг видео хэлбэрээр “*ахмад багш нарын туршлагын сан*” нэртэй Youtube сувагт байршуулах байдлаар шийдэж байна. Мөн өртөөчилсөн байдлаар нэг ахмад багшийг гурван сар дагалдаад дараагийн багш руу шилжихээр өөрчлөлт оруулж болно.
- “Дагалдан суралцах” хөтөлбөр нь Сингапур улсын багшийн хөгжлийн загвартай дүйхээс гадна үр дүнтэй болох нь судалгаанаас нотлогдсон учир үндэсний хэмжээнд хэрэгжиж болохуйц хөтөлбөр юм.

Ном зүй

- Авдай, Ч. Энхтуяа, Д. (2019). Судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх арга зүй, Улаанбаатар
- Ариунбаатар, Ц. (2019). Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих боломж, арга зам сургалтын материал, БМДИ
- БШУЯ-ны харьяа Боловсролын хүрээлэн, (2021). Эрдэм шинжилгээний бичиг №26, Улаанбаатар
- БСШУСЯ, Боловсролын хүрээлэн, (2019). “Багш хөгжил – сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний хэрэглээ”, Улаанбаатар
- БСШУЯ, (2016). Хүүхэд нэг бүрийн хөгжил (туршлага, амжилт, үр дүн), Улаанбаатар, 176-178-р тал
- Вейдт, В.П. Пути решения проблем молодого учителя, (2015). Калининград, страница-59
- Дэлгэржав, М. (2018). Багшийн хөгжил, Улаанбаатар, 696-698-р тал
- Пүрэвдорж, Ч. (2013). Багшлахуйн менежмент, Улаанбаатар, 351,355-р тал
- Ичинхорлоо, Ш. (2011). Сургуулийн хөгжлийн зарим асуудал, Улаанбаатар, 44-46-р тал
- Ичинхорлоо, Ш. (2011). Сургалт, Улаанбаатар, 27-31-р тал
- Ичинхорлоо, Ш. (2012). Хамтран ажиллах ухаан, Улаанбаатар, 5-8-р тал
- Сако Хидэказү. (2022). Сургуулийн менежмент, Сургуулийн судалгаа, хөгжлийн Шинэ Монгол төв
- Чойжил, Л. (2011). Туршлага хуучирдаггүй. 30-35-р тал. Улаанбаатар,
- Сэлэнгэ аймгийн Боловсролын газар.(2021). Шинэ зууны шилдэг туршлага эмхэтгэл
- Отгонтуяа, Д., Оюун-Эрдэнэ, М., Оюунбилэг, Т. (2021). Багшийн мэргэжлийн хөгжлийн бүлгийг хөгжүүлэх зарим асуудал. “Боловсролын тулгамдсан асуудал, шийдэл, арга зам” эрдэм шинжилгээний үндэсний хамтарсан VII хурал. Улаанбаатар.

Сэтгүүл

- Эрдэнэтуяа, Д., Батзаяа, Д. (2015). Багшийн хөгжлийн асуудалд. “Боловсрол судлал” сэтгүүл. Дугаар 10 (118), 34-39. Улаанбаатар: Соёмбо принтинг.
- Сарантуяа, Д., Монголхатан, Г. (2022). Хөтөлбөрийн хэрэгжилт ба хүүхдийн хөгжлийн зарим асуудал. “Боловсрол судлал” сэтгүүл. Дугаар 01 (179), 41-43. Улаанбаатар: Соёмбо принтинг.

Цахим эх сурвалж

- Чернобай, Е.В., Ташибаева, Д. Н. (Апрель, 2020.) Профессиональное развитие учителей в Российской Федерации и Республике Казахстан По результатам исследования TALIS-2018 (<https://cyberleninka.ru/article/n/professionalnoe-razvitiye-uchiteley-v-rossiyskoy-federatsii-i-respublike-kazakhstan-po-rezultatam-issledovaniya-talis-2018/viewer>)
- TALIS, Creating Effective Teaching and Learning Environments (2009) Chapter-3, page 51-52 (<https://www.oecd.org/berlin/43541636.pdf>)
- <https://esis.edu.mn/hr/index.html#/infographic>
- https://mongoltoli.mn/dictionary/detail/30048?fbclid=IwAR0olxHqQJ_gHCnGWhmCBY5z9TronqzDv4HluvKdCNbLzhR-QqQ309ELYE

СУРАГЧДЫН НОМ УНШИХ, УНШААД ОЙЛГОХ ЧАДВАРЫГ НЭМЭГДҮҮЛЭХЭД АХМАД БАГШИЙН АРГА ТУРШЛАГЫГ ТУРШИН ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

(II байр)

Ц.Мөнхцэцэг¹, Б.Адъяацэрэн², Э.Болормаа³, Б.Даваажав⁴, Б.Өлзийдэмбэрэл⁵

Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын

Ерөнхий боловсролын сургууль

ts.monh8@gmail.com¹, b.adiya7980@gmail.com², ebolormaa_0095@gmail.com³,
b.dawaajaw9011@gmail.com⁴, oogiinze99@gmail.com⁵

Хураангуй

Өргөн хүрээнд бие дааж унших чадвартай хүн тасралтгүй суралцах чадвартай байдгийг судлаачид баталснаас үзэхэд бүтээлчээр сэтгэж, бие даан суралцах чадвартай иргэн болж төлөвшихөд нөлөөлж буй суурь чадвар нь унших юм. Манай улсад сурагчдыг бага ангиас нь минутын уншлагаар шахаж, хурд хөөлгөдөг нь сурагчдын уншаад ойлгох чадвар сулрах, цаашлаад ном унших сонирхлыг бууруулахад нөлөөлж байна. Уншихын зорилго бол ойлгох юм. Энд бид ЕБС-ийн 6-12 дугаар ангийн суралцагчдын “Уншаад ойлгох чадварыг тодорхойлох” шалгууруудыг боловсруулан судалж, энэ түвшний сурагчдад унших дадлыг хэвшүүлэх, уншаад ойлгох чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 2 жилийн турш туршсан үйл ажиллагааны үр дүн, сурагчдад илэрч буй эерэг өөрчлөлтийг тусган харуулахыг зориллоо.

Түлхүүр үг: унших чадвар; ном; ахмад багш; арга туршлага; уншаад ойлгох чадварын судалгаа.

Оршил

БШУСЯ, Монголын ахмад багш нарын холбооноос санаачлан 2018 онд зохион байгуулсан “Бүтээлч ахмад багш нарын 3 дугаар зөвлөгөөн” -ий үеэр ахмад багш нар: “Сургалтын чанарыг сайжруулахад залуу багш нарын ур чадвар, ёс зүйг дээшлүүлэх шаардлага тулгарч байна” гэдэгтэй санал нэгдсэн байдаг. Мөн 2021 оны 2 дугаар сард Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан Монголын ахмад багш нарын төлөөллийг авч уулзаж, тэдний санал зөвлөмжийг сонсож, цаашид хамтран хэрэгжүүлэх чиглэл хэлэлцэхдээ “Ахмад багш нар бол Монголын боловсролын үнэт капитал” хэмээн онцлон тэмдэглээд, ахмад багш нарт хандан: Залуу үеэ халамжлан хүмүүжүүлэх, багш бүр сурагчдад өгөөжтэй байж, хүүхдэд үглэж бус үлгэрлэж сургах зэргээр ахмад багш нарын тус дэм, хүчийг ашиглах талаар хэлэлцэн тохирсон байна. “Ахмад багш гэдэг бол боловсролын салбарын капитал. Боловсролын салбар өөрийнхөө бий болгосон капиталын үр өгөөжийг хүртэх ёстой. Тухайн ахмад багш хөдөлмөрлөх бололцоотой гэвэл “ур чадвар”-ыг нь, “арга туршлага”-ыг нь ашиглая”⁵. Ийм ч учраас энэ жилийн илтгэлийн сэдэв маань энэ чиглэлээр зарлагдсан биз ээ. Хувь хүний амьдралын чанарыг илтгэдэг, дэмждэг, тухайн улс орны хөгжлийг

⁵ БШУСайд Л.Энх-Амгалан

тодорхойлдог тэргүүлэх салбар бол боловсрол юм ⁶. Аливаа улс үндэстний боловсролыг олгох хэрэглүүр нь хэл бичиг юм. Бид энэ илтгэлдээ ахмад багшийн арга зүй арвин их баялаг сангаас сурагчдын эх хэлээрээ уншаад ойлгох чадварыг нэмэгдүүлэх, ном зохиол уншуулах арга туршлагыг хэрхэн авч хэрэглэх боломж, шийдэл байгааг судалгаа, туршилтаар нотолж, шийдвэрлэх арга замыг дэвшүүлэн гаргалаа.

Хэрэгцээ шаардлага

1. ХХ зууны дунд үе хүртэл дэлхий нийтээр боловсролын үйлчилгээг танхимын сургалтын хэлбэрээр голчлон хүлээн авч байсан цаг үе ард үлдэж ХХI зуун буюу мэдээлэл технологийн хурдацтай хөгжлийн эрин үед боловсрол төдийгүй нийгмийн бүхий л салбарт интернэт, цахим платформыг дэвшилтэт технологүүдыг ашиглан сургалт болон аливаа үйл ажиллагааг явуулах боломж бүрдэж байгаа ч ахмад багшийн арвин их өв сан, туршлагыг оновчтой шийдлээр авч хичээл сургалтдаа ашиглах, арга зүйгээ сайжруулах хэрэгцээ шаардлага тулгарч байна.

2. Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллага (OECD)-аас хэрэгжүүлдэг Program for International Student Assessment (PISA) буюу сурлагын амжилтын олон улсын үнэлгээнд Монгол улс анх удаа хамрагдахаар болсон. PISA нь суурь боловсролоо эзэмшсэн 15 настай суралцагчид танхимаар олж авсан мэдлэг, чадвараа амьдрал дээр хэрхэн хэрэглэж байгаа, тухайн улсын боловсролын тогтолцоо энэ чадварыг ямар хэмжээнд олгож байгааг тандан судалдаг сурлагын амжилтын олон улсын үнэлгээ бөгөөд суралцагчдын мэдлэг, чадварыг математик, байгалийн ухаан, УНШИХ, бүтээлч сэтгэлгээний агуулгаар судалдаг. Энэ үнэлгээнд сурагчдын унших чадварыг онцлон авсан нь унших чадвар эзэмшсэн хүн судалж буй бүх хичээлүүдийн агуулгыг эзэмшихээс гадна шаардлагатай мэдээллийг бусад эх сурвалжаас эрж олох, асуудалд, өөрийн байр сууринаас хандах, шүүн тунгаах чадвартай болдог гэж үздэг учир сурагчдыг уншуулах, уншсанаа ойлгодог, өөрийн уншиж мэдсэн мэдээллээ задлан шинжлэх, харьцуулах, ангилах, практикт хэрэглэх зэрэг бүтээлч үйл хийдэг сурагчдыг төлөвшүүлэх шаардлага тулгарч байна. ⁷

3. Сүүлийн 2 жилд ковидын улмаас танхимын сургалт цахим сургалтад шилжсэнтэй холбоотойгоор цахим хэрэглээ ихсэж байгаа нь хүүхдүүдийн эх хэлээрээ зөв зохистой ярьж бичих, аливааг эрэл хайгуул хийх чадварт сөргөөр нөлөөлж байна.

Үндэслэл

Эрх зүйн үндэслэл нь: Иргэдийн эх хэлний боловсролын чанар хэрэглээ, иргэдийн харилцааны соёлын түвшинг дээшлүүлэх, эх хэлний дархлааг сайжруулах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг БШУ-ны сайдад үүрэг болгосугай.

1.2. Ерөнхий боловсролын сургууль төгсөгч, их, дээд сургууль, коллежид элсэгчдээс монгол хэл бичгийн хичээлээр шалгалт авч байх журам тогтоон 2013-2014 оны хичээлийн жилээс эхлэн мөрдүүлэх;

⁶(МУЗГ, Алсын хараа 2050)

⁷ <https://said.mn/content/10/122579>

Практик үндэслэл: 2018-2019 оны хичээлийн жилээс монгол хэл бичгийн шалгалтыг босго оноотой болгож, босго оноо давсан сурагч их дээд сургуульд элсэн суралцах эрхтэй болдог болсон нь МХУЗҮБ-ийн багш бид бүхний хувьд томоохон үүрэг хариуцлага ирсэн.



Манай сургуулийн хувьд хэл бичгийн шалгалтад 2017-2018 оны байдлаар аймаг, улсын дунджаас доогуур, 2019 онд аймгийн дунджаас доогуур шалгагдсан нь сурагчдын эх хэлээрээ уншаад ойлгох чадвар болон бичих чадвар хангалтгүй байгааг илтгэж байна. **2019 онд ахмад багш Ц.Цэвэлмаа:** 2019 онд 12-р ангиа төгсөх гэж буй сурагчдаас хэл бичгийн агуулгаар шалгалт авахад 12а-57%, 12б-71%, 12в-46,8% -тай үнэлэгдсэн. Энэ үед жирэмсний амралттай багшийн оронд түр хугацаанд ажиллаж байсан ахмад багш Ц.Цэвэлмаа шалгалтын анализыг дүгнэхдээ:

Сурагчдын уншаад ойлгох чадвар хангалтгүй байна. Уншаад ойлгоод гүйцэтгэх даалгавар дээрээ хангалтгүй оноо авч буй сурагчид бичих даалгавар дээрээ тааруу оноо авах магадлал өндөр байдаг. Уншаад ойлгох чадварыг эзэмшүүлэхийн тулд сурагчдыг багаас нь тасралтгүйгээр хөгжүүлэх шаардлагатай байдаг учраас хүүхдийг 12 дугаар ангид ороход нь хэл бичгийн шалгалтад зориулан бэлтгэх гэхгүй багаас нь уншаад ойлгох чадварыг суулгаж тасралтгүйгээр хөгжүүлэх шаардлагатай байна. Энэ чадварыг нэмэгдүүлэхийн тулд хамгийн эхэнд унших үйлийг идэвхжүүлэх хэрэгтэй.

Ахмад багш Ц.Цэвэлмаагийн арга туршлага, зөвлөгөөг МХУЗ-ын багш Б.Даваажав туршин хэрэгжүүлж үр дүнд хүрсэн учраас сурагчдынхаа уншаад ойлгох чадварыг нэмэгдүүлэх, цаашид номоор дамжуулан сурагчдынхаа хандлага төлөвшилд эергээр нөлөөлөх боломжтой гэж үзсэн нь энэхүү судалгааны ажлыг эхлүүлэх нэг гол үндэслэл болсон. Үр дүнд нь ерөнхий монгол хэлний шалгалтад 540.6 хэмжээст онооны дундажтайгаар аймаг улсын дунджаас дээгүүр шалгагдсан.

Дэвшүүлж буй таамаглал

“Уншаад ойлгох чадварын судалгаа” (УОЧС)-ны аргаар сурагчдаа оношлон, судалгаанд тулгуурлан сурагчдын унших үйлийг идэвхжүүлэх ажлуудыг туршин хэрэгжүүлж үр дүн хүрнэ.

Судалгааны зорилго

Сурагчдын уншаад ойлгох чадварыг илрүүлэх хамгийн хялбар судалгааны аргыг сонгон, сурагчдын уншаад ойлгох чадварын түвшинг оношилж, ахмад багш нарын сурагчдад ном уншуулах, уншаад ойлгодог болгох арга туршлагыг багш бүр өөрийн арга зүйд шингээн туршин хэрэгжүүлэх гарц шийдэл боловсруулан үр дүнг томьёолно.

Судалгааны зорилт:

1. Ахмад багш нартай харилцан ярилцаж арга туршлагыг илрүүлэн судалж хэрэгжүүлэх
2. Сурагчдын номтой нөхөрлөж байгаа эсэхийг тодорхойлон ном уншихад тулгарч буй саад бэрхшээлийг илрүүлэх
3. УОЧС\FLAT судалгааны арга зүйг дунд ахлах ангийн сурагчдын түвшинд тохируулан боловсруулсан “Уншаад ойлгох чадварын судалгаа”-гаар сурагчдаа оношилж уншаад ойлгох чадварын түвшинг тодорхойлох
4. Судалгаанд тулгуурлан сурагчдын унших үйлийг идэвхжүүлэх ажлуудыг туршин хэрэгжүүлэх

Судалгааны арга


Асуулгын арга, “Уншаад ойлгох чадварын судалгаа”, ажиглалтын арга, фокус ярилцлагын арга.

Судалгааны объект

Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын ЕБС-д монгол хэл, уран зохиолын багшаар ажиллаж байсан ахмад багш нар болон 6-12 дугаар ангийн сурагчид

Судалгааны хэсэг

Зураг 1,2. Бичиг үсэг тайлагдалтын Flat судалгаа – уншаад ойлгох чадварын харьцуулалт



Дээрх харьцуулсан судалгаанаас үзэхэд унших үйлийг тасралтгүй авч яваа 8г, 12б ангиуд бусад ангиасаа гүйцэтгэлийн хувиар илүү байна. Тиймээс сурагчдаа ном унших, уншаад ойлгох үйлд тасралтгүй уриалах ажлуудыг тогтмолжуулж, сурагчдаа бүтээлчээр сэтгэх бие дааж суралцах чадварт суралцуулах нь чухал юм.

Судалгааны ажлын эерэг нөлөөлөл


“Өглөөний гайхамшиг” найман удаагийн сорилтод давхардсан тоогоор 476 хүн оролцсон. Үүнээс 6-12 дугаар ангийн 398 сурагч оролцсон нь өглөөний цагаа сурч боловсрохдоо, эрүүл мэнддээ зарцуулж өөрийгөө бүхий л талаараа хөгжүүлэхээс гадна бусдадаа эерэг нөлөөллийг үзүүлж байлаа. 2018 оноос эхлэн уран зохиолын,

хувь хүний хөгжлийн танин мэдэхүйн номнуудыг унших МХУЗ-ын багшийн тоо ихэсч бүгд уншигч багш нар болсон. Үүгээр ч зогсохгүй сургуулийн бусад багш нарт нөлөөлж ном уншдаг багш нарын тоо нэмэгдэж, АУБ нар бидэнтэй хамтран ангийн сурагчдаа ном уншуулах, номтой болгоход хамтран ажиллаж байгаа нь сайшаалтай байна.

Судалгааны ажлын дүн


Асуулт 1: Сурагчдын уншаад ойлгох чадварыг сайжруулахын тулд ямар ямар арга хэрэглэж байсан бэ?

Зураг 1. Уншаад ойлгох чадварыг сайжруулахад хэрэглэсэн аргууд




Ахмад багш нарын тогтмол хийж хэрэгжүүлдэг байсан дээрх аргуудаас туршин хэрэгжүүлэхэд дээрх арга туршлагуудын ололттой тал нь багш бүр өөрийн арга зүйдээ шингээн өнөөгийн нөхцөлд шууд аваад хэрэглэхэд тохиромжтой. Харин утаснаас хол байлга, огт бүү хэрэглүүл, зөвхөн номтой нөхөрлүүл гэсэн зөвлөгөөг шууд хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байлаа. Учир нь нийгмийн олон талт хэрэгцээнээс шалтгаалан ухаалаг утсыг зохистой хэрэглэх шаардлага тулгарч байна. Тиймээс цахим ном уншуулах, аудио ном уншуулах, интерактив ажлын хуудас ажиллуулах, подкаст сонсох зэргээр ашиглуулж байна.

Судалгаа 1. Цахим ертөнцөд эдгээр зүйлсийн алинд нь илүү цаг зарцуулдаг вэ?




Судалгаа 2. Цахим ертөнцөд эдгээр зүйлсийн алинд нь илүү цаг зарцуулдаг вэ?



Зургаас харахад сонсдог ном, подкаст сонсох зэрэг нэмэгдсэн байна.


Зураг 3. Хамгийн сүүлд уншсан ном




2019 онд авсан судалгаагаар ном уншдаг хүүхэд цөөхөн байсан төдийгүй хамгийн сүүлд уншсан номын нэр нь сурах бичигт байсан зохиол төдийхнөөр хязгаарлагдаж байсан бол сүүлд авсан судалгаагаар ном уншдаг хүүхдийн тоо нэмэгдэж хамгийн

сүүлд уншсан номуудын нэр нь хувь хүний хөгжлийн, танин мэдэхүйн, уран зохиолын номуудаар баяжигдсан байна.


Зураг 4. Хамгийн олон уншсан ном



Зураг 5. 12-р ангийн хэл бичгийн шалгалтын “Уншаад ойлгох чадвар” агуулгын 2021-2022 оны хичээлийн жилд авсан шалгалтын анализ



Зураг 6. Сэтгэл ханамжийн судалгаа



6-12 дугаар ангийн сурагчдын 128 эцэг эх, асран хамгаалагчдаас түүврийн аргаар судалгаа авч, ном уншсанаар хүүхдэд гарч буй зэрэг өөрчлөлтийн талаар асуухад ухаалаг утас ашиглах нь багассан, тайван амгалан болсон, өөдрөг үзэлтэй болсон гэсэн хариултыг хамгийн их өгчээ.


Ном сурталчилгаа

Энэ нь маш өргөн хүрээг хамарсан буюу олон хүүхдийг нэгэн зэрэг хамарснаас гадна хүүхдэд хүүхдээсээ суралцах, үлгэр дуурайл авах сайхан үйл ажиллагаа болж тасралтгүй үргэлжилж байна

Номтой болгоё: Ном монита, Номтой бэлэг, Ном худалдаа зэрэг үйл ажиллагааг зохион байгуулснаар сурагчид ангиараа номтой болж байна. “Номтой нөхөрлөө” клуб нь анх 2019 онд 10 номтой үйл ажиллагаагаа эхэлж байсан бол 2022 онд Түрээсийн мөнгөөр болон уншигчдын хандиваар 139 ширхэг номтой болсон.

2020-2022 оны хооронд 318 уншигч клубийн номын сангаар үйлчлүүлж өөрийн хөгжилд тодорхой хэмжээний зэрэг үр дүн гаргасан (Зураг 7).

Зураг 7. Ном уншсанаар гарсан үр дүн



Дүгнэлт

Сургуулийнхаа үнэт капитал болсон ахмад багш нарын арга туршлагыг сургууль дээрээ туршин хэрэгжүүлсэн нь, үр дүнгээ өгсөн, цаашид эх хэлний төдийгүй сурагчдын хандлага төлөвшилд ч ач холбогдолтой, үр дүнгээ үзүүлсээр байх олон ажлын эхлэл болсон. Ахмадын сургаал алт, Хүн хэлэхээс нааш, цаас чичихээс нааш гэдэг. Хэрэв бидний унших үйл багассан алдааг ахмад багш хараагүй бол, зааж зөвлөөгүй бол... энэ олон үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж үр дүнд хүрэхгүй л байсан болов уу гэж дүгнэж байна. Ахмад багш Ц.Цэвэлмаагийн зөвлөснөөр “УОЧС”-ны арга аргачлалыг дунд ахлах ангийн түвшинд тохируулан боловсруулж хэрэгжүүлсэн нь сурагчдын уншаад ойлгох чадварыг бодитой тогтооход үр дүнтэй байсан ба судалгааны үр дүнд тулгуурлан унших үйлийг дэмжсэн олон талт үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлсэн нь сурагчдад гарч буй зэрэг өөрчлөлтүүдээс болон судалгааны дүгнэлтүүдээс тодорхой харагдаж байна.

“Уншаад ойлгох чадварын судалгаа”-ны аргачлалыг боловсруулах явцад ахлах ангийн хувьд агуулгын хүрээ нэмэгдэж буй учраас шалгуурыг нарийвчлалтай гаргахад хүндрэлтэй байсан ба хичээл сургалтын үр дүнг үнэлэх шалгуурын гүйцэтгэлийг

түвшинг баримжаалан 1-4 оноогоор дүгнэхээр оруулж өгсөн. Мөн шалгуур аргачлалыг дунд ахлах гэж ангилах биш анги тус бүрээр сурагчдын түвшинд тохируулан гаргаж өгснөөр илүү бодитой үнэлэгдэхэд түлхэц болсон гэж бодож байна. Бид энэхүү судалгааны ажилдаа: “Уншаад ойлгох чадварын түвшнийг тодорхойлох” (УОЧС) судалгааны аргаар сурагчдаа оношлон, судалгаанд тулгуурлан сурагчдын унших үйлийг идэвхжүүлэх ажлуудыг туршин хэрэгжүүлж үр дүн хүрнэ хэмээн судалгааны ажлын таамаглалыг дэвшүүлсэн байсан бөгөөд судалгааны ажлын төгсгөлд дүгнэж үзэхэд ахмад багш Ц.Цэвэлмаагийн зөвлөснөөр “УОЧС”-ны арга аргачлалыг сайжруулан хэрэгжүүлж, судалгаанд үндэслэн бусад ахмад багш нарын ном уншуулах, унших үйлд хөтлөн чиглүүлдэг арга туршлагаудыг туршсан хэрэгжүүлж нь үр дүнд хүрснээр таамаглал батлагдаж байна

Харин ахмад багш нарын зөвлөгөө, арга туршлагаас ухаалаг утаснаас хол байлга, огт хэрэглүүлэхгүйгээр цаасан ном уншуул хэмээн зөвлөсөн нь дижитал төрмөл үе гэж нэрлэгдэж буй альфа, Z үеийн хүүхдүүдэд боломжгүй болох нь судалгааны ажлын явцад батлагдсан. Тиймээс бид сурагчдаар цахим ном уншуулах, аудио ном сонсгох, интерактив ажлын хуудас ажиллуулах, подкаст сонсгох зэргээр ухаалаг утсыг хэрэгцээтэй, зөв зүйлд ашиглуулахыг зорилоо.

Мөн энэхүү судалгаанд хамрагдсан сурагчдын ном унших үйлийг олон талт үйл ажиллагаагаар идэвхжүүлэн чиглүүлснээр *ном уншсан сурагч бүр бие даах чадвар нэмэгдэж, сурах үйлийг өөрөө үйлдэн, өөрөө өөрийгөө сурах үйлдээ хөтөлдөг, эергээр нөлөөлөгч, манлайлагч, идэвхтэй оролцогч болж өөрчлөгдөж* байгаа нь энэхүү судалгааны ажлын ололттой тал гэж дүгнэж байна.

Дэвшүүлж буй санаа

Сургуулийн түвшинд:

- Багш өөрөө тасралтгүй судалж, суралцах хэрэгцээ шаардлагатай тулгарч байдаг мэргэжил учраас шинэ залуу үеийн багш нар маань өөрөөсөө илүү хөгжсөн болон ахмад, дунд үеийн багш нараасаа зөвлөмж зөвлөгөө авч өөрийн арга барилд нийцүүлэн заах арга зүйгээ хөгжүүлж тасралтгүй суралцаж байх нь нэн чухал байна.
- МХУЗ-ын багш бүр уншигч байж сурагчдаа ном унших үйлд уриалан хөтлөх
- “Хүүхдээс хүүхдэд” аргачлалаар ном сурталчилгаа хийлгэх
- Сурагчдыг унших номтой болгох үйл ажиллагааг АУБ нар эцэг эхтэйгээ хамтран зохион байгуулах (Ном монита, номын бэлэг, төсөл хөтөлбөрүүд ...).

Улсын түвшинд:

- Ахмад багш нар оролцсон хэлэлцүүлэг, уулзалтуудыг зохион байгуулах.
- Бага ангийн сурагчдыг бичиг үсгийн тайлагдалтын FLAT судалгааны аргаар судлан, дунд ахлах ангид ороход нь тасралтгүйгээр үргэлжлүүлж УОЧ-ын судалгааны аргачлалыг сайжруулан боловсруулж сурагчдаа судлах, судалгаанд тулгуурлан унших үйлийг дэмжсэн үйл ажиллагааг зохион байгуулах
- “Өглөөний гайхамшиг” сорилтыг үндэсний хэмжээнд дэмжин сум сургуульдаа зохион байгуулах уриалгыг гаргах

- Сургуулийн номын санг сурагчдын нас сэтгэхүйд тохирсон сүүлийн үеийн эрэлттэй байгаа ном зохиолуудаар тогтмол баяжуулж байх, стандартад нийцсэн номын сангийн орчныг бүрдүүлэхэд анхаарах
- Хүүхдийг гэр бүлийн орчинд нь унших үйлийг дэмжсэн үйл ажиллагааг бодлогоор дэмжих, уриалах, (сэтгэл зүйн болон, материаллаг орчныг бүрдүүлэхэд чиглэсэн, Жишээ нь: гэрийн номын сантай болох, унших орчныг бүрдүүлэх, үлгэрлэн дагуулж уншуулах).

Ном зүй

МУЗГ, Алсын хараа 2050)

<https://said.mn/content/10/122579>

<https://legalinfo.mn/mn/detail/9047>

Бага ангийн сурагчдын унших чадварыг хөгжүүлэх үнэлэх зарим арга хэрэгсэл 2018 УБ БСШУСЯ

<https://www.mass.mn/n/26871>

<https://www.japan-center.mn/a/23076>

Х.Хатанбаатар “Уншихуйн гайхамшиг” УБ 2009

Мортимэр Адлер “Ном хэрхэн унших вэ?” 1940 он

Зохиолч Бүжинлхамын “Цойлогсод” ном

Зохиолч Хэл Элролд “Өглөөний гайхамшиг, Өглөөний гайхамшиг оюутан” ном

“Ахмадын уламжлал” арга зүйн ном. Ах, 1975

“Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл” –ийн тайлан

2016-2021 оны сургуулийн болон хэл бичгийн шалгалтын дүн мэдээ.

О.Мягмар “Судлаач багшийн гарын авлага” УБ, 2011

Google.mn

www.teacher.sur.mn

Medle.mn

Танхим болон цахим хосолсон сургалтын арга зарчим Ж.Төгсөө, Ж.Оюун-Эрдэнэ, С.Сайнзаяа

СУРАГЧДЫН СУРЛАГЫН ХОЦРОГДЛЫГ АХМАД БАГШИЙН ТУРШЛАГА, АРГА ЗҮЙГЭЭР НӨХӨХ БОЛОМЖИЙГ СУДАЛСАН НЬ (НИЙГЭМ СУДЛАЛ ХИЧЭЭЛИЙН ЖИШЭЭН ДЭЭР)

(III байр)

Алтангэрэлийн ХҮСЛЭН¹, Бат-Оршихын ХАНДАРМАА²,

Нийслэлийн Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын

“Улаанбаатар” сургууль

a.khuslen0119@gmail.com¹, batorshihhandarmaa99@gmail.com²

Хураангуй

Сурагчдын сурлагын хоцрогдлыг ахмад багшийн туршлага, арга зүйгээр нөхөх боломжийг нийгэм судлалын хичээлийн жишээн дээр судаллаа. Ахмад ба залуу багш нарын дунд судалгааг явуулж сурлагын хоцрогдлыг арилгахад ашиглаж буй 27 сургалтын арга зүйг илрүүлж, нээлттэй асуулгын арга болон онолын судалгааг хийх замаар сурлагын хоцрогдолд ашиглах ахмад багшийн онцлох нэг арга зүйг туршин гүйцэтгэлээ. Туршилт судалгааг гүйцэтгэхдээ тухайн арга зүй нь: Сурагчид өөрсдөө судалгаа эрэл хайгуул хийх боломжтой байдал, дүгнэлт бичих боломжтой байдал, бусад сургалтын арга зүйтэй хослуулан хэрэглэх боломжтой байдал зэргийг шалгуур болгон “Корнеллийн тэмдэглэл хөтлөх арга зүй”-г 10 дугаар ангийн нийгэм судлалын сонгон суралцах ангийн сурагчдыг хамруулсан болно. Сурагчдын хийсэн Корнеллийн тэмдэглэлд контент анализ хийж, 1. Түлхүүр үг бичсэн байдал, 2. Тулгуур асуулт боловсруулсан байдал, 3. Мэдээлэлд эрэл хайгуул хийсэн байдал, 4. Мэдээлэл боловсруулсан байдал, 5. Дүгнэлт хийсэн байдал” зэрэг таван шалгуурт үнэлгээ (тус бүр 0-5 оноо) өгөх замаар сурагчдын өмнөх ба дараах үр дүнг харьцуулахад сурагчдын үнэлгээ 0.4-0.6 онооны ахицтай гаржээ.

Түлхүүр үг: сурлагын хоцрогдол; багшийн арга зүй; Корнеллийн тэмдэглэлийн арга зүй.

Оршил

НҮБ-ын Хүүхдийн сангаас “Монгол дахь теле хичээлийн чанар, хүртээмжийг хэмжих судалгаа”-г гүйцэтгэжээ. Тус судалгааны үр дүнд Монгол Улсын хэмжээнд цэцэрлэг болон сургуулийн насны 903 мянган хүүхэд шинэ коронавирусээс шалтгаалж хөл хорионд орж теле хичээлд хамрагдсан. Сурагчдын 16% нь теле хичээлийг хангалттай хэмжээнд үзэх боломжгүй байжээ. Хүртээмжтэй байдлын хувьд авч үзвэл судалгаанд хамрагдсан сурагчдын 16 орчим хувь нь теле хичээлийг хангалттай хэмжээнд үзэж судлах боломжгүй байсан байна. Үүнээс үүдэн 174 мянган хүүхэд хичээлийн

хоцрогдолд орсон гэсэн судалгаа байна.⁸ Тиймээс сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөхөд дэмжлэг үзүүлэх үр дүнтэй аргыг олон жил мэргэжлээрээ үр бүтээлтэй ажилласан туршлагатай багш нараас судалж, залуу багш нарт түгээн дэлгэрүүлэх боломжийг турших явдал хэмээн үзлээ.

Судалгааны зорилго

Сурлагын хоцрогдлыг нөхөхөд мэргэжлээрээ олон жил ажилласан багшийн туршлагаас судалж, сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөхөд үр дүнтэй арга, арга зүйг илрүүлж, шинэ залуу багш нарт түгээн дэлгэрүүлэх боломжийг судалж, турших зорилготой.

Судалгааны зорилт

- Цар тахлын үеийн хөл хорионоос үүдэлтэй сурлагын хоцрогдлыг нөхөхөд залуу багш нарт тулгамдаж буй асуудлыг тодорхойлох
- Сурлагын хоцрогдолтой сурагчидтай ажиллах ахмад багш нарын арга, арга зүйг судлах, сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөхөд үр дүнтэй арга, арга зүйг илрүүлж тодорхойлох
- Шинэ залуу багш нарт түгээн дэлгэрүүлэх боломжтой байгаа байдлыг туршилтаар тодорхойлох

Онолын хэсэг

Сурагчдын хоцрогдлыг хүмүүжлийн болон сурлагын гэж ангилдаг байна. *Хүүхдийн хүмүүжил*: Хүүхдийн хүмүүжил гэдэг нь хүний эрхэм нандин чанаруудыг төлөвшүүлэх, хүмүүстэй зөв харилцах, зан төрөхөд үзүүлэх нөлөө бөгөөд түүний үр дүн юм. Үүнээс бид сурлагын хоцрогдлын талаар гүнзгийрүүлэн судлан илтгэлээ бичихийг зорилоо. Эх сурвалж судалгааны ном бүтээлүүдийг судалж үзэхэд сурагчдын сурлагын хоцрогдлыг судлаачид олон янзаар тайлбарласан байна.

Хүүхэд сурлагаар хоцорч цаашид амжилтгүй сурахад дараах хүчин зүйлүүд нөлөөлдөг. Үүнд:

- Хүүхдийн эрүүл мэнд, оюун ухааны хөгжлийн онцлог, сурах чадамж гэх зэрэг хүүхэдтэй өөртэй нь холбоотой хэсэг шалтгаан.
- Сурагч сурлагаар хоцрох нь сургууль багшийн сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаа, сургалтын агуулга гэх зэргээс их шалтгаалдаг.
- Улс орны нийгэм, эдийн засгийн байдал, гэр бүлийн орчны нөхцөл, эцэг эхийн харьцаа, хайр халамж зэрэг нийгэм зүйн шалтгаанууд хүүхдэд сурлагаар хоцрох шалтаг болдог (Эрдэнэцэцэг, С. 2010).

⁸Бүх Нийт Боловсролын Төлөө! (2020) “Ковид 19-ийн шалтгаант хөл хорионы үеийн багшлахуй, суралцахуй”. 25-27 дахь тал.

Судалгааны үр дүн

Хамрах хүрээ: Хоцрогдлыг нөхөхөд түүх нийгэм, судлалын 75 залуу багш нарт тулгамдаж буй асуудлыг нээлттэй асуулгын аргаар судалж гүйцэтгэн, ахмад багш нарын арга зүйг судлах судалгааг түүх нийгэм судлалын мэргэжлээрээ 15 ба түүнээс дээш жил ажилласан багш нарын дунд явуулав. Туршилт судалгааг Улаанбаатар сургуулийн нийгэм судлал хичээлийн 10 дугаар ангийн сонгон судлах ангийн сурагчдын хүрээнд гүйцэтгэв.

Залуу багш нарын дунд явуулсан асуулга судалгааны үр дүн

Сурагчдын хичээлийн хоцрогдлыг нөхөхийн тулд залуу багш нарын ашиглаж буй арга, арга зүй, тулгамдаж буй хүндрэл бэрхшээл зэргийг судлах зорилгоор нээлттэй асуулгын аргаар судалгааг явуулж, чанарын шинжилгээг хийж гүйцэтгэв.

Асуулт 1. *Цар тахлын үеийн хичээлийн хоцрогдлыг нөхөхөд танд тулгамдаж буй хүндрэл бэрхшээлүүдийг тоочин бичнэ үү.*

Тус асуултад хариулсан оролцогчдын хариултын утгыг ойролцоо утгаар нь нэгтгэж утгын нэгжүүдийг боловсруулан тоон давтамжийг тодорхойлов.

Хүснэгт 1. Цар тахлын үеийн хичээлийн хоцрогдлыг нөхөхөд залуу багш нарт тулгамдаж буй хүндрэл бэрхшээлүүд

Утгын нэгж	Утгын нэгжийн код	Тоон давтамж
Ном сурах бичгийн хүрэлцээ муу	У.Н-1	8 (Min)
Анги танхимын хүрэлцээ-материаллаг орчны бааз муу	У.Н-2	10
Танхимаар орж буй цаг хангалтгүй байна	У.Н-3	9
Сурлагын хоцрогдолтой сурагчидтай ажиллах хичээлийн арга зүйн сан хангалтгүй байна	У.Н-4	16 (Max)
Асран хамгаалагч, эцэг эхчүүдийн оролцоо дэмжлэг сул байна	У.Н-5	11
Сурагчдын хичээлийн идэвх оролцоо сул байна	У.Н-6	15
Гар утас, интернэтгүй сурагчид их байгаа тул тэдгээр сурагчдын хоцрогдлыг цахимаар ажиллаж арилгахад хүндрэл тулгарч байна	У.Н-7	14
Багш нарын бичиг хэргийн ажил их байна	У.Н-8	12
Сурлагын хоцрогдолтой сурагчидтай ажиллах туршлага дутагдаж байна	У.Н-9	15
Сурагчид цахим сургалтанд хамрагдахдаа идэвх муутай оролцож байна	У.Н-10	8 (Min)
НИЙТ	10	118 (давтагдсан тоогоор)

Үр дүнгийн тайлбар: Судалгаанд хамрагдсан 75 залуу багш нар хичээлийн хоцрогдлыг нөхөхөд тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлохдоо хоорондоо ялгаатай утга бүхий 10 төрлийн хариултуудыг өгчээ. Судалгаанд оролцогч нэг багш тооны хязгааргүй олон хариулт өгөх боломжтой ба давтагдсан тоогоор 118 хариулт илгээжээ. Үүнээс хамгийн их давтагдсан утгын нэгж нь: У.Н-4. У.Н-6. У.Н-9 байна.

Асуулт 2. *Сурагчдын хоцрогдол арилгах сургалтад ямар ямар төрлийн арга зүй ашиглаж байна вэ?* гэсэн асуултад дараах байдлаар хариулсан байна.

Хүснэгт 2. Залуу багш нар сурагчдын сурлагын хоцрогдол арилгах сургалтад ашиглаж буй аргуудын ангилал

Утгын нэгж	Утгын нэгжийн код	Тоон давтамж
Идэвхтэй уншлагын арга зүй	У.Н-1	19
Мэтгэлцээнт хичээлийн арга зүй	У.Н-2	18
KWL арга зүй	У.Н-3	16
Түргэн бичвэрийн арга зүй	У.Н-4	6 (MIN)
Эвлүүлгийн арга зүй	У.Н-5	22
Оюуны зураглалын арга зүй	У.Н-6	21
Багийн гишүүдийг үүрэгт хуваарилан хичээл орох	У.Н-7	29
Хамтын уншлагын арга зүй	У.Н-8	20
Уламжлалт аргаар лекцэлж орох	У.Н-9	30 (MAX)
Илтгэл тавих	У.Н-10	22
Дүрд хувирах арга зүй	У.Н-11	24
НИЙТ	11	227 (давтагдсан тоогоор)

Үр дүнгийн тайлбар: Сурагчдын хоцрогдол арилгах сургалтандаа ямар ямар төрлийн арга зүйнүүдийг ашиглаж байна вэ? Гэсэн асуултад залуу багш нар хоорондоо ялгаа бүхий 11 төрлийн арга зүйнүүд нэрлэжээ.

Хамгийн их давтагдсан утга нь У.Н-9 буюу “Уламжлалт аргаар лекцэлж орох” гэсэн хариултыг хамгийн их ирүүлжээ. Түүнчлэн судалгаанд хамрагдсан 75 залуу багш нар давтагдсан тоогоор 227 удаа 11 төрлийн арга зүйг нэрлэж байгаа нь залуу багш нарын хичээлийн олон төрлийн арга зүйг ашиглах мэдлэг-ур чадвар “Хангалттай бус” байна хэмээн дүгнэж болохоор байна.

Ахмад багш нарын дунд явуулсан асуулга судалгааны үр дүн

Ахмад багш нараас хичээлийн хоцрогдлыг нөхөхөд ашиглаж буй сургалтын арга зүйнүүд, тэдгээрийн тухай нарийвчлан судалж үзэх нь зүйтэй гэж үзсэн. Иймд мэргэжлээрээ 15 ба түүнээс дээш жил ажилласан багш нарын дунд нээлттэй асуулгын аргаар судалгаа явуулж, чанарын шинжилгээг хийж гүйцэтгэв.

Асуулт 1. Сурагчдын хоцрогдол арилгах сургалтад ямар ямар төрлийн арга зүй ашиглаж байна вэ?

Хүснэгт 3. Ахмад багш нар сурагчдын сурлагын хоцрогдлыг арилгах сургалтад ашиглаж буй аргууд

Утгын нэгж	Утгын нэгжийн код	Тоон давтамж
Бүтэцчилсэн танилцуулгын арга	У.Н-1	2
Чөлөөт бичвэрийн арга зүй	У.Н-2	13
Идэвхтэй уншлагын арга зүй	У.Н-3	18
Хэлэлцүүлгийн тор	У.Н-4	1
Хамтын уншлага-Хамтын ярилцлага	У.Н-5	8
Мэтгэлцээнт хичээлийн арга зүй	У.Н-6	24
Үнэт зүйлийн тэнхлэгийн арга	У.Н-7	1
Юу гэж, Тэгээд юу гэж, одоо юу гэж? Арга зүй	У.Н-8	6
KWL арга зүй	У.Н-9	16
Бодол санааны өрнөлт арга зүй	У.Н-10	3

Түргэн бичвэрийн арга зүй	У.Н-11	7
Эвлүүлгийн арга зүй	У.Н-12	11
Асуултын самбар гүйцэтгэх арга зүй	У.Н-13	5
Асуулт хариултын карт	У.Н-14	4
Оюуны зураглалын арга зүй	У.Н-15	20
Хамтын хайгуул арга	У.Н-16	1
Корнеллийн тэмдэглэл хөтлөх арга зүй	У.Н-17	2
Багийн гишүүдийг уурэгт хуваарилан хичээл орох	У.Н-18	15
Чиглүүлэгтэй уншлагын арга зүй	У.Н-19	13
Сурагч-багш болох арга	У.Н-20	10
Хамтын уншлагын арга зүй	У.Н-21	15
Уламжлалт аргаар лекцэлж орох	У.Н-22	4
Текстийг кодолж унших арга зүй	У.Н-23	5
Илтгэл тавих	У.Н-24	15
Үзгээ тавь, үгээ хэл	У.Н-25	3
Дүрд хувирах арга зүй	У.Н-26	20
Санаагаа наймаалцах арга зүй	У.Н-27	1
НИЙТ	27	243 (давтагдсан тоогоор)

Үр дүнгийн тайлбар: Тус асуулгад 75 ахмад багш нар хоорондоо ялгаа бүхий 27 төрлийн арга зүйнүүдийг нэрлэн бичсэн бөгөөд судалгаанд хамрагдсан ахмад багш нар давтагдсан тоогоор 243 удаа 27 төрлийн арга зүйг нэрлэж байгаа нь залуу багш нарын хичээлийн арга зүйн мэдлэг-ур чадвараас харьцангуй өндөр байна хэмээн дүгнэж болохоор байна.

Асуулт 2. Таны сургалтандаа ашиглаж буй арга зүйгээс хамгийн үр дүнтэй аргын тухай тодорхойлон бичнэ үү.

Тус асуулгын хариултуудад шинжилгээ хийж БЗД-ийн “J” (сургуулийн нэрийг кодлов) багшийн “Корнеллийн тэмдэглэл хөтлөх арга зүй”-г сонгон авч туршилт судалгааг хийхэд ашиглах аргаар сонгон авав.

Туршилт хийх арга зүйг сонгохдоо дараах шалгууруудыг үндэслэл болгов.

- Сурагч мэдээлэл цуглуулж, эрэл хайгуул хийх боломжтой байдал
- Сурагч мэдээллийг өөрөө боловсруулах боломжтой байдал
- Сурагч өөрөө дүгнэлт тайлбарыг хийх боломжтой байдал
- Багшийн заавар тусламж аль болох багатайгаар сурагч өөрөө бие даан гүйцэтгэх боломжтой байдал
- Бусад арга зүйтэй хослуулан хэрэглэх боломжтой байдал

Туршилтын судалгааны үр дүнгийн хэсэг (Корнеллийн тэмдэглэлийн арга зүйг туршсан нь)

Улаанбаатар сургуулийн 10-р ангийн “Нийгэм судлал” хичээлийн сонгон суралцах 18 сурагчтай ангид 2021 оны 10 сарын 7-ны өдрөөс эхлэн Корнеллийн тэмдэглэл хөтлөх арга зүйг туршиж эхлэв. Сурагчдын явцын сорилд авч буй оноо дараах байдлаар өссөн байна.

Зураг 1. Корнеллийн тэмдэглэл хөтлөхөөс өмнөх ба дараах шалгалтын анализ




9 сарын 16-аас 10 сарын 7-ны буюу эхний 3 сорил нь Корнеллийн тэмдэглэл хөтөлж эхлэхээс өмнөх сорилын дүн. Тус 3 сорилын дундаж 59.7 буюу IV түвшинд байна. Харин 10 сарын 21-ээс хойш буюу корнеллийн тэмдэглэл хөтөлж эхэлснээс хойш авсан сурагчдын сурлагын амжилт тасралтгүй өссөн шинжтэй үр дүн гарсан бөгөөд

шалгалтын дундаж оноо 70.1 буюу VI түвшинд хүрсэн ахиц гаргажээ.

Сурагчдын корнеллийн тэмдэглэлд контент анализ хийж үр дүнг боловсруулсан нь

Улаанбаатар дунд сургуулийн сонгон судлах нийгэм судлалын 10 дугаар ангийн сурагчдын гүйцэтгэсэн эхний 3, сүүлийн 3 Корнеллийн тэмдэглэлүүдэд тус тус контент анализ хийж, тоон үнэлгээгээр харьцуулалт гаргав. Сурагчдын нэрсийг С-1, С-2...С18 хүртэл кодлов. Ингэхдээ сурагчдын дараах 5 ур чадварт 1-5 оноог өгч үр дүнг тооцон гаргасан.

Зураг 2. “Корнеллийн тэмдэглэл”-д хийсэн контент анализын үр дүн



Дээрх үр дүнгээс үзэхэд Корнеллийн тэмдэглэл хөтөлснөөр сурагчдын дээрх 5 ур чадварт ахиц гарсан бөгөөд хамгийн өндөр ахиц гарсан ур чадварыг тоон утгад үндэслэн тодорхойлбол “Мэдээлэл цуглуулах ур чадвар” байна.

Дүгнэлт

Багш нарын арга зүйг “Сурагч мэдээлэл цуглуулж, эрэл хайгуул хийх, сурагч өөрөө дүгнэлт тайлбар хийх, багшийн заавар тусламж багатайгаар сурагч өөрөө бие даан гүйцэтгэх боломж, бусад арга зүйтэй хослуулан хэрэглэх боломж” зэрэг шалгууруудыг үндэслэн “Корнеллийн тэмдэглэл хөтлөх арга зүй”-г сонгон авч туршилт судалгааг явуулсан. Туршилт судалгаагаар Корнеллийн тэмдэглэл хөтлөх арга зүйг ашиглаж эхэлснээс хойш сурагчдын явцын сорилын дүн сайжирч байгаа нь (IV-VI түвшин рүү) тодорхойлогдсон.

Түүнчлэн контент анализын үр дүнгээс үзэхэд сурагчдын “мэдээлэл цуглуулах ур чадвар”, “мэдээлэл боловсруулах ур чадвар”, “түлхүүр үгсийг тодорхойлох чадвар”, “тулгуур асуулт томъёолох ур чадвар”, “дүгнэлт бичих чадвар”-уудад Корнеллийн тэмдэглэл бичих арга зүй нь сайн нөлөө үзүүлж байна гэсэн дүгнэлтэд хүрлээ.

Ном зүй

- Нэргүй,С. (1985). Сурлагаар хоцрогсодтой ажиллах тухай. Улаанбаатар.
- Цэвэлмаа,Г. (1999). Сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх арга зам. Улаанбаатар.
- Эрдэнэцэцэг,С. (2010). Багш боловсролын үндэс. Улаанбаатар.
- Бүх Нийт Боловсролын Төлөө! ИНУЭ (2020) “Ковид 19-ийн шалтгаант хөл хорионы үеийн багшлахуй суралцахуй” . Улаанбаатар.
- Бямбасүрэн,М. (2015). Сургалтын төвийн үйл ажиллагаагаар суралцагсдын сурлагын хоцрогдлыг арилгах менежментийн асуудал. Улаанбаатар.
- МУБИС, БСС Судалгааны арга зүйн профессорын баг (2017). *Судалгааны арга зүй*. Улаанбаатар: Соёмбо принтинг.
- Энхтүвшин,С., Байгалмаа,Ч., Төртогтох,Б. (2015). Багшлахуйн үндэс. Улаанбаатар: МУБИС-хэвлэлийн цех
- Даваа,Ж. (2018). Сургалтын технологи. Улаанбаатар.
- (2021). МУ-ын Боловсрол Шинжлэх Ухааны сайдын тушаал “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын хоцрогдол арилгах гурван жилийн цогц төлөвлөгөө 2021-2023”. Улаанбаатар.
- Collis, B. A. (1998). New wine and old bottles? Tele-learning, telematics, and the University of Twente. In M. F. Verdejo & G. Davies (Eds.), *The virtual campus: trends for higher education and training* (pp. 3–17). London: Chapman and Hall.
- Salmon, G. (2004). *E-moderating: The key to teaching and learning online*. London: Taylor and Francis.
- Ertl, B., Reiserer, M., & Mandl, H. (2005). Fostering collaborative learning in videoconferencing: the influence of content schemes and collaboration scripts on collaboration outcomes and individual learning outcomes. *Education, Communication and Information*,
https://www.academia.edu/2285193/Tele_learning_and_Distance_Learning_re_engineering_process
<http://bagsh.itpd.mn/fayluud/hicheel%20tolovloft.pdf>
<https://community.articulate.com/articles/what-is-e-learning>
<https://economictimes.indiatimes.com/definition/e-learning>
<https://lavai.msue.edu.mn/index.php?role=no>
(https://en.wikipedia.org/wiki/Intellectual_disability, 2021)
https://ikon.mn/n/25pl?fbclid=IwAR0npgHTXsvFQmXP_7Y1Dm5IZUK-h_PBWOHcNF64UFXSL5k02qUvOEITWc

ХИЧЭЭЛ ЗОХИОН БАЙГУУЛАХДАА АХМАД БАГШ НАРЫН ТУРШЛАГААС СУРАЛЦАЖ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮР ДҮН

(III байр)

Ц.Нармандах¹, Ө.Отгонсайхан², Г.Түвшинжаргал³

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн ерөнхий боловсролын “Шинэ Үе” сургууль

narmandakh@shineue.edu.mn¹, otgonsaikhan.u@shineue.edu.mn²,

tuvshinjargal@shineue.edu.mn³

Хураангуй

Геометр айн агуулгаар эзэмших чадварыг сайжруулахын тулд ЭЕШ болон математикийн хичээлийг олон жил үр дүнтэй зохион байгуулсан ахмад багш нарын хичээлийг ажиглан, туршлагаас нь суралцаж, заах арга зүй, мэдлэг, чадвараа нэмэгдүүлэхийн тулд өөрийн арга зүйтэй хослуулан туршиж байна. Энэ нь суралцагчдын геометрийн хичээлээр эзэмших чадварыг нэмэгдүүлэхээс гадна хөтөлбөрийн агуулгын залгамж холбоог хөгжүүлэхэд түлхэц болж байна.

Ингэж ахмад багш нарын туршлагаас суралцан, хамтран ажилласнаар сургалтын бүхий л арга болон сургалтын явцад багшийн заах арга зүй, үр чадварт 25%, сурагчдын төсөөлөх, хийсвэрлэн сэтгэх, зурах, дүрслэх чадварт 29.4%-ийн ахиц гарч, сургалтын үйл ажиллагаанд бодит үр дүн үзүүлээ. Энэхүү зорилгын хүрээнд хийсэн ажил маань багш бидний хувьд цаг үеийн нөхцөл байдалтай уялдсан, суралцагчдын хамтын хөгжилд ихээхэн түлхэц боллоо.

Түлхүүр үг: геометр ай; арга зүй; сургалтыг дэмжих программ.

Оршил

Судалгааны үндэслэл

1960-аад оны үед Геометрийн айг нэг судлагдахуун болгож оруулж долоо хоногт 2-3 цагийн хичээлийг ордог байсан. 2003 онд Боловсролын тухай багц хуулинд өөрчлөлт оруулаад “Цогц чадамжид суурилсан боловсрол”-д Геометрийн бие даасан судлагдахууныг, Математикийн судлагдахууны зөвхөн нэг ай болгон сурах бичигт оруулсан. 2009-2010 оноос Геометрийн айг математикийн бүх айд шингээж, задалж оруулдаг болсон.

Судалгааны шинэлэг тал

Геометрийн айн агуулгыг Математикийн агуулгын айгаас салгаж тусд нь авч үзэж байгаа нь шинэлэг тал болно. Арга зүйгээ сайжруулах нь геометрийн хичээлд сурагчдыг татан оролцуулах, ээлжит хичээлийг үр дүнтэй болгосон.

Судалгааны зорилго

Геометрийн айн агуулгын сургалтын чанар үр дүнг сайжруулахын тулд ахмад багш нарын туршлагаас суралцах, өөрийн арга зүйг шинэчлэн, сурагчдын сонирхол, хандлагыг нэмэгдүүлэх, чанарын ахиц гаргах

Судалгааны зорилт

- Геометрийн айн шалгалтын үр дүнд анализ хийх (ЭЕШ-ын үр дүн)
- Геометрийн айн үр дүнтэй зохион байгуулдаг ахмад болон туршлагатай багш нарын хичээлийг ажиглах, туршлагыг судлах, сонголт хийх
- Сонгосон туршлагуудаа туршин нэвтрүүлж өөрийн арга зүйтэй хослуулах, шинэ арга зүй боловсруулах, турших, (хичээл зохион байгуулах, орчин үеийн арга хэрэглэгдэхүүнүүдийг ашигласан арга зүй боловсруулах)
- Туршилт судалгаанд оролцогчдын ахицын үр дүнг тооцох, дүгнэлт гаргах

Онолын хэсэг

Багшийн тодорхойлолт

- Ахмад багш нь өргөн хүрээтэй ойлголт бөгөөд энэхүү ангилалд багш нарыг ажилласан жил болоод, дадлага туршлага зэргээс нь хамааруулан ойлгоно.
- Туршлагатай багш - олон жил ажиллаж мэдлэг чадвартай болсон багш⁹-ийг хэлнэ.
- Суралцагч - сургалтын тодорхой орчин нөхцөлд сургалтыг зохион байгуулагч, удирдагч, багш нарын оролцоо, өөрийн зүтгэлийн үр дүнд хувийн туршлага хуримтлуулж буй хүнийг суралцагч гэнэ.

Тиймээс бид ахмад болон залуу багш нарын харилцаа, хамтран ажиллах боломжийг бий болгох үүднээс ахмад багш нарын туршлагыг судлан өөрийн сургуульдаа хэрэгжүүлэх, үнэ цэнтэй туршлагыг ээлжит хичээлдээ буулгаж, туршин хэрэгжүүллээ.

Хичээлийг хөгжүүлэх шаардлага

- Сурагчдад сурч мэдэх үйл ажиллагаанд хандах эерэг хандлага, сэдэл тэмүүлэл төлөвшүүлэх
- Сурагчдын идэвхийг өрнүүлж, хөгжүүлэх, арга барилуудыг эзэмшүүлэх
- Сурагчдын сэтгэл зүйн онцлог, хөгжлийн түвшинд тохируулж тэдний оюун ухааныг хөгжүүлэх
- Нийгмийн хөгжил сурагчдын оюун ухаан, сэтгэл зүйд гарч байгаа өөрчлөлтийг харж мэдрэн, багш сургалтын аргадаа өөрчлөлт шинэчлэл хийж байх

Хичээлд анализ хийх зорилго:

- Багшийн ажилд үнэлэлт, дүгнэлт хийх, багш нарын заах аргыг боловсронгуй болгох
- Багш нарын сурган хүмүүжүүлэх туршлагыг судалж, нэгтгэх, нийтийн хүртээл болгох
- Багш нарын алдаа дутагдлыг засаж залруулах, мэргэжил дээшлүүлэх

⁹ https://mongoltoli.mn/search.php?opt=1&ug_id=89998

- Шинэ залуу багш нарыг хичээл зохион байгуулах аргад сургах¹⁰

Иймээс хичээл сургалтын үйл ажиллагаа нь хүүхдийн эрэлт хэрэгцээг хангасан байх ёстой.

Ахмад багш нарын туршлагаас

Олон жил ажилласан ахмад, туршлагатай багш нарынхаа зөвлөмжөөс хүргэхэд:

- МУ-ын Ардын багш, математикийн багш Ү.Маамын туршлага (МУ-ын Ардын багш, зөвлөх багш, Боловсролын байгууллагад тасралтгүй 60 гаруй жил ажилласан).

“Багш хичээлээ сайн зохион байгуулдаг байх хэрэгтэй” хэмээн үзэж хичээлд сууж ажиглалт хийдэг, зөвлөн тусалдаг, хамтран ажилладаг.

- МУ-ын зөвлөх, математикийн багш Н.Дайвий-Одын туршлага (Монголын математикийн олимпиадын 4 удаагийн аварга, Боловсролын байгууллагад 30 гаруй жил ажилласан).

Мэргэжлийн үг хэллэгийг хичээл сургалтдаа оновчтой ашиглах, тэмдэг тэмдэглэгээг сурагчдад эзэмшүүлэх, онол, арга зүйн ном сурах бичгийг ашиглах чадвартай болох.

- МУ-ын зөвлөх, математикийн багш Б.Ганболдын туршлага


Геометрийн агуулгыг маш сайн бэлтгэх, хүүхэд нэг бүрийг оношлох, түвшин түвшинд нь тохирсон бодлого, дасгалыг боловсруулах нь маш чухал.

- МУ-ын гавьяат багш, МУ-ын зөвлөх, математикийн багш З.Бат-Эрдэнийн туршлага
- Сурагчдыг үнэлэх арга туршлага.

Судалгааны хэсэг

Багшид гарсан үр дүнгийн судалгаа:

- МУ-ын Ардын багш Ү.Маамын багшлах эв дүй, ур чадварыг суулгах




Үр дүн:

Сул тал	Сайжруулалт	Үр дүн
Хичээл төлөвлөлт, цаг ашиглалт	Хичээлийн төлөвлөлтийг оновчтой зөв зохион байгуулж, цагийг менежментийг тохируулж сурсан	Ур чадварын уралдаанд тогтмол ахицтай, амжилттай оролцож ирсэн.
Даалгаврын өгөгдөл	Даалгавар гүйцэтгэх хугацааг тохируулж сурсан	
Арга зүй	Даалгаврын өгөгдлийг сурагчдын мэдлэгийн түвшинд боловсруулж сурсан	
	Технологийн дэвшилтэй уялдуулан арга зүйгээ төлөвлөж сурсан.	

¹⁰ http://unjiitechnology.blogspot.com/2016/03/blog-post_72.html


- Н.Дайвий-Од багшийн мэргэжлийн үг хэллэг, онолын мэдлэгийг дээшлүүлэх



Үр дүн:


Сул тал	Сайжруулалт	Үр дүн
Онолын мэдлэг	Багштай болон тэнхимийн хамт олонтой хамтран тогтмол бодлого бодож өөрийгөө хөгжүүлсэн Хичээл сургалтад ашиглагдах онолыг бие даан судалж зөвлөгөө авсан Сурах бичгийн агуулгын задаргааг анги бүрээр гаргасан.	Мэргэжлийн олимпиад, уралдаанд шавь нараа бэлтгэн амжилттай оролцуулдаг.
Мэргэжлийн үг хэллэг	Ээлжит хичээлийн агуулгыг мэргэжлийн үг хэллэгээр хэлэх, ярих, тайлбарлан таниулах аргаас суралцсан	

- Б.Ганболд багшийн геометрийн хичээл заах арга зүй болон залуу багш нартай ажиллах



Сул тал	Сайжруулалт	Үр дүн
Хүүхэд нэг бүрийг оношлох	Ангиар нь хэд хэдэн удаагийн давтамжтай шалгалтуудыг авах Түвшингээр нь болон ганцаарчилсан хувилбараар билет, тест бэлтгэж сурсан.	Багаар ажиллаж сурсан. Сурагчид геометрийн хичээлд хандах хандлага, сонирхлыг бий болгосноор ахуй амьдралд хэрэглэгдэх өгөгдлүүдийг тооцоолох чадвартай болсон.
Геометрийн хичээлд бэлтгэх	Ээлжит хичээл бэлтгэхдээ сурагчдын геометр сэтгэлгээг дэмжихүйц бодлого дасгалыг үе шаттай, даалгавар нь хөнгөнөөс хүнд рүү чиглүүлсэн байдлаар боловсруулж сурсан.	

- 3.Бат-Эрдэнэ багшийн сурагчдыг үнэлэх



<i>Сул тал</i>	<i>Сайжруулалт</i>	<i>Үр дүн</i>
Үнэлгээний аргачлал дутмаг	Сурагчдыг өөрөө өөрсдөөр нь үнэлүүлдэг Эхний 5-6 сурагчийн даалгаврын гүйцэтгэлийг шалгана Тухайн бодлогыг зөв бодож, авсан оноогоороо байр эзэлдэг. Багц багцаар /5-10 ш/ нь бэлтгэсэн бодлогыг самбарт бичиж бодуулах ба бодолт дууссаны дараа багш самбарт зөв бодолтыг тайлбарлан бичиж, оноо өгөх заавар өгнө. "Байраа солиорой" гэх багшийн командаар их оноотой сурагчид урагшаа, бага оноотой сурагчид хойшоо суудлаа сольж сууна. Хэд хэдэн багц бодлого бодсоны дараа сурагчид авсан онооны дарааллаар урдаас хойш байрлаж суусан байна. Энэхүү үйлдлийн явцад сурагчид ямархуу үнэлгээтэй дүгнэгдэж байгаа болон тухайн сэдвийн ойлгоц хэр байгаа нь багшийн нүдэнд ил тод харагдана.	Сурагчид шударгаар өөрсдийгөө үнэлж сурсан Бусдаас суралцах, сонсох чадвартай болсон Бусдад туслах, зөвлөгөө өгөх чадвартай болсон. Багаар ажиллаж сурсан

Эдгээр туршлагыг өөрийн заах арга зүйтэй хослуулан геометрийн айг орчин үеийн хүүхдүүдийн хэрэгцээ сонирхолд нийцүүлэн, GeoGebra программыг сургалтдаа сонгон авч хослуулан зааснаар багшийн хувьд цагийн менежментийг зөв төлөвлөх, ажилдаа хандах хандлага эрс өөрчлөгдөн, багаар ажиллах аргад түлхүү суралцсан бөгөөд ажлын бүтээмж дээшилсэн.

Заах арга зүй

<i>Хөгжсөн чиглэл</i>	<i>Өөрчлөлт</i>	<i>Хувь</i>
Онолын мэдлэг	Багш, сурагчдын асуултад илүү оновчтой хариулт өгөх боломжтой.	25%
Мэргэжлийн үг хэллэг	Сурагчдад зааж буй мэдлэг ойлголт ойлгомжтой, цэгцтэй болсон.	20%
Geogebra программын сургалтандаа оновчтой ашиглах чадвар	Программыг сурагчдад заахад илүү ойлгомжтой болсон ба заах арга зүй дагаж өөрчлөгдсөн, тест боловсруулж сурсан.	25%
Техник технологийн чадамж	Геометрийн хичээлд GeoGebra программ болон бусад тест боловсруулах программуудыг ашиглаж сурсан.	42%

Сурагчдад гарсан үр дүн

Сурагчдын хувьд гарсан үр дүнг харуулбал: Нийт 9-12-р ангийн 201 хүүхдийг хамруулахад

<i>№</i>	<i>Чадвар</i>	<i>Ээлжит хичээлийн үр дүн</i>	<i>Өмнө</i>		<i>Одоо</i>	
			<i>тоо</i>	<i>хувь</i>	<i>тоо</i>	<i>хувь</i>
1	Харилцаа, хандлагад гарсан өөрчлөлт	Бусдад өөрийгөө илэрхийлэхдээ илүү сайн болж байгаа.	124	61%	160	80%
2		Өгөгдлийг зөвөөр ойлгож чаддаг болсон.	63	31%	172	86%

3	Дадал зуршилд эерэг өөрчлөлт гарсан	Хамтран багаар ажиллаж сурсан.	87	43%	158	79%
4		Нэгэндээ тусалж сурсан.	103	51%	178	89%
5		Бусдаас тусламж хүсч сурсан.	81	40%	147	73%
7		Өөрийгөө бүрэн ойлгож дүгнэлт хийдэг болсон.	110	55%	165	82%
8		Анхаарал төвлөрөл сайжирсан.	94	47%	139	69%
9		Би эмх цэгцтэй болсон.	124	62	173	86%
10	Суралцах чадварт гарсан ахиц	Аливаа зүйлд хүндэтгэлтэй харьцдаг болсон. Хэлсэндээ хүрдэг болсон.	106	53%	189	94%
11		Чөлөөт цагийг зөв өнгөрүүлдэг болсон.	113	56%	167	83%
12		Төсөөлөн бодож, загварчлах чадвар дээшилсэн	43	21%	154	76%
13		Биетүүдийг ялгаж сурсан.	126	63%	194	96%
14		Геометрийн хичээлд дур сонирхолтой болсон.	47	23%	138	69%
15		Хийсвэр зүйлийг бодит болгож харж сурсан.	38	19%	171	85%
16		Огторгуйн геометрийн бодлогуудын зургийг зөв байгуулж сурсан.	51	25%	163	81%


Чадварын ахиц амжилт

9-12-р ангийн сурагчдаас геометрийн хичээлээр түүврээр авсан сорилын дундаж үр дүн

№	Анги	12а анги 20 сурагч			11б анги 17 сурагч			10а анги 18 сурагч			9а,б анги 24 сурагч		
	Чадвар	анх	дараа нь	Өөрчлөлт	анх	дараа нь	Өөрчлөлт	анх	дараа нь	Өөрчлөлт	анх	дараа нь	Өөрчлөлт
1	Төсөөлөх	5	12	7	6	9	3	5	9	4	9	15	6
		25%	60%	35%	35%	53%	18%	28%	50%	22%	37%	62%	25%
2	Дүрслэх, зурах	6	9	3	7	10	3	7	9	2	10	16	6
		33%	45%	12%	41%	59%	18%	39%	50%	11%	41%	67%	26%
3	Тооцоолол хийх	8	12	4	6	9	3	6	10	4	12	16	4
		40%	60%	20%	35%	53%	18%	33%	55%	22%	50%	67%	17%

4	Дүгнэлт гаргах	9	11	2	8	11	3	9	12	3	13	17	4
		45%	55%	10%	47%	64%	17%	50%	67%	17%	54%	71%	17%

SPSS программын судалгаа, үр дүн: Геометрийн агуулгын айн чадваруудыг хөгжүүлэх



явцад гарсан үр дүн давтамж, хандлага, ЭШ-д үзүүлсэн онооны хамаарлыг шинжлэн холбоо хамааралтай эсэхийг тогтоох. Сурагчдаас авсан сорилын оноо болон хариулсан давтамж, хандлагын хамаарал байгаа эсэхийг Корреляцийн матрицаар илэрхийлэв.

	Хүүхдийн тоо	Төсөөлөх	Дүрслэх	Тооцоолол	Дүгнэлт гаргах
Хүүхдийн тоо	1	0.811	0.777	.990*	.959*
Төсөөлөх	0.811	1	.878**	.907**	.799**
Дүрслэх	0.777	.878**	1	.923**	.949**
Тооцоолол	.990*	.907**	.923**	1	.951**
Дүгнэлт гаргах	.959*	.799**	.949**	.951**	1

*. Correlation is significant at the 0.05 level (2-tailed).

**. Correlation is significant at the 0.01 level (2-tailed).

Чадварын дундаж утгыг авч үзэхэд

	дундаж	дан хувь нь	N	1	маш муу
Төсөөлөх	7.50	3.477	12	2	муу
Дүрслэх	7.33	3.869	12	3	дундаж
Тооцоолол	7.83	4.064	12	4	сайн
Дүгнэлт гаргах	8.50	4.681	12	5	маш сайн

Үр дүн: Нэрлэсэн шкалаар харахад энэхүү даалгаврын өгөгдөл нь 3-аас их 5-аас бага байгаа нь сайн гэсэн үзүүлэлтийг харуулж байна. Иймээс энэ даалгаврын дагуу боловсруулсан ээлжит хичээл үр дүнтэй заагдаж, сурагчдад хүрсэн нь харагдаж байна.

“Огторгуйн геометрийн олон талст огтлол” (10-р ангид) нэгж сэдвийн хүрээнд богино хугацаанд сорил авахад гүйцэтгэлийн дундаж хувь нь 78.6%, медиан нь 80%, графикаас харахад муруй нормаль тархалттай байгаа нь тухайн сэдвийн тохирц сайн, сурагчдын мэдлэг ойлголт жигд ахиж байгаа нь харагдаж байна.

Сурагчдад гарсан өөрчлөлтийн харьцуулалтыг харвал.

Туршилтын (9А) болон хяналтын (9Б) ангиудын сорилын үр дүнгийн харьцуулалт:

<i>Чадвар</i>	<i>9а (GG)</i>	<i>9б (үндсэн)</i>
Төсөөлөх	92%	39%
Зурах, дүрслэх	83%	23%
Тооцоолох	87%	69%
Дүгнэлт гаргах	75%	19%

Сурагчдын төсөөлөх, зурах, хийсвэрлэн сэтгэх, дүгнэлт гаргах чадвар нь Geogebra программыг сургалтад ашиглаж заасан 9а ангийн хувьд 9б ангиас илүү ахицтай байгаа нь харагдлаа. Харин геометрийн бодлогын математик тооцоолол нь ижил хийгдэх учраас үр дүн ойролцоо байна.

Дүгнэлт

Багшлахуйд гарсан өөрчлөлт:

- Сурагчдын идэвх оролцоо, хандлага сайжирч, массын сурлагын чанарт 29.4%-ийн,
- Дээрх багш нарын үнэтэй туршлагаудыг өөрийн арга зүйтэй хослуулан ашиглаж, сургалтыг зохион байгуулснаар багшийн заах арга зүй, ур чадварт 25%-ийн,
- Мэргэжил нэгт залуу багш нартаа дээрх арга зүйгээ түгээн дэлгэрүүлснээр геометрийн агуулгын массын чанарт ахиц тус тус гарч байна.

Суралцахуйд гарсан өөрчлөлт:

- Арга зүйг туршсанаар сурагчдын хэрэгцээ, сонирхол, сурах үйлийг дэмжсэн, сурлагын чанарт нь ахиц гарсан үр дүнтэй, шинэлэг арга байлаа.
- Ээлжит хичээлд ашигласан программууд нь сурагчийн бие даан суралцах үйлд дэмжлэг үзүүлэв.
- Сурагчид цахим сангаас сонгон өөрөө бие даан хэрэглэх, ажиллах боломж олгох давуу талтай.

Санал

Сургуулийн түвшинд:

Геометрийн айн заах арга зүйг сайжруулахад анхаарах, туршлагатай, ахмад багш нар болон залуу багшаас бүрдсэн холимог баг бүрдүүлэх

Нийслэл, дүүргийн түвшинд:

- Геометрийн агуулгыг анхааралдаа авч, ээлжит хичээлийг заах арга зүйг сайжруулах, туршлагатай багш нараасаа зөвлөгөө авах

Үндэсний түвшинд:

- Зөвлөх багш, ахмад багш нартай хамтран ажиллах эрх зүйн орчин, арга зүйн зөвлөгөө өгдөг баг бий болгох, улсаас цалинжуулах
- Гүнзгийрүүлсэн сургалттай сургуулиудын хувьд геометрийн айг тусад нь нэг судлагдахуун болгон орж байгаа нь үр дүнтэй учраас тухайн айг бие даасан судлагдахуун болгох.

Илэрч болох үр дүн

Сургуулийн түвшинд:

- Геометрийн айн чанарын ахиц гарч, залуу болон ахмад багш нар онол арга зүй болон шинэ программуудад харилцан суралцана.

Нийслэл, дүүргийн түвшинд:

- Чадварлаг боловсон хүчин бий болох, ур чадвараа нэмэгдүүлэх

Үндэсний түвшинд:

- Тэтгэвэрт гарсан ахмад, туршлагатай багш нараараа зөвлөн туслуулах, туршлагыг нь хойч үедээ авч үлдэх.
- Сурагчдын цаашдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, ахуй амьдралдаа ашиглахад нэн чухал юм

Ном зүй

Адъяасүрэн,В. (2021). Геометр 6-11. Сурах бичиг. Улаанбаатар

Байгальмаа,Ч. (2013). Багшийн мэргэжлийн хөгжил туршилт судалгаа. Улаанбаатар

Батчимэг,П. (2006). Багшийн хөгжилд хувийн зохион байгуулалт нөлөөлөх нь. Улаанбаатар

Жаргал,Г., Сэлэнгэ,Н. (2009). Судалгааны арга зүйд өөрөө сурах бичиг. Улаанбаатар

(2018). Шинэ-Үе сургууль 15 жилийн ойн номноос.

(2019). Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр. 28-р тал

(2016). Элсэлтийн ерөнхий шалгалтын тайлан. 45-65-р тал

(2017). Элсэлтийн ерөнхий шалгалтын тайлан. 35-46-р тал

(2019). Элсэлтийн ерөнхий шалгалтын тайлан. 38-61-р тал

(2019). Математик 9-11. Сурах бичиг. Улаанбаатар

(1983). Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын чадвар, дадлыг хөгжүүлэх асуудалд. Багш нарын гарын авлага. Улаанбаатар

(2009). МХ-ий хураангуй тайлбар толь. 815-р тал. Улаанбаатар

БАГШЛАХУЙН ЗАЛГАМЖ ХОЛБОО

Ахмад багшийн сургалтын арга технологийг өвлөн хөгжсөн бодит жишээн дээр

(III байр)

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ерөнхий боловсролын “Титэм” сургууль

Б.Түвшинсүх¹, Д.Хүрэлбаатар², Г.Төмөрхуяа³, М.Ганболд⁴, Б.Оюунцэрэн⁵

tuwsukhee@gmail.com¹, khurelbaatar7411@gmail.com², tuumkaa8989@gmail.com³,
gsubaru1930@gmail.com⁴, oyuntserenbatsuuri@gmail.com⁵

Хураангуй

Ахмад багш нарын сургалтын арга, технологийг өвлөн авч, туршин хэрэгжүүлсэн нь багшийн мэргэжлийн өсөлтөд ихээхэн нөлөөлсөн. Энэхүү судалгааны ажлын гол аргачлал нь: Монгол хүний сэтгэхүйд тохирсон оюуны зураглалын нэгэн хэлбэр болох “Ухагдахууны сүлжээ”-г “багшаас багшид”, “багшаас шавьд” гэсэн залгамж холбоогоор өөриймшүүлсэн явдал юм. Алтан үеийн эрдэмтэн багш нарын арга туршлагаас өвлөн авч, бахархан хөгжих, бүтээлч оролцоог нэмэгдүүлэх нь нийгмийн хэрэгцээ шаардлага төдийгүй тулгамдсан асуудал болоод байна. Энэхүү асуудлыг сургуулийн бодлого, төлөвлөлт, хамтын ажиллагаагаар хэрхэн шийдвэрлэсэн тухайгаа та бүхэндээ толилуулж байна.

Түлхүүр үг: ахмад багш; багшийн хөгжил; мэргэжлийн өсөлт; оролцоо; ухагдахууны сүлжээ.

Практик үндэслэл

Нийт 149 багш оролцсон “тандалт”-ын судалгаанаас үзэхэд багш нарын мэргэжлийн өсөлтөд ахмад багш нарын оролцоо, нөлөө сул байна гэж залуу багш нар үзэж байгаа нь судлаач бидний анхаарлыг татаж байна.

Хүснэгт 1. Тандалтын судалгааны хүчин зүйлийн шинжилгээ

N	Percent	Sq1 Frequencies /Давтамжит үзүүлэлт / Responses Percent of Cases-Тохиолдолын хувь			
	huchin zuil ^a	Сургуулийн захирал	17	4.3%	10.8%
		Үе тэнгийн багш нар	31	13.0%	32.3%
		Сургалтын менежер	27	10.6%	26.2%
		ЗАН	40	18.6%	46.2%
		Сурагчид	18	5.0%	12.3%
		Ахмад багш нар	49	24.2%	60.0%
		Залуу багш нар	19	5.6%	13.8%
		Бие даан судалсан зохиол	22	7.5%	18.5%
		Албан болон албан бус	28	11.2%	27.7%
		Total	251	100.0%	247.7%

a. Dichotomy group tabulated at value 1. Хүчин зүйлийн шинжилгээ

Хүчин зүйлийн шинжилгээгээр багш нарын мэргэжлийн өсөлтөд ахмад багш нар бусад хүчин зүйлүүдийг тодорхойлж чадахуйцаар, хүчтэй нөлөөлж байгаа нь ахмад багш нарыг сургалтын үйл ажиллагаанд татан оролцуулах нь тулгамдсан асуудал болохыг харуулж байна. Мөн Боловсрол, ШУ-ны сайд Л.Энх-Амгалан: “Ахмад багш нар бол монголчуудын капитал юм. Энэ капиталын үр өгөөжийг хүртэх ёстой. Боловсролын салбар өөрийнхөө бий болгосон капиталын үр шимийг үзэж чадахгүй байна. Тухайн ахмад багш хөдөлмөрлөх бололцоотой гэвэл ур чадварыг нь ашиглая. Ахмад, дунд, залуу үеийн уялдаа холбоо байж ажил урагшилдаг. Ахмад багш нар маань тэтгэвэрт гарсан болохоос хамгийн чадварлаг, хамгийн туршлагатай багш нар гэртээ суугаад байгаа юм” гэжээ.

Дээрхээс үзвэл тухайн асуудлыг боловсролын салбар бодлогын түвшинд авч үзэх зайлшгүй шаардлагатай нь харагдаж байна. Үүний тулд ахмад багш нарын ажлын туршлага, сургалтын арга, технологийг хойч үеийн багш нарт түгээн дэлгэрүүлж, тэднийг сургалтын үйл ажиллагааны нэгээхэн хэсэг болгох нь нэн чухал хэмээн үзэж энэхүү сэдвийг сонголоо.

Судалгааны зорилго

Ахмад багш нарын сургалтын арга, технологийг түгээн дэлгэрүүлж, өвлөх явдал нь багшийн мэргэжлийн өсөлтөд ихээхэн нөлөөлдөг болохыг практик жишээн дээр тулгуурлан илрүүлж, тэдний оролцоог нэмэгдүүлэх арга замыг тодруулахад оршино.

Судалгааны зорилт

- Багшийн хөгжил, мэргэжлийн өсөлтийн талаар онолын үзэл баримтлалыг судлах
- Багш нарын мэргэжлийн өсөлтөд нөлөөлдөг хүчин зүйлсийн талаар тандалтын судалгаа авах, боловсруулах, үр дүнг шинжлэх
- Тулгамдсан асуудлыг шийдвэрлэх гарц гаргалгааг эрэлхийлэх, шийдвэрлэх арга замыг тодорхойлох
- Б.Галбаатар багшийн “Ухагдахуун сүлжээ” сургалтын технологийг Д.Хүрэлбаатар багш өвлөн авч, тухайн сургалтын технологи нь багшийн болон мэргэжлийн багийн багшлахуйн өсөлтөд нөлөөлсөн болохыг шинжлэх

Судалгааны хэрэгцээ

Залуу болон дунд үеийн багш нарт ахмад багш нарын сургалтын арга технологи, ажлын туршлагаас суралцах, түүнийг өөриймшүүлэх хэрэгцээ бодитоор үүсээд байна.

Судалгааны шаардлага

Ахмад багш нарын бий болгосон шилдэг арга технологи тэдэнтэй хамт алга болоод байна. Тэдний олон жилийн хөлс хүчээ шавхан байж бий болгосон тэрхүү шижир алт адил үнэтэй арга технологийг өвлөн авч үлдэх, үүнд ахмад багш нарын оролцоог нэмэгдүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Судалгааны арга

Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай баримт материал хангалттай байгаа бөгөөд бүтээлчээр эрж хайж дараах арга зүйг ашигласан болно. Үүний тулд чанарын судалгааны арга болох фокус бүлгийн ярилцлагын аргыг ашиглан ахмад,

туршлагатай багш нартай багшийн мэргэжлийн өсөлтөд нөлөөлдөг хүчин зүйлүүдийн талаар хэлэлцүүлэг, судалгаа хийлээ.

Асуулгын арга, бичиг баримт судлах арга, фокус бүлгийн ярилцлага, кейс судалгаа: түүврийн арга. Судалгааны мэдээллийг боловсруулахдаа анализ, синтез, индукцийн арга болон SPSS-24 программыг ашиглав.

Судалгааны таамаглал

- Ахмад багш нарын арга зүй, технологийг өвлөн авч өөриймшүүлэн хөгжүүлсэнээр багш нарын мэргэжлийн өсөлт хөгжил эергээр нөлөөлнө.
- Багш нарын мэргэжлийн өсөлтөд ахмад багш нарын оролцоог нэмэгдүүлэхэд тухайн багшийн хичээл зүтгэл, сургуулийн бодлого төлөвлөлтөөс ихээхэн шалтгаална.

Судалгааны шинэлэг тал

Тус сургуульд багшилж байсан биологийн багш Б.Галбаатарын бий болгосон, өдгөө мартагдах аюулд өртөөд байгаа “Ухагдахууны сүлжээ” сургалтын технологийг “Нийгэм судлал” хичээлд ашиглаж хэрэгжүүлэн, сүүлийн жилүүдэд тодорхой үр дүнд хүрснийг илрүүлж, ахмад багш нарын оролцоог хичээл сургалтын үйл ажиллагаанд нэмэгдүүлэх арга замуудыг судалснаараа шинэлэг талтай.

Судалгааны дэвшүүлж буй асуудал

Ахмад багш нарын арга туршлагыг багш нартаа үлдээх, улмаар бусад багш нарт түгээн дэлгэрүүлэх асуудал орхигдоод байгаа тул уг асуудлыг бодлогын хүрээнд авч үзэх шаардлага байна. Иймээс багш мэргэжлийн өсөлтөд ахмад багш нарын оролцоог нэмэгдүүлэхэд сургуулийн бодлого төлөвлөлтөд тусгах, хамт олны санал санаачилгыг өрнүүлэх, хувь багшийн зүгээс хүч чармайлт гаргах, ахмад багшаараа бахархан дуурайх үзэл санааг төлөвшүүлэх нь дээрх асуудлыг шийдэх боломж юм.

Судалгааны хэсэг

Тандалтын байдлаар багш нарын мэргэжлийн өсөлтөд нөлөөлдөг хүчин зүйлийг илрүүлэхийн тулд 22-35 насны 53 залуу багш нар, 35-45 насны 40 багш, 45-аас дээш насны ажиллаж буй 36 багш нар, тэтгэвэрт гарсан 20 багш нараас урьдчилан бичсэн асуумж, асуулгаар авсан судалгааны сонирхолтой үр дүнгүүдийг танилцуулъя.

Багш нарын мэргэжлийн өсөлтөд “Ахмад багш нар” ихээхэн нөлөөлдөг ч өнөөгийн залуу багш нар болон ахмад багш нарын хоорондын оролцоо, уялдаа холбоо сул байна. Ахмад багш нарын оролцоо, нөлөөллийг нэмэгдүүлэх арга замуудыг судлах, тэдний үед ямар бодлого үйл ажиллагаа явуулж байсан, багшлахуйн залгамж уялдаа холбоо, оролцоо, нөлөөлөл сайн туршлагуудыг сэргээн санах, сайжруулж ажиллах хэрэгцээ үүслээ. Залуу багш нар ахмад багш нарын “Заах арга зүй”-г өвлөх, авч үлдэх хүсэл эрмэлзлэл байгаа хэдий ч ахмад багш нартай хамтран ажиллах, тэднээс суралцах боломж нөхцөлийг сургуулийн түвшинд бодлогоор зохицуулах ажил дутагдаж байгаагаас суралцах эрмэлзлэлээ орхиж байна.

Фокус бүлгийн ярилцлагын судалгааны үр дүн

<i>Та анх багш болоод яаж хөгждөг байсан бэ?</i>	<i>Та өнөөгийн залуу багш нарт багшлах арга зүй, мэргэжлийн талаар ямар зөвлөгөө өгөх вэ?</i>
Ахмад багш нартаа шинэ залуу багш нараа хариуцуулж, дагалдан багшлуулах гэрээ байгуулж, тайлан тавиулдаг байсан. Сурган хүмүүжүүлэх уншлагад жил бүр оролцож, олон зүйлийг судалж хөгждөг байсан Сургуулийн захиргаа улирал тутамд багш нарын онолын мэдлэгийг шалгадаг байсан нь хөгжилд нөлөөлдөг байв.	Залуу багш нарт зөвлөмж өгөхийн тулд хичээлд нь удаа дараа сууж, дүн шинжилгээ хийж, оношилсоны дараа тэдэнд заах арга, дидактик шийдэл санал болгож зөвлөх боломжтой
Та сургууль удирдах ажил хийж байхдаа багшийн хөгжлийн талаар ямар бодлого баримталж байсан бэ?	Та сургууль удирдах ажил хийж байхдаа залуу багш, ахмад багш нарын уялдаа, хамтран суралцах талаар ямар үйл ажиллагаа зохион байгуулдаг байсан бэ?
Сайн багшийн хөргийг гаргаж, залуу багш нарыг даган дуурайлгадаг байв. Сайн, шилдэг хичээлийн уралдааныг явуулж, хэлэлцүүлэг хийдэг байсан	Сургуулийн ажлын төлөвлөгөөнд ахмад багш нараас суралцах, тэдний туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг тусгаж, сургуулийн хөгжлийн нэгэн хүчин зүйл болгодог байв
Багш нарын мэргэжлийн өсөлтөнд ахмад багш нарыг яаж татан оролцуулах вэ?	Хөвсгөл аймгийн бусад сургуулийн багшийн хөгжлийн бодлогын талаар?
- Байнгын үйл ажиллагаатай “Ахмад багш нарын өрөө”-тэй байхад сургуулийн зүгээс анхаарах - Хичээлд давтамжтай суулгаж, хичээлийн хэлэлцүүлэг өрнүүлэх	Сургууль гол тулгуур багш нарыг бодлогоор бэлтгэдэг.


Асуудлын шийдэл санаа

- Сургуулийн бодлого төлөвлөлтөд ахмад багш нарын арга туршлагаас суралцах зорилт, үйл ажиллагааны чиглэлийг тусгаж оруулах, хөгжлийн нэг үзүүлэлт болгох. Тухайлбал: ЗАН-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж болно.
- Ахмад болон залуу багш нарыг хамтын үйл ажиллагаагаар холбож, албажуулах. Үүнд:
- Ахмад багш нартаа шинэ залуу багш нараа хариуцуулж, дагалдан багшлуулах гэрээ байгуулж, тайлан тавиулах
- Ахмад багш нарын арга туршлагаас өвлөх, турших, хэрэгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх үйлийг залуу багш эрхэм болгох

Асуудлыг шийдвэрлэх арга аргачлал боловсруулсан нь

Онолын хэсэг

Зураг 1. Багш нийгмийн хөгжлийн диалектик холбоо¹¹



Ухагдахууны сүлжээ сургалтын технологийн онолын үндэслэл

Энэ хэсэгт Ахмад багш Б.Галбаатар багшаас өвлөж, туршиж, хэрэгжүүлж үр дүнд хүрсэн “Ухагдахууны сүлжээ” сургалтын технологийг танилцуулах болно.

Аливаа сургалтын арга, технологийг бий болгоход онолын үзэл баримтлалууд хөрс суурь нь болж өгдөг. Тиймээс “ухагдахууны сүлжээ” сургалтын технологийг бий болгохын тулд дараах онолын болоод судлаачдын үзэл баримтлалуудыг харьцуулан судалсан болно.

Ухагдахууны сүлжээ ба оюуны зураглалын арга

Оюуны зураглалын арга нь нэгэнт уугуул монгол арга болохоор манай багш сурган хүмүүжүүлэгчид багш нар өөр өөрийн онцлог арга барилд шилжүүлэн баяжуулан хэрэглэж олон янзын нэршлийг бий болгожээ. Тухайлбал: Доктор Ц.Баасандорж – бүтэц логикийн бүдүүвч, үндэсний сургагч багш Т.Алтанцэцэг- багцлах арга, Булган аймгийн багш Л.Булгамаа- логик зураглал, Хөвсгөл аймгийн биологийн багш Б.Галбаатар- ухагдахууны сүлжээ гэх мэт. Манай багийн зөвлөхөөр манай сургуулийн зөвлөх багш Б.Галбаатар ажилласан болохоор бид энэ аргыг цаашид “ухагдахууны сүлжээ” гэж нэрлэсэн болно.

Боловсруулсан арга аргачлал, шийдэл


Галбаатар багшийн “ухагдахууны сүлжээ” арга технологи

Зураг 2. Ухагдахууны сүлжээ сургалтын технологи




¹¹ Энхтүвшин.С нар. (2015). “Багшлахуйн үндэс”. т145

Багш Д. Хүрэлбаатарын “ухагдахууны сүлжээ” арга технологи (өөриймшүүлсэн байдал)



Зураг 4. Арга зүй, алхамчлал¹²



¹² Шагдар.Х нар. (2015). Монгол цэргийн урлаг. т18-19

Хүснэгт 1. Алхамчлалын дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Арга, алхамчлал	Үйлийн товчоо	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа
ДАЙРАХ	Довтлох буюу нэг, шулуун чиглэлтэй үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Сурагчдын өмнөх мэдлэгийг сэргээн сануулсны дараа одоо үзэх сэдвийн дагуу онолын ойлголтуудыг оюуны зураглал ашиглан багшийн зүгээс тайлбарлана. Нэг ёсондоо багшийн зүгээс оюуны довтолгоо хийх замаар сурагчдад шинэ мэдлэг эзэмшүүлнэ. Энэ үед багшийн оролцоо давамгайлна.
БУРУУЛАХ	Арга хэлбэрээ өөрчлөх, хувилбарт нөхцөлд шилжих	Энэ үе шатанд багш чиглүүлэх үүрэгтэй болж хичээлийн гол тоглогчийн байраа орхисноор сурагчид гол тоглогч болж, өөрсдөө мэдлэгээ бүтээх алхмыг хийх болно. Энэ үед сурагчийн оролцоо давамгайлна. Багаар ажиллан багшийн бүтээсэн оюуны зураглалыг “Ухагдахууны сүлжээ болгон гүйцэнэ.
ХОРООЛОХ	Хүрээлэн буй ойлголтуудыг сэргээн санах зарчмаар нэгтгэн дүгнэх, цөмд шилжих	Багш сурагчдын шинээр эзэмшсэн мэдлэгийг хадгалах, улмаар чадвар болгон төлөвшүүлэх үүднээс дасгал даалгавар ажиллуулах замаар дүгнэлт гаргуулах. Сурагчид ухагдахууны сүлжээ ашиглан даалгаврыг (тест) ажиллах замаар мэдлэгээ бататгах, дүгнэлтэнд хүрэх.

Дээрх 2 багшийн сургалтын арга технологийн хувьд ижил болон ялгаатай зүйлийн харьцуулсан дүгнэлт:

Ижил төсөөтэй шинж:

- Сургалтын технологи бүр нь хичээлийн үйл ажиллагааны явцад сурагчидтай ажиллах арга, дараалал нь системчлэгдсэн.
- Мэдлэг, чадвар эзэмшүүлэх үйлийн техник нь зорилгоос хамаарсан уян хатан шинж чанартай
- Тухайн үеийн сургалтын үнэлгээнд нийцсэн, үнэлж дүгнэхэд оновчтой байдлаар хийгдсэн байна.

Ялгаатай тал:

- Технологи боловсруулсан хэлбэрийн хувьд: Б.Галбаатар багшийн сургалтын технологи нь сургалтын үйл явцыг бүтнээр агуулсан шинж чанартай: Бэлтгэл үе, Сургалтын үе, Үнэлгээ, Бие даалт гэсэн хэсгүүдээс бүрдэж байсан бол Хүрэлбаатар багшийн арга зүй, технологи нь нэгж болон ээлжит хичээлийн үйл явц руу илүү чиглэсэн, илүү нарийвчлагдан боловсруулагдсанаараа гол ялгаа нь оршино.
- Судлагдахууны хувьд: Биологийн хичээлийн туршилт, арга зүйг түүх, нийгмийн ухааны хичээлийн агуулгад нийцүүлэн хэрэгжүүлж ажилласан зэрэг онцлог ялгаатай талуудаар хөгжүүлж ирсэн байна. (Энэхүү сургалтын арга зүйгээ туршин хэрэгжүүлж ажилласны үр дүнд “Бүгдийн биш чухлыг” багш, сурагчдад зориулсан гарын авлага боловсруулан гаргаж сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж байна).

Туршин хэрэгжүүлсэн байдал, үр дүн

Д.Хүрэлбаатар багшийн ухагдахууны сүлжээ арга технологийн хэрэгжилт, өөриймшүүлсэн байдал

АБТА, Тэргүүлэх багш Б.Галбаатар багшийн 30 гаруй жилийн нөр их хөдөлмөрийн үр дүнд бий болсон УССТ нь монгол хүүхдийн уугуул шинжид тохирсон арга тул сурагчдын сурах чадварын өсөлтөд мэдэгдэм ахиц дэвшил гаргасныг Титэм сургуулийн сурагчдын амжилтаас харж болно. Иймээс багш сурагчдад зориулан УССТ-иор “Бүгдийг нь бус чухлыг нь” хэмээх гарын авлагыг анх 2018 онд дараах шалтгаанаар бүтээв. Үүнд:

- УССТ нь багштай хамт мартагдах эрсдэл тулгарсан учир түүнийг сургалтад ашиглах, хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх хэрэгцээ байсан.
- “Нийгэм судлал” сонгох хичээлд хамрагддаг сурагчдын зөвхөн дэвтэр, сурах бичиг л гарын авлага болж байсан.
- “Нийгэм судлал” судлагдахуунаар ЭЕШ-д бэлтгэж буй сурагчид 8-11-р ангийн сурах бичгийн агуулгыг судлах шаардлагатай болсон тул тэдэнд агуулгын босоо тогтолцоогоор бэлтгэсэн гарын авлагатай болох хэрэгцээ үүссэн зэргээс үндэслэн дээрх гарын авлагыг гарсан болно.

Дээрх гарын авлагыг сургалтад ашигласнаар сурагчдын хувьд түлхүүр үг, тулгуур ухагдахуунуудыг ашиглан “Нийгэм судлал” хичээлээр эзэмшдэг ойлгох, сэргээн санах чадвараа хөгжүүлэн, цэгцтэй мэдлэг эзэмших дедуктив аргыг ашиглах арга барилд суралцаж байгаа нь шавь нарын маань гаргасан амжилтуудаас харагдана.

Б.Галбаатар багшийн арга технологийг нийгмийн ухааны хичээлд хөрвүүлэх, эхийг бэлтгэхдээ дараах өөрчлөлтийг хийсэн. Үүнд:

1. Байгалийн ба нийгмийн ухааны хичээл ялгаатай учир бичиглэлийг их болгосон.
2. Он сар, хүний нэр, газар орны нэр, ном зохиолын нэр зэргийг заавал оруулах болсон.
3. Үндсэн сэдэв, дэд сэдэв, түүний төрөл, ангилал, задаргааг өөр өөр хүрээгээр тэмдэглэсэн
4. Он сар, хүний нэр, газар орны нэр, ном зохиолын нэр зэргийг заавал оруулах болсон.
5. Багш маань бичиг үсгийн чадвар хэтийдсэн хүн тул гараар бичдэг байсан бол миний хувьд компьютерээр номын эхээ өөрөө бэлдсэн.
6. 8-11-р ангийн сурах бичгийн бүх агуулгыг багтаасан “Бүгдийг нь бус чухлыг нь ном 200 ш хэвлэгдсэн
7. Уг ном аймгийн төвийн 6, сум орон нутгийн 8 сургуулиудаар тараагдсан байгаа юм.

Сургалтад “Гарын авлага”-ыг хэрэглэсэн байдал (Сонгон суралцах хичээлийн жишээн дээр)

Аливаа багш ямар нэгэн сургалтын арга технологийг өөриймшүүлсний үр дүнд мэргэжлийн мэдлэг, чадвар, хандлагад чанарын эерэг өөрчлөлт гардаг байна.

Тухайлбал: Д.Галбаатар багш олон жилийн сурган хүмүүжүүлэх ажлынхаа үр дүнд “Ухагдахууны сүлжээ” хэмээх сургалтын арга, технологийг бий болгосон нь түүнд үр өгөөжөө өгч Хөвсгөл аймагтаа нэрд гарсан, чадварлаг багш байсныг түүний амжилтаас харж болно. Хүн мэдлэгийг өөрөө зохиомжлон бүтээдэг хэмээх конструктивизм онолоор бол суралцагчдын мэдлэг бүтээх нэг сонгодог аргачлал нь ухагдахууны сүлжээ юм. Түүний энэхүү арга технологийг ТНУ-ны багш Д.Хүрэлбаатар өвлөн авч, туршиж, өөриймшүүлсэн нь мэргэжлийн өсөлт, хөгжилд нь нөлөөлөөд зогсохгүй хамтран ажилладаг залуу багш нарын мэргэжлийн өсөлтөнд дэмжлэг болсоор байна. Сургалтын арга технологийг “ахмад, дунд, залуу” үеийн багш нарын залгамж холбоотойгоор хөгжүүлж, сургалтын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх нь багш нарын мэргэжлийн хөгжил, өсөлтөд ихээхэн нөлөөлөөд зогсохгүй ахмад багш нарын оролцоог нэмэгдүүлдэг томоохон ач холбогдолтой болох нь туршилт судалгаанаас харагдлаа.

Хүснэгт 2. Арга зүй, технологийн хэрэгжилт, үр дүн

Оролцоог хангасан байдал	Багшид гарсан өөрчлөлт	Мэргэжлийн багт гарсан өөрчлөлт	Сурагчид гарсан өөрчлөлт
Онолын хөгжил	Онол, ойлголтыг зураглал, түлхүүр үг хэлбэр оруулж, сэргээн санахад хялбар болсон.	Мэргэжлийн текстүүдийг ойлголтуудаар илэрхийлэн, ойлголтын сайжирсан.	Хичээлийн агуулгын гол тулгуур ойлголтыг цээжилж, ойлгосон тул шалгалтын оноо, дундаж өссөөр байна.
Арга зүйн хөгжил	Хичээлийн хүнд, их текст агуулгыг тулгуур үгүүдээр илэрхийлэх арга зүйг хичээлд ашигласан.	Ухагдахууны сүлжээг ашигласнаар хичээл заах шинэлэг арга зүйтэй болсон	Хичээлийн агуулга, номын текстүүдэд шинжилгээ хийж, тулгуур гол ойлголтыг илрүүлж, схем, бүдүүвч зохиох чадвар эзэмшсэн.

Дүгнэлт

Багш нарын хамтын ажиллагаа, уялдаа холбоонд мэргэжлийн өсөлт, хөгжил бий болж, хичээл сургалтын үйл ажиллагаа үр дүнтэй болдог. Ахмад багш нарын сургалтын арга, технологийг багш нарт өвлүүлэх нь тэднийг хөгжүүлэх, мөн ахмад багш нарын оролцоог нэмэгдүүлэх ач холбогдолтой. Үүний тулд:

- Сургуулийн ажлын бодлого төлөвлөлтөд ахмад багш нараас суралцах, тэдний туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг тусгаж өгөх шаардлагатай.
- Багшийн ажлын үр дүнгийн үзүүлэлтэд хамааруулан төлөвлөгөөнд тусгах.
- Халамжлан хүмүүжүүлэгч багш нарыг томилох, албажуулах.
- Залуу багш нар ахмад багш нарын ажлын туршлага, арга зүйг өвлөн авч сургалтын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх тал дээр хичээл зүтгэл гаргах.
- “Залуу багш манлайлал”-ын мөн чанарыг ойлгон, ахмад үеэрээ бахархан дуурайх үзэл санааг төлөвшүүлэх, түгээн дэлгэрүүлэх зэрэг бүтээлч үйлийг сургуулийн жишээн дээр хэрхэн туршиж хэрэгжүүлсэн туршлага болов.

Энэхүү ажлын үр дүнгээс үзвэл хамгийн сайн туршлага бидний ахмад үед байгаа тул нийгмийн хангагдаагүй хэрэгцээг хангахын тулд тэдний сайн зүйлийг шингээн авч үлдэх нь хамгийн ойрхон үнэт зүйл юм. Мөн үүнийг олж харж өвлөн авч үлдсэн багшийн

хувьд багшлахуйн ур чадвар төлөвшин тогтсон ба бүх нийтээрээ хэрэглэх боломж бүрддэг нь харагдаж байна. Боловсролын салбарт багшлах боловсон хүчин сүүлийн жилүүдэд эрс залуужиж байгаа энэ цаг үед ахмад багш нарын оролцоо, нөлөөлөл зайлшгүй шаардлагатай. Залуу багш нарыг ажлын гараагаа эхлэх үед нь дээрх арга замуудыг хэрэгжүүлэх нь тэдний мэргэжлийн чиг баримжаагаа олох, ахмад багш нарын ажлын туршлага, арга технологийг өвлөн авах, цаашлаад мэргэжил боловсролоо дээшлүүлэх томоохон боломжуудыг олгодог нь энэхүү судалгаагаар илэрлээ.

Ном зүй

- БШУЯ. (2015). Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр. Улаанбаатар
- БСШУСЯ. (2019). Иргэний ёс зүйн боловсрол: сургалтын хөтөлбөр, удирдамж. Улаанбаатар
- Батсүх, С. (2012). “Хүн байхын учир”. Улаанбаатар
- МУБИС. (2010). Бага насны хүүхдийн сэтгэл судлал. Улаанбаатар
- Цэвэл, Я. (1966). Монгол хэлний товч тайлбар толь. Улаанбаатар
- Жавзан, Б., Энхбаяр, Б. (2009). *Боловсролын сэтгэл судлал*. Улаанбаатар
- Хүрэлбаатар, Д. (2021). *Бүгдийг нь биш, Чухлыг нь*. Мөрөн хот
- Пүрэвдорж, Ч. (2008). *Багшлахуйн менежмент*. Улаанбаатар
- Ичинхорлоо, Ш. (2011). *Диссертацийн ажлын арга судлалын үндэс*. Улаанбаатар
- Энхтүвшин, С., нар. (2015). *Багшлахуйн үндэс*. Улаанбаатар
- (2018). Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль. Улаанбаатар

АХМАД БАГШИЙН ЦИФРТЭЙ ХОЛБООТОЙ БОДЛОГО БОДОХ ХЯЛБАР АРГА ЗҮЙГ ТУРШИН ҮР ДҮНД ХҮРЭХ НЬ

(Тусгай байр)

С. Наранцэцэг¹, Б. Алтанцэцэг², С. Наранзаяа³, Б. Саранчимэг⁴

Дархан-Уул аймаг, ЕБ-ын лаборатори

“Оюуны ирээдүй” цогцолбор сургууль

S.narka9003@gmail.com¹, Saranchimeggs@gmail.com²,

B.Altaa0310@gmail.com³, buynaanarantsetseg@gmail.com⁴

Хураангуй

“Боломж тооцоолох” бодлогууд нь комбинаторик, магадлал цаашлаад тоон гарын үсэг, бар код зохиох үндэс суурь болдог. Цифртэй холбоотой бодлогууд нь тооцоолол ихсэх тутам “Тоочин бичих”, “Мод ургуулах” аргыг хэрэглэхэд хүндрэлтэй байдаг. Ахмад багш Ц.Дэдхүү үржүүлэхийн дүрмээр заадаг байсан туршлагыг 2014-2017 онд багш С.Наранцэцэг ангид ага туршин “Хүснэгтийн арга” болгон сайжруулсан. 2017-2021 онд Б.Алтанцэцэг, С.Наранзаяа, Б.Саранчимэг багш нартай хамтран сурагчдын ялгаатай байдал, видео хичээл, интерактив ажлын хуудас болгож цаг үеийн байдалд тохируулан арга зүйгээ сайжруулан судалгаат хичээлүүдийг заан туршсан. Энэхүү илтгэлээр ахмад багшийн туршлагаас суралцан, багш заах арга зүйгээ сайжруулах боломжтой болохыг бага ангийн боломж тооцоолох бодлого бодох аргаар жишээ татан харуулахыг зорилго.

Түлхүүр үг: бага боловсрол; боломж тооцоолох бодлого; хүснэгтийн арга; хичээлийн судалгаа; цахим; интерактив; түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа.

Оршил

Өнөө үед багш гэдэг бол өсвөр залуу үеийнхэнд амьдралд нь хэрэгтэй мэдлэг, чадвар олгох тэднийг бие хүн болгон хүмүүжүүлэх арга ухааныг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах мэргэжлийн ур чадвартай хүн юм. Тиймээс багш нар тасралтгүй хөгжиж өөрийн гэсэн арга зүйтэй болох, шинэ арга зүйг турших, ахмад багш нараасаа арга зүйн зөвлөгөө авах зайлшгүй шаардлагатай байна. Мэдээллийн IY хувьсгалын энэ эрин үед техник, технологийн өндөр хурдацтай өөрчлөлтөд дасан зохицож, юмс (мэдээлэл, технологи, эд зүйл, бараа материал гэх мэт)-ыг сонгож авах, янз бүрээр байршуулах зүй тогтлыг олж, өдөр тутмын амьдрал ахуйдаа хэрэглэж сурах чадварыг сурагчдад бага ангиас нь эхлэн олгох нь өнөөгийн боловсролын нэн чухал зорилт билээ. Иймд бага ангийн математик сургалтад тоо, цифр, үсэг, зурган хэлбэрээр кодлогдсон өгөгдлүүдийн боломжит хувилбарыг тооцоолох, байршуулах, сонгох зорилгоор “Боломж тооцоолох” бодлого бодох аргуудыг оруулсан байдаг. Үүнд, тоочин бичих, мод ургуулах загвар, үржүүлэхийн дүрэм ашиглах гэх мэт аргуудыг дурдаж болно. Хувцас сонгож, тааруулж өмсөх, 256 бөх тойргийн журмаар барилдвал хэчнээн

барилдаан гарах, ангийн сурагчдаас бүжгийн хосыг хэдэн янзаар сонгох гэх мэтийн бодлогуудыг комбинаторикийн 13 бодлогууд гэж нэрлэдэг. Бага ангийн “Боломж тооцоолох”-ын бодлогууд нь дунд ангид комбинаторик, магадлал цаашлаад тоон гарын үсэг, бар код зохиох үндэс суурь болдог. 1-5-р ангийн “Боломж тооцоолох” сэдвийн хүрээнд цифртэй холбоотой бодлогуудыг бодоход тооцоолол ихсэх тутам “Тоочин бичих”, “Мод ургуулах” аргыг хэрэглэхэд хүндрэлтэй байдаг. Иймд ахмад багш Ц.Дэдхүү үржүүлэхийн дүрмийг ашиглан боломж тооцоолох бодлогыг хялбар аргаар заадаг байсан туршлагыг багш С.Наранцэцэг ангидаа туршин хэрэгжүүлсэн бөгөөд улмаар тухайн аргыг боловсронгуй болгон сайжруулж, “Хүснэгтийн арга” болгон боловсруулж, туршин хэрэгжүүлж байна. Энэхүү илтгэлээр ахмад багшийн туршлагаас суралцан, багш заах арга зүйгээ сайжруулах боломжтой болохыг бага ангийн боломж тооцоолох бодлого бодох аргаар жишээ татан харуулахыг зорьсон болно.

Судалгааны зорилго

Ахмад багшаас суралцсан цифртэй холбоотой боломж тооцоолох хялбар аргуудыг туршиж, арга зүйг сайжруулах, бусдад түгээх, багаар хамтран ажиллаж үр дүнд хүрэх

Судалгааны зорилт

- Цифртэй холбоотой боломж тооцоолох бодлогыг хялбар заах арга зүйг сонгон турших
- Цифртэй холбоотой боломж тооцоолох бодлогыг бодох хялбар арга зүйгээ судалгаат хичээлийн үр дүнгээр тооцож, дүгнэлт гаргах
- Багш нараас санал асуулга авч үр дүнг тооцон, түгээн дэлгэрүүлэх

Сэдвийн судлагдсан байдал

Бага боловсролын математикийн онол арга зүй (Б.Бадамдорж, 2011) номонд цифртэй холбоотой бодлогыг мод ургуулах, тоочин бичих аргаар заасан байна. Бага ангийн багшийн гарын авлага II (Ж.Баатар, 2011) номонд цифртэй холбоотой бодлогыг мод ургуулах, тоочин бичих, үржүүлэхийн дүрмээр тус тус багш нарт зөвлөмж болгон оруулсан байдаг. “Хүснэгтийн арга” нь мэдээллийг эмхэлж цэгцлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулан жиших, ойлгомжтой товч тодорхой байдлаар харуулдаг учраас энэхүү хүснэгтийн аргыг боломж тооцоолохын цифртэй холбоотой бодлого дээр туршсан нь үр дүнтэй байлаа. Бага боловсролын багш С.Наранцэцэгийн энэхүү арга нь судлагдаагүй болно. Бид энэ аргаар 2009-2014 он “Үржүүлэхийн дүрэм”, 2014-2017 он “Хүснэгтийн арга”, 2017-2019 он “Хүснэгтийн арга”, 2019-2021 он “Хүснэгтийн арга” (видео) , 2021-2022 он “Хүснэгтийн арга” (интерактив) хичээл болгон заан туршсан болно.

Судалгааны ажлын үндэслэл

Ерөнхий боловсролын гол зорилго нь суралцагчдад *мэдэх, бүтээх, нийгэмшин иргэнших, бие даан амьдрах* цогц чадамжийг төлөвшүүлэхэд оршино гэж ЮНЕСКО-оос зөвлөмжилсөн билээ. Энэхүү зөвлөмжийн дагуу манай орны математикийн бага, дунд боловсролын зорилгод “...бодит амьдралын аливаа асуудлын харилцан

¹³ Комбинаторик (Бага ангид боломж тооцоолох) гэдэг нь нэгтгэх, хослох гэсэн латин үгнээс гаралтай.

хамаарал, уялдаа холбоог математикаар загварчлан таних, оновчтой шийдвэрлэх цогц чадамж төлөвшүүлнэ”¹⁴ гэжээ. Энэхүү зорилгын хүрээнд бага боловсролын математикийн сургалтын хөтөлбөр болон суралцахуйн зорилт 3.4в, 4.4г 5.4д-д “мэдээллийн өгөгдлийг бүртгэж, ажиглалт ба туршилтаар илрэх үзэгдлийн тоог тооцоолох”, “үзэгдлийн илрэх боломжийг тоочиж бүртгэх модны загвар ашиглан боломж тооцоолох” суралцахуйн үйл ажиллагааг тодорхойлсон байдаг нь “Ахмад багшийн цифртэй холбоотой бодлого бодох хялбар арга зүйг туршин үр дүнд хүрэх нь” сэдвийн үндэслэл болж байна. 2009-2021 онуудад явуулсан туршилт судалгааны үр дүнд боломж тооцоолох бодлого бодох аргыг заах арга зүйн хөгжүүлэлт хийх зайлшгүй шаардлага бий болж байсан юм.

2018 онд зохион байгуулагдсан “Бүтээлч ахмад багш нарын III зөвлөгөөн”-ий шийдвэрт сургалтын чанарыг сайжруулахад залуу багш нарын ур чадвар, ёс зүйг дээшлүүлэх шаардлага тулгарч буйд ахмад багш нар санал нэгдсэн байдаг. Иймээс ахмад багш нарын туршлагыг хойч үедээ дамжуулах нь бидний үүрэг гэж үзсэн учраас мэргэжлийн ном, сэтгүүл унших, ахмад бүтээлч багш нарын туршлагыг судлах, тэдний олон аргуудаас тухайн нэг сэдвийн заах арга зүйг оновчтой сонгож, хичээлээ боловсруулах, бүтээлчээр хэрэглэн үр дүнг тооцож үнэлэх, цаашид илүү үр дүнтэй болох талаар дүгнэлт хийж, харилцан туршлага судлан бусдын хүртээл болгохыг зорьж байна.

Судалгааны арга

Баримт бичгийн шинжилгээ, туршилт, хэлэлцүүлэг/ярилцлага, асуулга, сорил

Цифртэй холбоотой (боломж тооцоолох) бодлого бодох арга зүй

Бага ангийн “цифртэй холбоотой боломж тооцох бодлого” сэдвийн хүрэх үр дүн нь дүрсэн ба тоон дарааллын зүй тогтлыг олох өмнө эзэмшсэн мэдлэг чадвараа ашиглан дүрсэн ба тоон дарааллын зүй тогтол, боломжийн тоог “тоочин бичих арга”, “модны загвар”, “үржүүлэхийн дүрэм” зэрэг аргуудыг ашиглан олоход оршино. Бага ангид бодит юмс, зураг, зураглал, бичвэр зэргийг *ажиглах, турших, хийж бүтээх, үр дүнг бүртгэх, таамаглах, дүгнэлт гаргах, асуудал шийдвэрлэх, ярилцах* зэрэг үйлийг сургалтын явцад түгээмэл хэрэглэнэ.

Зүй тогтол, боломж тооцоолох сэдвийн хүрээнд сурагчид дараах мэдлэг, чадвартай болно. Үүнд,

Мэдлэг - тоо, хос үүсгэх, зүй тогтол, математикийн үг хэллэг

Чадвар – тоо, зүй тогтлыг олох, юмсыг хослуулах, үргэлжлүүлэх


- Тодорхой зүй тогтлоор хос хослолыг үүсгэх, тоон дараалал зохиох, хүснэгтэд бүртгэх,
- Таамаглал дэвшүүлэх, шалгах, арга, шалтгааныг амаар, бичгээр тайлбарлах

Мод ургуулах арга

¹⁴ Хүүхдээр математикийн хялбар мэдлэг бүтээлгэх арга зүй, Зөвлөмж-1, Суралцаагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил, БСШУЯ-ЖАЙКА-ийн хамтарсан төсөл, 2007, 15-16-р хуудас

Цифртэй холбоотой боломжийг тооцохдоо цифрүүд давтагдах, давтагдахгүй байх тохиолдлуудыг ажиглуулж, ялгаатай байдлыг тодорхойлно.

Жишээ : 0, 3, 4, 6 гэсэн дөрвөн цифрээр (цифр давтагдах) 3 оронтой тоо хэдийг бичиж болох вэ?



Бодолт: $3 \text{ мод} \times 4 \text{ мөчир} \times 4 \text{ нахиа} = 48 \text{ тоо}$

Энэхүү ажиглан ярилцах үйл ажиллагааны үр дүнд сурагчид дараах зүй тогтлыг илрүүлнэ. Үүнд:

- Аливаа оронд байж /бичиж / болох цифр, тийм боломжийн тоог зөв тооцох
- Аливаа олон оронтой тоо 0 цифрээр эхэлж болохгүй
- Цифр давтагдахгүй гэсэн тохиолдолд, сонгох цифрийн тоо нь орон буурах бүрд нэгээр хорогддог болох
- Цифр давтагдах үед боломжийн тоо ихэснэ.
- Модны тоо бүх боломжит 100-тын орны цифрийн тоог харуулна, мөчрийн тоо нь бүх боломжит 10-тын орны цифрийн тоог харуулна, мөчрийн салаа нь бүх боломжит нэгжийн орны тоо хэд байгааг харуулж байна.

Мод ургуулах аргыг хэрэглэхэд дараах хүндрэл, бэрхшээл гардгийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

- Цифрийн тоо олон болж тооцоолол ихсэх тутам тухайн аргаар бодоход хүндрэлтэй,
- Бодлогын үр дүнг харахын тулд цаг хугацаа их шаардагдана,
- Дэвтрийн бичиглэл эмх цэгцгүй болох.

Тоочин бичих арга

Бодлого 1 0, 3, 4, 6 гэсэн дөрвөн цифрээр (цифр давтагдахгүй) 3 оронтой тоо хэдийг бичиж болох вэ? гэсэн бодлогыг тоочин бичих аргаар бодъё.

304, 306, 340, 360, 346, 364, 403, 406, 430, 460, 436, 463, 603, 604, 630, 640, 643, 634 нийт -18 тоо

Бодлого 2 0, 3, 4, 6 гэсэн дөрвөн цифрээр (цифр давтагдах) 3 оронтой тоо хэдийг бичиж болох вэ?

300, 303, 304, 306, 330, 333, 334, 336, 340, 343, 344, 346, 360, 363, 364, 366,

400, 403, 404, 406, 430, 433, 434, 436, 440, 443, 444, 446, 460, 463, 464, 466

600, 603, 604, 606, 630, 633, 634, 636, 640, 643, 644, 646, 660, 663, 664, 666 нийт -48 тоо

Тоочин бичих аргаар бодоход 0 цифр орсон тохиолдолд сурагчид дараах зүй тогтлыг илрүүлнэ. Үүнд:

- Ямар нэг тоо 0 цифрээр эхэлж болохгүй.
- Аль нэг цифрээр эхэлсэн тоог тоочин бичих явцдаа бүх боломжийг бичиж байж бодлогын үр дүн зөв гарна.
- Боломж тооцох бодлогод тоочин бичих аргыг хэрэглэж, бодлогын үр дүнг харахын тулд цаг хугацаа их шаардагдана.
- Дэвтрийн бичиглэл эмх цэгцгүй болох,
- Тоог тоочин бичих явцдаа эрэмбэлж бичихгүй бол тоо орхих тохиолдол гарах

Хүснэгтийн арга

Хүснэгтийн арга нь мэдээллийг эмхэлж цэгцлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулан жиших, ойлгомжтой товч тодорхой байдлаар харуулдаг.

Бодлого 1: 0, 3, 4, 6 гэсэн дөрвөн цифрээр (цифр давтагдах) 3 оронтой тоо хэдийг бичиж болох вэ? бодлогыг хүснэгтийн аргаар бодъё.

З	А	Н
3	4	4
	0	0
3	3	3
4	4	4
6	6	6

Хариу: $3 \times 4 \times 4 = 48$ тоо

Тэг цифр орсон үед бодох аргачлал

1. 3 оронтой тоо зохиох учир 3 нүдтэй хүснэгт зурна.
2. Орон ангийг хүснэгтийн дээр бичнэ. Жишээ нь зуут /з/, аравт /а/, нэгж /н/
3. Эхний хүснэгтэнд тоог бичихдээ цифр давтагдах, цифр давтагдахгүй, тэгийн цифр орсон уу? гэдгийг сайн анхаарч бичнэ.

- Зуутын орон дээр 3,4,6 гэсэн 3 цифр байх боломжтой (тоо 0-ээр эхлэхгүй)
- Аравтын орон дээр 0, 3, 4, 6 гэсэн 4 цифр байх боломжтой (цифр давтагдана, тэг цифр аравтын орон дээр бичигдэнэ. Жишээ нь 304, 305 гэх мэт тоо үүснэ)
- Нэгжийн орон дээр 0, 3, 4, 6 гэсэн 4 цифр байх боломжтой (цифр давтагдах учир)

4. Хүснэгт дэх тоонуудаа үржүүлэхийн дүрэм ашиглан үржиж үр дүнг гаргана.

Бодлого 2: 0, 3, 4, 6 гэсэн дөрвөн цифрээр (цифр давтагдахгүй) 3 оронтой тоо хэдийг бичиж болох вэ? бодлогыг хүснэгтийн аргаар бодъё.

БОДОЛТ Цифр давтагдахгүй тохиолдлыг бодох аргачлал

З	А	Н
3	3	2
3	0	
4	4	4
6	6	6

Хариу: $3 \times 3 \times 2 = 18$ тоо

1. 3 оронтой тоо зохиох учир 3 нүдтэй хүснэгт зурна.
2. Орон ангийг хүснэгтийн дээр бичнэ. Жишээ нь зуут /з/, аравт /а/, нэгж /н/
3. Эхний хүснэгтэнд тоог бичихдээ цифр давтагдах, цифр давтагдахгүй, тэгийн цифр орсон уу? гэдгийг сайн анхаарч бичнэ.

Зуутын орон дээр 3,4,6 гэсэн 3 цифр байх боломжтой (тоо 0 эхлэхгүй)

- Аравтын орон дээр 0, 4, 6 гэсэн цифрийн аль нэг байх боломжтой тул 3 боломж байна (цифр давтагдахгүй, тэг цифр аравтын орон дээр бичигдэнэ. Жишээ нь 304, 305 гэх мэт тоо үүснэ).
- Нэгжийн орон дээр 0, 6 гэсэн 2 цифрийн аль нэг байх боломжтой тул 2 боломж байна (цифр давтагдахгүй учир).

Хүснэгт дэх тоонуудаа үржүүлэхийн дүрэм ашиглан үржиж үр дүнг гаргана

Энэхүү аргаар цифртэй холбоотой бодлогыг “Хүснэгтийн арга”-аар бодсоноор сурагчид 23-25 секундын дотор үр дүнг харах боломжтой юм.

Судалгааны хэсэг

Туршилт судалгааны зорилго

Ахмад багшаас суралцсан цифртэй холбоотой боломж тооцоолох хялбар аргуудыг туршиж, арга зүйгээ бусдад түгээх, сайжруулах, багаар хамтран ажиллаж үр дүнд хүрэх

Туршилт судалгааны зорилт

- Цифртэй холбоотой боломж тооцоолох бодлогыг хялбар заах арга зүйг сонгон турших
- Цифртэй холбоотой боломж тооцоолох бодлогыг бодох хялбар арга зүйгээ судалгаат хичээлийн үр дүнгээр тооцож, дүгнэлт гаргах
- Багш нараас санал асуулга авч үр дүнг тооцон, түгээн дэлгэрүүлэх

Хэрэгжүүлсэн хугацаа ба хамарсан хүрээ:


	<i>Сонгосон арга</i>	<i>Хаана</i>	<i>Хэн хамрагдсан</i>
2009-2014 он, Судалгаат хичээл-1	Үржүүлэхийн дүрэм		259 сурагч /4,5-р анги/
2014-2017 он, Судалгаат хичээл-2	Хүснэгтийн арга	ДУА-ийн ОИЦ сургууль, Энэрэл цогцолбор	472 сурагч, 100 гаруй багш
2017-2019 он, Судалгаат хичээл-3	Хүснэгтийн арга	сургууль, Орхон сум 8-р сургууль	1030 сурагч, 65 багш
2019-2021 он, Судалгаат хичээл-4	Хүснэгтийн арга, цахим		363 сурагч, 351 багш
2021-2022 он, Судалгаат хичээл-5	Хүснэгтийн арга, интерактив		

Судалгаат болон туршилтад хичээлүүдийг 2009-2021 онд заан туршиж, туршилтын явцдаа зөвлөн тусалсан ахмад багш нар, арга зүйч, сургалтын менежерүүд, хичээлд судалгаа хийсэн багш нарын санал зөвлөгөөг тусган, хөтөлбөрөө сайжруулах, хэрэглэгдэхүүнээ шинэчилж өөрчлөх, дасгал даалгавар, ажлын хуудсаа тухай бүрд боловсронгуй болгох замаар мэдлэг бүтээлгэх үйл ажиллагаа явууллаа. Мөн 3-р ангиас тооцоолол ихэсдэг учир өмнөх хоёр арга (мод ургуулах, тоочин бичих) -тайгаа хүснэгтийн аргаа хослуулан хэрэглэх нь үр дүнтэй байсан.

Судалгаат хичээлүүдийн үнэлгээ

Судалгаат хичээлүүдэд бага боловсролын багш нарын 10-12 хүний бүрэлдэхүүнтэй баг үнэлгээ дүгнэлт хийдэг бөгөөд багийн гишүүдийн үнэлгээ, дүгнэлтийг нэгтгэж үзэхэд туршилт 3-аас туршилт 5-ын хооронд хичээлийн агуулга, багшийн заах арга зүй гэх мэт сургалтын технологийн элементүүд судалгаат хичээлийн үе шат бүрт ахисан байгааг доорх зургаас харж болно.

Зураг 1. Судалгаат хичээлүүдийн үнэлгээ




Зураг 1-ээс харахад 2014-2017 оны судалгаат хичээлд цифртэй холбоотой бодлогыг заахад хичээлийн цагийн төлөвлөлт 57 хувь байсан бол хүснэгтийн аргаар зааснаар 2020-2021 оны судалгаат хичээлд 95 хувь болж өссөн байна. Мөн сурагчдын өмнөх төсөөлөл 65-аас 92 хувь, хичээлийн хэрэглэгдэхүүний ашиглалт 53-аас 98 хувь, багшийн заах арга зүй 70-аас 98 хувь болж тус тус өссөн байгаа нь боломж тооцоолох бодлого бодох арга зүйн туршилтууд үр дүнтэй болсныг харуулж байна.

Туршилтын ба хяналтын бүлгийн сорилын үр дүн

Оюуны ирээдүй цогцолбор сургуулийн 2020-2021 оны хичээлийн жилийн 6-р ангийн математикийн сонгоны хоёр бүлгээс авсан сорилын гүйцэтгэлийг харьцуулсан үр дүнг зураг 2-т харуулав. 3-5-р ангидаа “хүснэгтийн аргыг өмнөх хоёр арга (мод ургуулах, тоочин бичих)-тай хослуулан заалгасан” туршилтын, “уламжлалт арга” (мод ургуулах, тоочин бичих)-аар заалгасан хяналтын гэсэн ялгаатай 2 бүлгийг сонгон сорилын анализыг дунд ангийн сургалтын менежерээс авч үр дүнг нэгтгэв.


Зураг 2. Туршилтын ба хяналтын бүлгийн сорилын үр дүн (6-р анги)



Залуу багш нараас авсан асуулгын товч үр дүн

Бид бусад залуу багш нарт ахмад багш нараас суралцах хэрэгцээ байдаг эсэх, тэднээс ямар чиглэлийн тусламж дэмжлэг авах нь илүү шаардлагатай байдаг талаар доорх асуулгад авч, өөрсдийн үр дүнтэй харьцуулсан болно. Асуулгад Дархан-Уул аймгийн Дархан, Шарын гол сум, Хөвсгөл, Баянхонгор аймаг, Улаанбаатар хотод ажиллаж буй 1-5 дахь жилдээ ажиллаж байгаа 78 багш хамрагдлаа.

Зураг 3: Зөвлөн туслах хэлбэр



Залуу багш нарын үзэж байгаагаар ажлын байран дээр гараад ахмад багш нараас зөвлөгөө дэмжлэг авах, оюутан байхдаа төгсөх курстээ ахмад багш нараас дэмжлэг, тусламж авах гэсэн 2 сонголтод бараг ижил хувь (48.1 ба 51.9 хувь)-тай хариулсан нь багшаар бэлтгэгдэж буй их дээд сургуулиудын хувьд ч, ажлын байран дээр хүлээн авч буй ЕБС-ийн хувьд ч анхаарах асуудал юм. Өөрөөр хэлбэл, ахмад багш нарын зөвлөн туслах, дэмжих үйл ажиллагаа хэрэгтэй бөгөөд тэдний олон жилийн ажилласан дадлага, туршлага, үүрэг оролцоо нь багш бидний мэргэжил, арга зүйн өсөлт, хөгжилтөд маш чухал болохыг судалгааны дүн харуулж байна.

Дүгнэлт

Энэхүү илтгэлийг “Ахмад багшаас суралцсан цифртэй холбоотой боломж тооцоолох хялбар аргыг туршиж, арга зүйгээ бусдадаа түгээн, сайжруулж, багаар хамтран ажиллаж үр дүнд хүрэх” зорилгын хүрээнд бичсэн.

1. 2009-өөс 2022 он хүртэлх хугацаанд ахмад багшийн цифртэй холбоотой бодлого бодох хялбар арга зүйг байнга сайжруулан багаар хамтран амжилттай хэрэгжүүлж, тодорхой үр дүнд хүрлээ. Тодруулбал, ахмад (зөвлөгч) багш нарын зөвлөмж зөвлөгөөг тусган бусдадаа түгээн, цифртэй холбоотой бодлогыг “Хүснэгтийн арга”-аар бодох хялбар арга зүйгээ нийт багш-868, сурагч-2629, сургууль 6, эцэг эх 243, оюутан -35 нарт түгээн дэлгэрүүлж, 5 удаагийн судалгаат хичээл явуулсан.
2. Судалгаат хичээл заах явцад ахмад багш нар, БСГ-ын мэргэжилтэн, сургалтын менежерүүдийн ээлжит хичээлийн үе шат бүрд хийсэн судалгааг нэгтгэн дүгнэхэд төсөөлөл ба хичээлийн зорилго зорилт 27%, агуулга 10%, арга зүй 28%, цагийн төлөвлөлт 38%, үнэлгээ 34, хэрэглэгдэхүүн 45% -ийн ахицтай байна.
3. 2017 оноос эхлэн үр дүнгээ илтгэл, өгүүлэл болгон боловсруулж улсад ЭШХ -3 удаа, “Нээлттэй боловсрол 2017” “Нээлттэй цахим хэрэглэгдэхүүнийг ашиглан бага ангийн сурагчдын математик сэтгэлгээг хөгжүүлэх нь”, “Боловсролын тулгамдсан асуудал, шийдэл арга зам 2021” “Танхим ба цахим хичээлд хүүхдийн нас сэтгэхүйд тохирсон багшийн арга зүй чухал болох нь”, “Нээлттэй боловсрол

2021” “Танхимын ба цахим сургалтад багшийн арга зүй чухал болох нь” аймаг – 1 удаа 2020 он “Танхимын ба цахим хичээлд багшийн арга зүй чухал болох нь бүсийн “Сайн туршлага” 2018 он илтгэлд “Цифртэй холбоотой бодлогыг хүснэгтээр аргаар хялбар бодох нь”, Төвийн бүсийн лаборатори сургуулиудын зөвлөгөөнд 3 удаа хэлэлцүүлснээр 80 гаруй багш хичээл сургалтандаа энэхүү аргыг ашиглаж, эргэх холбоотой ажиллаж байгаа зэргээс үзэхэд сургалтын тодорхой арга зүйг ахмад багшаас суралцан хөгжүүлж, бусдадаа түгээн дэлгэрүүлэх зорилго биелсэн бөгөөд багш заах арга зүйн хувьд хөгжих боломжтой гэж дүгнэж байна.

4. Ахмад багш нар залуу багш нарт зөвхөн хэлж сургахаас илүүтэйгээр даган дуурайлгах, дэмжиж туслах хамтран ажиллах нь цаашид багш нарыг хөгжүүлэх, чадваржуулах үндэс болохыг бидний судалгааны үр дүн харуулж байна.

Судалгааны санал, зөвлөмж

- Багш багшаасаа суралцах (Япон багш нарын туршлагаас судлахад багш багшаа бэлтгэдэг, Ахмад багш нараасаа туршлага судлах ёстой гэж үздэг).
- Залуу багш нараас авсан судалгаанаас харахад багш бэлтгэж буй их дээд сургуулиуд тэтгэвэрт гарсан ахмад багш нарын баг бүрдүүлэн тусгайлсан анги танхим бэлдэж төгсөх курсын оюутнуудыг сургалт арга зүйгээр дадлагажуулах, ажлын байранд гарах багшлах дадлагыг үе шаттай зохион байгуулах нь зүйтэй.
 - Багшийн хөтлөх бичиг баримт
 - Онол, арга зүй
 - Анги удирдах
 - Харилцаа, хандлага , сэтгэлзүйг бэлдэх чиглэлүүдээр
- Дунд ахлах ангийн босоо холбоо гаргаж мэргэжлийн багш нартай хамтран ажиллах
- Амжилттай хэрэгжүүлж буй багш нарын арга зүйг бусад аймгийн багш нарт түгээн дэлгэрүүлэхэд дэмжин туслах

Ном зүй

Б.Бадамдорж,Ж. (2011). Бага боловсролын математикийн онол арга зүй. Цэцэрлэг хот.

Баатар,Ж. (2011). Бага ангийн багш гарын авлага II. Улаанбаатар: ОИЦ.

Ж.Баатар, А. Н. (2011). Бага ангийн багшийн гарын авлага II. Улаанбаатар: Бит пресс.

Ш.Ичинхорлоо. (2014). Багшийн ном. Улаанбаатар.

ЗАЛУУ БАГШ НАРЫН ТАСРАЛТГҮЙ ХӨГЖИЛД МЭРГЭЖЛИЙН БҮЛГИЙН ТУРШЛАГАТАЙ БАГШ НАРЫН НӨЛӨӨЛӨЛ

(Тусгай байр)

*Т.Гансүвд¹, Х. Пүрэвсүрэн², Э.Нацагсэвжид³, Т. Хэрлэнцэцэг⁴,
Г. Мармтуяа⁵, Д. Ганцэцэг⁶, Г. Өнөртуяа⁷, М. Нямхүү⁸
Хэнтий аймгийн Хэрлэн сумын ерөнхий боловсролын
лаборатори 1 дүгээр сургууль*

*tuvaangansuvd146@gmail.com¹, fpurevsuren@gmail.com², nacagsevzidenhbaatar@gmail.com³,
kherlentsetseg2015@gmail.com⁴, marttuya123@gmail.com⁵, gantsetseg4844@gmail.com⁶,
onortuya2@gmail.com⁷, minjnymkhuu@gmail.com⁸*

Хураангуй

Залуу багш нарт тулгарч буй бэрхшээлийг илрүүлж, асуудлыг шийдэх арга замыг эрэлхийлэх зорилгоор тандалт судалгааг ажиглалт, асуулга, ярилцлагын аргаар хийж, мэргэжлийн онолын мэдлэг, заах ур чадварын хувьд бэрхшээл тулгараад байгааг илрүүлж, шийдэх арга зам нь мэргэжлийн бүлгийн туршлагатай багш нартай хамтран ажиллах хэмээн тодорхойлсон. Тиймээс менежментийн R- PDCA циклд тулгуурлан мэргэжлийн бүлгийн хүрээнд 4 жил туршилт судалгаа хийснээр залуу багш нарын мэргэжлийн онолын мэдлэг 11 хувиар, заах ур чадвар 20 хүртэлх хувиар ахисан. Мөн сайн туршлагаа аймаг, бүсийн сургуулиудад түгээн дэлгэрүүлсэн.

Түлхүүр үг: мэргэжлийн өсөлт; мэргэжлийн бүлэг; туршилт; харьцуулалт; хэрэгжилт.

Оршил

Судалгааны үндэслэл

Ахлах ангийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд залуу багш нарт онол, арга зүйн хувьд бэрхшээл тулгарсан. Хэрэгцээ шаардлагад тулгуурласан үйл ажиллагааг судалж, туршин өөрсдийн хувь нэмрээ оруулах нь илтгэлийн сэдвийн үндэслэл болж байна.

Судалгааны шинэлэг тал

Залуу багш нар ажлын байрандаа тасралтгүй өсөж, хөгжихөд мэргэжлийн бүлгийн туршлагатай багш нарын нөлөөлөл хамгийн чухал байсныг 4 жилийн хугацаанд туршиж, үр дүнд шинжилгээ хийж, баталгаажуулаад түгээн дэлгэрүүлж эхэлснээрээ шинэлэг гэж үзлээ.

Судалгааны арга зүй

Залуу багш нарт тулгарч буй бэрхшээлийг 1-3 жил ажиллаж байгаа 60 багшаас асуулгын, судлагдахууны 7 залуу багшаас ярилцлагын аргаар тодруулж, түүнийгээ ажиглалтын болон онолын судалгааны аргаар баталгаажуулсан. Бэрхшээлийг шийдэх арга замыг хайж менежментийн R- PDCA циклд тулгуурлан мэргэжлийн бүлгийн 11 багшийн хүрээнд туршилт судалгаа явуулсан. Туршилтаа харьцуулалтын аргаар дүгнэсэн.

Судалгааны зорилго

Залуу багш нарт тулгарч буй бэрхшээлийг судалж, шийдвэрлэх арга замыг туршин, гарч буй үр дүнг тооцох

Зорилт

- Залуу багш нарт сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг судлах
- Тулгамдсан асуудлыг шийдвэрлэх туршилт судалгаа хийх
- Дүн шинжилгээ хийж, үр дүнг тооцох

Сэдвийн судлагдсан байдал

Судлагдсан байдлыг гаргахын тулд багшийн мэргэжлийн хөгжлийн бүлэгтэй холбогдуулан гүйцэтгэсэн АНУ, Австрали, Канад, Англи, Франц, Тайланд зэрэг улсын судлаачдын болон, бусад аймаг, сумдын туршлагыг эх сурвалж болгон ашиглаж, уншиж судалсан. Жишээлбэл: Судлаач Веннет судалгааны ажлаараа мэргэжлийн хөгжлийн бүлэг (МХБ) нь сурган хүмүүжүүлэгчдийн мэргэжлийн түвшний хамтын ажиллагаа, харилцан хамаарал, мэдээлэл солилцох боломжийг нэмэгдүүлдэг бөгөөд энэ нь суралцагчийн сурлагын болон хүмүүжил төлөвшлийн хувьд ахиц, амжилтад хүрэх магадлалыг нэмэгдүүлдэг гээд багшийн МХБ-ийн үйл ажиллагаа нь сурагчдын сурлагын амжилтад нөлөөлөх нөлөөллийг судалж, мэдэгдэхүйц ялгаатай өөрчлөлт байгааг статистик тоо баримтаар нотолсон байна.¹⁵

Онолын үндэс

Багшийн мэргэжлийн чадамж өсөхөд нөлөөлж буй хэд хэдэн хүчин зүйл байдаг. Эдгээрээс мэргэжлийн бүлгийн хамтын ажиллагаа нь олон талт мэдлэгийг богино цагт, нэг эх сурвалжаас, тасралтгүй авч болохоороо бусдаасаа давуу талтай байгааг дараах онолын хэсгээс харж болохоор байна. Столл нар “байнгын тасралтгүй явагдах, бүгдийг эрх тэгш хамруулсан, хамтын оролцоо ба эргэцүүлэлд суурилсан, суралцахуй болон мэргэжлийн өсөлтийг дэмжсэн арга замаар өөрийн үйл ажиллагааг бүтээлчээр эргэцүүлэн эрэл хайгуул хийх бүлэг хүмүүс”¹⁶ гэж тодорхойлсон байна. Мөн Ширли М.Хорд , Ричард ДуФор, Роберт Э.Эйкер нарын судалгааны дүгнэлтийг харгалзан үзэж, багшийн мэргэжлийн хөгжлийн бүлэг хэмээх ойлголтыг бүх гишүүд нь шинэ ойлголт буюу тулгамдсан тухайн нэг асуудалд төвлөрч, шийдлийг хамтдаа эрэлхийлж,

¹⁵ Отгонтуяа,Д., Оюун-Эрдэнэ,М., Оюунбилэг,Т. Багшийн мэргэжлийн хөгжлийн бүлгийг хөгжүүлэх зарим асуудалд.

¹⁶ мөн тэнд.

нээлттэй хэлэлцэж, шийдэлд хүрэх арга замыг боловсруулж, хүрэх үр дүнг төсөөлөн харилцан бие биеэ дэмжин ажилласны эцэст практик үр дүнд хүрдэг өндөр хариуцлагатай бүлэг гэж ойлгож болохоор байна.

Мөн Алсын хараа 2050-д “Багшийн мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг зөвхөн танхимын сургалтаар хязгаарлан ойлгож байгаа ба багшийг ажлын байрнаас нь хөндийрүүлэхгүйгээр орон нутгийн, сургалтын байгууллагын онцлог, хэрэгцээнд нийцсэн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих чанартай, шинэ арга хэлбэрүүд дутагдалтай байна”¹⁷ гэжээ.

Судалгааны хэсэг

Бид практик үйл ажиллагаагаа менежментийн R-PDCA циклд тулгуурлан хэрэгжүүлсэн. Үүнд:

Судлах (research) - төлөвлөх (Plan) - гүйцэтгэх (Do) - хянах (Control) - сайжруулах (Act)

Судлах шат (research)


- Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд залуу багш нарт мэргэжлийн мэдлэг, чадварын хувьд бэрхшээл тулгарч, дэмжлэг хэрэгтэй болсон.
- Тулгарч буй бэрхшээлийг мэргэжлийн бүлгээрээ ярилцлага, асуулга, ажиглалтын аргуудаар тодорхойлоход эх хэлний 7 залуу багшийн хувьд онолын мэдлэг (сорил шалгалт 63-70 хувийн гүйцэтгэлтэй), заах арга зүйн туршлага /хичээл заадаг ангийн сурлагын чанар, багш сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээлийг бүлгийн ярилцлагын аргаар/ бусад мэргэжлийн чадамжуудаас дутмаг байсан.
- Тулгарч буй бэрхшээлээ шийдэхийн тулд мэргэжлийн өсөлтөд нөлөөлөх хүчин зүйлийг онолын судалгааны аргаар тодруулсан.
- Багшийн өсөлтөд нөлөөлж болох хамгийн гол хүчин зүйл нь мэргэжлийн бүлэг буюу судлагдахууны багаараа хамтран ажиллах гэдгийг өөрийн сургуулийн туршлага, дэлхийн олон улс орны багшийн хөгжлийн стратеги баталж байна.

Төлөвлөх шат (Plan)

Дээрх судалгаанд үндэслэн бодлогын томьёолол буюу залуу багш нараа мэргэжлийн бүлгийн хамтын ажиллагааны хүрээнд хөгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөсөн. Мэргэжлийн бүлгийн залуу багш нарын хэрэгцээ шаардлагад тулгуурлан онолын мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Цугаараа хөгжье”, заах ур чадварыг хөгжүүлэх зорилгоор “Нэг багш нэг түгээлт”, “Багшийн багш” зэрэг туршилт судалгааг 2017 оноос эхлэн 5 жилийн хугацаанд туршлагатай багш нараа түшиглэн зохион байгуулсан.

¹⁷ Алсын хараа 2050

Схем 1. Мэргэжлийн бүлгийн хөгжлийн төлөвлөгөөний загвар



“Цугаараа хөгжье” мэргэжлийн онолын мэдлэгээ дээшлүүлэх туршилт

Улсын төрөлжсөн монгол хэл, бичгийн олимпиадын 2-ын давааны 11 алт, 1 мөнгө, 3-ын даваанд 1 мөнгөн медаль, 4 удаагийн тусгай байрын шагналт АБТА, Зөвлөх багш Г.Өнөртуяагийн чиглүүлгээр 5 жилийн хугацаанд монгол хэл, бичиг, уран зохиолын хичээлийн ахлах ангийн буюу хүнд, хүндэвтэр агуулгын хүрээн дэх онолын мэдлэгийг нэмэгдүүлэх зорилготой давтлагыг туршсан. Төлөвлөгөөний дагуу 14 хоногт нэг удаа 5 жилийн хугацаанд:

Хүснэгт 1. “Цугаараа хөгжье” туршилтад зарцуулсан хугацаа


Давтлагын хэлбэр	Нийт өдөр	Нийт цаг	Бүгд
Танхим хэлбэрээр	48	96 цаг (5760минут)	64 өдөр
Цахим хэлбэрээр	16	32 цаг минут ()	128 цаг (7680минут)

- “Цугаараа хөгжье” туршилтаар хийсэн ажлын чиглэл:
- Чиглүүлэгч багш хүнд, хүндэвтэр агуулгаар сургалт зохион байгуулах
- Мэргэжлийн чиглэлийн дасгал, даалгавар ажиллах
- Агуулгын хүрээнд хэлэлцүүлэг хийх
- Дараагийн хичээлийн чиглүүлэг, зөвлөгөө өгөх
- Бие даан ажилласан даалгавраа шалгуулах
- Ахиц амжилтыг тодорхойлох сорил, шалгалт авах
- Шалгалтыг засаж, үр дүнд үндэслэн багш бүрт тохирсон дасгал, даалгавар өгөх


Туршилтын үр дүн

Залуу багш нар ахлах ангид сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тулгардаг байсан бэрхшээлийг шийдвэрлэсэн. Энэ нь ярилцлагын аргаар болон сургалтын чанараар батлагдсан. Мөн багш нэг бүрийн мэдлэгийн хувь өссөн. Үүнийг ахиц амжилтыг үнэлэх сорилуудаас харж болно.


Зураг 1. Гарааны үнэлгээ



Зураг 2. Мэргэжлийн шалгалт, хөндлөнгийн үнэлгээний багш бүрийн ерөнхий дундаж



Зураг 3. Эх хэлний судлагдахууны багш нарын мэдлэг чадварын ахиц, амжилт



“Нэг багш - нэг түгээлт ” заах ур чадварыг хөгжүүлэх туршилт

Мэргэжлийн бүлгийн залуу багш нарын хувьд ээлжит хичээлийг төлөвлөх, заахад хүндрэл бэрхшээл тулгарч байсан болохоор зэргэд бүлгүүдэд багш нараа тэнцүү хуваан туршлагатай багш нараасаа суралцан ажиллах боломжийг эрэлхийлсэн. Мөн хөгжүүлэх төлөвлөгөө хийсэн.

Туршлагатай багш М. Сарнай “Үндэсний бичгийн хичээлийг заах арга зүй”, Д. Ганцэцэг “ Уран зохиолын хичээлийг заах арга зүй”, М. Ууганчимэг “ Монгол хэлний хичээлийг заах арга зүй” чиглэлээр дараах туршилтад үйл ажиллагааг зохион байгуулсан.

- 14 хоногт 1 удаа хэлэлцүүлэгт хичээл заах
- Туршлагатай багш нар 2 сард 1 удаа үзүүлэх хичээл заах
- Нэгж, ээлжит хичээлийг үр дүнтэй төлөвлөх аргад суралцах зөвлөгөө, зөвлөмж өгөх

Хүснэгт 2. Нэг багш – Нэг түгээлт туршилтын үйл ажиллагааны тоон үзүүлэлт

<i>Залуу багш нар</i>	<i>Хэлэлцүүлэгт хичээл заасан тоо</i>	<i>Хичээлд сууж, туршлага судалсан тоо</i>	<i>Зөвлөгөө авсан тоо</i>
Багш 1	39	104	54
Багш 2	38	101	67
Багш 3	32	90	61
Багш 4	29	125	69
Багш 5	18	80	88
Багш 6	12	78	58
Багш 7	12	79	63
Нийт	180	657	460

Туршилт судалгаа аймгийн хэмжээнд сайшаагдаж, бусад сургуулийн зүгээс зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулах санал тавьснаар дараах ЕБС-иудад 7 хоногийн хугацаатай очиж түгээн дэлгэрүүлсэн.

Хүснэгт 3. "Миний туршлага" үйл ажиллагааны мэдээлэл

<i>№</i>	<i>Туршлагаа түгээн дэлгэрүүлсэн багш</i>	<i>Хэдэн онд</i>	<i>Хаана</i>	<i>Ямар туршлага</i>
1	М. Сарнай	2017	Мөрөн сумын ЕБС	Үндэсний бичгийн хичээлийг заах арга зүй
2	М. Ууганчимэг	2018	Жаргалтхаан сумын ЕБС	Үндэсний бичгийн цахим бичвэр
3	Т. Гансүвд	2018	Хэрлэнбаян-Улаан тосгоны ЕБС	Сурагчдын ярих чадварыг хөгжүүлэх арга зүй
4	Г. Өнөртуяа	2019	Биндэр сумын ЕБС	ЭЕШ-д амжилттай бэлдэх арга зүй
5	Э. Нацагсэвжид	2019	Гурванбаян тосгоны ЕБС	Сурагчдын зохион найруулж бичих чадварыг хөгжүүлэх арга зүй

Туршилтын үр дүн

“Нэг багш- Нэг түгээлт” туршилтыг 5 жилийн хугацаанд мэргэжлийн бүлгээрээ сургуулийн болон аймгийнхаа бусад ЕБС-уудын хүрээнд туршсанаар дараах үр дүнгүүд гарсан.


- Массын сургалтын чанарт багш багшаас шалтгаалан 5-15 хувийн ахиц гарсан.
- ЭЕШ-ын дундаж оноо дээшилсэн.
- Аймаг, бүс, улсын чанартай олимпиад, уралдаан, тэмцээнд багш, сурагчид тасралтгүй амжилттай оролцсон.
- Монгол хэлний чанарын үнэлгээний шалгалтад аймаг, улсын дунджаас тогтмол дээгүүр шалгагдсан.
- Туршлагаа түгээн дэлгэрүүлсэн ЕБС-д тухайн чиглэлийн хүрээнд ахиц амжилт гарсан.

Г.Өнөртуяа багш “ЭЕШ-д амжилттай бэлдэх арга зүй” туршлагаа 2019 онд түгээн дэлгэрүүлж, цаашид хамтран ажилласнаар тухайн ЕБС-ийн ЭЕШ-ын дундаж оноо тасралтгүй ахисан байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 4. ЭЕШ дундаж оноо

2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он
489.3	531.1	594.5	579.5	585

Зураг 4 Массын шалгалтын дүн



“Багшийн багш” заах ур чадварыг хөгжүүлэх туршилт


Туршлагатай багш залуу багшаа хариуцан мэргэжлийн мэдлэг, чадвар, заах арга зүй, анги удирдах урлаг, сургалтын хөтөлбөр төлөвлөгөө боловсруулах зэрэг багшлахуйн бүхий л эрдэмд зөвлөн тусалж, багшийн багшийн болж ажилласан. Энэ үйл ажиллагаа нь эх хэлний мэргэжлийн бүлгийн нэрийн ажил болон олон жил амжилттай үргэлжилж байгаа. Туршлагатай багш нар ч мөн адил “Багшийн багш”нэрийн ажлын хүрээнд хөгжсөн.

Туршилтын үр дүн

“Багшийн багш” туршилтын үр дүнд залуу багш нар зөвхөн заах ур чадварын хувьд хөгжөөд зогсохгүй боловсролын баримт бичиг хөтлөх, анги удирдах, өөрийн шилдэг арга зүйтэй болох гэх мэт чадварт суралцаад явж байна. Туршилтын хугацаанд 7 залуу багшийн 4 нь заах аргач мэргэжлийн зэрэг, 4 нь арга зүйч цол тэмдэг, 2 нь багшийн алдар цол тэмдэг, 1 нь ЭЕШ 800 онооны эзэн, 3 нь аймгийн топ 10 багшийн нэг, 1 нь оны тэргүүний багш зэрэг шагнал урамшууллыг хүртсэн байна.

Туршилт судалгаанаас гарсан үр дүнгүүдээс жишээлэн үзүүлбэл: туршилтын хугацаанд Д.Ганцэцэг багшийн уран зохиолын хичээлийг заах “Семинарын хичээл” улирлын эхэнд амжилттай суралцах төлөвлөгөө буюу хичээл сургалтаа хэрхэн зохион байгуулах төлөвлөлтийг багш, сурагчид хамтран хийнэ. Сурагчид өөрсдийн сонгож авсан ээлжит хичээлийг төлөвлөн зааж, багш сүүлийн 15 минутад хичээлийг нэгтгэн дүгнэнэ. / арга зүйг багш нар уран зохиолын хичээл заахдаа 4 жил туршиж сургалтын чанараа 15 хувиар ахиулсан. Үүнийг нэгжийн үнэлгээ, хөндлөнгийн шалгалт, ЭЕШ-ийн уран зохиолын агуулгын гүйцэтгэлийн хувь, үнэлгээнээс харж болно.

Зураг 5. ЭЕШ-ын уран зохиолын хичээлийн агуулгад хийсэн анализ



www.stat.eec.mn ЭЕШ статистикаас авав. 2019 онд уран зохиолын агуулга задгай даалгавраар өгөгдсөн учраас статистикт байхгүй байна.

ЭЕШ-ын даалгаварт анализ хийхэд уран зохиолын агуулгын гүйцэтгэл хангалтгүй байсан учраас мэдлэг чадварыг ахиулах үүднээс тайлант хичээл арга зүйг туршсан нь үр дүнд хүрч 2018 оноос 2021 он хүртэл 8.4 хувиар ахисан байна.

Хянах, үр дүнг тооцох шат (Control)

Мэргэжлийн бүлгийн хүрээнд хамтран залуу багш нарын мэдлэг, чадварыг хөгжүүлэх “Цугаараа хөгжье, нэг багш – нэг түгээлт, багшийн багш” гэсэн 3 үйл ажиллагааг 5 жилийн хугацаанд туршиж хэрэгжүүлсний ач холбогдол буюу давуу тал дараах байдлаар илэрсэн.

- Туршилт судалгааны явцад 1 жилд 2 удаа ахиц, амжилтаа тооцох сорил шалгалтыг зохион байгуулж, үр дүнгээ хэлэлцэж, тухай бүрт нь үйл ажиллагаагаа засан сайжруулж байсны үр дүнд багш бүрийн монгол хэл, үндэсний бичиг, уран зохиолын онолын мэдлэг 7-24 хувиар ахисан.
- Заах ур чадварыг хөгжүүлэх “нэг багш – нэг түгээлт” туршилтын үр дүнд залуу багш нар ээлжит хичээлийг үр дүнтэй төлөвлөн заах аргад суралцаж, тасралтгүй хөгжүүлж байна. Багш бүр өөрийн гэсэн нэрийн арга зүйтэй болж, түүнийгээ улам сайжруулан түгээн дэлгэрүүлэх үйл явц руу шилжсэн. Туршлагатай багш нараасаа суралцаж, мэдлэг чадвараа ахиулан ажилласнаар аймгийн хэмжээнд түгээн дэлгэрүүлэх ажлыг 2017, 2018 онуудад сургуулийн туршлагатай багш нар зохион байгуулдаг байсан бол 2019 оноос залуу багш нар өөрсдийн арга зүй, туршлагаа түгээн дэлгэрүүлж эхэлсэн.
- Залуу багш нар мэдлэг, чадвараа хөгжүүлснээр заадаг ангийн сурлагын чанар 2017 оноос 2021 оны хугацаанд 5 - 13 хувиар ахисан.
- Багшийн багш туршилтын үр дүнд шавь байсан багш бусад залуу багш нарынхаа багш нь болтлоо хөгжсөн. Жишээлбэл М. Ууганчимэг багшийн шавь байсан Т. Гансүвд 4 жилийн дараа Т. Хэрлэнцэцэг багшийн багш болон хамтран ажиллаж байх жишээтэй.
- Мэргэжлийн бүлгийг хөгжүүлэх, мэргэжлийн бүлгийн хүрээнд хамтран ажиллахын хамгийн том давуу тал нь нэг эх сурвалжаас, олон талт мэдлэгийг, тасралтгүйгээр авч чадаж буй явдал.

Сайжруулах шат (Act)

Багшийн мэргэжлийн өсөлтөд дан ганц сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх мэдлэг, чадвар хамаарагдахгүй. Анги удирдах, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх гэх мэт олон чадамжууд багтана. Тиймээс бид 2022 оноос эхлэн мэргэжлийн бүлгээрээ хамтран дараах чиглэлээр туршилт үйл ажиллагаагаа улам сайжруулан ажиллахаар төлөвлөсөн. Залуу багш нараасаа технологид суурилсан буюу цахим хичээл бэлтгэх арга зүйг суралцах

- Ангитай болон хүүхэдтэй ажиллах ур чадвараа дээшлүүлэх
- Сурлагын хоцрогдол арилгах чиглэлээр ахмад багш нартайгаа хамтран ажиллах

Түгээн дэлгэрүүлсэн байдал

Хэнтий аймгийн Лаборатори 1 дүгээр сургуулийн нийгмийн ухаан, англи хэлний судлагдахууны багийн 16 багшид, аймгийн бусад ЕБС-ийн 5 судлагдахууны баг буюу 10 багшид туршлагаа түгээн дэлгэрүүлж хамтран ажиллаж байна.

Ерөнхий дүгнэлт

Залуу багш нар багшлахад олон асуудал бэрхшээл тулгардаг. Түүнээс нэн түрүүнд хөгжүүлэх шаардлагатай чадамж нь мэргэжлийн онолын мэдлэгээ дээшлүүлэх, хичээлээ хэрхэн төлөвлөж, үр дүнтэй заах арга зүйд суралцах гэдгийг судлагдахууны багийн болон бусад залуу багш нараас авсан судалгаа баталж өгсөн.

Залуу багш нарт тулгараад буй бэрхшээлийг хэрхэн шийдэж болохыг онолын судалгаа хийж, өөрийн сургуулийн судлагдахууны багийн туршлагад үндэслэн мэргэжлийн бүлгээрээ хөгжих нь хамгийн бодит, тасралтгүйгээр хөгжих оновчтой стратеги болохыг тодорхойлсон. Мэргэжлийн бүлгээрээ хөгжлийн төлөвлөгөө гарган түүнийхээ дагуу 3 туршилт үйл ажиллагааг 5 жилийн хугацаанд зохион байгуулснаар залуу багш нар мэргэжлийн онолын хувьд 24 хүртэлх хувиар ахиж, заах ур чадвараа хөгжүүлснээр сурагчдын сурлагын чанар 13 хүртэлх хувиар ахисан. Багш 1 хувиар ахихад түүний үр өгөөж нь сурагчдад нь шууд нөлөөлж байдаг гэдгийг энэ туршилт судалгаа баталсан.

Дэвшүүлж буй санаа

Залуу багш мэргэжлийн бүлгийн туршлагатай багш нарын дэмжлэгээр ажлын байрандаа тасралтгүй хөгжих боломж байгааг өөрсдийн туршилт судалгаагаар баталж, хэрэгжүүлэхийг санал болгож байна.

Ном зүй

Цэвэл, Я. (1966). Монгол хэлний тайлбар толь. Улаанбаатар.

Пүрэвдорж, Д. (2013). Багшлахуйн менежмент, ардчилал, зах зээлийн орчин дахь багшлахуйн онол, практик. Улаанбаатар

(2007). Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолт. Улаанбаатар.

Намжилдагва, Р. (2014). Сургалтын менежментийн онол арга зүй. Улаанбаатар.

БСШУЯ. (2019). Элсэлтийн ерөнхий шалгалтын тайлан. Сүүлийн 3 он. Улаанбаатар.

Ичинхорлоо, Ш. (2013). Судалгааны ажлын үндэс. Улаанбаатар: Соёмбо принтинг

Эрдэнэцэцэг,С., Батхуяг,С., Ичинхорлоо,Ш. ба бус Багш боловсролын үндэс. Улаанбаатар: Содпресс

Ичинхорлоо,Ш. (2013). Судалгааны ажлын үндэс. Б.10. Улаанбаатар: Эдмон

Сүрэнчимэг,Д. (2019). Зөвлөх багшийн арга зүй, туршлага. Улаанбаатар.

Мягмар,О. (2019). Судлаач багшийн гарын авлага. Улаанбаатар.

Исмаил, Боз. (2013). Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй. Улаанбаатар.

Отгонтуяа,Д., Оюун-Эрдэнэ,М., Оюунбилэг,Т. Багшийн мэргэжлийн хөгжлийн бүлгийг хөгжүүлэх зарим асуудалд эрдэм шинжилгээний өгүүлэл.

Дамдинсүрэн,Ц. Осор,Б. (1983). Монгол үсгийн дүрмийн толь. Улаанбаатар: Ардын боловсролын яамны сурах бичиг, сэтгүүлийн нэгдсэн редакцын газар.

Бинье,А. (2000). Арга зүйд суралцахуй II. Улаанбаатар.

(2021). Цэцэрлэг, ЕБС-ийн багш удирдах ажилтны эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл

(2020). Цэцэрлэг, ЕБС-ийн багш удирдах ажилтны эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл

(2017). Цэцэрлэг, ЕБС-ийн багш удирдах ажилтны эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл

ӨӨРИЙГӨӨ ХӨГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨГӨӨР АХМАД-ЗАЛУУ БАГШИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ

Л.Хишигт

Нийслэлийн Баянгол дүүргийн ерөнхий боловсролын

лаборатори 28 дугаар сургууль

l.khishigt@gmail.com

Хураангуй

Багшийн хөгжил нь багшийн боловсрол мэргэжлийн ур чадвар, сурган хүмүүжүүлэх арга зүйн мэдлэг, арга барил, үзэл бодол, харилцаа хандлага, сэтгэхүй, зан үйлтэй холбоотой бүхий цогц асуудал юм. Багш өөрийгөө хөгжүүлэхийн тулд мэргэжлийн үйл ажиллагааныхаа явцад “юуг, хэрхэн, хэзээ, хаана” өөрчлөн шинэчлэх вэ? гэдгийг нарийвчлан судалж, үр дүнтэй төлөвлөгөө гарган бүтээлчээр хэрэгжүүлэх хэрэгтэй. Залуу багш нарт ахмад, туршлагатай багш нар зөвлөн чиглүүлэх, харилцан туршлага солилцох, туршлагаа түгээн дэлгэрүүлэх, бүтээлч оролцоо зэрэг үйл ажиллагааг хийх нь ажлын байран дээрээ тасралтгүй хөгжих гол нөхцөл юм. Энэхүү үйл ажиллагааг багш өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөндөө тодорхой тусгаж уялдаа холбоотой ажиллах, төлөвлөгөөгөө бодитой хэрэгжүүлэхэд оршино.

Түлхүүр үг: багшийн хөгжил; өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөө; сурах; зөвлөх.

Оршил

Сурлагын хоцрогдлыг арилгах хэрэгцээ шаардлага үүссэн өнөөгийн нөхцөлд олон жилийн дадал туршлагатай ахмад багш нараас зөвлөмж, дэмжлэг авч уламжлал шинэчлэлээ хослуулан ажиллах нэн шаардлагатай байна. Ажил мэргэжлийнхээ хувьд “юуг-хэзээ-яаж” хөгжихөө бодитой, хүрч болохуйцаар төлөвлөсөн өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөө нь хувь хүн, хамт олны хөгжлийн түлхүүр байх ёстой. Гэтэл бодит байдал дээр ихэнх тохиолдолд багш нар “өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөө”-г жилийн эхэнд батлуулаад, үр дүнгүй тамгатай цаас болгон хадгалдаг нь энэхүү сэдвийг судлах нөхцөл боллоо.

Судалгааны зорилго

Багшийн “өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөө”-ны үйл ажиллагааг багшаас секцэд, секцээс нэгдэлд, нэгдлээс сургуулийн төлөвлөгөөтэй уялдуулж ахмад болон залуу багшийн хамтын ажиллагааг дэмжих, залуу багш нарын хөгжилд ажлын туршлагатай, ахмад багшийн зөвлөн туслах, багш нарын хамтын оролцоо, үр дүнг судалж шинжилгээ хийх.

Судалгааны зорилт

- Багш хөгжил, хөгжих боломжуудыг судлах
- Багшийн “өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөө”-ний үр дүн, бодит хэрэгжилтийг судлах
- Ахмад болон залуу багш нар хамтран ажиллах үр дүн, өөрчлөлтийг илрүүлэн, цаашид хамтран ажиллах арга хэлбэрийг тодруулах

- Багшийн өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөө, багш хөгжлийн төвийн төлөвлөгөө, сургуулийн үйл ажиллагааны төлөвлөгөөний уялдааг нэмэгдүүлэх

Судалгааны арга зүй

Асуулга, анкетын аргаар (google form) дээр бэлтгэж 200 багшаас авч, БГД-ын багш нараас ярилцлага, кейс буюу нөхцөл жишээн дээр анализ дүн шинжилгээ хийх, тандалтын аргаар авч нэгтгэв.

Дэвшүүлж буй санаа

Залуу багш болон ахмад багш хамтын ажиллагааг бодитой, үр дүнд хүргэхийн тулд багшийн төлөвлөлтөөс- секц- нэгдэл- сургууль гэсэн дараалалтай уялдуулж үр дүн нь багшийн хөгжил, хамтын ажиллагаа, сурагчийн хөгжил дээр нэгтгэгдэж байх нь чухал юм.

Онолын хэсэг (Багшийн хөгжил, хөгжих боломжууд)

Багш бидний хувьд хөгжил гэж юуг ойлгох вэ? Багшийн хөгжлийг дэмжих хуулийн 3.1.1-р зүйлд “Багшийн хөгжил” гэж багшийн мэдлэг, арга зүй, ур чадвар, боловсролоо дээшлүүлэх тасралтгүй үйл явцыг¹⁸ хэлнэ хэмээн тодорхойлсон.

<i>Ажилласан жил</i>	<i>Гол шинж</i>	
1-3	Шинээр эхлэх орчиндоо дасан зохицох, байр сууриа хайх, хөлөө олох, “нээлт хийх”	
4-6	Тогтворжих байр сууриа олох	
7-18	Туршилт “Идэвхжил”	Эргэцүүлэл “Өөртөө эргэлзэх”
19-30	Туйлшрал, тоомсоргүй хандлага	Хуучнаа хадгалж үзэх
31-41	Орчноос тасарч, хэт чөлөөтэй болох	

Багшийг хөгжлийнх нь хүрээгээр хөгжих бололцоотой багш- хөгжиж буй багш- хөгжсөн багш гэж ангилан үздэг. Мөн Америкийн эрдэмтэн В. Сандер “Багшлах ажилд дадах, тасралтгүй суралцах загвар”-аар Багшийн хөгжлийг Оюутан багшаас - Туршлагатай ахмад багш хүртэл 5 үе шат болгон ангилсан байдаг.¹⁹ 2021 онд батлагдсан чадварлаг багш хөтөлбөрт ахмад- залуу багшийн хамтын ажиллагааг тусгасан.

Ментор багш нь багшлах, бусад багш, тэр дундаа шинэ залуу багш нарыг дадлагажуулах, заан сургах буюу коучинг хийх, зөвлөн туслах ба шинэ залуу, туршлага багатай багш ажилдаа дадлагажин дасан зохицох, тэдэнд багшлахуйгаас гадна эерэг харилцаа, хандлага төлөвшүүлж, урам өгч дэмжих багш ахиц амжилтын өөрийн үнэлгээ хийх, хөгжлийн төлөвлөгөө гарган хэрэгжүүлэхэд ганцаарчилсан болон жижиг бүлгээр зөвлөн ажиллана²⁰ хэмээн заасан байна.

Багшийн хөгжлийг дэмжих хуулийн 10.1.1-р зүйлд “Багш нь хувь хүний санаачилга, бүтээлч үйл ажиллагаанд суурилсан бие дааж хөгжих богино, дунд, урт хугацааны

¹⁸ Багшийн хөгжлийг дэмжих хууль, 2018

¹⁹ <http://itpd.mn/article/460>


²⁰ “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө, 2021

төлөвлөгөөтэй байна”²¹, 10.4.Багш нь бүх шатны боловсролын сургалтын байгууллага, орон нутгийн боловсролын сургалтын байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөтэй хувийн болон сонирхлын бүлгийн хөгжлийн төлөвлөгөөг уялдуулна²² хэмээн тусгасан байдаг. Мөн Монгол улсын боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 1 дүгээр сарын 14-ны өдрийн А/07 дугаар тушаалын хавсралт “чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөнд багшийн өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөө хийж батлуулах тухайн заасан.

Судалгааны хэсэг


Залуу багшид тулгарч буй бэрхшээл, ахмад болон залуу багш нарын хамтран ажиллах боломж, өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөний бодит хэрэгжилтийг тодруулах зорилгоор google forms ашиглан нийт 200 багшаас авсан судалгааны үр дүнгээс:

Зураг 1. Багш нарын ажилласан жил



Судалгаанд оролцсон нийт багшийн 47% нь туршлагатай, ахмад багш нар, 53% нь залуу багш нар хамрагдсан.

Зураг 2. Залуу багш нарт тулгамдаж буй бэрхшээлүүд



Судалгаанд оролцсон нийт багш нарын хувьд залуу багш нарт тулгамдаж байгаа бэрхшээлийг нь заах арга зүй багшлах ур чадвар, сурагчидтай ажиллах арга барил, хөтөлбөр төлөвлөгөө боловсруулах, хичээл төлөвлөх чадвар, онолын мэдлэг дутуу гэж үзсэн байна.

²¹ Багшийн хөгжлийг дэмжих хууль, 2018

²² мөн тэнд

Зураг 3. Залуу багш нарын хүсэж буй дэмжлэгийн төрлүүд



Судалгаанд оролцсон нийт багш нарын хувьд 63% нь ахмад туршлагатай багш нарын зөвлөгөө зөвлөмж буюу ментор багш хэрэгтэй байдаг гэж үзсэн бөгөөд хамтын ажиллагаа чухал болохыг харуулж байна.

Зураг 4. Ахмад-залуу багшийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх боломжууд



Судалгаанд оролцсон нийт багш нарын хувьд 40% нь халамжлан хүмүүжүүлэгч багштай байх, ахмад багш нар хичээлд сууж зөвлөгөө өгөх чиглүүлэх нь чухал байна гэсэн санааг илэрхийлжээ.

Багшийн өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөнд хийсэн дүн шинжилгээ:

Залуу багш нар төлөвлөгөөнд тусгагдсан нийтлэг төлөвлөсөн ажил	Ахмад багш нар төлөвлөгөөнд тусгагдсан нийтлэг төлөвлөсөн ажил
- Арга зүйн зөвлөгөө авах - Ур чадвараа дээшлүүлэх - Мэргэжлийн сургалт семинарт хамрагдах - Хичээлийн хөтөлбөр төлөвлөлтөө хийх түүнийгээ сайжруулах - Онолын мэдлэгээ дээшлүүлэх нөхцөл - Олон талт чадвараа хөгжүүлэх	- Залуу багш нарт арга зүйн зөвлөгөө өгөх - Хичээл төлөвлөлтөд нь тусламж дэмжлэг үзүүлэх - Өөрийн туршлагаа бусдад хүргэх сургалт явуулах - Залуу багш нартай хамтран ажиллах - Интернэт орчинд залуу багш нараас сурах


28 дугаар сургууль болон БГД багш 50 багшийн өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөнд хийсэн дүн шинжилгээг авч үзвэл багш нар 2-5 чиглэлээр ажил төлөвлөснөөс 20%-46% нь арга зүй, ур чадвараа сайжруулахын тулд ахмад, туршлагатай багш нараас зөвлөгөө авах ажлууд төлөвлөгдсөн байна. Үүнээс үзэхэд багш нарын өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөнд ахмад залуу багшийн хамтын ажиллагаа нь СУРАХ-ЗӨВЛӨХ гэсэн үндсэн хүчин зүйл дээр нэгдэж байна.

Залуу багш миний боловсруулсан өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөнд 2 чиглэл 8 зорилтын хүрээнд 26 ажлаас 16 буюу 62% нь арга зүй, ур чадвараа дээшлүүлэх, ахмад туршлагатай багш нараас зөвлөгөө авах үйл ажиллагаа төлөвлөгдсөн байна. Үр дүнд хүрсэн, мэргэжлийн хувьд өсөлт гаргасан ажлаа шар өнгөөр тэмдэглэсэн бөгөөд 90% биелж байна. Үүнээс үзэхэд ахмад залуу багш нартай хамтран ажиллах, харилцан бие биенээсээ суралцах туршлагаа түгээх ажлыг зөв төлөвлөж сургуулиас энэхүү үйл ажиллагааг дэмжиж өгснөөр мэргэжил ур чадвар ахисан, анги удирдах арга барилд суралцсан зэрэг олон ахиц гарсан.

Нийт 74 ажил төлөвлөсний 8 буюу 11% нь багшийн хөгжлийг дэмжих ажил байна. Үүнээс 3 ажил буюу 37.5% нь ахмад залуу багш нарын хамтын ажиллагааг дэмжих, хамтран ажиллах, зөвлөн туслах, туршлагаа хуваалцах гэх мэт чиглэлээр төлөвлөсөн байна.

Ахмад залуу багшийн хамтын ажиллагааны талаар “Багшийн өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөө- Багш хөгжлийн Төвийн төлөвлөгөө- Сургуулийн үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд гарсан өөрчлөлтийг авч үзвэл:

Зураг 5. Сургуулийн төлөвлөгөөнүүдийн харьцуулалт




Ахмад болон залуу багш нарын өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөө, багш хөгжлийн төв, сургуулийн үндсэн төлөвлөлтийн уялдаа холбоо сайжирч эргэх холбоотой болсноор дараах үйл ажилгаануудыг БГД лаборатори 28 дугаар сургуулийн зохион байгуулаад байна. Үүнд:

- Багшийн хөгжилд чухал сургалтуудыг 7 хоног бүр нэг удаа олон чиглэлээр зохион байгуулдаг болсон нь багшийн олон талт чадварыг хөгжүүлж байна.

- Ямар чиглэлээр хэнээс сургалт авахыг багш нараас санал асууж, багшийн өөрийгөө хөгжүүлэх төлөвлөлтийг үр дүнтэй болгож байна. I улирлын амралтаар БШУЯ, БҮТ, БМДИ, АХМАД багш нартай хамтарсан 14 хоногийн сургалтыг зохион байгуулсан.
- Medle.mn болон бусад сайтад ахмад залуу багш нар хамтран хичээл оруулж байна
- Сургуулийн ахмад багш нар 1-5 дахь жилдээ ажиллаж байгаа залуу багш нараа дэмжих ур чадварын уралдааныг хувиасаа санхүүжүүлэн зохион байгуулсан бөгөөд жил бүр зохион байгуулахаар бусад багш нар дэмжээд байна.
- Олон төсөл хөтөлбөр хэрэгжиж байна.

Зураг 6. Сургалтын дараах сэтгэл ханамж



Багш нарын хэрэгцээ сонирхлыг хангасан сургалт, үйл ажиллагаа явуулах нь багшийн хөгжилд маш сайн нөлөөлсөн, ахмад багш нараас сургалт авч хамтран ажиллах нь үр дүнтэй байсан байна.

Дүгнэлт

Тэгвэл “Өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөгөөр ахмад-залуу багшийн хамтын ажиллагааг нэмэгдүүлж” багшийн хөгжлийг хэрхэн дэмжих боломжтойг онол практикийн үүднээс судалж дүн шинжилгээ хийн сургуулийн үйл ажиллагаанд нэвтрүүлснээр дараах дүгнэлтэд хүрлээ:

- Залуу багш нарт хамгийн түгээмэл тулгарч буй хүндрэл бэрхшээлийг залуу багш болон ахмад багш нарын зүгээс “заах арга зүй, багшлах ур чадвар, сурагчидтай

ажиллах арга барил, хөтөлбөр төлөвлөгөө боловсруулах, хичээл төлөвлөх чадвар, онолын мэдлэг дутуу” зэргээр тодорхойлсон. Энэхүү бэрхшээлээс гарах арга зам нь ментор багшийг томилох, багшийг хөгжүүлэх мэргэжлийн сургалтыг тогтмол зохион байгуулах, сургууль бодлогоор дэмжиж өгөх нь чухал, мөн сургууль бүр багш хөгжлийн төвийг бий болгож түүний үйл ажиллагааг идэвхжүүлэх, багш өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөндөө бэрхшээлийг давах арга замаа бодитой тусгаж өгөх хэрэгтэй байдаг нь харагдаж байна.

- Багш мэргэжлийн хөгжил нь насан туршид суралцах үйл явц бөгөөд “юуг-хэзээ-яаж” хийхээ тусгасан өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөө багш нарт зайлшгүй байх баримт бичиг юм.
- Залуу багш болон ахмад багш нарын өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөнд аль алинд нь 20%-46% нь залуу багшийг хөгжүүлэх зорилгоор хамтран ажиллах талаар тусгагдсан байдаг. Энэхүү үйл ажиллагааг бодитой, үр дүнд хүргэхийн тулд БАГШИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨС- СЕКЦ- НЭГДЭЛ- СУРГУУЛЬ гэсэн дараалалтай уялдуулж үр дүн нь багшийн хөгжил, хамтын ажиллагаа, сурагчийн хөгжил дээр нэгтгэгдэж байх нь чухал юм.
- Манай сургуулийн залуу багш нар өмнөх жилүүдэд хийгээд үр дүнд хүрдэггүй байсан өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөндөө ахмад багшаас сурах ажиллагааг илүү тусгаж өгсөн. Жишээ нь миний өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөнд 2 чиглэл 8 зорилтын хүрээнд 26 ажил төлөвлөсөн. Үүний 16 буюу 62% нь арга зүй, ур чадвараа дээшлүүлэх, ахмад туршлагатай багш нараас зөвлөгөө авах үйл ажиллагааг төлөвлөн түүнийгээ хэрэгжүүлсэн. Нийт өөрийгөө хөгжүүлэхээр хийсэн төлөвлөгөөний 90% үр дүнд хүрсэн байна. Үүнээс үзэхэд ахмад залуу багш нартай хамтран ажиллах, харилцан бие биенээсээ суралцах туршлагаа түгээх ажлыг зөв төлөвлөж сургуулиас энэхүү үйл ажиллагааг дэмжиж өгснөөр мэдлэг, арга зүй, ур чадвар дээшилсэн, мөн багаар ажиллах чадвар, ёс зүй, бусдыг ойлгож сонсох чадвар, анги удирдах арга барилд суралцсан зэрэг олон ахиц амжилт гарсан
- Сургуулийн хувьд ахмад залуу багшийн зөвлөх-сурах гэсэн хамтын ажиллагааг бодлогын хүрээнд дэмжсэн. Багш, заах аргын секц, нэгдэл (тэнхим), сургалтын албаны шат дараалсан, эргэх холбоотой хамтын үйл ажиллагаа сайжруулсан нь судалгаанаас болон бодит байдал дээрээс харагдаж байна. Ингэснээр манай сургууль багш нар ажлын байран дээр олон талт чадвараа хөгжүүлэх сургалтад хамрагдаж, ахмад багш нарын зөвлөх үйл ажиллагаа тогтмол авч, ур чадварын хичээлийг бүх багш нар болон залуу багш нарын дунд зохион байгуулан арга зүйгээ сайжруулж, ахмад туршлагатай багш нараасаа суралцаж байна. Үүний үр дүнд хичээл төлөвлөлт, цахим контент бэлтгэх ажилд хамтарсан баг болон ажиллах, хүүхдийн эрхийн тухай цуврал нэвтрүүлэг хийх, олон төсөл хөтөлбөр дээр багш нар хамтран ажиллаж хамтдаа хөгжиж байна. Мөн дан ганц залуу багш нарыг хөгжүүлээд зогсохгүй ахмад багш нар ч залуу багш нараас орчин үеийн техник технологи, цахим сургалтын талаар суралцаж уламжлал шинэчлэлээ хослуулан ажиллаж байна.

Ном зүй

- Алтанцэцэг,П. Байгалмаа,Ч. Ичинхорлоо,Ш. Ононтуул,Б. Мөнхбат,Э. Эрдэнэцэцэг,С. Энхжаргал,Б. (2010). Багш боловсролын үндэс.
- Байгалмаа,Ч. (2009). Багшийн хөгжлийн практик. Улаанбаатар.
- Баттогтох,Д. (2018). Боловсрол судлалын өгүүллүүд. Улаанбаатар.
- Бямбасүрэн,П., Сүрэнчимэг,Д. (2016). Багш бүр чиглүүлэгч. Лавай эрдэм шинжилгээний сэтгүүл
- Дэлгэржав,М. Багшийн хөгжил. (2018).
- Оюун,Ц. Түмэндэмбэрэл,Д. (2005). Багшийн хөгжил. Улаанбаатар.
- Пүрэвдорж,Ч. Багшийн менежмент. Улаанбаатар.
- (2021). “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө. Улаанбаатар.
- (2019). “Багшийн хөгжил” сэтгүүл. Улаанбаатар.
- (2020). “Багшийн хөгжил” сэтгүүл. Улаанбаатар.

СУРАГЧДЫН СУРЛАГЫН ХОЦРОГДЛЫГ НӨХӨХ, АРИЛГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ ХИЙХЭД АХМАД БАГШ НАР НӨЛӨӨЛӨХ НЬ

Б.Отгонцэцэг¹, Б. Наранцэцэг²

Нийслэлийн Багануур дүүргийн ерөнхий боловсролын лаборатори

“Боловсрол” цогцолбор сургууль

naraanarantsetseg99@gmail.com¹, otgoooo1012@gmail.com²

Хураангуй

Цаг үеийн нөхцөл байдлаас үүдэлтэйгээр БШУ-ны сайдын А/190 дүгээр тушаалын дагуу сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах төлөвлөгөө боловсруулах хэрэгцээ, шаардлага үүссэн. Төлөвлөгөө боловсруулахад залуу багш нарт тодорхой хэмжээний бэрхшээл тулгардаг мөн тэрхүү бэрхшээлийг даван туулахад ахмад багш нарын оролцоо шаардлагатай байгаа нь судалгааны дүгнэлтээс харагдаж байна. Тодруулбал: залуу багш нар туршлага дутмаг учир хоцрогдлоо хэзээ нөхөх, шинэ агуулга хэзээ үзэх, хэрхэн уялдуулах, агуулгаа яаж багцлах интеграцчилах талаар ахмад багштай хамтарч төлөвлөгөө боловсруулах нь зүйтэй. Иймд ахмад багшаас зөвлөгөө авч хамтран сургалтын үйлээ зохион байгуулж хэрхэн үр дүнд хүрснээ энэхүү илтгэлээрээ илэрхийлэхийг зорьсон болно.

Түлхүүр үг: сурлагын хоцрогдол; төлөвлөгөө; ахмад багш; залуу багш.

Оршил

Ковид-19 цар тахлын үеийн сургалтын хүртээмж хангалттай биш байгаа нь сурагчдын чанарыг бууруулахад нөлөөлж болзошгүй байна. 2021 оны 03 дугаар сард багш нараас асуулгын судалгаа авахад судалгаанд хамрагдсан 1140 багшийн 92.5% нь сурагчдын хичээл, сурлагын хоцрогдлыг 40-50%-тай гэж үзсэн байна. Дээрх судалгаанаас үзвэл цаг үеийн нөхцөл байдлаас үүдэн сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах, сурагчдын нийгэм, сэтгэл зүйн хэвийн байдлыг хангах, бусад асуудлыг шийдвэрлэхийн тулд цогц төлөвлөгөө хэрэгжүүлэх шаардлага тулгарсан нь харагдаж байна. Суралцахуйн үйл ажиллагаанд төлөвлөх, төлөвлөгөө боловсруулах үйл ихээхэн нөлөөтэй тул хамгийн түрүүнд сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөгөө сайтар боловсруулан сурагчдад оновчтой мэдлэг олгох нь зүйтэй юм. Төлөвлөгөө хийх явцад сурагчдын хоцрогдлыг хэрхэн арилгах, яг аль агуулга чухал болох, түүнийг ямар аргаар заахаа тодорхойлох, гол нь тухайн сурагчдын онцлогт таарч тохирсон ойлгомжтой, оновчтой, уялдаа холбоотой агуулга хэрхэн хүргэх зэргээ тусгах, мэдлэг, чадвар, хандлага талаасаа хөгжүүлэх гэх мэтчилэн багшаас мэргэжлийн өндөр ур чадвар, арга барил, туршлагыг нэхсэн олон асуудал, асуултууд тулгарч байгаа юм. Эдгээр нь ажлын туршлага нимгэн залуу багш нарын хувьд томоохон бэрхшээл болж байна. Яг энэ тохиолдолд ажлын туршлагатай ахмад багш нарын дэмжин туслах үйл ажиллагаа, нөлөөлөл, зөвлөгөө, хамтын ажиллагаа хэр хэмжээнд байгааг судлахаар энэ сэдвийг сонгосон.

Судалгааны зорилго

Сурагчдын сурлагын хоцрогдлыг оношилж, бууруулах төлөвлөгөө хийхэд залуу багш нарт тулгарч буй бэрхшээл, түүнд ахмад багш нар хэрхэн нөлөөлж байгааг тодруулахад судалгааны ажлын зорилго оршино.

Судалгааны зорилт

- Суралцагчдын сурлагын хоцрогдлыг оношлох, илрүүлэх
- Хоцрогдлыг хэрхэн бууруулах арга замыг тодорхойлох
- Хоцрогдол арилгах төлөвлөгөө боловсруулах, хоцрогдлыг бууруулахад ахмад багш нартай хэрхэн хамтран ажиллах арга замыг тодорхойлох

Шинэлэг тал

- Цаг үеийн нөхцөл байдалтай уялдсан
- Багш нарын одоо гүйцэтгэж байгаа ажил үүргийн бодит байдлыг тусгасан
- Боловсролын салбарт тулгамдсан асуудлыг хөндсөн

Үндсэн хэсэг

Боловсролын олон улсын ангилал (ISCED)-д тодорхойлсноор боловсрол нь хүний сурч боловсрох хэрэгцээг хангахад чиглэсэн, урьдчилан нарийвчилж төлөвлөсөн, системтэй үйл ажиллагаанаас бүрдэх ба боловсролын үйл ажиллагаа нь эрдэм мэдлэг олгоход чиглэсэн зохион байгуулалттай, тасралтгүй үргэлжлэх харилцаа холбоо юм. Монгол улсын “Боловсролын тухай” хуульд боловсролын үндсэн зарчим нь боловсрол эзэмшүүлэх арга, хэлбэр, суралцагчийн хэрэгцээ, хувийн болон хөгжлийн онцлогт нийцсэн олон хувилбартай, чөлөөтэй, нээлттэй байна гэж заасан байдаг. Төрөөс дэвшүүлж буй боловсролын зорилгыг хангахын тулд үндэсний, орон нутгийн, сургуулийн болон суралцагчийн бодит нөхцөл байдлыг харгалзан, бие даан хөгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах үйл ажиллагааг боловсруулан ажиллах нь багш бидний өдөр тутамдаа хийдэг үйл ажиллагаа юм. Багш хүний хамгийн гол хийх ёстой зүйл бол хүүхдээ судлах, ойлгох асуудал юм. Үүний тулд шинжлэх ухааны үндэстэй боловсруулсан сургалтын хөтөлбөрийг багш нарийвчлан судалж, өөрийн болгох хэрэгтэй. Үүнийгээ ээлжит болон нэгж хичээл дээрээ буулгаж, хүүхэд нэг бүрийнхээ онцлогт тохирсон агуулга, арга зүйгээр чиглүүлэх нь чухал болсон. Тэгвэл үндэсний хөтөлбөр, суралцахуйн удирдамж, сургуулийн түвшний сургалтын хөтөлбөр хоорондоо нягт уялдах ёстой. Үндэсний хөтөлбөр, суралцахуйн удирдамжийг багш бүр ширээний ном болгож, нэг бүрчлэн судалж, өөрийн болгож байж, сургуулийн түвшний хөтөлбөр боловсруулагдана.


Судалгааны үр дүн

Судалгаа 1. Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори “Боловсрол” цогцолбор сургуулийн ТНУ-ны ЗАН-ийн 1 ахмад багш, 8 залуу багш судалгаанд оролцсон болно. Судалгаанд ярилцлагын аргыг ашигласан. Ярилцлагын дүнг нэгтгэвэл:

Ахмад багш нарын нөлөөлж буй байдал	• Арга зүйн зөвлөгөө өгсөн. • Төлөвлөгөөний жишиг загвар харуулж, тайлбарласан. • Суралцахуйн зорилтод туссан агуулгуудын залгамж холбоог задалж тайлбарласан. • Төлөвлөгөөний ерөнхий бүтэц, чиглэлийг тус тус танилцуулав.
ТНУ-ны ЗАН-ийн багш нарын сайн туршлагаас	• Оношлохдоо нүсэр байх албагүй. Эхлээд өмнө жилийн агуулгаа цахимаар үзэж судалсан эсэхийг тандах. • Оношилгоондоо үндэслээд анги, сурагч тус бүрээр дүгнэлт гаргасан. • Дүгнэлтэд үндэслэн заах сэдэв, ойлгуулах агуулгаа тодорхойлсон.


Судалгаа 2. Бид сурагчдын сурлагын хоцрогдлыг оношилж бууруулах төлөвлөгөө хийхэд залуу багш нарт ямар ямар бэрхшээл тулгарч байгаа, түүнийгээ даван туулахад ахмад багш нарын нөлөөлөл, оролцоо хэр байгаа тухайд санал асуулга боловсруулж ерөнхий боловсролын сургуульд 1-13 дахь жилдээ ажиллаж буй залуу багш нараас авч үзлээ. Үүний үр дүнг товчоор танилцуулъя. Уг судалгаанд 256 багш хамрагдсан. Судалгааг анкетын аргаар авсан болно.

Зураг 1. Судалгаанд оролцогчдын ажилласан жил




Энэхүү судалгааны ажил нь сурагчдын сурлагын хоцрогдлыг оношилж бууруулах төлөвлөгөө хийхэд залуу багш нарт тулгарсан бэрхшээл, түүнд ахмад багш нарын нөлөө, зөвлөн туслах үйл хэр хэмжээнд байсныг тодруулахад чиглэгдэж байгаа бөгөөд асуулгад оролцогчдын ихэнх хувийг 2-4 дэх жилдээ ажиллаж байгаа буюу залуу багш нар эзэлж байгаа юм.

Зураг 2. Төлөвлөгөө хийхэд залуу багш нарт тулгарсан бэрхшээлүүд



Төлөвлөгөө хийхэд залуу багш нарын олонхд ямар нэгэн бэрхшээл тулгарч байсан байна. Тэдгээрээс дурдвал, арга зүйн мэдлэг, туршлага дутсан бэрхшээл давхардсан тоогоор 30-аас дээш хувь, цаг зав хомс - 46.2%, яаж хийхээ ойлгохгүй байсан бэрхшээл 25%, ахмад багш нарын зөвлөгөө дутсан бэрхшээл 16.7%-д тулгарсан байгаа юм. Эндээс харахад залуу багш нарын мэргэжлийн өсөлт, суралцах ба хөгжих, дадах үйл ажиллагаанд арга зүйн зөвлөгөө өгөх, туршлагаа хуваалцах ахмад багш нарын оролцоо чухал байгааг харж болохоор байна.

Зураг 3. Тулгарсан бэрхшээлийг даван туулсан байдал



Дээрх асуулгад дурдсан бэрхшээлүүдийг залуу багш нарын олонх нь онол, арга зүйн зөвлөмж, суралцахуйн удирдамж уншиж, өөрийн ойлгосноороо төлөвлөж даван туулсан гэсэн хариулт өгсөн байна. Мөн багаар ажилласан, сургалтын менежер болон ахмад багш нараас зөвлөгөө авсан гэсэн хариултууд иржээ. Бэрхшээл гэдэг бол залуу багш нарын хувьд цаашид өсөх, хөгжих, суралцах, ур чадвар, мэдлэгээ дээшлүүлэх, туршлагажих боломж болдог. Гол нь тулгарсан бэрхшээлийг оновчтой, зөв гаргалгаагаар давах туулах хэрэгтэй. Тиймийн тул багаар ажиллах, заавар зөвлөгөө авах, уншиж судалсны үндсэн дээр хийсэн төлөвлөгөө илүү үр өгөөжтэй, чанартай болох юм.

Хүснэгт 1. Төлөвлөгөөний хэсэгт ахмад багш нарын зөвлөн тусалсан байдал

Цаг төлөвлөхөд	9.5%
Оношлох төлөвлөгөөний суралцахуйн зорилтыг тодорхойлоход	26.2%
Хоцрогдол бууруулах төлөвлөгөөний суралцахуйн зорилтыг тодорхойлоход	10.7%
Оношлох, нөхөх арга тодорхойлоход	20.2%
Агуулга хоорондын залгамж тодорхойлоход	21.4%

Нөхөх, бууруулах агуулга тодорхойлоход	14.3%
Ээлжит хичээлийн төлөвлөлт хийхэд	13.1%
Багш, сурагчийн үйл ажиллагаанд	8.3%
Зорилго, зорилтоо тодорхойлоход	8.6%
Алхам тодорхойлоход	3.6%
Дээрх бүгд	8.3%
Бусад	25.0%

Судалгаанд оролцогчдын хариултаас харахад төлөвлөгөөний бүх хэсэгт ахмад багш нар их, бага ямар нэгэн хэмжээгээр зөвлөн тусалсан байна. Оношлох төлөвлөгөөний суралцахуйн зорилтоо тодорхойлоход, агуулга хоорондын залгамж тодорхойлоход, оношлох нөхөх аргаа төлөвлөхөд зөвлөн тусалсан гэсэн хариулт давхардсан тоогоор 20-с дээш хувийг эзэлсэн байна.

Судалгаанд үндэслээд нийслэлийн зөвлөлдөх багийн гишүүн "Зөвлөх багш", ахмад багш Б.Цэцгээтэй хамтарч хоцрогдсон агуулгыг илрүүлэх, 12 дугаар ангийн төгсөгчдөд давтлага өгөх, хоцрогдлыг нөхөх төлөвлөгөө боловсруулах ажлуудыг хийж тодорхой үр дүнд хүрсэн нь бидний цаашдын ажилд туршлага болж үлдсэн.

Орхигдсон агуулга илрүүлэх

2020-2021 оны хичээлийн жилийн 11 дүгээр сард хөл хорио тогтоосноор суралцагчдад хичээлийн хоцрогдол үүссэн. Дараах судалгааг авч агуулгын хоцрогдлыг илрүүлсэн бөгөөд судалгаандаа үндэслэн цахим хичээлийн агуулгаа төлөвлөсөн.

Үйл ажиллагааны алхам

- Судлагдахууны агуулга хэсэгт I улиралд судлахаар төлөвлөсөн агуулга буюу суралцахуйн зорилтуудын жагсаалтыг гаргана.
- Танхимын хичээлээр судалсан болон теле хичээлээр судалсан агуулгыг хүснэгтэд тэмдэглэнэ.

Хүснэгт 2. Судалсан агуулгын тэмдэглэлийн жишээ

Анги	Судлагдахууны агуулга	Агуулга		
		Танхимын хичээлээр судалсан	Теле хичээлээр судалсан	Орхигдсон
Х анги	-Нийгмийн бүтэц, тогтвортой тал -Нийгмийн онолууд -Нийгмийн институт -Нийгэмшилт -Нийгмийн гажуудал, хяналт -Нийгмийн судалгаа -Соёл, соёлыг бүрдүүлэгч элементүүд -Соёлын түгээмэл ба нийтлэг шинж -Соёлын ангилал -Хүний эрхэм чанар	-Нийгмийн бүтэц, тогтвортой тал -Нийгмийн онолууд -Нийгмийн институт -Нийгэмшилт -Нийгмийн гажуудал, нийгмийн хяналт -Нийгмийн судалгаа	-Нийгмийн бүтэц, тогтвортой тал -Нийгэмшилт -Нийгмийн судалгаа -Соёлын бүтэц -Соёлын ангилал	-Соёлын түгээмэл шинж -Хүний эрхэм чанар -Үндсэн хууль ба эрх зүйд захирагдах ёс -Иргэний эрх зүй -Хөдөлмөрийн эрх зүй -Захиргааны эрх зүй

-Үндсэн хууль ба эрх зүйд захирагдах ёс -Иргэний эрх зүй -Хөдөлмөрийн эрх зүй -Захиргааны эрх зүй -Нийгмийн хамгааллын эрх зүй			-Нийгмийн хамгааллын эрх зүй
--	--	--	------------------------------

Хоцрогдсон агуулгыг цахим хичээлээр нөхөх явцад багш нар Google forms, meet, zoom, teams гэх мэт программуудыг ашигласан. Энэ нь багш нарын цахим орчинд ажиллах чадварыг нэмэгдүүлсэн. Мөн цахим хичээлд хамрагдах боломжгүй сурагчдад гэрээр зочлох, хэвлэмэл материал тараах зэргээр орон нутгийн захиргааны байгууллагатай хамтарч ажилласан нь үр дүнтэй байсан.

"Нэг багш - нэг сэдэв"

Цаг үеийн нөхцөл байдалтай холбон сурагчдын сурлагын хоцрогдлыг арилгах давтлага өгөх үйл ажиллагааг дүүргийн Боловсрол цогцолбор сургууль, Гүн галуутай цогцолбор сургууль, Оюуны эрин цогцолбор сургуулийн түүх-нийгэм, газарзүйн мэргэжлийн багш нартай хамтран явуулсан.

Үйл ажиллагаа, зохион байгуулалт: Мэргэжлийн багш нарын цахим уулзалт зохион байгуулах, Дүүргийн мэргэжлийн багш нарын нэгдсэн facebook групп ажиллуулах, мэргэжлийн багш нар элсэлтийн ерөнхий шалгалтын шалгуулагчдад зориулсан зөвлөгөө өгөх, шалгалтдаа хэрхэн бэлтгэж амжилт үзүүлэх вэ? төгсөгчдийн зөвлөгөө, элсэлтийн ерөнхий шалгалтын блупринт судалж агуулгыг тодорхойлох, сэдвээ гаргах, давтлагын хуваарь гаргах, хуваарийн дагуу мэргэжлийн багш нар давтлагад оролцож хэлэлцүүлэг хийх, харилцан туршлага судлах, залуу багш нарт зөвлөн туслах,

Дээрх хамтын ажиллагааны үр дүнд: Нийгмийн ухааны хичээлээр улс, нийслэлийн дунджаас 14-16 хувиар дээгүүр үнэлэгдсэн болно. Тус Боловсрол цогцолбор сургууль нь дүүргийн дунджаас 2 хувиар дээгүүр үнэлэгдсэн байна.

Хоцрогдол оношлох, бууруулах төлөвлөгөө боловсруулах

Түүх нийгмийн ухааны зөвлөх багш Б.Цэцгээ залуу багш нарт БШУ-ны сайдын А/190 дугаар тушаалын талаар мэдээлэл сургалтыг явуулж, сурагчдын сурлагын хоцрогдол нөхөх, арилгах төлөвлөгөө боловсруулж загварчлалыг гарган заавар зөвлөгөө хүргэсэн. Түүний дагуу багаар хамтран ажиллаж төлөвлөгөөний хугацаа хийгээд анги бүрт хэрхэн хоцрогдлыг нөхөх талаар санаа бодлоо солилцон цаашдын үйл ажиллагаагаа тодорхойлсон. Төлөвлөгөөний дагуу суралцахуйн үйл ажиллагаагаа явуулж сурагчдын ахиц амжилтыг тооцон ажиллаж байна.

Сурагчдын сурлагын хоцрогдол арилгах төлөвлөгөөг боловсруулан батлуулж суралцахуйн үйл ажиллагааг явуулсан. Төлөвлөгөөний дагуу:


1. Хоцрогдол арилгах төлөвлөгөөний хэрэгжилт, сурагчдын ахиц амжилтыг тооцож буй байдал, цахим хичээл зааж байгаа арга туршлага, зайнаас хичээллэж буй сурагчидтай холбогдон ажилласан
2. Сургуульд суурилсан үнэлгээнд анализ хийн түүний мөрөөр ажилласан байдал.

11 дүгээр ангийн нийгмийн хичээл дээр сурагчдын хийсэн даалгаврын гүйцэтгэлд хяналт тавьж, дүгнэлт гарган агуулгыг тодруулсан.

Цаашид: Одоо ажиллаж буй ахмад багш нараас заавар зөвлөгөөг авахад тухайн багшид ажлын ачаалал болон цаг завьн байдлыг ажиглахад бага зэрэг хүндрэл байсан. Үүнийг шийдвэрлэхэд боловсролын байгууллагад 25-аас дээш жил ажиллаж байгаа багш нарын үндсэн цагийн тодорхой хувийг залуу багш нартай хамтран ажиллах цаг болгож өгвөл зүгээр санагдсан. (19 цагийн 15 цагийг нь хичээл сургалтын үйл ажиллагааны цаг болгон үлдсэн 4 цагийг залуу багш нартай хамтран ажиллах, арга туршлагаа хуваалцах цаг болгох)

Төлөвлөгөөг боловсруулахын тулд бид МУ-ын БШУ-ны Сайдын 2021 оны 08 дугаар сарын 03 сарын 18-ны А/88 дугаар тушаал “Хөтөлбөр батлах тухай”, 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/190 дугаар тушаал “Төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэх тухай” зэрэг баримт бичгүүдийг судалсан. Үүний үндсэн дээр хоцрогдол нөхөх, арилгах төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулсан.

Зураг 4. Үнэлгээ



Хувь хүний үйлдэл ба нийгмийн бүтэц, нийгэмшил, нийгмийн гажуудал гэсэн 3 сэдвийн хүрээнд шүүлэг авахад сурагчдын үнэлгээний дундаж нь 37.6% байсан. Сургалтын үйл ажиллагаа эхлээд сар хагас болсны дараа сургуульд суурилсан үнэлгээний шалгалт авахад сурагчдын дундаж үнэлгээ 51%-тай байсан. Хөтөлбөр хэрэгжээд дууссаны дараа 11 дүгээр сард шалгалт авахад сурагчдын үнэлгээний дундаж 66%-тай болж өмнөх сургуульд суурилсан үнэлгээнээс 15%-иар ахисан ахиц харагдаж байна.

Дүгнэлт

- Дэлхий нийтээр аюулт өвчний улмаас сурагчид суралцах анги танхимдаа очиж чадахгүй, улмаар цахимаар алсын зайнаас сурах үйл, ажлаа явуулсаар байна. Үүссэн онцгой нөхцөл байдлын улмаас танхимын сургалт хаагдаж теле болон цахимаар хичээллэсэн ч суралцагчдад сурлагын хоцрогдол үүссэн нь нэгэнт бодит байдал болоод байна.
- Суралцагчийн сурлагын хоцрогдлыг оношлох, нөхөх, арилгаж үр дүнд хүрэх нь багшийн ур чадвараас төдийгүй сургуулийн менежментээс шууд хамаарна.
- Монгол улс теле болон цахим хэлбэрээр хичээлээ үргэлжлүүлж байгаа нь боловсролын хуульд заасан “Боловсрол эзэмшүүлэх арга хэлбэр нь олон хувилбартай, чөлөөтэй, нээлттэй, тасралтгүй байна гэсэн” зарчмыг хангаж байна гэж үзэж болохоор байна.
- Залуу багш нарт олон бэрхшээл тулгардгийн нэг нь хичээлийн төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагаа байдаг. Энд ахмад багш нарын оролцоо чухал гэдэг

нь судалгаанаас харагдсан бөгөөд багш нарын хамтын ажиллагаа ус агаар мэт чухал болох нь мэдрэгдсэн. ЗАН-ийн ажлыг энд чиглүүлэх нь зүйтэй болов уу.

- Хоцрогдсон агуулгаа оношлох, нөхөхөд ямар арга зүйгээр хэрхэн яаж нөхөх вэ? гэдгийг төлөвлөх, тухайлбал: агуулгаа багцлах, интеграцчилах г.м
- Сурлагын хоцрогдол нөхөх, арилгах үйл ажиллагаа 2021-2022 оны хичээлийн жилээр зогсохгүй 2022-2023 оны хичээлийн жилд үргэлжлэх төлөв байдал ажиглагдаж байна.
- Боловсролын салбарт тохиолдсон энэхүү үзэгдлийг ЮНЕСКО “*нэгэн үеийнхний сүйрэл*” хэмээн тодорхойлсон.

Санал

Сургуулийн түвшинд:

- Ахмад болон залуу багш нарын залгамж холбоог сайжруулах
- Ахмад багш нарын сайн туршлагыг сурталчлах
- Залуу багш нарт зориулсан ахмад багш нарын сайн туршлага, гарын авлага, зөвлөмж, эмхэтгэл зэргийг хэвлэн гаргах, нийтийн хүртээл болгох
- Багшийн ажлын байран дээрээ хөгжих боломж, нөхцөл, орчноор ханган дэмжих

Дүүргийн түвшинд:

- Ахмад залуу багш нарын бүлгэм байгуулж ажиллах.
- Залуу багш, ахмад багш нарын хамтарсан зөвлөгөөн зохион байгуулах.
- Дүүргээрээ хамтран сурлагын хоцрогдол нөхөхөд чиглэгдсэн суралцагчдад зориулсан дасгал, даалгавар, гарын авлага гаргаж хамтран ажиллах

Ном зүй

Жамц,Л. (2013). *Ерөнхий сэтгэл судлал*. Улаанбаатар.

Цэндсүрэн,Ө. (2011). Амжилттай багшлахуй-III. Улаанбаатар.

Пүрэвдорж,П., Мөнхсэлэнгэ,П. (2019). Багшлахуйн менежмент. Улаанбаатар: "Мөнхийн үсэг"ХХК

<https://cdn.greensoft.mn/uploads/users/2649/files/Orders/Order%202021%20A-190.pdf>

АНГИ УДИРДАХАД АХМАД БАГШ НАРЫН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Р.Казиза¹, С.Энхзаяа², Т. Ардах³

Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын “Бастама” сургууль
rkaziza2016@gmail.com¹, enkhzaya5484@gmail.com², ashuknice@gmail.com³

Хураангуй

Багшийн мэргэжлийн өсөлтөд ахмад багш нарын залгамж холбоог сайжруулах, арга зүй, туршлагаа өвлүүлж түгээн дэлгэрүүлэх чин хүсэлтэй ахмад багш нар олон байдаг. Тийм учраас багшийн мэргэжлийн өсөлтөд ахмад багш нарын залгамж холбоог сайжруулах, хөгжүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх нь чухал хэрэгцээ шаардлага болж байна.

Түлхүүр үг: багшийн хөгжил; анги удирдах урлаг; ахмад багш-үнэт хөрөнгө; ур чадвар; туршлага; хамтын ажиллагаа.

Оршил

Хүнийг байгаль ба нийгмийн бүтээгдэхүүн гэж үзвэл нийгмийн бүтээгдэхүүний эхийг тавигч нь багш юм. Багш хүний үндсэн ажил нь сурагчдад мэдлэг, чадвар, амьдрах ухаан, төлөвшил олгож өв тэгш иргэн болгон төлөвшүүлэх юм.

Багшийн өөрийгөө хөгжүүлэх үйл ажиллагаа нь олон чиглэлтэй. Үүнд:

1. Өөрийн суурь мэдрэмжийг хөгжүүлэх
2. Сурган хүмүүжүүлэх сэтгэлгээ, ажилдаа хандах хандлага, харилцаа зэргээ өөрчлөх
3. Сурган хүмүүжүүлэх арга барил, ур чадвар, эв дүйгээ шинэчлэн боловсронгуй болгох
4. Өөрийн сурган хүмүүжүүлэх ёс зүйд байнга анхаарч төгөлдөржүүлэх
5. Багш хүн дан ганцаараа хүүхдийг сургаж, төлөвшүүлэх нь үр дүнд хүрэхгүй бөгөөд бусад багш нар болон эцэг эх, асран хамгаалагчидтай хамтран ажиллах
6. Өөрийгөө хөгжүүлэхийн тулд зөвхөн мэргэжлийн мэдлэг, ур чадвараас гадна нийгэм, эдийн засгийн, хууль эрх зүйн, улс төрийн мэдлэг боловсролоо байнга дээшлүүлж байх
7. Дэлхийн улс орны багш нар өөрийгөө хөгжүүлэх ямар арга барилтайг судалж ашиглах
8. Багш өөрийгөө хөгжүүлэх хамгийн гол арга зам бол сурган хүмүүжүүлэх судалгааны арга зүйг эзэмших явдал юм.

Судалгааны зорилго

Сургалтын үйл ажиллагаанд ахмад багш нарын оролцоог нэмэгдүүлэх, тэдний дуу хоолойг сонсох, идэвх санаачилгыг дэмжих, сурган хүмүүжүүлэх арга туршлагыг нь залуу үеийнхэнд өвлүүлэх зорилготой.

Судалгааны зорилт

- Ахмад багш нараас суралцах чухал хэрэгцээ байгаа эсэхийг судалж тогтоох
- Ахмад багш нарын анги удирдах арга туршлагаас залуу багш нарт түгээн дэлгэрүүлэхэд сургууль болон ахмад багш нараас туршлагыг нь хэрхэн ямар замаар хүргэх боломжуудыг судлах
- Ахмад багш нарын хичээлд сууж ажиглалт дүгнэлт хийх

Судалгааны арга

Цахим асуулга (Google forms), цахим хэлэлцүүлэг, ярилцлагын арга, ажиглалтын арга.

Онолын хэсэг

Ахмад багш гэж ямар хүнийг хэлэх вэ?

Ахмад багш нар боловсролын салбарын аль ч үед хүүхэд багачуудыг сурган хүмүүжүүлэх үнэт өв хэвээр ирсэн билээ. Багш хүн, багшийн мэргэжлийн онцлог нь насан туршдаа сурган хүмүүжүүлсээр, мэдлэгээ түгээсээр байдаг.

Энэ арга зүй, туршлагаа өвлүүлж, түгээн дэлгэрүүлэх чин хүсэлтэй ахмад багш нар олон байдаг. Аливаа сургалтын үйл ажиллагаа нь ахмад, дунд, залуу үеийн хэлхээнд уламжлагдах ёстой.

Сайн сурагчийг төрүүлдэг гол хүн бол анги удирдсан багш юм. Үүнээс үзэхэд “Анги удирдах” – үйл ажиллагаанд ахмад багш нарын арга туршлагыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, үр дүнд хүрэх арга замыг онцолж байна.

Анги удирдсан багшийн арга туршлага

Анги удирдсан багш нь ангийн сурагчдын сурлагын амжилт, хүмүүжил, төлөвшлийг шинжлэх ухааны үндэстэй удирдан чиглүүлдэг, сурагчдад биеэ авч явах соёл, харилцаа хандлага, ёс зүйгээрээ үлгэр дуурайлал болсон сурагчдыг зорилтдоо хүрэхэд нь зөвлөгөө өгч тусалдаг, тэдний дотны анд, туслагч, хамтран зүтгэгч байхын зэрэгцээ эцэг эх, сургууль, хүүхдүүдийг холбодог Монгол улсын ирээдүйг хариуцсан өндөр үүрэг хариуцлагатай боловсролын ухааны идэвхтэй судлаач хүн юм.

Судалгааны хэсэг

Тус сэдвийн хүрээнд 2021.10.05-2021.12.05 хүртэл интернэт орчинд цахим хэлэлцүүлэг, нээлттэй хичээл, ярилцлага, асуулга болон Ерөнхий Боловсролын Бастама сургуулийн багш нарын дунд ажиглалтын хэлбэрээр судалгааны ажлаа явуулсан.

Цахим хэлэлцүүлгээр:

Судалгааны ажлын явцад “Ахмад багш гэж хэн бэ?” гэсэн асуулт гарч ирсэн бөгөөд уг асуултанд хариулахын тулд цахим орчинд хэлэлцүүлэг хийсэн. Уг цахим хэлэлцүүлгээр “Ахмад багш гэдэг нь 25-аас дээш жил ажиллаж байгаа болон тэтгэвэрт гарсан, ажлын арвин туршлагатай бусдад үлгэр дуурайлал болохуйц багшийг хэлнэ” гэсэн дүгнэлтэнд хүрсэн.

Нээлттэй хичээлээр:

Сургуулийн хэмжээнд багшийн ур чадвар, заах арга барилыг хөгжүүлэх, нэг нэгнээсээ суралцах нөхцөл боломжийг хангах замаар “Багшлах ур чадвар”-ын тэмцээн явуулсан ба сургуулийнхаа 25-аас дээш жил ажиллаж буй бүх ахмад багш нарын хичээлд сууж тэдний туршлага, заах арга зүй, ур чадвараас суралцсан.

Хүснэгт 1. Ярилцлагын үр дүн

<i>Асуулт</i>	<i>Хариулт (одоо ажиллаж буй болон тэтгэвэрт гарсан 5 багшаас ярилцлага авсан)</i>	<i>Дүгнэлт</i>
Та залуу багштай хамтран ажиллахыг хүсдэг үү?	100% тийм хэмээн хариулсан.	
Залуу багштай хамтран ажиллах боломж хэр байдаг вэ?	Боломж бага, заримдаа ажлын ачааллаас хамаарч нөхцөл бүрддэггүй.	
Ахмад багш таны зүгээс хэлсэн аливаа үг, үйлдлийг залуу багш нар хэрхэн хүлээж авдаг вэ?	100% янз бүрээр хүлээж авдаг хэмээн хариулсан.	
Тантай байнга хамтран ажилладаг залуу багш байгаа юу?	Байгаа	Ахмад багш нар залуу багш нартай хамтран ажилладаг.
Та залуу багшийн аль чадварт нь илүү нөлөөлдөг гэж боддог вэ?	Арга зүй, ангитай ажиллах чадвар, бичиг баримт хөтлөлт, боловсруулалтад нөлөөлж чаддаг гэж боддог.	Дан ганц ахмад багш залуу багшид заан сургах, зөвлөх бус ахмад багш маань залуу багш нараасаа суралцах боломжтой.
Таны бодлоор залуу багшийн хөгжилд ахмад багш нар ямар туслалцаа дэмжлэг үзүүлэх хэрэгтэй вэ?	Арга зүйн зөвлөгөө өгөх, аливаа цаг үед тохирсон зөвлөгөө өгөх	Харилцан суралцах, хөгжих боломжтой нь харагдаж байна.
Та залуу багштай ямар аргаар ажиллавал илүү үр дүнтэй гэж үзэж байна вэ?	Дэмжих, зөвлөн туслах, харилцан хамтран ажиллах чадвар, сургалтын арга, хүүхэдтэй ажиллах байдал зэргийг судалсан.	
Танд залуу багшаас суралцах зүйл гардаг уу?	Тийм гардаг.	
Та залуу багштай хамтран ажилласнаар, харилцан бие биенээсээ суралцсанаар ямар ямар үр дүнд хүрсэн бэ?	МХХТ, сүүлийн үеийн шинэ арга барилуудыг залуу багш нараасаа сурсан бол, хүүхэдтэй хэрхэн харилцах, эцэг эхтэй хэрхэн хамтран ажиллах, заах арга зүй, бичиг баримт хөтлөлт гэх мэтээр харилцан бие биенээсээ суралцаж байна.	

Хамтын хөгжил болон ажиглалт

Багш нар харилцан нэг нэгнээсээ туршлага солилцон суралцах анхны алхмыг тухайн байгууллага буюу сургууль нь үйл ажиллагаандаа тусгах нь хөгжихөд ихээхэн түлхэц болдог. Жишээ нь: манай сургууль багш хоорондоо хөгжих хуваарь гаргаж өгдөг. Үүнд:

1. Хичээл буюу судлагдахуун тус бүрээр хөгжих цагийг хуваарьт тусгаснаар заавал ахмад гэлтгүй нэг нэгнээсээ сурч хөгждөг.
2. Даваа гариг бүрийн үдээс хойш аль нэг багш өөрт байгаа сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаандаа хэрэглэж буй арга туршлагаасаа хуваалцаж, бусад багш нартаа түгээн дэлгэрүүлж сургалт явуулдаг (online-stopwatch, evalbee, pleakers, kahoot, nearpod, quiziz, google forms, emaze, гэх мэт программуудыг болон ангитай хэрхэн ажиллах, мөн сурагчидтай хэрхэн харилцах талаар арга туршлагаасаа хуваалцдаг).
3. НУЗАН, БУЗАН, БАЗАН гэсэн заах аргын нэгдлүүдээрээ нэг нэгнийхээ хичээлд суух замаар арга туршлагаа хуваалцдаг.

Анги удирдах арга барилыг ахмад багш нараасаа хэрхэн суралцах вэ?

Судалгаагаар авсан нийт 13 асуултаас чухал дүгнэлтэд хүргэсэн зарим асуултын хариултыг хүснэгт болон зургаар харуулав.

Хүснэгт 2. Ахмад болон залуу багш нар мэргэжлээрээ хамтран хөгжихийн тулд байгууллагын зүгээс ямар дэмжлэг хэрэгтэй вэ?

Санал	Хариултын тоо
Мэдэхгүй байна, байгууллагаас дэмждэггүй, байхгүй	11
Хичээлийн цагийг зохицуулах	7
Сургалт зохион байгуулах (ахмад, дунд, залуу үеийн багш нарын хамтарсан хичээл, нээлттэй хичээл, судалгааны хичээл, хамтран хөгжих цаг гэх мэт)	63
Санхүүгийн дэмжлэг үзүүлэх (ахмад багш нарт цагийн хөлс олгох гм)	8
Орон байр, орчин нөхцөлөөр хангах (сурах бичиг, МХХТ, компьютер гм)	11
Тусгай хуваарь бүхий цаг гаргаж өгөх	5
Тэгш хандах	1
Уралдаан тэмцээн явуулах	5

Дээрх хүснэгтээс үзэхэд төрөл бүрийн сургалтад хамрагдах хүсэлтэй байгаагаа ихэнх багш нар илэрхийлжээ.


Анги удирдах арга туршлагыг ахмад багш нараасаа суралцсан эсэх? гэсэн дараагийн асуултад дийлэнх нь буюу 60.4% нь “*тийм*” гэж хариулжээ.

Хүснэгт 3. Анги удирдах арга туршлагыг ахмад багш нараас суралцсан туршлага

Туршлага	Хариултын тоо
Үгүй, туршлага байхгүй, зөвлөгөө авч байгаагүй	30
Одоогоор ангигүй учир туршлага хуваалцаагүй	4
Ямар нэг байдлаар зөвлөгөө, сургамж авч хамтран ажилладаг. Үүнд:	76
1. Анги удирдах урлаг номыг уншиж судалж байсан	
2. Мэдэхгүй зүйлээ асуудаг	
3. Даасан ангийн хүүхдүүдтэй хэрхэн ажиллах талаар зөвлөгөө авдаг	
4. Хүүхдийн маш сайн төлөвшүүлэхэд ахмад багш нараас байнга суралцдаг	
5. Судалгаа авах, сурагчдын хэрэгцээ сонирхлыг судлах	
6. Туршлага	
7. Шинэ сэтгэлгээ	
8. Эцэг эх, асран хамгаалагчидтай хамтран ажиллах	
9. Найз шигээ дотно байх талаар	
10. Ангитайгаа хэрхэн ажиллах талаар	

11. Хүүхдийн сайн туслагч, зөвлөгч байх 12. Янз бүрийн зан араншин, амьдралын нөхцөл байдал өөр сурагчтай хэрхэн ажиллах	
13. Хүүхдийн ар гэрээр зочилсон. Эцэг эхчүүдтэй илүү ойр болсон, гурвалсан холбоо сайжирсан. 14. Тулгамдсан асуудлаар ахмад багш нараас зөвлөгөө авна 15. Сургалтын арга, хөтөлбөр төлөвлөгөө 16. Сурлагын хоцрогдолтой сурагчтай эерэг аргаар ажиллах 17. Сурагчдын сэтгэлзүйн талаар зөвлөгөө тусламж авах 18. Хүүхдийг таних гэх мэт	77

Асуулт 12: Сургалтын үйл ажиллагаанд ахмад багш нарын оролцоог хэрхэн нэмэгдүүлэх вэ? 3 хүртэлх зүйлийг сонгоно уу.



Хүснэгт 4: Сургалтын үйл ажиллагаанд ахмад багш нарын оролцоог хэрхэн нэмэгдүүлэх вэ?

Санал	Хариултын тоо
Цалин нэмэгдүүлэх нь зөв, урамшуулал олгох	10
Сургалт, яриа, туршлага солилцох, зөвлөгөө авах, нээлттэй хичээл орох зэргээр харилцан ажиллах	68
Боловсролын газрын арга зүйч нар болон сургуулийн захиргаанаас тодорхой төлөвлөгөө, удирдамж гарган зохион байгуулах	23
Ахмад багш нар ажиллахыг хүсэхгүй	6
Санал байхгүй, мэдэхгүй байна	5

Анги удирдах талаар ахмад багш нараас туршлага солилцсон байдал

Анги удирдан ажиллах, хүнээр хүн хийх, нийгэмшүүлэх, хүнлэг, энэрэнгүй нинжин сэтгэлтэй бие хүнийг төлөвшүүлэх нь анги удирдсан багш (АУБ)-ийн хувьд маш хариуцлагатай үүрэгт ажил юм. Тийм ч учраас багш хүн энэ хариуцлагаа ухамсарлаж шавь нартаа бүх талаараа үлгэр дуурайлал болохуйц ёс суртахуунтай иргэн байх хэрэгтэй. Ангиа сайн удирддаг багш нараас олон арван арга барилыг сонсож судалж үзсэнээ доор хэдэн жишээгээр дурдъя.

Туршлага 1

Нэгэн ахмад багш ангидаа нийгмийн идэвх гэсэн хүснэгтийг ажиллуулдаг. Ялангуяа 6-8 дүгээр ангид нь буюу хүүхдүүдийн шилжилтийн нас, мөн хамгийн их хөдөлгөөнтэй байдаг үед нь энэ хүснэгтээр дүгнэх нь тэднийг аливаа ажилд хариуцлагатай байх, үр

Туршлага 2

Туршлага 3

“Ангийн багш-эцэг эх-сурагч-сургууль” хоорондын холбоог маш сайн уялдуулан ажилладаг. Үүний нэг жишээ нь эцэг эхтэйгээ хамтран ажиллаж “Сайн үйлс” аяныг зохион явуулжээ. Уг аянаараа ангийнхаа эмзэг бүлгийн 2 айлд тусламж үзүүлсэн, эцэг эхтэй хамтран сургуулийн хашаанд мод тарьсан, ангийн сурагчдыг дагуулан байгууллагуудаар очиж ажилчдын үйл ажиллагаатай танилцсан. Мөн ангийн эцэг эхийн нэрэмжит “Спортын их наадам”-ыг сургуулийн эцэг эхчүүдийн дунд явуулсан. Эцэг эх-багш нарын “Нээлттэй өдөрлөг” явуулсан.

Туршлага 4

Туршлага 5

101

авчрах даалгавар өгсний үр дүнд их хэмжээний цэвэр цаас цугларсан байна. Эдгээрийг хайрцагт хийж ангидаа тавиад шалгалт авах болон ноорог цаас хэрэгтэй болох үед хэрэглэдэг болсон нь сурагчдын дуртай үед дэвтрээ урж хуудсыг нь цөөрүүлэх, шалгалт авах, цаас хэрэг болох үед нэг нэгнээсээ гуйж төвөг уддаг явдлыг таслан зогсооход ихээхэн нөлөөлсөн ажил болсон бөгөөд үүнийг ч хэд хэдэн багш нар ангидаа хэрэгжүүлсэн нь үр дүнтэй ажил болсон.

Дүгнэлт

- Энэ бүгдээс харахад залуу багш нар ахмад багш нараас байнга зөвхөн хичээл сургалтыг заах арга зүйд суралцах бус, анги удирдах ур чадварын талаар зөвлөгөө авч, хамтран ажиллах хэрэгцээ шаардлага байгаа нь харагдаж байна.
- Ер нь багшлах гэдэг нь багшаас зөвхөн хичээлээ үр дүнтэй, чадварлаг заахаас илүүтэйгээр сурагчидтайгаа илүү ойр дотно харьцаж, тэдний хүмүүжилд эергээр үлгэр дуурайлал үзүүлж, нийгэмд өөрийн гэсэн байр суурьтай, хүмүүнлэг, энэрэнгүй, бүтээлч иргэнийг хөгжүүлэн хүмүүжүүлэгч байхыг шаардаж байна. Энэ үүрэг нь анги удирдсан багшид бусад багшийг бодвол илүү их ногдож, үүнд нарийн ур ухаан, үүрэг хариуцлага шаардагдах нь тодорхой юм.
- Сайн удирддаг багштай ангид урам зориг болон хайр мэдрэгдэж байдаг.
- Хүүхдийг зөв хүн болгон төлөвшүүлэхэд эцэг эх багш нарын хамтын үйл ажиллагаа хамгийн чухал үүрэгтэй. Тиймээс ангиа удирдахдаа эцэг эхчүүдтэй хамтран ажиллахаас гадна ахмад туршлагатай багш нарын арга зүй ур ухаан, туршлагаас цаг тутамд суралцан өвлөн авч, уламжлал болгон өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, суралцах, хамтран ажиллах шаардлагатай болох нь энэхүү судалгаанаас харагдаж байна.

Ном зүй

Исмаил Боз. (2006 он). Анги удирдах урлаг. Улаанбаатар

Бадамханд,С. (2011). Анги удирдсан багшийн гарын авлага. Улаанбаатар

Жантэн Каяа. (2010). Багшид өгөх зөвлөгөө. Эмпати төв. Улаанбаатар.

Мягмар,О. (2013). Судлаач багшийн гарын авлага. Улаанбаатар

БШУЯ, Боловсролын хүрээлэн (2021) “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт” цэцэрлэг, ЕБС-ийн багш , удирдах ажилтны эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл.

“Боловсрол судлал” сар тутмын сэтгүүл

МЭРГЭЖЛИЙН БАГШ НАРЫН ҮР ДҮНТЭЙ БАГ БҮРДҮҮЛЭХЭД АХМАД БАГШ НАРЫН ОРОЛЦОО

П. Энхзаяа¹, Ү. Ариунзаяа²

Баянхонгор аймгийн Баянхонгор сумын ерөнхий боловсролын

“Эрдэнэмандал” сургууль

epurevdorj4@gmail.com¹, ariunzayaaa0912@gmail.com²

Хураангуй

“Чадварлаг багш” хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд багш хамтын ажиллагаагаар хөгжих ёстой гэсэн үндэслэлээр ковидын хоцрогдлыг нөхөхөд ахмад багш нарыг дэмжигч багшаар ажиллуулах хэрэгцээ шаардлага үүсээд байна. Энэхүү судалгаагаар ахмад багш нарт ямар чадамж байгааг судлах зорилго тавьж, өнөөгийн багшийн ажлын байранд багийн үйл ажиллагаанд доголдож байгаа асуудлыг шийдвэрлэх, ахмад багш нарын ямар давуу тал, нөөц боломжийг ашиглах вэ гэдгийг тодруулах зорилт дэвшүүлээ. Судалгаанд асуулгын, баримт шинжилгээний болон социометрийн аргуудыг ашиглан, шинэ үеийн суралцагсдын сэтгэлзүйн хандлагыг ойлгож ажиллах нь чухал болсон, үүний тулд багшийн ажлын байранд цалин чухал хэдий ч хамт олноосоо хүртэх сэтгэл ханамж түүнээс чухал гэсэн онолыг үндэс болгов. Шинэ үеийн хүүхэд хувийн асуудлыг нь ойлгож итгэл хүлээх багшийг хүсдэг, ахмад багш нар сэтгэл хөдлөлөө удирдах чадвар сайтай байх ба хамт олны дунд таатай харилцаа үүсгэдэг гэсэн дүгнэлтэд хүрлээ.

Түлхүүр үг: үр дүнтэй баг; шинэ үеийн хүүхэд; хүүхдийн итгэл олох; сэтгэлзүй чухал.

Оршил

Багшийн ажлын байрны үнэлэмж муу байгаагаас сайн хүүхэд багшийн мэргэжлээр суралцдаггүй, сурсан ч багшаар ажилладаггүйгээс жилээс жилд мэргэжлийн багшийн ажлын байранд шинэ төгсөгч ирэхгүй боловсон хүчний дутагдалд ороход хүргэж байна.

Тиймээс Монгол Улсын Засгийн газар 2021-2024 онд “Чадварлаг багш” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр мөрийн хөтөлбөртөө тусгасан. Үүний гол зарчим нь ажлын байрандаа хамтын ажиллагаагаар хөгжих ёстойг чухалчилсан.

Судалгааны хэрэгцээ шаардлага

Дэлхийн нийтийг хамарсан цар тахлын улмаас Монгол улсад сургууль боловсролын үйл ажиллагаа жил, сараар тасалдаж, сурлагын хоцрогдлыг нөхөж хэвийн үйл ажиллагаанд оруулахад багшийн ажлын байрны ачаалал нэмэгдэж мэргэжлийн багш нар, хүн хүчний нөөц боломжийг эрэлхийлэх, үр дүнтэй баг бүрдүүлж багаар хамтран ажиллах, багшдаа ч, хүүхдэдээ ч сэтгэлзүйн эерэг орчин бүрдүүлж дэмжлэг үзүүлэх дархлаа дэмжих зайлшгүй шаардлагатай. Иймээс тэтгэврийн багш, ахмад багш нарыг дэмжигч багшаар ажиллуулахыг төр бодлогоор дэмжихийг чухалчилж байна.

Судалгааны зорилго

Боловсролын шинэчлэлийн өнөөгийн нийгэмд багшийн ажлын байранд тавигдаж буй мэргэжлийн шаардлагуудыг тодорхойлж мэргэжлийн багш нарын үр дүнтэй баг бүрдүүлэхэд ахмад багш нарын ямар чадамж хэрэгцээтэй байгааг судлах.

Судалгааны зорилт

- Орчин үед Монголын боловсролын хөгжилд төдийгүй дэлхийн боловсролын хөгжилд багшийн ажлын байранд тавигдаж буй шаардлагуудыг судлан шинжлэх
- Багшийн ажлын байрны багийн үйл ажиллагаанд анализ хийж багийн үйл ажиллагааг сайнаас шилдэгт хөтлөхөд шаардлагатай элементүүдийг илрүүлэх
- Багшийн ажлын байранд үр дүнтэй баг бүрдүүлэхэд ахмад багш нарт байгаа давуу тал, нөөц боломжийг судлах.

Судалгааны ажлын шинэлэг тал

Хорин нэгдүгээр зууны боловсролын байгууллага, хувь хүн бүр:

Бүх орчинд багаар хамтран ажиллах. багийн гишүүд бүр бие биедээ бүрэн дүүрэн итгэдэг байх, багийн гишүүд бүр дотроо идэвхтэй, эрүүл зөв урсгалын маргаантай, бие биеийнхээ өмнө хариуцлага хүлээдэг байх нь багшийн ажлын байрны эн тэргүүний шаардлага байна гэж үзэж үр дүнтэй баг бүрдүүлэх асуудлыг судалсан байгаа.

Судалгаанд хэрэглэсэн арга:

Асуулгын арга, баримтын шинжилгээний арга, социометрийн арга.

Онолын хэсэг

Шинэ үеийн хүүхдийн сэтгэлзүйн онцлог, тэдэнтэй яаж харьцах вэ? Энэ хэсэгт орчин үеийн хүүхдийн сэтгэлзүйн онцлогийг шинжлэх харгалзан ямар асуудал дэвшүүлэх вэ? гэдгээ тодруулах шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээ мэдээллийг авч тавьсан.

Америкийн сэтгэл судлалын нийгэмлэгээс жил болгон явуулдаг Стрессийн судалгааны үр дүнд *шинэ үеийнхэн* өмнөх үеүүдтэй харьцуулахад хамгийн муу сэтгэлзүйн эрүүл мэндтэй үе бөгөөд дийлэнх буюу 91 хувь нь стресс болон сэтгэцийн асуудлаас болоод бие физиологийн болон сэтгэл зүйн хувьд ямар нэгэн өөрчлөлтийн шинж тэмдгүүд мэдрэгддэг болсон. Тухайлбал:

- 45% - Сошиал медиа байнга ашигласнаар ямарваа нэгэн мэдээ мэдээллийг сөрөг талаас нь тусган авч шүүмжлэлтэй ханддаг болсон.
- 38% - Сошиал медиа нь тэдэнд өөрийгөө голох, бусадтай өөрийгөө харьцуулах зэрэг таагүй мэдрэмж төрүүлдэг.
- 88% - Мөнгө санхүүгийн асуудлаас болж ихээхэн дарамт мэдрдэг.
- 64% - Байнга түгшүүрийн мэдрэмж авдаг.

Иймээс *шинэ үеийн суралцагсдын сэтгэл зүйн хандлагыг ойлгож ажиллах нь чухал болсон.*

Багшийн ажлын байранд багаар хөгжихөд юу чухал вэ? Энэ хэсэгт ахмад ба залуу багш нарын багийн үйл ажиллагаанд адил тулгамдаж байгаа асуудлыг илрүүлэх шинжлэх ухааны үндэслэлийг авч тавьсан.

Багшийн ажлын бүтээл нь ямагт *хамтын шинжтэй*, эцсийн үр дүн нь урт хугацааны дараа харагддаг. Аливаа ажлын үр дүнгийн 20-30% нь мэргэжлийн мэдлэг, ур чадвараас 70-80% нь харилцааны эв дүй, сэтгэл зүтгэлээс хамаардаг.

Ажилтнуудын 90% нь гүйцэтгэлийн үнэлгээг үр дүн муутай хэмээн боддог. Ажилтнуудын 74% нь байгууллагын дотоод улс төр ажлын гүйцэтгэлд нөлөөлдөг гэж үздэг. Эерэг сэтгэл хөдлөл нь боломжуудыг тэлж тэмүүлэх хязгаарын мэдрэмжийг төрүүлж оюун ухааныг задалдаг учраас шинэ чадваруудыг эзэмшихэд зоригжуулж нөлөөлдөг. Хошин мэдрэмжтэй байх нь хэрэгтэй.

Мэргэжлийн ур чадвартай багш гэж хэн бэ? Энэ хэсэгт ахмад ба залуу багш мэргэжлийн ур чадвар буюу хүүхэдтэй харьцах арга ухааныг харьцуулан судалж ахмад багш нарын нөөц боломжийг эрэлхийлсэн.

Багш үндсэн 3 механизмаар суралцагчдадаа нөлөөлж чадвал сургалт үр дүнтэй болох талтай. а) Татах байдлаар: Өөрийн хичээл зүтгэл, биеэрээ үлгэрлэх, үйл ажиллагаагаараа нөлөөлөх; б) Итгүүлэх байдлаар: Сайн ханддаг хүнийхээ үгэнд илүү анхааран ханддаг хүний сэтгэлзүйн онцлог байдаг. Үүн лугаа адил хайрлан байгаа багшийн үг бол суралцагч хүнд тун үнэ цэнтэй; в) Ухааруулах байдлаар: уяруулан дагуулж, ухамсарлуулан сэнхрүүлж, тодорхой сэдэл өдөөж чадна гэдэг багшаас маш их ур ухаан, чадварыг шаарддаг. *Сэтгэл зүйн* мэдлэг чухал байр суурьтай.

Эцэг эхчүүдтэй харилцан ойлголцох нь нэг төрлийн урлаг. Энэ хэсэгт ахмад багш нарын эцэг эхтэй харилцах арга барилыг илрүүлэх зорилго тавьсан.

Боловсролын үндсэн тулгийн 3 чулууг санах хэрэгтэй.

Эцэг эх, багшийн харилцааны ач холбогдол: Эцэг эх, багш нар нь хоорондоо нүүр тулан харилцдаг хүүхдүүд дараах зүйлийг хийх магадлал өндөр байдаг ба доорх өөрчлөлтүүд сурагчдад гардаг.


- Хичээлээ таслахгүй байдаг
- Гэрийн даалгавраа бүрэн хийдэг
- Өндөр үнэлгээ авахын төлөө эрмэлздэг
- Хичээл, үйл ажиллагаанд оролцоотой болдог
- Сургуулийн талаар эерэг сэтгэгдэлтэй

Судалгааны хэсэг


Шинэ үеийн хүүхэд ямар багшийг хүсдэг вэ?

Судалгаанд 10-12 дугаар ангийн нийт 105 суралцагчийг хамруулж 2 асуулгын хүрээнд дөрвөн хаалттай хариулт өгч сонголт хийлгэсэн.

Зураг 1. Суралцах эрхэм зорилгоо хэрэгжүүлэхэд ямар багш илүү тусалж чадна гэж бодож байна?



Зураг 2: Дотно харилцаатай байж хувийн асуудлаар туслалцаа хүсэх шаардлага гарвал ямар багшид нэн тэргүүнд хандах вэ?



Дээрх судалгааны үр дүнгээс бидний цаашдын хайх асуудал нь:

- Мэргэжлийн үр чадвартай багш гэж хэн бэ?
- Ахмад, туршлагатай багшийн ямар чадамжийг залуу багш нарын мэргэжлийн үр дүнтэй багийн өсөлтөд оролцуулах вэ? Энэ асуудлыг олон өнцгөөс харж, хайж болно. Бид дараах өнцгөөс шинжилгээ хийж хайсан болно.

Баримт 1. Дэлхийн шилдэг багшийг ямар шалгуур үзүүлэлтүүдээр үнэлдэг вэ?

1. Хичээл сургалтын ажлын зэрэгцээ анги хамт олныг төлөвшүүлэх, нийгэмшүүлэх, иргэншүүлэх талаар хийсэн ажлын үр дүнд хамт олон, тэдний эцэг эх, гэр бүлд гарсан эерэг өөрчлөлт, хүмүүжлийн эерэг аргууд, шилдэг арга туршлага, түүнийг түгээн дэлгэрүүлсэн байдал,
2. Сургалтын үйл ажиллагааны мэдлэгийн үйлдвэрлэл нь сурагчдад хүнлэг энэрэнгүй, ёс зүйтэй, бусдад хүндэтгэлтэй хандах хүмүүжил, төлөвшилт олгож, дэлхийн иргэнийг бэлтгэхэд оруулсан хувь нэмэр юу болохыг тодорхойлсон байдал,

Эдгээр үзүүлэлтийг түлхүү анхаарч бидний онолын үндэстэй таарч буй бөгөөд бид дээрх хайж буй асуудалдаа холбон авч үзсэн.

Баримт 2. 2020 онд “Дэлхийн шилдэг багш” шагналыг хүртсэн Андриа Зафираку: 39 настай, 12 жилдээ ажиллаж байгаа, ядуу тосгоны сургуульд багшилдаг. Тэрээр

хүүхдийн “*итгэл*”-ийг олчихвол бусад бүх юм аяндаа болчихдог. Иймээс итгэлийг олохын тулд бүхий л цаг хугацаагаа зарцуулж эрэл хайгуул хийж толгойгоо гашилдаг гэж ярилцлага өгсөн байна. Энэ баримт бас бидний хайж буй асуудлын харах өнцөг гэж үзсэн.

Баримт 3. “Манай улс цээжлэх, давтах гэсэн доод эрэмбийн мэдлэг түгээж байгаа нь хамгийн том дутагдал” Сайд Л.Энх-Амгалан

Баримт 4. “Суралцагсдыг олимпиадад бэлтгэдэг биш амьдралд бэлтгэдэг боловсролын тогтолцоо бүрдүүлнэ” Сайд Л.Энх-Амгалан.

Эдгээр баримтууд нь бас бидний харах өнцөг гэж үзсэн.

Эдгээр сошиалд тавигдсан төрийн бодлого чиглэл нь нийгмээс цөөнгүй эерэг хандалт авсан байна. Иймээс: Багийн сэтгэлзүй, байгууллагын соёлыг бүрдүүлэхэд шаардлагатай элементүүдийг илрүүлэх зорилгоор

Багийн үйл ажиллагааг сайнаас шилдэгт хөтлөхөд ажлын байранд ямар асуудал дутагдалтай байна вэ? байна вэ?

“Дэлхийн түвшний монгол багш” хөтөлбөрийн үр дүнтэй багийн үйл ажиллагаанд мониторинг хийх арга аргачлалыг ашиглаж 20 өгүүлэмж бүхий сэтгэл зүйн судалгаа авч дүгнэлээ.

1.Багийн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн үнэлгээний сэтгэл ханамж:

Өгүүлэмж: 4, 6, 7, 10, 11, 12, 18

2.Багийн сэтгэлзүй, соёлын хандлага:

Өгүүлэмж: 1, 2, 3, 5, 8, 13, 14, 15

3.Багш мэргэжлийн ёс зүй, өөртөө хандах хандлага: Өгүүлэмж: 9, 16, 17, 19, 20.

Гүүглээр нийт 14 хоногийн турш байршуулж 65 багш хамрагдаж судалгааны үр дүнг өгүүлэмжүүдийн нийлбэрээр нэгтгэж багаар болон хувь хүнээр салгаж харсан.

Хүснэгт 1. Судалгааны дүн

<i>Үзүүлэлт</i>	<i>Залуу багш нар</i>	<i>Ахмад багш нар</i>	<i>Дүгнэлт</i>
Багийн ажлын гүйцэтгэл үр дүнгийн үнэлгээний сэтгэл ханамж	2.2	2.1	Нэлэнхийдээ сэтгэл ханамж тааруу байна.
Багийн сэтгэлзүй, соёлын хандлага	4.8	4.2	Удирдлагаас хамт олондоо санаа тавих, дэмжлэг үзүүлэх, сэдэлжүүлэх асуудал дулимаг
Багшийн мэргэжлийн ёс зүй, өөртөө хандах хандлага	5.9	4.8	Залуу нь илүү нийгмийн идэвхтэй, өөрийгөө хөгжүүлэх эрмэлзэлтэй.

Дээрх судалгааны үр дүнгээс харахад Багшийн ажлын байрны багийн үйл ажиллагаанд доголдолтой байж Багийн үйл ажиллагааг сайнаас шилдэгт хөтлөхөд шаардлагатай элемент нь: “*Багийн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн үнэлгээний сэтгэл ханамж*” гэдэг үзүүлэлт нь гарч байна.

Хүснэгт 2. Мэргэжлийн үр чадвартай багш гэж хэн бэ?

Үзүүлэлт	Залуу багш нар	Ахмад багш нар	Дүгнэлт
Би багш мэргэжилдээ эзэн байж чаддаг (Үнэхээр тийм)	22.7%	24%	Өөртөө итгэх өөрийгөө үнэлэх чанараар ойролцоо.
Би байнга суралцаж хөгжих шаардлагатай байдаг (Үнэхээр тийм)	38.6%	28%	Өөрийгөө хөгжүүлэх, нийгмийн идэвхээр залуу нь илүү.
Ажлын гүйцэтгэлд байгууллагын дотоод улс төр нөлөөлдөг (Огт үгүй)	7.5%	12.5%	Удирдлагатайгаа зохицож, хүндэтгэх чанараар ахмад багш нь илүү.
Хүүхдүүд миний итгэлийг төрүүлдэг (Үнэхээр тийм)	86.4%	96%	Ахмад багш нь Хүүхдийн сэтгэлзүйг ойлгож хүүхдийн итгэл хүлээх чанараар илүү
Орчин үеийн хүүхдийн ухамсар дорой (Үнэхээр тийм)	43.2%	24%	

Энэхүү судалгааны үр дүнгээс Ахмад туршлагатай багш нарыг хүүхэд “хувийн асуудлаар тусалцаа хүсэх”-ээр сонгохын учир нь “хүүхдэд хайртай, хүүхдийн итгэлийг олж чаддаг”-т байдаг гэж гарч ирлээ.

Багийн үйл ажиллагааны үр дүнгийн гүйцэтгэлийг дээшлүүлэхэд ахмад багшид ямар нөөц чадамж байна вэ? гэдэг асуудлаа олохын тулд: мөн “Дэлхийн түвшний монгол багш” хөтөлбөрийн ажлын байрны сэтгэл хөдлөлөө удирдах чадварыг оношлох арга зүйгээс хувь хүний ажлын байрны сэтгэлзүйгээ удирдах чадварын тест (Уур бухимдлаа удирдах чадвар, сэтгэл хөдлөлөө анзаарч ойлгох чадвар, аз жаргалаа үнэлэх чадвар) -үүдээс нэг нэг өгүүлэмж авч харьцуулсан үнэлгээ хийв. Харьцуулсан байдлаар хүснэгтээр харъя.

Хүснэгт 3. Ахмад багш нар сэтгэл хөдлөлөө удирдах чадвар сайтай эсэх

Өгүүлэмж	Залуу багш	Ахмад багш	Дүгнэлт
Би өөрийгөө хамгийн сайн найз шигээ өөртэйгөө ярьдаг (Байнга)	21%	36%	Сэтгэл хөдлөлөө анзаарч ойлгох чадвараар Ахмад нь илүү
Би өөрийгөө хангалттай, амжилттай, ухаалаг гэж мэдэрдэг (Байнга)	65%	87%	Уур бухимдлаа тайлах, тайвшрах чадвараар Ахмад нь илүү
Би хүмүүст эвтэйхнээр “Үгүй” гэж хэлж чаддаг (Хааяа)	29.2%	66%	Бусдыг ойлгох чадвараар Ахмад нь илүү
Би заримдаа стрестдэг (Хааяа)	36.2%	35.4%	Орчноо үнэлэх чадвараар ойролцоо
Би ажил, амьдрал, найз, нөхөд, хамтрагч гээд гаргасан шийдвэртээ итгэдэг (Ихэнхдээ)	28%	67%	Аз жаргалаа үнэлэх чадвараар Ахмад нь илүү

Ийнхүү эдгээр судалгааны үр дүнд ахмад багш нар нь сэтгэл хөдлөлөө удирдах чадвар өндөртэй бөгөөд

- Ажилдаа сэтгэл ханамжтай байх
- Хамтран ажиллагчдаа ойлгох
- Таатай харилцаа үүсгэх

Ажлын байранд үүсдэг элдэв асуудлыг тохиромжтой байдлаар шийдэх чадвартай.

1. Ахмад багш нар хамт олны дунд таатай харилцаа үүсгэдэг үү?

д/д	Социометрийн асуулга	Нийт сонгогдсон нэрс ба сонголтын тоо	Энд багтсан ахмад багш нарын нэрсийн тоо, сонголтын эзлэх хувь	Үр дүнгээс гарах Дүгнэлт
1.	Та байгууллагынхаа албан үүргийн чиглэлээр ажил мэргэжлийн зөвлөгөө авахыг өөрийнхөө тэнхимээс хэнд хамгийн түрүүнд хандах вэ?	50 хүний нэр 88 сонголт хийгдсэн.	8 хүний нэр сонголтын 51.14%	Ахмад багш нар хамт олон дотроо Аливаа асуудалд Зөвлөгч байдаг.
2.	Та тэнхимээрээ аялал зугаалгаар явах болбол хэн хэнтэй нэг гал болохыг хүсэх вэ?	64 хүний нэр 92 сонголт хийгдсэн	7 хүний нэр сонголтын 29.35%	Ахмад багш нар сэтгэл хөдлөлөө барьж хүлээцтэй ханддаг.
3.	Тэнхим дотор бичил баг үүсгэж Онигооны уралдаан зохиовол хэн хэнтэй нэг баг болохыг хүсэх вэ?	40 хүний нэр 66 сонголт хийгдсэн.	6 хүний нэр сонголтын 54.55%	Ахмад багш хамт олон дотор Хошин наргианч харилцаа үүсгэдэг.
4.	Та хувийн асуудлаараа харилцаа үүсгэж тусламж хүсэх шаардлага гарвал өөрийнхөө тэнхимээс хэн хэнд хамгийн түрүүнд хандах вэ?	36 хүний нэр 58 сонголт хийгдсэн.	7 хүний нэр сонголтын 72.41%	Ахмад багш нар Ажлын байрны үүсдэг элдэв асуудлыг тохиромжтой байдлаар шийддэг.
5.	Танд хэн нэгнээс ажил мэргэжлийн туршлага судалж тайлан хамгаалах үүрэг ноогдвол өөрийнхөө тэнхимээс хэн хэнд хамгийн түрүүнд санал тавих вэ?	44 хүний нэр 64 сонголт хийгдсэн.	9 хүний нэр сонголтын 89%	Ахмад багш нар Мэргэжлийн ур чадвараараа манлайлагч байдаг.

3. "Ахмад багш нар ажил мэргэжлийн ур чадвараараа манлайлагч" байдаг уу?

Судалгаанд Х.Очирхуяг багшийн 5 дахь жилдээ даан ажиллаж байгаа анги 10в ангийн 26 эцэг эхээс 21 нь хамрагдав.

№	Асуулга	Хариулт	Дүгнэлт
1.	Та хүүхдийн багштайгаа ямар хэлбэрээр харилцдаг вэ?	Утсаар-18 Фэйс группээр- 6 Нүүр тулсан ярилцлагаар- 15	
2.	Хичээлийн жилийн эхэнд ба эцэст хүүхдийн тань багш тантай зорьж уулздаг уу?	Тийм-20 Үгүй-1	Хувийн тохироо хийдэг. Гэр бүл бүрт хамгийн сайн тохирох аргыг олж судалдаг.
3.	Хичээлийн жилийн дундуур тантай хэдэн удаа биечлэн уулзсан бэ?	Нэг-7 Хоёр ба түүнээс дээш-14	
4.	Та хүүхдийнхээ эцэг эхийн хуралд оролцсон уу? Оролцсон бол жилд хэдэн удаа?	Нэг-8 Хоёр ба түүнээс дээш-9 Үгүй-4	Хуучинсаг арга барилаар Нэг талыг барьж ярьдаг.

5.	Эцэг эхийн хурлаар голчлон ямар асуудал яригддаг вэ? Шийдвэрлэсэн чухал асуудлаас санаж байгаа асуудал байна уу?	Сурлага, хүмүүжил, тэмцээн, уралдаанд оролцох		
6.	Таны хүүхдийнхээ АУБ-аас авсан мессэж, захидал, уулзалт яриа зэрэг харилцаанаас хамгийн их эерэг сэтгэгдэл үлдээсэн зүйл байна уу?	Үнэтэй зөвлөгөө өгдөг-10 Сэтгэлдээ баярлаж явдаг-3 Байхгүй-6 Мэдэхгүй-2	Эцэг түншлэлтэй.	эхийн

Дүгнэлт

1. Шинэ үеийн хүүхдүүдэд НОМ, ЭРДЭМ, МЭДЛЭГ эзэмшиж хөгжих хэрэгцээнээс илүү ГАНЦААРДАЛ, СЭТГЭЛ ГУТРАЛЫГ давах сэтгэлзүйн зөвлөгөө мэдээлэл өгдөг ХҮҮХДЭД ХАЙРТАЙ, ИТГЭЛ ХҮЛЭЭХ ЧАДВАРТАЙ багш хэрэгцээтэй болж энэ хэрэгцээг хангаж байвал МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАРТАЙ БАГШ гэж тодорхойлох болсон байна.
2. Үр дүнтэй баг бүрдүүлэхэд “Багийн үйл ажиллагааны үр дүнгийн сэтгэл ханамж”-ийг дээшлүүлэх нь нэн тэргүүний анхаарах асуудал байна.
 - Багийн үйл ажиллагааг САЙНААС ШИЛДЭГТ хөтлөхөд ахмад нарт:
 - Сэтгэл хөдлөлөө удирдах
 - Хамт олон дунд таатай харилцаа үүсгэх
 - Мэргэжлийн мэдлэг, ур чадвараараа манлайлах нөөц боломжтой байна.

Ном зүй

Дэлхийн түвшний монгол багш хөтөлбөрийн гарын авлага

www.gurunacademy.edu.mn

Түмэндэмбэрэл,Д., Оюун,Д., Дуламрагчаа,Т. (2009). Судалгаа хийх арга зүй. Улаанбаатар

Сумхомлинский “Багшид өгөх зуун зөвлөгөө”

Ц.Баатархүү. (2011). Зөв ярих ухаан. Улаанбаатар

ЗАЛУУ БАГШ НАР ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛААР АХМАД БАГШ НАРААС СУРАЛЦАХ НЬ

Б. Даваасүрэн¹, М.Бямбасүрэн²

Булган аймгийн Дашинчилэн сумын
ерөнхий боловсролын сургууль

Davaasuren0110@gmail.com¹, bymbuuka0427@gmail.com²

Хураангуй

“Ахмад багшаас асуух залуу багшийн 100 асуулт” сэдэвт үйл ажиллагааг Дашинчилэн сумын ерөнхий боловсролын сургуулийн багш нарын дунд төлөвлөн хэрэгжүүлсэн нь маш үр дүнтэй үйл ажиллагаа болсон учраас Булган аймгийн хэмжээнд 16 сумын ерөнхий боловсролын сургуулийн хүрээнд цахимаар зохион байгуулж үйл ажиллагааны үр дүнд цахим гарын авлагыг бүтээн түгээн дэлгэрүүлсэн. Цахим номон дахь ахмад багш нарын зөвлөгөө, арга туршлагаас хамгийн их давхцалтай тусгагдсан 4 агуулгыг сонгон Дашинчилэн ерөнхий боловсролын сургуулийн залуу багш нарын Түүчээ клубын үйл ажиллагаанд тусган ажилласнаар залуу багш нарын заах арга зүй ур чадвар сайжирсан нь маш олон үр дүнгээр батлагдаж байна.

Түлхүүр үг: багшийн хөгжил; ахмад багш нар; оролцоо; туршлага; арга зүй.

Оршил

Багшийн хөгжил бол боловсролын салбарын болон тухайн байгууллагын амжилтын үндэс юм. Тэгвэл багш хэрхэн хөгжих тухай асуулт урган гарч ирж байна. Бид залуу багш нарын төлөөлөл болох “Түүчээ” клубын 18 багшаас “Залуу багш та хэрхэн хөгждөг вэ?” гэсэн асуулт асуухад ахмад багшаас суралцах болон интернэт орчин ашиглан өөрийгөө хөгжүүлдэг гэсэн хариултыг ихэнх нь өгсөн.

Зураг 1. Залуу багш хэрхэн хөгждөг



Тиймээс эдгээр аргуудад тулгуурлан “Ахмад багшаас асуух залуу багшийн 100 асуулт” сэдэвт үйл ажиллагааг аймгийн хэмжээнд хэрэгжүүлж, үр дүнг тооцон ажиллахыг үндэс болголоо.

Судалгааны ажлын хэрэгцээ, шаардлага

Багш бол цаг ямагт хөгжиж байх ёстой мэргэжил юм. Ялангуяа залуу багш нарын хувьд хэрхэн хөгжих арга замыг тодорхойлох хэрэгцээ үүсээд байна. Тэрхүү арга замыг тодорхойлохын тулд судалгаа хийж, асуудлуудыг тодорхойлох, шийдвэрлэх шаардлага бий болж байна.

Судалгааны ажлын дэвшүүлж буй асуудал

Цаг хугацаа, орон зайнаас үл хамааран ахмад багш нарын арга туршлагаас суралцах боломжтой юу?

Судалгааны арга зүй

Санал асуулга, хэлэлцүүлэг, харилцан ярилцлагын арга, баримтад дүн шинжилгээ хийх, ажиглалт судалгааны арга

Зорилго

Орон зай цаг хугацаанаас үл хамааран ахмад багш нараас суралцах боломжийг олгох, түгээн дэлгэрүүлэх, залуу багш нарын сургалтын арга зүйг сайжруулах, сургалтандаа ашиглах, үр дүнд хүрэх

Зорилт

- Залуу багш нарт тулгамдаж буй асуудлыг тодорхойлох (Залуу багшийн асуулт)
- Асуудал тус бүр дээр ахмад багш нарын туршлагыг тусгах (Ахмад багшийн хариулт)
- Судалгааг нэгтгэн дүгнэж, туршлагыг түгээн дэлгэрүүлэх
- Сургалтын арга зүйг сайжруулах, баяжуулах

Онолын хэсэг

Сурган хүмүүжүүлэх ухааны нэрт эрдэмтэн Эрик Эриксон “Бие хүний хөгжлийн онол”-д насны үечлэлийг 8 хэсэгт хувааж үздэг²³.

1. Итгэх - үл итгэх: 0-1 нас
2. Бие даасан байдал – эргэлзээ: 1-3 нас
3. Санаачилга - гэм буруу: 4-5 нас
4. Бүтээлч - үнэ цэнэ муутай: 6-11 нас
5. Адилтгал – будлиан: 12-18 нас
6. Хайр халамж – ганцаардал: 18-22 нас
7. Бүтээлч - зогсонги байдал: 23-49 нас
8. Амжилтын тодрол – цөхрөл: 50- түүнээс дээш

Энэ үечлэлээс үзвэл хүн насан туршдаа хөгжиж байж бие хүн болон төлөвшиж байдаг. Өөрөөр хэлбэл “Хүн хүнээс төрсөн л бол хүн болдоггүй харин нийгмийн харилцаанд оролцож байж хүн болдог” Хүн төрөлхтний түүхэнд амьтадтай цуг өссөн хүүхдүүд тухайн амьтны зан авир, биеийн ерөнхий шинж ойролцоо болсон байдаг бөгөөд тийм ч удаан амьдарч чаддаггүй байна.

²³ Мягмар,О. (2007). Сэтгэл судлал. Улаанбаатар.

Үүнээс үзвэл “Багш мэргэжил эзэмшсэнээр багш болдоггүй харин өөрөө тасралтгүй хөгжиж, орчноосоо суралцсанаар багш болдог” гэж дүгнэж болохоор байна.

Судалгааны хэсэг

Туршлага түгээн дэлгэрүүлэх

- Дашинчилэн ЕБС-ийн залуу багш нарт тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлж, ахмад багш нараас арга зүйн зөвлөгөө авч, хэлэлцүүлэг зохион байгууллаа.
- Дээрх ажлын хүрээнд тэргүүлэх зэрэгтэй багшийн үзүүлэх хичээл зохион байгуулж, арга туршлагыг түгээн дэлгэрүүллээ
- Залуу багш нар судлагдахуун бүрийн ахмад багш нартай хамтран ажиллаж, заавар зөвлөгөө авч сургалтын төлөвлөлт үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүллээ.

Дээрх үйл ажиллагааг сургуульдаа хэрэгжүүлэхэд үр дүнтэй байсан тул Булган аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 20 ерөнхий боловсролын сургуулийг хамруулан “Ахмад багшаас асуух залуу багшийн 100 асуулт” сэдэвт үйл ажиллагааг эхлүүлсэн. Энэхүү үйл ажиллагаанд 16 сумын залуу багш нар хамрагдсан бөгөөд нийт 74 асуулт ирүүлсэн. Тэдгээрийг боловсруулж залуу багш нарт тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх арга замыг ахмад багш нараас туршлагаас судлан тодорхойлов. Судалгааны үр дүнг тооцож залуу багш нарт түгээн дэлгэрүүлэх зорилгоор цахим гарын авлага бүтээв.

Бидний энэхүү судалгаанд ирүүлсэн нийт 65 асуултыг ерөнхий агуулгаар нь ангилж үзвэл:

1. Төлөвшил хандлага,
2. Багшийн заах арга зүй, ур чадвар
3. Масс сургалтыг сайжруулах,
4. Бие даан ажиллах чадварт сургах,
5. Анги удирдах ур чадвар,
6. Хоцрогдол арилгах
7. Бие даан суралцах арга
8. Гэрийн даалгавар гэсэн агуулгуудад хамаарч байна.


Мөн нийт 74 асуулт ирүүлснээс утга давхцалгүй 60 төрлийн асуулт байгаа нь залуу багш нарт сурч мэдэхийг хүссэн маш их зүйлс буйг харуулж байна.

Хүснэгт 1. Судалгааны дүн

Асуултуудын агуулга	Хариултын тоо
Төлөвшил хандлага	13
Заах аргазүй	17
Масс сургалт	8
Гэрийн даалгавар	9
Хоцрогдолтой сурагчтай ажиллах	6
Бие даан суралцах арга	4
Анги удирдах урлаг	7
Бусад төрлийн асуулт	10

Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд асуулт тус бүрт олон жилийн туршлагатай ахмад багш нараас заах арга зүй, ур чадварын туршлага судалж хариулт авлаа. 8 агуулгын хүрээнд сум тус бүрт агуулга давхцахгүй байхаар тооцож асуултуудыг хуваарилсан. Тухайн сумын залуу багш нараас ирсэн асуултуудыг өөр сумдын ахмад багш нараас асуух хэлбэрээр зохион байгуулав.

Зураг 2. Ажилласан жил



Зураг 3. Мэргэжлийн зэрэг



Зарим сумд “Ахмад багш нараас асуух Залуу багшийн 100 асуулт сэдвийн хүрээнд хэлэлцүүлгийг хийж асуудлыг шийдвэрлэж чадсан.

Булган аймгийн Дашинчилэн, Хутаг-Өндөр, Баяннуур сумдын залуу багш нар ахмад багш нараас асуух 100 асуулт сэдвийн хүрээнд хэлэлцүүлгийг зохион явууллаа.

Цахим гарын авлага

“Ахмад багшаас асуух залуу багшийн 100 асуулт” үйл ажиллагааны хүрээнд давхцаагүй тоогоор залуу багш нарт тулгамдаж буй 65 асуудлын дагуу 36 ахмад багшийн хариултыг багтаасан цахим гарын авлага бэлтгэн Булган аймгийн ЕБС-ийн бүх сургуульд түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа зохион байгууллаа. Цахим номны холбоос <https://www.flipsnack.com/67EEBD77C6F/11.html>

Цахим гарын авлагыг сургалтад нэвтрүүлснээр

Мөн үйл ажиллагааны хүрээнд судлагдсан арга зүйг Дашинчилэн ЕБС-ийн багш нарт түгээн дэлгэрүүлэх, үйл ажиллагаанд тусган хэвшүүлэх, залуу багш нарын арга зүй, ур чадварыг сайжруулах зорилгоор цахим номонд хамгийн их давтамжтай тусгагдсан туршлага арга зүйн талаар судалж өөрийн сургууль дээр хэрэгжүүлж ажиллав. Үүнд:

- Самбар төлөвлөлтийн арга зүй
- Түвшинд тохирсон гэрийн даалгавар
- Унших чадварыг сайжруулах арга зүй
- Багшийн тасралтгүй хөгжил гэсэн 4 чиглэлээр үйл ажиллагаануудыг төлөвлөн зохион байгуулж байна.

Үйл ажиллагаа 1: “Дэвтэр бол сурагчийн толь” аян

Энэхүү аян нь улирал бүр уламжлал болгон зохион байгуулахаар төлөвлөж, нэгдүгээр улирлын аяны хүрээнд сурагчдын дэвтэр хөтлөлтийн зарчим болон шаардлагыг гарган мөрдүүлж, сургуулийн 1-12 дугаар ангийн 600 гаруй суралцагчийг хамруулж, цэвэр сайхан бичигтэн анги хамт олон, цэвэр бичигтэн сурагчийг шалгаруулав. Мөн энэхүү аяны хүрээнд “Шилдэг самбар төлөвлөлттэй багш”, “Цэвэр сайхан бичигтэн багш”

уралдааныг зохион байгуулж шагнаж урамшуулав. Тус уралдаанд бага боловсролын багш М.Бямбасүрэн (5 дахь жилдээ ажиллаж буй), А.Сувд-Эрдэнэ (6 дахь жилдээ ажиллаж буй), нар Шилдэг самбар төлөвлөлттэй багшаар шалгарсан нь залуу багш нар хөгжиж буйн илрэл юм.

Үйл ажиллагаа 2: Түвшинд тохирсон гэрийн даалгавар бэлтгэх

Нэгдүгээр улирлын сурагчдын амралтын хугацаанд суралцагчдыг 3-4 түвшинд ангилан түвшин бүрт тохирсон даалгаврыг бэлтгэн, эцэг эхтэй хамтран зохион байгуулав. Ингэснээр суралцагчдын гэрийн даалгаврын гүйцэтгэл 10.2%-иар өссөн үзүүлэлттэй байна. Мөн эцэг эхийн оролцоо нэмэгдэх, хүүхдийн өөртөө итгэх итгэл, суралцах идэвх өсөх хандлагатай байна. Энэ үйл ажиллагааг мөн уламжлал болон суралцагчдад хэвшүүлэхээр багш нарын үүрэгт ажлын хуваарьт тусган, үр дүнг тооцон үнэлж байна. Энэхүү үйл ажиллагааны үр дүнд залуу багш нар сурагчдын ялгаатай байдалд тохируулан ажиллах, харьцах үр чадварт суралцаж байна.

Үйл ажиллагаа 3: Унших чадварыг сайжруулах арга зүйг хэвшүүлэх

Хүүхдийн бүтээлчээр унших, бичих, ярих, сонсох сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх замаар хичээлийн хоцрогдлыг багасгах, сонирхлыг өдөөх, багаар хамтран ажиллах үйл ажиллагаанд сургах зорилгоор 2-6 дугаар ангийн суралцагчдын дунд “Унших чадварыг цогцоор хөгжүүлэх” арга зүйг төлөвлөн хэрэгжүүлж байна. Суралцагч бүрийг хөгжүүлэх үйл ажиллагаанд бага боловсролын болон МХБУЗ-ын багш нар хамтарч ажиллав. Хүүхдийн мэдлэгийн түвшингээс хамаарч чадвар нь янз бүр байхын зэрэгцээ үйл ажиллагааны явцад хувьсан өөрчлөгдөж байгаагийн дийлэнх хувь нь эерэг үр дүнг харуулж байна. Энэхүү үйл ажиллагааны үр дүнд суралцагчид уншсан зүйлийнхээ утга санааг зөв ойлгож сурах, түүнийгээ тайлбарлан ярих чадварт суралцаар байна. Мөн залуу багш нар олон жилийн арга туршлагатай ахмад багш нартай болон, МХБУЗ-ын мэргэжлийн багш нартай хамтарч ажилласнаар заах арга зүйн болон онолын мэдлэг сайжирч байна.

Үйл ажиллагаа 4: Багшийн тасралтгүй хөгжил

Ахмад, залуу багшийн залгамж холбоог сайжруулах, шинэ түвшинд хүргэх, залуу багш нарын заах арга зүйг сайжруулах, заах арга зүйд гарч буй алдааг засах, зөвлөн туслах, багшийн хөгжлийг дэмжих, сургалтын олон арга зүйгээс суралцах, шилдэг технологийн сан бүрдүүлэх зорилгоор ахмад болон залуу багш нарыг баг болгон хувааж хэлэлцүүлэгт хичээл зохион багуулж шилдэг заах арга зүйтэй багийг шалгаруулав. Хэлэлцүүлэгт хичээл зохион байгуулснаар залуу багш нарын заах арга зүйн алдааг засаж өөрсдийн гэсэн нэг арга зүйг эзэмшүүлэх зорилготой байв. Залуу багш нарын хувьд хичээл заах үр дүй болон хичээл бэлтгэлийн үйл ажиллагаа нь нэг түвшин ахиж, өөрийн заасан хичээлийг дүгнэж, задлан шинжилгээг хийж, сайжруулалт хийх чадамжтай болсон. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд залуу багш нарын үр чадвар сайжирч байгаа нь дараах багш нарын жишээн дээр харагдаж байна. Газарзүйн багш Б.Даваасүрэн 2019 оноос хойш сургуулийн үр чадварын уралдаанд оролцож 8-5-р байруудад эрэмбэлэгдэж байсан бөгөөд ахмад багштай хамтарч ажилласнаар Шилдэг арга зүйтэй багш уралдаанд тэргүүн байрт шалгарч, бага боловсролын багш М.Бямбасүрэн 2018 оноос хойш сургуулийн үр чадварын уралдаанд 10-8-р байруудад эрэмбэлэгдэж байсан бол тус уралдаанд гутгаар байранд шалгарсан зэрэг нь ахмад

багштай хамтарч ажилласнаар залуу багшийн заах арга зүй ур чадвар сайжирч байгааг илтгэж байна. Тус уралдааныг мөн уламжлал болгон зохион байгуулахаар төлөвлөж байгаа бөгөөд нэг залуу багш 5-6 ахмад багштай хамтарч ажиллаж шинэ шинэ арга туршлагуудыг эзэмших боломжийг нээж өгөхөөр төлөвлөж байна. Дан ганц ахмад багшийн арга зүйгээс суралцахаас гадна залуу багш нар өөрийн чаддаг техник технологийн чадварыг ахмад багш нарт эзэмшүүлэх үйл ажиллагааг мөн зохион байгуулж байна. Ингэснээр багш нар багаар ажиллаж арга зүй ур чадварын томоохон түгээн дэлгэрүүлэлт болох юм.

Дүгнэлт

Багшийн мэргэжил бол цаг ямагт хөгжиж дэвшиж байхыг шаарддаг онцлог мэргэжил юм. Ялангуяа, залуу багш нарын хувьд мэдэхгүй, чадахгүй зүйл их тохиолддог учраас ичиж, нэрэлхэхгүйгээр асууж, тодруулж, тэр хэрээрээ хөгжих юм. Иймд бидэнд хамгийн ойр хамгийн том нөөц бололцоо, эрдэм мэдлэгийн уурхай нь ахмад багш нар билээ. Булган аймгийн нийт сургуулиудын залуу багш нарыг хамруулан 60 гаруй асуудлыг дэвшүүлэн гаргаж ирсэн нь залуу багш бидэнд мэдэхийг хүссэн зүйлс маш их байдгийг харуулж байгаа юм. Дээрх тулгамдаж буй асуудлуудаа бид цаг хугацаа, орон зайнаас үл хамааран интернэт орчин ашиглаж ахмад багш нараас арга туршлага судалж, заавар зөвлөмж аван шийдвэрлэж чадсандаа баяртай байна. Нийт залуу багш нартаа тухайн арга туршлагаа хуваалцах зорилгоор ахмад багш нарын зөвлөсөн арга туршлагуудыг нэгтгэн цахим гарын авлага бүтээлээ. Техник технологийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхаж буй багш бидэнд цаг хугацаа, орон зайнаас үл хамааран ашиглахад хялбар туршлага арга зүйн томоохон хэрэглүүр болно хэмээн үзэж байна. Цахим гарын авлагыг хэрэглээнд нэвтрүүлснээр арга туршлага хуваалцахаас гадна Булган аймгийн хэмжээнд ахмад багш нарыг алдаршуулах, тэднээс үлгэр дуурайлал авах, ахмад багш залуу багшийн хамтын ажиллагааг дэмжихэд томоохон нөөц болох юм. Залуу багш нарт хамгийн их тулгамдаж буй эдгээр асуудлуудыг шийдвэрлэн “Түүчээ” клубийн 18 залуу багш ахмад багш нарын арга туршлагыг нэвтрүүлэн ажиллалаа. Мөн самбар төлөвлөлт, түвшинд тохирсон гэрийн даалгавар, багшийн тасралтгүй хөгжил, унших чадварыг сайжруулах ажлуудыг зохион байгуулаад байна. Дээрх үйл ажиллагааг өдөр тутамдаа хэвшүүлэн, үр дүнг тооцон ажиллаж байна. Тус үйл ажиллагаануудын үр дүнд залуу багш нарын арга зүй, ур чадвар сайжирч байгаа нь тодорхой харагдаж байна. Түүнчлэн бусад сумын залуу багш нар түгээн дэлгэрүүлсэн гарын авлагыг ашиглан сургалтын арга зүйгээ сайжруулах бүрэн боломжтой. Эдгээр үйл ажиллагаанууд нь ахмад багшийн арга туршлагаас хуваалцах тэднийг хойч үеийн залгамж халаа болох залуу багш нартаа түгээн дэлгэрүүлэх их ажлын минь нэгээхэн хэсэг болох юм.

Дэвшүүлж буй санал

- Энэхүү цахим гарын авлагыг бусад сумын залуу багш нар сургалтын үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх
- Гарын авлагаас санаа авч орон зай, цаг хугацаанаас үл хамааран хамтран суралцах
- Залуу багш нарын технологитой ажиллах чадварыг ахмад багш нарт түгээн дэлгэрүүлж хэлэлцүүлэгт хичээл зохион байгуулах

Ном зүй

- Ариунаа,Т., Отгонбаяр,Т., Баттогтох,Д. (2013). Идэвхтэй сургалтын арга. Улаанбаатар.
- Батболд,Т., Ариунаа,Д. Баярмаа,Б., Батцэцэг,С. (2018). Судалгааны арга зүй. Улаанбаатар.
- БСШУЯ. (2021) Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих арга зүйн зөвлөмж. Улаанбаатар.
- Ган-Өлзий,Ч. (2002) Нийгэм судлал. Улаанбаатар.
- Дашпүрэв,Д. (2001). Нийгмийн тухай мэдлэг. Улаанбаатар.
- Мягмар,О. (2012). Сэтгэл судлал. Улаанбаатар.
- Мягмар,О. (2009). Судлаач багшийн гарын авлага. Улаанбаатар.
- Нармандах,П. (2019). Сургалтын аргуудаас суралцахуй. Багшийн хөгжил Улаанбаатар.
- Оюунцэцэг,Ш. (2018). “Бага ангийн сурагчдын унших чадварыг хөгжүүлэх, үнэлэх зарим арга хэрэгсэл” гарын авлага.
- Рэнцэндорж,Р. Цагийн урсгалд элэгдээгүй тайлбартай дасгалын арга.
- Түмэндэмбэрэл,Д., Оюун,Ц. (2015). Судалгаа хийх арга зүй. Улаанбаатар.
- Цахим хичээл page хуудас
- Flipsnack цахим программ
- Mals.mn

ЧАДВАРЖСАН БАГШ ХӨГЖИЛД ХӨТӨЛНӨ

Л.Наранжаргал¹, Ү.Баярмаа², Б.Мянганбаяр³

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын

лаборатори 1 дүгээр сургууль

naranjargal0301@gmail.com¹, ubayarmaa999@gmail.com², ajmyangan@gmail.com³

Хураангуй

Нийгэм хөгжихийн хэрээр боловсролын байгууллага тэр дундаа багшаас асар их ур чадвар шаардах болжээ. Учир нь амьдрах чадвартай, улмаар дэлхийн иргэнийг бэлтгэхэд багшийн хөгжил онцгой чухал. Багш нь ирээдүйн нийгмийг авч явах иргэнийг бэлтгэдэг тул багшийн сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаа нь ирээдүйд чиглэсэн арга барил байх ёстой.

Энэхүү судалгааны ажлаараа багш чадваржсанаар хөдөлмөрөө бодитой үнэлүүлж, орлогоо нэмэгдүүлэх олон боломж байгааг, залуу багш нарын оролцооны өнөөгийн байдал нь хангалтгүй түвшинд байгаа нь ажиглагдсан, багш нартай хамтран, бүтээлчээр санаачилгатай ажиллахад анхаарах шаардлагатайг олж харсан юм.

Илтгэлээрээ дамжуулан хэрхэн чадварлаг багш болох, чадваржиж хөгжсөн багшид гарч ирэх боломжуудын талаар мэдээлэх болно. Монгол улсын засгийн газраас “Гүйцэтгэлд суурилсан үнэлгээ”-ний системийг хэрэгжүүлэх болсонтой уялдуулан, багш хөдөлмөрөө бодитой үнэлүүлэх ямар арга замууд байгаа, багш хөгжихөд хамтын ажиллагаа чухал хөшүүрэг болох талаар саналаа дэвшүүлэхийг зорилоо.

Түлхүүр үг: багшийн хөгжил; боломж; хамтын ажиллагаа.

Оршил

Багш нар мэдлэг боловсролоо тасралтгүй дээшлүүлж, хөгжихийн тулд санаачилгатай байх, бусдаас суралцах шаардлагатай болж байна. Мөн Ковид-19 цар тахалтай холбоотой дэлхийн болон Монголын боловсролын тогтолцоонд хоцрогдол бодитой бий болсон бөгөөд үүнийг арилгах хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ахмад багш нарын дэмжлэг авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд уриалсан зэрэг нь илтгэлийг бичих үндэслэл боллоо.

Зорилго

Монгол улсын засгийн газраас “Гүйцэтгэлд суурилсан үнэлгээ”-г хэрэгжүүлэх болсонтой уялдуулан хамтын үйл ажиллагаанд суралцсанаар багш бүр хөгжин, мэргэжлийн үнэ цэнээ өсгөх боломж нээгдэж байгааг судлах.

Зорилт

1. Багшийн хөгжлийг онолын үүднээс тодорхойлох
2. Багш чадваржих арга зам болон чадваржсан багшид олдох боломжийг эрж хайх

3. Ахмад болон залуу багш нарын хамтын ажиллагааг илрүүлэх санал асуулга боловсруулах, чадваржих арга замыг судлан тогтоох

Судалгааны ажилд хэрэглэсэн арга:

- Задлан шинжлэлийн арга
- Дүн шинжилгээ хийх
- Асуулгын арга

Судалгааны объект

Судалгааны хүрээнд Говь-Алтай аймгийн ерөнхий боловсролын 1, 2, 3, 4, ХЭЦС сургуулийн болон 18 сум, сургалтын менежерүүд.

Судалгааны ажлын шинэлэг тал

Ахмад болон залуу багш нарын хамтын ажиллагааг судлан илрүүлэх, харилцан биенээ чадваржуулах туршлага, чадваржсан багшид нээгдэх боломжуудын талаар судалж байгаагаараа шинэлэг.


Судалгааны ажлын ач холбогдол

Багш нар хамтран ажиллах туршлагыг түгээн дэлгэрүүлэх, багш чадваржсанаар хөдөлмөрөө бодитой үнэлүүлэх, сурлагын хоцрогдлыг арилгах нэг арга замыг илрүүлсэнд оршино.

Онолын хэсэг

Улс орны нийгэм эдийн засаг, соёлын үнэт зүйлсийн хөдөлгөгч хүч нь боловсролын хөгжил байдаг. Боловсролын хөгжил нь өөрчлөлтийн үр дүнд шинэчлэгдэн урагшилж байдаг тасралтгүй үйл явц юм. Хөгжил гэдэг нь өмнө байсан мэдлэг, чадвар дээрээ суурилсан шинэ мэдлэг, шинэ чадвар өөртөө олж авахыг хэлнэ. Багш, түүний хөгжлийн талаарх үзэл баримтлал нь дараах байдлаар хувьсан өөрчлөгдөж байна.

Зураг 1. Багш, багшийн хөгжлийн талаарх үзэл баримтлал



Ингэж хувьсаж байгаа нь нийгмийн шаардлагатай холбоотой. Бидний сурагчид бол α болон Z үеийнхэн. Ийнхүү X , Y , Z гэж нэрлэх болсон шалтгаан нь технологийн хөгжил, мэдээллийн хэрэгсэл хэрэглэх, ашиглахтай холбоотой. α болон Z үеийнхний онцлогийг товчоор дурдвал :

Альфа хүүхдүүд : 2011-2025 онд төрсөн хүүхдүүд энэ бүлэгт хамаарагдана. Альфачууд бол өөрсдөө ч ойлгоогүй байхдаа хэдийн дижитал ертөнцийн хэрэглэгч байтугай эд эн нь болсон тэр бүлэг юм.

Z үеийн хүүхдүүд: 1995-2010 онд төрсөн хүүхдүүд энэ бүлэгт хамаарагдана. Тэдний хувьд энэ платформ нь харилцаа, холбооны “багаж, зэвсэг”.

Ийм чадвартай хүүхдийг бид сургаж хүмүүжүүлэх болоод байгаа тул хуучин хандлага, арга барилаа өөрчилж, өөрийгөө хурдацтай хөгжүүлэн чадавхжуулах нь эн тэргүүний зорилт болж байна. Ажлын байрандаа суралцах хэлбэр бол багшийн хөгжлийн чухал үйл явц юм. Багшийн хөгжилд нөлөөлөх гол хүчин зүйл нь ахмад багшийн оролцоо байдаг.

Чадварлаг багш хөтөлбөр

Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих бодлогыг холбогдох хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдэд тусган хэрэгжүүлж байгаагийн нэг жишээ нь Чадварлаг багш хөтөлбөр юм.

Багшийн хөгжих орчныг цэцэрлэг, сургууль гэж үзэх бөгөөд тэднийг ажлын байрандаа хамт олноороо тасралтгүй хөгжих шинэ арга хэлбэрүүд (сургалт, дагалдуулан сургах, хичээлийн ажиглалт, хэлэлцүүлэг, хамтын төлөвлөлт, үнэлгээ, өөрийн үнэлгээ, практик үйлийн судалгаа)-ээр хөгжүүлэхийг зорьж байгаа төдийгүй хөгжих үйл ажиллагаанд мэдээлэл харилцааны технологи ашиглах нөхцөл боломж бий болгох нь энэхүү хөтөлбөрийн чухал зорилтын нэг юм. Энэ хөтөлбөрөөс харахад багш чадваржих гол хөшүүрэг нь багшийн өөрийн идэвхээс гадна хамтын ажиллагаа юм.

Багш чадваржих арга зам

Чадварлаг багш хөтөлбөрт багшийн мэргэжлийн хөгжлийн бүлэг нь чадваржсан багшийг бий болгоход онцгой ач холбогдолтойг тусгажээ. Энэ нь багшийн хөгжилд хамтын ажиллагаа хамгийн чухал болохыг илтгэж байна. Хөгжлийн гарцыг хаа холоос, ямар нэгэн сургалт, зөвлөгөөнөөс эрж хайх биш, дэргэдээ байгаа туршлагатай багш нартаа тулгуурлан, хамтын хүчээр чадваржих дотоод нөөц боломжийг эрж хайх нь багшийн хөгжил болоод чадварт хамгийн чухал бөгөөд өгөөжтэй гэж үзэж байна.

Багш өөрийгөө хөгжүүлэхээс гадна харилцан биенээсээ суралцаж, туршлага солилцсоноор хамтдаа чадваржих боломж байгааг өөрийн сургуулийн нэгэн туршлагад тулгуурлан дурдъя. Бага ангийн нийт 28, ахмад багш 7, дунд үеийн 12, залуу үеийн 9 багш монгол хэл, математикийн судлагдахууныхаа суралцахуйн зорилтоос эхлэн хамтран шинжилж, анги хоорондын агуулгын залгамж холбоог тодорхойлон, мэдлэг ойлголт, чадвар, хандлага гэсэн үнэлгээний зорилтын дагуу чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн, шинжлэн судлах арга барилд сургах зорилго бүхий даалгаврыг боловсруулсан юм. Даалгаврыг “Багшгүйгээр яаж сурах вэ” гэдэг үүднээс бие даан өөрийгөө хөгжүүлэх хандлагыг төлөвшүүлэх, онолын мэдлэгээ бататгах, дадлагажуулах үйлд хөтөлсөн.



дарааллаар боловсруулсан.

Энэ бол зүгээр нэг гарын авлага биш. Орчин үеийн иргэнд зайлшгүй байх шинжлэн судлах арга барилтай сурагчийг бэлтгэхэд чиглэсэн хөтөч бүтээл юм.

Ийнхүү тодорхой үр дүн гарсан тул бага ангиас дунд анги руу шилжих залгамж холбоог хадгалах, улмаар шинжлэн судлах арга барилтай болсон хүүхдийг дунд ангид нь асуудал дэвшүүлэн шийдвэрлэх аргад сургах үүднээс 6-р ангид монгол хэл, математикийн хичээлээр тухайн судлагдахууны багш нар хамтран, гарын авлагыг бүтээж, энэ хичээлийн жилээс туршин, бүтэн нэг улирал болоод байна. Уг гарын авлагыг монгол хэл, математикийн бүх багш буюу монгол хэлний судлагдахууны ахмад багш-5 (45-56 нас) , дунд үеийн – 2 (35-45 нас), залуу багш – 3 (35 –с доош нас), математикийн судлагдахууны ахмад багш-1 (51 нас), дунд үеийн-2 (43 нас), залуу багш- 4 (23-30 нас) хамтран бүтээсэн юм. Хүүхдүүд маань шинжлэн судлахаас асуудлыг шийдвэрлэх аргад бага боловч суралцаж байна.

Сурагчдын мэдлэгийн түвшинг намар тогтооход: (10 дугаар сар) Монгол хэл:

Монгол хэл: (10 дугаар сар)

Анги бүлэг	Бүх сурагчдын тоо	Оношлогдсон сурагчдын тоо	Авах оноо	Авсан оноо	Гүйцэтгэлийн хувь
6а	38	35	1050	645	61.4
6б	39	32	960	566	58.9
6в	34	22	660	378	57.2
6г	38	31	930	515	55.4
6д	37	29	866	542	62.5
Дүн	186	149	4466	2646	59.2

Монгол хэл: (12 дугаар сар)

Анги бүлэг	Бүх сурагчдын тоо	Оношлогдсон сурагчдын тоо	Авах оноо	Авсан оноо	Гүйцэтгэлийн хувь
6а	38	38	1050	700	66.7 \(\pm 5.3\)
6б	39	31	930	590	63.4 \(\pm 4.5\)
6в	34	28	840	490	58.3 \(\pm 1.1\)
6г	38	33	990	560	56.5 \(\pm 1.1\)
6д	37	30	900	580	64.4 \(\pm 1.9\)
Дүн	186	160	4710	2920	61.9

2 сарын хугацаанд ангиудын дундаж 59.2%-аас 61.9% болж, 2.7%-иар өсчээ.

Гарын авлагыг багш нар хамтран бүтээсний үр дүнд:

Сурагчдын тухайд онолын мэдлэг нь өгөгдсөн учир бие даах чадварт ахиц гарсан, эмх цэгцэд суралцсан, хичээл сургалтын хоцрогдол багасаж, бүтээлч байдал сайжирсан, хөтөч номоо цэвэр нямбай хэрэглэх нь чухал гэдэг зөв хандлагатай болж байна.

Багшийн тухайд хамтран ажилласнаар суралцахуйн зорилтыг сайн шинжилж, даалгавар боловсруулж сурсан, мэдээллийн технологийн чадвараа сайжруулсан, арга зүй, туршлагаа хуваалцсанаар заах арга зүйд өөрчлөлт гарч байна, хамтран бүтээлийн сантай болсноор сургалтын чанар сайжирсан, хоцрогдолгүй сургахад ахиц гарсан зэрэг олон эерэг үр дүн гарлаа.

Энэ жишгээр заавал ямар нэгэн сургалтаар биш, ажлын байрандаа нөөц боломжоо зөв ашиглан, чадваржих боломж багш бүрд нээлттэй байна.

Багш чадваржсанаар хөдөлмөрөө бодитой үнэлүүлэх боломжууд

Өнөө үед багш өөрийгөө чадваржуулах маш олон боломж байна. Эдгээр боломжийг зөв ашиглаж чадвал гүйцэтгэлд суурилсан үнэлгээтэй уялдан хөдөлмөрөө үнэлүүлэх, улмаар цалингаа өсгөж болохоор байна. Тухайлбал бидний олж харснаар чадваржсан багшид хөдөлмөрөө үнэлүүлэх дараах боломжууд байна.

1. Цахим контент, хичээл бэлтгэн байршуулах

Тухайн сайтад байршуулсан контентуудыг харахад дутуу байгаа сэдвээр оролцох боломж нээлттэй байна (Эх сурвалж: www.medle.mn).

2. ТВ нэвтрүүлэгт оролцон ур чадвараа сорих: Монгол улсад “Би багш” нэвтрүүлэг 2 дахь удаагаа зохиогдож байгаа бөгөөд хамгийн чадвартай нь шалгардаг.
3. БШУЯ, Юнескогийн Үндэсний зөвлөл, Багшийн хөгжлийг дэмжих Боловсрол сан хамтран зохион байгуулсан “Үндэсний шилдэг багш” шалгаруулах уралдаанд 630 багш оролцсоноос эхний шатанд 50 багш, 2-р шатанд 10 багшийг шалгаруулан “Үндэсний шилдэг багш”-аар өргөмжлөн шагнаан урамшуулсан. Энэ бол мэргэжлийн үнэ цэнээ өсгөх маш том боломж юм.
4. Орон нутаг бүр багшийн хөдөлмөрийг үнэлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Тухайлбал Говь-Алтай аймгийн ИТХ-ын 2021 оны 11-р сарын 23-ны 78-р тушаалаар батлагдсан “Боловсролын чанарыг сайжруулах” дэд хөтөлбөрийн хүрээнд ЭЕШ-д 800 оноо авсан сурагч болон, түүнийг бэлтгэсэн багшийн хөдөлмөрийг 1 сая төгрөгөөр урамшуулжээ.
5. Мөн багш өөрийгөө хөгжүүлснээр манлайлал өсөж, ур чадвар, кабинет, мэргэжлийн зэргийн нэмэгдэл гэх мэт олон төрлийн нэмэгдэл цалин авах боломж байна.
6. Чадваржсан багш танхимын болон цахим сургалтыг төлбөртэй явуулах, сургалтын төв ажиллуулан, бодит орлого олж болно.
7. Туршлагатай болон шилдэг багш нараас суралцах, хамтран ажилласнаар багш хамгийн сайн хөгжиж, сурагчдаа хөгжүүлэх хамтын бүтээлтэй болж болно. Тэрхүү бүтээлээ оюуны өмчөөр бүртгүүлэн баталгаажуулж, тэргүүн туршлага болгон түгээн дэлгэрүүлж манлайллаа өсгөж болно. Тэргүүн туршлагатай сайн багшид өндөр цалинтай ажлын байр нээлттэй байгаа.
8. Технологийн чадвараа ашиглан, бусад багш нартаа цахим хичээл бэлтгэх чиглэлээр төлбөртэй сургалт явуулж болно.


Судалгааны хэсэг

Багшийн хөгжлийн нэг хөшүүрэг нь ахмад болон залуу багш нарын хамтын ажиллагаа билээ. Тэгвэл залуу багш нарын ахмад багштайгаа хэрхэн хамтарч ажилладгийг тодруулах зорилгоор дараах судалгааг Гүүгл форм ашиглан авсан. Судалгаанд Говь-Алтай аймгийн ерөнхий боловсролын 1, 2, 3, 4, ХЭЦС сургуулийн болон 18 сум, сургалтын менежерүүд, нийт 212 багш оролцсон.


Судалгаа 1:

Зорилго нь ахмад болон залуу багш нарын хамтын ажиллагааны түвшинг илрүүлэх.

Зураг 1. Боловсролын байгууллагад ажиллаж буй жил



Зураг 2. Та ахмад багш нарын арга туршлагыг сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаандаа тусган ажилладаг эсэх




Ахмад, залуу, дунд 3 үеийн багш нар хамтарч ажилласнаар ямар үр дүн гарна гэж бодож байгаа талаар тодруулж асуухад:

багшид “Чадварт хөтөлсөн хөтөч” гарын авлагыг хэрэгжүүлж буй туршлагынхаа талаар танилцуулах мэдээлэл хийж, цаашид ингэж хамтарч ажиллах нь багшийн хөгжилд чухал нөлөөтэй байгааг зөвлөсөн болно.

Судалгаа 2:

Зорилго: Ахмад болон залуу багш нар хамтран бүтээл туурвихын ололттой болон бэрхшээлтэй талыг судлах

Зураг 6. Боловсролын байгууллагад ажиллаж буй жил



“Чадварт хөтөлсөн хөтөч” гарын авлагыг хамтарч боловсруулахад ямар бэрхшээл тулгарсан талаар тодруулахад:

- Монгол хэлний суралцахуйн зорилтод тохирсон эх сонголт олоход
- Мэдээллийн технологийн чадвар
- Цаг хугацаа
- Туршлага
- Даалгавар боловсруулахад хугацаа их шаардсан гэсэн бэрхшээлүүдийг хэлсэн байна.

Хүснэгт 1. Даалгавар боловсруулахад хэнээс зөвлөгөө авсан бэ?

Ахмад багш	9
Мэргэжлийн бүлэг	10
Сургалтын менежер	6
Бие дааж	1

Энэхүү асуулгаас харахад мэргэжлийн бүлэг болон туршлагатай ахмад багш нарт түлхүү ханддаг байна.

Гарын авлагыг боловсруулахад бусдаас суралцсан ололтын талаар тодруулж асуухад:


- Хийж буй зүйлээ бүтээгдэхүүн болгох
- Даалгаврын жин тохируулах бас мэдлэгийг оновчтойгоор тодорхой болгох тал дээр
- Секц бүр багш бүр хөтчийг хийж байгаа явцаа танилцуулан, бусдаас санал зөвлөгөө авч засан сайжруулж байснаар маш их зүйлийг сурсан
- Бодлогыг олон аргаар бодох
- Дасгал даалгаврын боловсруулалт
- Хичээл төлөвлөлт хүүхдийн сэтгэхүйд тохирсон дасгал даалгавар боловсруулах.
- Дасгал даалгаврууд сонирхолтой байх, зарим агуулга дээр санаа авах, өнгө үзэмж

- Даалгаврын тавил
- Мэдээллийн технологийн чадвар
- Багаар ажиллах гэх мэтээр багшийн хөгжилд хамтын ажиллагаа чухал болох нь илэрч байна. Хамтын үйл ажиллагааны үр дүнд багш бүрд мэдлэг арга зүйн хувьд хөгжсөн байна.

Энэ гарын авлагыг боловсруулснаар багшлах ур чадварт ямар ахиц гарсан бэ?

- Бэлэн хэрэглэгдэхүүнтэй болсон, хөнгөнөөс хүнд рүү чиглэсэн хэлбэртэй тул шинэ хичээлд шууд дагуулж явдаг
- Суралцахуйн зорилтын үг бүрийн утгыг ойлгож мэдэрч судалсан. Тохирсон даалгаврыг боловсруулахад ахицтай болсон
- Суралцахуйн зорилт, сургалтын хөтөлбөрөө гүнзгийрүүлж судалсан , Одсүрэн багшийн номыг бас судалсан, өмнө нь хэтэрхий олон агуулга оруулж заадаг байснаа больж яг суралцахуйн зорилтын дагуу сургалтаа явуулдаг болсон.
- Суралцахуйн зорилтоо ойлгоод яг ямар чадвар эзэмшүүлэхээ мэдээд авахад хаа хамаагүй юм хамаагүй суралцахуйн зорилтдоо яг тохирсон агуулгыг заах
- Хичээл ороход эмх цэгцтэй.
- Нэг даалгаврыг олон аргаар хийлгэдэг болсон.
- Суралцахуйн зорилт бүрээ шинжилж чаддаг болсон.
- Онолын мэдлэг, заах арга зүй, дасгал даалгавар боловсруулах, мэдээллийн технологийн чадварт илүү ахиц гарсан гэх мэтээр хариулсан нь ажлын байрандаа харилцан нэгнээсээ суралцаж өөрийгөө хөгжүүлэх бүрэн боломжтойг харуулж байна.

Зураг 7. Гарын авлагыг боловсруулахад ямар чадвар түлхүү шаардлагатай байсан бэ?



Асуулгаас харахад онолын мэдлэг, бусдаас суралцах, мэдээллийн технологийн чадвар түлхүү шаардагдаж байна. Энэ чадварыг хөгжүүлэх гол хүчин зүйл нь мөн л хамтын ажиллагаа юм.

Гарын авлагыг боловсруулж туршсанаар сурагчдын мэдлэг, чадвар, хандлагад ямар ахиц гарсан бэ? гэж асуухад:

- Бие даах чадвар нэмэгдсэн
- Үзсэн зүйлээ бататгах
- Дадлагажихад дөхөм болсон, мэдлэг чадвар, хандлагад ахиц гарсан
- Нэг даалгаврыг олон аргаар хийлгэх боломжтой учраас сурагчид сайн хөгжиж, чадваржиж байна

- Онолын мэдлэг өгөгдсөн учраас сурагчид бие даан хийх боломжтой.
- Хөтөч номоо цэвэр нямбай хэрэглэх нь чухал гэдэг зөв хандлагатай болж байна.
- Шинжлэн судлах арга барилд суралцах байна.
- Алхах дарааллаар хийж чадварууд хөгжсөн
- Олон багш нарын даалгавар орсон учраас сурагчдын бүтээлч байдал сайжирсан.
- Агуулгад тохирсон даалгаврыг хийж мэдлэгээ хэрэглээ болгож байгаа зэргээс үзвэл сурагчид бие даан ажиллах чадвар нэмэгдэн, даалгаврыг хийхдээ төлөвлөж төлөвлөгөөний дагуу хийж хэвшиж байгаа нь давуу талтай байна. Наад зах нь аливааг хийхдээ төлөвлөх ёстой гэдэг хандлагатай болж байгаа нь ололт юм.

Гарын авлагыг боловсруулж туршсанаар сурагчдын чадвар түлхүү хөгжиж байна гэж багш нарын 88.5% нь хариулсан бол хандлага – 7.7% гэсэн байна.

Дэлхийн иргэнд байх зайлшгүй зүйл бол чадвар юм. Дээрх гарын авлагыг туршсанаар сурагчдын чадвар хандлагад түлхүү өөрчлөлт орж хөгжиж байгаа нь ажиглагдаж байна.

Дэвшүүлэх санал

- Монголын боловсролын үнэт капитал болсон ахмад багш нарын дадлага туршлагаас суралцан, тэдний оролцоог нэмэгдүүлэх замаар арга зүйдээ шинэчлэл хийн хөгжих хэрэгтэй. Боловсрол, шинжлэх ухааны яамны сайдтай уулзах үеэрээ ахмад багш нарын төлөөлөл хамтарч ажиллан, туслахад бэлэн байгаагаа илэрхийлснийг бид бүтээлчээр хэрэгжүүлэх хэрэгтэй байна.
- Бидний сурагчид альфа болон Z үеийнхэн юм. Тэд мэдээллийн технологийн орчинд ажиллах өндөр чадвартай тул багш хүн түүнээс давсан чадвартай байж мэргэжлийн үнэ цэнээ хадгална. Иймд тэдэнтэй ажиллах цахимд суурилсан шинэ арга зүйг боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- Говь-Алтай аймаг “Боловсролын чанарыг сайжруулах дэд хөтөлбөр”-ийн хүрээнд 12-р ангийн 640 сурагчийг таблетжуулж, тэднийг чадварт нь тулгуурлан хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд ихээхэн анхаарч байна. Энэ жишгээр сурах орчны шинэчлэлийг сурагчдын онцлогт тохируулан бий болгох нь зүйтэй.

Дүгнэлт

- Монгол улсын хөгжлийн түлхүүр нь чадвартай ажиллах хүчин. Чадвартай хүн юуг ч ургуулж чадах “алтан үр” юм. Энэхүү алтан үрийн нэг бол багш хүн. Багш өөрийн мэргэжилдээ эзэн нь болж, ажилдаа дуртай сэтгэлтэй, хариуцлагатай байх нь багшийн хөгжлийн суурь үндэс болж байна.
- Багшийн мэргэжил мөнхийн тогтвортой биш тул үргэлж өөрчлөгдөн шинэчлэгдэж байдаг. Иймд нөөц бололцоогоо зөв ашиглан чадваржиж, хөдөлмөрөө бодитой үнэлүүлэх боломжуудыг эрж хайн, бүтээлчээр хандвал орлогоо нэмэгдүүлж болохоор байна. Бүтээлч багш хөгжинө. Хөгжихийн хэрээр чадваржина.
- Багшийн мэргэжлийн тасралтгүй өсөлт, хөгжилд нөлөөлөгч гол хүчин зүйлүүдийн нэг нь ахмад багш нарын зөвлөгөө, дэмжлэг байдаг. Залуу багш нар хөгжихийн тулд гадаад ба дотоод харилцааны аль нэгээр бүтээлч санаачилгатай ажиллахад анхаарах шаардлагатай. Гадаад харилцаа гэхээр сургуулиас гадна орших гавьяаныхаа амралтыг эдлэн буй багшаас суралцах, дотоод харилцаа гэхээр сургуульдаа одоо ажиллаж буй ахмад болон туршлагатай багш нартай хамтран

ажиллаж, мэдлэг арга зүйгээ тасралтгүй дээшлүүлэх үйл явц юм. Энэ нь боловсролын залгамж холбоо, тасралтгүй байдлыг илтгэж байна.

- Зөвхөн залуу багш нь ахмад багшаасаа суралцах биш, залуу багшаас суралцах давуу тал байна. Сүүлийн жилүүдэд багш мэргэжлээр төгсөж байгаа шинэ залуу үеийнхний мэдээллийн технологийн чадвар маш сайн байна. Тэдний энэ чадвар өнөөгийн шаардлагад нийцэж байгаа сайн тал юм. Танхим цахимын сургалт хосолсон энэ үед ахмад багш нар тэдний мэдээллийн технологийн чадвараас суралцах зайлшгүй хэрэгцээтэй байна. Залуу багш нь ахмад багшийнхаа арга туршлагыг, ахмад багш нь залуу багшийнхаа технологийн чадвараас суралцах зэргээр харилцан туршлагаа солилцон, хамтран ажиллавал сургалтын чанар сайжирч, ирээдүйг бүтээх дэлхийн иргэнийг бий болгож чадна.

Ном зүй

Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль. 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдөр

МУ-ын БШУС-ын А/07 тушаалаар батлагдсан “Чадварлаг багш” хөтөлбөр

БСШУС Сайдын 2018 оны 12-р сарын 20 А/812 “Мэргэжлийн зэрэг олгох, хасах журам

Говь-Алтай аймгийн ИТХ-ын 2021.11.23-ны №78 тушаал “Боловсролын чанарыг сайжруулах” дэд хөтөлбөр

<https://www.oecd.org/education/2030/learning-framework-2030.html/>

Medle.mn

БШУЯ Суурь боловсролын цөм хөтөлбөр. 2015 он

Оюун,Ц., Түмэндэмбэрэл,Д. (2005). Багшийн хөгжил. Улаанбаатар.

Сарангарав,С., Наранжаргал,Ц. “Багш ажлын байрандаа тасралтгүй хөгжих нь” илтгэл

Canva.com вэб сайт

Docs.google.com/forms

https://docs.google.com/forms/d/1_VpGqhPgWRNdZEi0s_8lCQbY0PjzOu6jAPh39ah5eHU/edit
/Багш нараас авсан судалгааны асуулгын линк/

<https://docs.google.com/forms/d/1NCKe7HksbmMBemZNqM3CG0UzIbKwGGGV1On7BI0-4eI/edit#responses>

ӨВЛӨХҮЙН УХААНД ХАМТДАА

М.Хандсүрэн¹, З.Золзаяа², А.Оюунчимэг³, Н.Энхжаргал⁴

Говьсүмбэр аймгийн ерөнхий боловсролын

5 дугаар сургууль

m.khandaa0526@gmail.com¹, zorigtbaatarzolzaya3544@gmail.com²,

a.oyunchimeg02@gmail.com³, Norovenheejaagii1234@gmail.com⁴

Оршил

Аливаа үндэстэн оршин тогтнохын эх үндэс нь эх хэл билээ. Эх хэлээрээ ярьж, уншиж, бичиж сурах нь бүх шинжлэх ухааны үндэс суурь болдог. Эх хэлээ хэрхэн эзэмшүүлэх вэ? гэдэг асуудал боловсролын түүхэн хөгжлийн явцад хамгийн чухал сэдэв байсаар ирсэн.

Даяаршин хөгжиж байгаа өнөө үед хэрхэн ондоошиж үлдэх, монгол өв соёлоо нандигнан хадгалахын анхны алхам бол эх хэлний дархлаа юм. Энэхүү дархлааг хадгалан үлдэхийн тулд бид ахмад багш нараасаа суралцах, залуу дунд үеийнхэн хамтдаа хөгжих нь чухал юм.

Эх хэлээрээ уншуулж бичүүлж сургахад багш бидний оролцоо нэн чухал. Сургахын тулд судлах нь бидний үүрэг билээ. Шинжлэх ухаан техникийн үсрэнгүй хөгжил олон шинэ зүйлийг бий болгохын зэрэгцээ хэрэглээ дагасан олон олон гадаад үг, хэллэг монгол хэлэнд минь холилдож байна. Үүнд анхаарлаа хандуулах нь боловсролын байгууллагын бодлого, багш бүхний сэтгэлд байх ёстой зүйл гэж үзлээ.

Сэдэв сонгосон үндэслэл

Эх хэлээ эзэмшихийн эхний үйл нь уншиж сурах юм. Уншиж сурснаар хүний сурах үйл нээгддэг. Бага боловсролд тулгамдаж буй асуудал бол ойлгож унших чадварыг хөгжүүлэх. Бага боловсролын унших чадварын үнэлгээ (EGRA)-г үндэсний түвшинд түүврийн аргаар зохион байгуулахад хамрагдсан сурагчдын 73% нь эхэд тулгуурласан асуултад хариулсан даалгаврын гүйцэтгэл буюу “Уншаад ойлгох” даалгаврын гүйцэтгэл нь доогуур үнэлэгдсэн. Ойлгож унших чадварын суурь нь авианы дуудлага. Бид сургуульдаа 4 бүлэгт хичээл заадаг залуу, дунд, ахмад үеийн төлөөлөл. Бидний өмнө танхим, цахим хосолсон өвөрмөц нөхцөлд сурагчдаа уншуулж, бичүүлж сургах шаардлага тулгарсан. Энэ үед хамтдаа хэрхэн ажилласан, ямар үр дүнд хүрснээ дүгнэн бичихээр шийдвэрлэлээ.

Монгол улсын гавьяат багш Б.Бүүдэд нь 1947 онд төрсөн. Бага ангийн багшаар тасралтгүй 54 жил ажиллажээ. Биднийг 1 дүгээр анги даан авч ажиллахад багш маань тэтгэвэрт гарсан ч сургуульдаа ажиллаж байсан. Б.Бүүдэд багшийн уншуулж сургадаг туршлага нь “Авиа, үсэг таниулахдаа авианы хэл, хэлэхийн онцлог, авианы задлаг, нийлэг аргаар заадаг. Авиаг хэлэхэд өгүүлэх эрхтэн хэрхэн оролцож байгааг нарийн ажиглуулж, зөв дуудуулж зүгшрүүлэхийг чухалчилдаг. Б.Бүүдэд багшийн анх ажиллаж байсан 60-аад оны дундуур авиа, үсгийг таниулахдаа “Авианы зүйн дуудлагыг” маш

сайн заадаг байсан байна. Ингээд бид багаараа ахмад багштайгаа хамтран ажиллаж арга туршлагаас нь суралцсан.

Онолын хэсэг

Тархи судлалын үүднээс авч үзвэл нялх хүүхэд эргэн тойронд өрнөж буй яриаг сонсох явцад тархи нь тухайн хэлний дүрэмд суралцаж, хожим уншиж сурах үйлд аажмаар бэлтгэгдэж байдаг. Сурагчид унших чадвар дадлыг хэдий сайн эзэмшвэл бичих чадварыг хөгжүүлэхэд төдий чинээ сайн нөлөөтэй байдаг. Цагаан толгойн үсэг тус бүрийн дүрс хэлбэрийг бүтээх зурлага, яаж бичих журам, бусад үсэгтэй холбон бичих журам зэрэг нь крилл бичигт зүүнээс баруун тийш нь хөндлөн бичиж, үсгийн ихэнх зурлагыг нар буруу эргүүлэн бичдэг өвөрмөц онцлогтой.

Уншуулж сургахын тухайд эхлээд зөв унших, зөв, хурдан унших, зөв хурдан, ойлгож унших, зөв, хурдан, ойлгож, бүтээлчээр унших аргуудыг анги ахих бүр нарийн шат дараатайгаар эзэмшүүлэх нь чухал. Унших чадвар эзэмшсэн хүн судалж буй хичээлүүдийн агуулгыг эзэмшихээс гадна шаардлагатай мэдээллийг бусад эх сурвалжаас эрж олох, асуудалд өөр өөрийн байр сууринаас хандах, шүүн тунгаах чадвартай болдог.

Сэдвийн судлагдсан байдал


Зөв унших нь авиаг зөв дуудахаас эхэлнэ. Сурагч авиаг зөв дуудаж сурвал үгээ зөв холбон унших, үгээ хэлбэрийн хувьд таньсан бол ойлгох, үгийн утгыг мэдэх, хэрэглэхэд ач тустай. Үгийг хэрэглэх үед харилцаа бий болж, бүхэл бүтэн эхийн түвшинд унших, сэтгэх, хэрэглэх болно. Яриа гадагш дуу авиагаар илрэх ба дуу авиа нь яригч этгээдийн оюун бодол, сэтгэл хөдлөл, зоригийг агуулсан бие сэтгэлийн нарийн үйл ажиллагааны үр дүн болдог.

Үсгийн зөв дуудлагыг тайлж, үгэнд хөрвүүлж, утгыг танихыг унших гэнэ. Уншихдаа авиануудыг зөв дуудаж, тэдгээрийн нийлц болох үе, үгийг зөв хэлж, сольж гээлгүй, амьсгалаа зөв тохируулан уншихыг зөв унших гэнэ. Женкинс, Жевелл (1993) нар уншлагын хурд ба ойлгох чадварын хоорондын хамааралд хүүхдийн нас хэрхэн холбогдож буйг судлахад уншлагын хурд ба ойлгох чадварын хоорондын хамаарлын коэффициент 1 дүгээр ангид 0.88 байснаа анги ахих тусам буурсаар 6 дугаар ангид 0.6 болсон байна. Энэ нь хүүхдийн уншиж ойлгох чадварыг бага ангиас нь хөгжүүлэх нь чухал гэсэн дүгнэлтэд хүрчээ.

2018 онд боловсрол соёл шинжлэх ухаан, спортын яам, Дэлхийн банк, Боловсролын хүрээлэн хамтарч “Боловсролын чанарын шинэчлэл” төслийг лаборатори сургуулиудад туршиж, 2019 оноос үндэсний хэмжээнд хэрэгжүүлсэн.

EGRA Олон улсын бага боловсролын унших чадварын үнэлгээнд хамрагдсан манай улсын ЕБС-ийн I, II ангийн сурагчдын үр дүнг графикаас харахад II даалгавар буюу үгийг сонсоод эхэнд нь сонсогдож байгаа авиаг хэлэх, III даалгавар буюу бичсэн үсгүүдийг хараад авиаг дуудах, IV даалгавар буюу бичил эхийг уншаад ойлгосныг үнэлэх зэрэг даалгаврын гүйцэтгэл нэлээд доогуур байна.


Зураг 1. EGRA үнэлгээний даалгаврыг гүйцэтгэсэн сурагчдын хувь



Нэгдүгээр даалгавар буюу үсэг нэрлэх даалгаврын гүйцэтгэл 59.03 хувьтай атал үг сонсоод эхэнд нь ямар авиа сонсогдож байгааг хэлэх даалгаврын гүйцэтгэл 25.91 хувь, сонсоод ойлгох чадварыг үнэлэх даалгаврын гүйцэтгэл 59.4 хувь байхад уншаад ойлгох чадварыг үнэлэх даалгаврын гүйцэтгэл 27.06 байгаа нь асуудал юунд байгааг илтгэж байна.

1, 2 дугаар ангийн хувьд эдгээр үзүүлэлт дараах байдалтай байжээ.

Зураг 2. EGRA үнэлгээний даалгаврыг гүйцэтгэсэн сурагчдын хувь, ангиар



Хамтын ажиллагаа

Бид 2019 онд 1 дүгээр анги даан авч ажиллахдаа зөвлөх, МУГБ Б.Бүүдэдээс “Авианы ерөнхий зүй тогтол”-ын талаар сургалт авч, хамтын хичээлийг 8 удаа заасан. Мөн тухайн үеийн нөхцөлд байдлаас шалтгаалан цахим хичээл бэлдэх шаардлагатай болсон. 1-р ангийн сурагчдад үсгийн авиаг дуудлага чухлаас гадна үсгийн зурлага нь ч мөн тэр хэмжээгээр чухал юм. Авиа үсгийн цахим хичээл – 10, унших болон дасгал




ажиллуулах цахим хичээл – 8, математикийн хичээл – 8 тус тус хамтран бэлдсэн. Хөдөө алслагдмал байдаг, цахим орчинд суралцах боломжгүй суралцагсдаа 8 удаа цаасаар хичээл бэлтгэн хүргүүлж ажилласан. 2-р ангид сурагчдын унших чадварыг хөгжүүлэх чиглэлээр Уншлагын хурд нэмэгдүүлэх харааны дасгалыг тогтмол хийсэн. Мөн унших идэвх сонирхлыг нэмэгдүүлэхийн

тулд самбар ашиглан урамшууллын ханыг босгосон.



Ойлгож унших чадварыг хөгжүүлэх хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон жижиг эх, гарын авлагыг сонгон уншуулах, ойлгосноо ярилцах зэрэг үйлүүдийг суралцагчдаар хийлгэж ажилласан нь үр дүнгээ өгч байна.




Судалгааны зорилго

Авиа, үсэг таниулахдаа багш авианы хэл, хэлэхийн онцлог, арга зүйн мөн чанарыг таньж заасан нь ойлгож унших чадварын суурь болж байгаа эсэхийг илрүүлэх.


Зорилт 1: Авиа үсэг таниулахдаа багш авианы хэл, хэлэхийн онцлогийг анхаарах

Судалгааны хэсэг


2019 оны 1-р ангиудын Үсгийн авианы дуудлагын харьцуулалт:



2021 оны 1-р ангиудын Үсгийн авиан дуудлагын харьцуулалт:




2019 ба 2021 оны 1-р ангиудын Үсгийн авиан дуудлагын харьцуулалт:




Зорилт 2: Үгийг зөв унших (танил, зохиомол)

1-р ангиуд




1 минутанд унших үгийн тооны дундаж:


1-р ангиуд




Зорилт 3: Ойлгож унших чадварын суурь болж байгаа эсэхийг илрүүлэх



Харьцуулсан судалгаа: 2017-2021 оны хичээлийн жилүүдэд 1-р анги даан авч ажилласан багш нараас авсан судалгаа:



1 дүгээр ангид авиа үсэг таниулах багш болгоныг “Авиа зүйн дуудлага”-д суралцуулах шаардлагатай байна. Хоёр ангид байрлуулсан үеийн хүснэгтээс харахад хуучин арга барилаараа авиа таниулсаар байгаа багш байгааг ч баталж байна.



Үүнийг бид багштай хийсэн ярилцлагаар тодруулахад “Би задгай үеэр заасан. Цээжээр бичүүлэхэд амар байдаг. Битүү үеийн арга төвөгтэй санагдсан” гэв.

Дүгнэлт

- “Боловсролын чанарын шинэчлэл” төсөл хэрэгжиж эхэлсэн онд багш нарын авиа, үсэг таниулах арга зүйд ахиц гарсан нь судалгаанаас харагдаж байна.
- Зөв уншиж сурсан хүүхэд ойлгож уншиж сурах нь мэдээж. Иймээс уншлагын алхам бүрийг нарийн сайн судалж суралцагчдаа уншуулж сургах нь бидний үүрэг юм.
- Авианы зүйн дуудлага битүү , задгай үеийн хоорондын ялгааг чухалчлан ойлгох.
- Багш өөрөө авиаг таниулахдаа өгүүлэгдэх онцлогийг нь сайн мэдэж байх нь зөв уншиж сургахад хамгийн чухал. Гийгүүлэгч авиаг таниулахдаа дуу анирын оролцоогоор, өгүүлэх эрхтний булчингийн чангарал сулралаар, бүтэх аргаар, бүтэх байраар нь хэл, тагнайн оролцоогоор, хамар нармайн оролцоогоор хэрхэн ангилдаг болохыг багш бид нарийн сайн судлах шаардлагатай байна.
- Ахмад багш нартайгаа хамтарч, тэдний арга зүйгээс суралцахаас гадна хамгийн чухал зүйл бол авианы зүйн дуудлагыг нь өвлөж үлдэх хэрэгтэй байна.

Дэвшүүлэх санал

- Багш бүр авиа, үсэг таниулахдаа авианы хэл, хэлэхийн онцлог, арга зүйн мөн чанарыг таньж хичээлээ төлөвлөн заах
- 2020-2021 онд 1-р анги даасан багш нар авиа үсгийн дуудлагыг хуучин аргаараа зааж байгааг бидний судалгаа илрүүлсэн. Иймд 1-р анги даан авч ажиллах багш бүрийг намар хичээл эхлэхээс өмнө” Авиан зүйн дуудлагад” суралцуулах нь зүйтэй гэж үзлээ.
- Бага ангийн сурагчдыг ойлгож унших чадварт сайн сургах нь нэн тэргүүний зорилго болж байгаад анхаарах
- “Уншиж сурна” гэдэг нь үсэгт тайлагдан, минутанд хурдан унших биш юм. Минутын уншлагад анхаарлаа хандуулдаг арга барилаасаа салж, ойлгож унших чадварыг хөгжүүлцгээе !

Ном зүй

Лхаахүү,Г. (1986). “Цагаан толгой”. Улаанбаатар.

С.Батхуяг, Б.Төртогтох, Н.Цогзолмаа. (2015). Боловсрол судлалын судалгааны арга техник. Улаанбаатар.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, соёлын яам. (2019). Сургалтын цөм хөтөлбөр

БСШУЯ, Дэлхийн банк, Боловсролын хүрээлэн. (2018). Бага ангийн сурагчдын унших чадварыг хөгжүүлэх үнэлэх, зарим арга хэрэгсэл. Ред. Оюунцэцэг,Ш. "Боловсролын чанарын шинэчлэл" төсөл, Орчин цагийн монгол хэлний онол-арга зүйн зөвлөмж. Улаанбаатар: Сопресс ХХК

Алтанцэцэг,Ч., Отгонбаяр,Ц. (2018). Авиан зөв дуудлагыг зүгшрүүлэх. Улаанбаатар.

СУРАГЧДЫН УНШИХ ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХЭД “ДАВТАН УНШИХ” АРГА ЗҮЙГ АШИГЛАСАН НЬ

М.Наранчимэг¹, Л.Эрдэнэзул²

Дорноговь аймгийн Сайншанд сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль

nn5609797@gmail.com¹, zulaa.zulaa9601@gmail.com²

Хураангуй

Бага ангийн сурагчдын унших чадварыг хөгжүүлэхэд залуу багш нарт тусламж дэмжлэг зайлшгүй шаардлагатай байна. Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд ахмад багшийн “Давтан унших арга зүй”-г өөрийн арга зүйтэй хослуулан хэрэгжүүлснээр сурагчдын унших чадварт ахиц гарсан. Энэхүү сайжруулсан арга зүйн талаар хийсэн судалгаа, туршилтын үр дүнг танилцуулж байна

Түлхүүр үг: ахмад багш; унших чадвар; арга зүй; оролцоо; өсөлт.

Оршил

Ухаант хүний тархинд нь бууж, дэвтэрт нь тэрлэгдсэн үнэт үгсийг тунгаахад илүүдэхгүй” гэж нэгэн эрдэмтэн хэлсэн байх бөгөөд энэ нь “Алтны дэргэдэх гууль шарлана” гэдэг монгол ардын зүйр үгтэй утга нэг гэж бодож байна. Бид ахмад багш нараасаа зөвлөгөө авч, тэдний арвин их туршлагаас нь цаг ямагт суралцаж ажиллавал заах арга зүйгээ сайжруулан, амжилттай ажиллах том боломж болдог.

Сургуулийнхаа ахмад багшийн арга зүйг хэрэгжүүлж, тодорхой үр дүнд хүрсэн талаараа санаа бодлоо хуваалцах, мөн залуу багш нар ахмад багш нараасаа суралцахын ач тусыг ойлгуулах үүднээс энэхүү илтгэлээ бичлээ.

Судалгааны зорилго

Бага ангийн сурагчдын унших чадварыг “Давтан унших” арга зүйд тулгуурлан хөгжүүлэх

Судалгааны зорилт

1. Бага ангийн сурагчдын унших чадварыг хөгжүүлэхэд тулгарч буй бэрхшээлийг илрүүлэх
2. Ахмад баш нарын бага ангийн сурагчдын унших чадварыг хөгжүүлдэг сайн туршлага, арга зүйгээс судлах
3. Ахмад багшийн сайн туршлага, арга зүйг өөрийн арга зүйтэй хослуулж, сайжруулсан арга зүйг боловсруулж, турших
4. Сайжруулсан арга зүйгээ түгээн дэлгэрүүлэх замаар боловсронгуй болгох ажлыг тогтмолжуулах

Судалгааны шинэлэг санаа

Сурагчдын нас сэтгэхүйн онцлогт нийцсэн дасгал даалгаврыг сонирхолтой аргаар, давтамжтайгаар ажиллуулсан нь тэдний эхийн агуулгыг ойлгож, уншилтад зарцуулсан хугацаа аажим аажмаар багасаж, өөртөө итгэлтэй болж байгааг тогтоосон нь судалгааны шинэлэг тал болно.

Судалгааны ач холбогдол

Унших чадварыг хөгжүүлэх арга зүйг ахмад болон залуу, дунд үеийн багш нарын арга зүйг нэгтгэн сайжруулж, баяжуулснаараа судалгааны ач холбогдол оршино.

Судалгааны арга

Асуулгын, ярилцлагын, туршилтын, ерөнхийгөөс тусгай руу, тусгайгаас ерөнхий рүү нэгтгэн дүгнэх

Судалгааны хамрах хүрээ

Бага ангийн багш нар

Онолын хэсэг

Дорноговь аймгийн Сайншанд сумын 1 дүгээр сургуулийн бага ангийн ахмад багш Х.Мягмарсүрэнгийн "Давтан унших арга зүй"-г сургалтдаа хэрэгжүүлж буй туршлага

<i>Зөв унших</i>	<i>Ойлгож унших</i>	<i>Хурдан унших</i>	<i>Уран унших</i>
Багшийн үлгэр жишээ уншлага Эхийг багш өгүүлэгчийн болон хүн ба амьтдын зан авирыг гаргасан өнгө аяс бүхий хоолойгоор уран тод, үлгэр жишээ уншиж өгнө. Багш уншаад эхэд юуны тухай өгүүлснийг ойлгосон эсэхийг тандах байдлаар асуултын дагуу ярилцана. Сурагчид өөрсдөө давтан, зөв уншина.	Зурган уншлага Үлгэрийн үйл явдлыг харуулсан зургийн дарааллыг ажиглуулж, ямар үйл явдал болж байгаа талаар сурагчидтай ярилцана. Ярилцаж дуусаад багш үлгэрийг уран уншиж өгдөг. Үүний дараа сурагчид өөрсдөө үлгэрийг уншиж, утгыг илүү сайн ойлгож авна.	Дамжуулан унших Эх болон үлгэрээс утгыг нь мэдэхгүй болон хүндэвтэр үгийг сонгож, урьдчилан хамтарч уншин, утгыг ярилцана. Үүний дараа сурагчид бие даан 3 удаа харааны уншлагаар уншина. Эцэст нь сурагчид үлгэрийг суудлын дарааллаар дамжуулан уншина.	Төлөөлөн унших Сурагчид үлгэрийг бие даан уншина. Үүний дараа багш буюу өөр нэг сурагч, үлгэр жишээ уншиж сонсоно. Дүрийг хуваарилан өгөх бөгөөд сурагчид өөрт оногдсон дүрийн үгийг бие даан уншиж бэлтгэнэ. Сурагчид хүн ба амьтдын зан авирыг гаргасан өнгө аясаар уншиж, дүрийн тоглолт хийнэ.

Судалгааны хэсэг

Бага ангийн багш нарт тулгамдсан асуудлуудыг тодорхойлох энэхүү асуулгыг Google forms программ ашиглан явуулсан бөгөөд Сайншанд сумын ЕБС-ийн 46 багш, УБ хотын ЕБС-ийн 32 багш, нийт 78 багш хамрагдлаа.

Асуулт 1. Сурагчдыг уншуулж сургахад залуу багш танд ямар бэрхшээл тулгардаг вэ? гэсэн асуултад хариулсан багш нарын хариултыг нэгтгэн дүгнэхэд:

- Авиаг таниулах болон авиаг зөв дуудуулж сургах арга зүй дутдаг учир хүндрэлтэй байдаг.
- Үе тогтоолгон, үеэр уншуулж, бичүүлж сургахад бэрхшээлтэй байдаг.
- Зөв, ойлгож, хурдан уншуулж сургах үе шатуудыг эзэмшүүлэх арга барил дутмаг.
- Уншуулж, бичүүлж сургах тоглоомын болон бусад олон арга зүйгээс суралцаагүй.
- Сургалтын цагт уншлагын цаг гэж байвал их зүгээр санагддаг. Хичээлээ цагт нь багтаах гээд сурагчдадаа дахин дахин уншуулж амждаггүй гэж хариулжээ.

Зураг 1. Сурагчдыг уншуулж сургахад тулгардаг бэрхшээлүүд




Дээрх зургаа үзэхэд залуу багш нар онолын мэдлэгээ хичээл, сургалтаас олж мэддэг боловч амьдрал дээр ахмад багш нарын тусламж дэмжлэг, зөвлөгөө маш чухал байдаг нь харагдаж байна. Ялангуяа, авиа таниулах, зөв дуудуулж сургах, унших чадварыг эзэмшүүлэх арга барил дутагдаж байна.

Асуулт 2. Эдгээр өөрт тулгамдсан асуудлаа хэрхэн шийдвэрлэдэг вэ? гэж асуухад:

- Өөрийгөө нээж, харуулан сурган хүмүүжүүлэх хичээл зааж, арга зүйгээ нэгтгэсэн.
- Бие даан болон баг болгон уншуулж, давтлага өгдөг.
- Эцэг эхтэй хамтарч ажилладаг.
- Үеийг сайн цээжлүүлж, хуулан бичлэг сайн хийлгэдэг.
- Хичээлийн цаг дээр уншлагын цаг нэмж оруулдаг.
- Бусад багш нараасаа асууж, шийддэг гэсэн хариултуудыг өгчээ.

Асуулт 3. Дорноговь аймгийн хэмжээнд бага ангийн нийт 213 багшаас Зөвлөх багш зэрэгтэй 3, Тэргүүлэх багш зэрэгтэй 61 багш байдаг бөгөөд үүнээс 41 наснаас дээш бага ангийн багш нарт Зөвлөх зэрэгтэй багш 3, Тэргүүлэх зэрэгтэй багш 21 байна. Мөн хүйсээр нь авч үзвэл Зөвлөх зэрэгтэй эмэгтэй багш 2, Тэргүүлэх зэрэгтэй эмэгтэй багш 20, эрэгтэй багш 1 байна. Дорноговь аймгийн төвийн ЕБ-ын зарим сургуулиудын ахмад багш нарын тоог гарган харахад 180 багшаас 41- ээс дээш насны 42 багш нар ажиллаж байна. Үүнээс бага ангид 10 багш нь ажиллаж байна.

Зураг 2. 41-ээс дээш насны багш нар



41-ээс дээш насны ахмад багш нар 23.3%-ийг эзэлж байна. Иймд залуу багш нар ахмад багш нараасаа суралцах нөөц бололцоо байна. Иймд залуу багш нар ахмад багш нарын арга зүйг өөрийн арга зүйтэй хослуулан практикт хэрэгжүүлэх боломжтой байна.

Ахмад багшийн арга зүйг өөрийн арга зүйтэй хослуулан “Давтан унших арга зүй”-г хэрэгжүүлсэн байдал ба гарсан үр дүн

2017-2018 оны хичээлийн жилд 1 дүгээр ангийг даан авснаар Х.Мягмарсүрэн багшийг дагалдан, зөвлөмж зөвлөгөөнийх нь дагуу ажиллаж эхэлсэн бөгөөд сурагчдаа уншуулж, бичүүлж сургах сургалтын үйл ажиллагаандаа Х.Мягмарсүрэн багшийн хэрэгжүүлдэг “Давтан унших” арга зүйг ашиглаж ирсэн. Ингэхдээ унших материалуудыг тухайн арга зүйтэй уялдуулан төрөл бүрээр бэлтгэж, сургалтдаа ашиглаж ирсэн бөгөөд үүний үр дүнд сурагчид маань унших чадварын хувьд ахицтай суралцаж чадсан.

Зурган эх унших арга

Энэхүү арга зүйг 1, 2 дугаар ангидаа хэрэгжүүлэхдээ сурагчдын нас, сэтгэхүйд тохирсон нэг эхийг сонгон авч, үйл явдлын дарааллыг зургаар илэрхийлсэн үзүүлэн, тараах материалыг бэлтгэн дараах үе шаттайгаар ашигласан.

1. Зургийн дарааллыг ажиглуулж, ямар үйл явдал болж байгаа талаар ярилцдаг.
2. Ярилцаж дуусаад багш өөрөө үлгэрийг уран уншиж өгдөг.
3. Сурагчид өөрсдөө үлгэрийг уншиж, утгыг ойлгож авна.

Зураг 3. Минутынуншлагын тэмдэглэл




Зураг 4. Сар бүрийн Түвшин тогтоох шалгалтын анализ



Үүний үр дүнд сурагчдын зөв хурдан унших чадвар хөгжиж, тус хичээлийн жилд зохион байгуулагдсан Анги хамт олны олимпиадад 1-ийн даваанд 80.2%, 2-ын даваанд 82.1%-тай үнэлэгдсэн.

Зураг 5: Анги, хамт олны олимпиад




Энэхүү графикаас харахад сурагчдын сурлагын чанарт ахиц гарч, 2017-2018 оны анги нийтийн олимпиадад сурагчдын унших чадвар 1-2 даваанд 4.8%-иар, 2018-2019 оны анги нийтийн олимпиадад 1-2 даваанд 1.9%-иар тус тус нэмэгдсэн нь харагдаж байна. Анги ахих тусам сурагчдын

унших чадвар нь маш сайн нэмэгдэж байна.

Өөртөө унших энэхүү арга зүйг 3, 4дүгээр ангид даа түлхүү хэрэглэж, сурагчдын ахицыг тооцож ажилласан. Ингэхдээ төрөл бүрийн эхийг сонгон, үзүүлэн тараах материал бэлтгэж, ашигладаг.

1. Эхлээд сурагчдаар эхийг уншуулна. Харааны уншлагаар 3 удаа уншина.
2. Эхийн утгыг ойлгосон эсэхийг шалгаж, төрөл бүрийн нээлттэй асуултуудыг асууна.
3. Дараа нь эхтэй холбоотой дасгал даалгавруудыг ажиллуулна.
4. Энэ аргыг “Дамжуулан унших”, “Нийтээр унших” аргатай хослуулж болно.

Зураг 6. Минутын уншлага



Энэ аргыг хэрэгжүүлснээр сурагчдын бие даан ойлгож унших, асуудлыг шийдвэрлэх чадвар нэмэгдэж, ангийн уншлагын дундаж хурд ахисан. Ингэснээр сар бүр авдаг унших чадварын шалгалтад ахиц гарч, 12 дугаар сарын шалгалтад 84.2%-тай шалгагдсан бөгөөд бусад 3-р ангиудаас дээгүүр үнэлэгдсэн.

Мөн 2019-2020 оны хичээлийн жилд Чанарын үнэлгээний шалгалтад улсын дунджаас 17.8%-иар, аймгийн дунджаас 10%-иар дээгүүр үнэлэгдсэн.

Өөрийн мэргэжлийн арга зүйд гарсан өөрчлөлт

Ахмад багшаа дагалдан, зөвлөгөө

Зураг 7. Чанарын үнэлгээний шалгалт, 2019



зөвлөмжийг нь дагаж ажилласнаар залуу багш миний заах арга зүй, ур чадварт ахиц гарч, сурган хүмүүжүүлэх арга ухаанаас илүү ихийг суралцаж, ингэснээр мэргэжлийн хувьд өсөж байна. Үүний үр дүнд:

- Сурагчдаа оношилж, сурлагын түвшинг нь тогтоож, ахиц бууралтыг тооцож сурсан.
- Арга зүйгээ хэрэгжүүлж, үр дүнг тооцдог болсон.
- Монгол хэлний хичээлд ашиглах 20 төрлийн нэгж хичээлийн хөтөлбөрийг бие даан болон бусад багш нартайгаа боловсруулсан.
- Монгол хэлний хичээлээр 84 төрлийн цахим хичээл болон видео хичээлүүдийг бэлтгэж төрөлжүүлсэн сан бий болгосон.
- Мөн 2021-2022 оны хичээлийн жилд “Нүдлэн цээжээр бичих” аргыг энэхүү аргатайгаа хослуулан бие даан ашиглаж байна.

Арга зүйгээ түгээн дэлгэрүүлсэн байдал ба үр дүн

2017-2018 оны хичээлийн жилд Сайншанд, Зүүнбаян, Иххэт сумын ЕБС дээр явагдсан бүсийн сургалтад 85 багшид “Зурган уншлагын арга зүй”-г түгээн дэлгэрүүлсэн. Мөн 2018-2029 оны хичээлийн жилд өөрийн сургуулийн багш нарт арга зүйгээ түгээн дэлгэрүүлж, сургалт явуулсан.

Арга зүйгээ секцийн багш нартаа түгээн дэлгэрүүлснээр 2018-2029 оны хичээлийн жилд аймгийн БСУГ-аас зохион байгуулсан Анги нийтийн олимпиадад 2 дугаар ангиуд маань амжилттай дүгнэгдсэн.

Хүснэгт 2. Анги нийтийн олимпиадын дүн

Анги	Бүлэг	Хүүхдийн тоо	Гүйцэтгэлийн хувь
2	а	43	59.5
2	б	42	54.6
2	в	44	82.1
2	г	43	84.8
2	д	43	74.4

Хүснэгтээс харахад БСУГ-аас зохион байгуулсан Анги нийтийн олимпиадад 2в, 2г, 2д ангиуд амжилттай дүгнэгджээ. Мөн 2 дугаар ангиудын нийт гүйцэтгэлийн дундаж 71.08%-тай дүгнэгдсэн.


Дүгнэлт

- Хэдийгээр бид ХХI зууны техник технологитой хөл нийлүүлэн боловсролыг чиглүүлж байгаа боловч сурагчдыг уншуулж сургахад залуу багш нарт ахмад багш нараасаа зөвлөмж зөвлөгөө авах, арга аргачлалаас нь суралцах шаардлага зайлшгүй тулгардаг нь судалгааны ажлаар тогтоогдсон.
- Эдгээр тулгамдсан асуудлаа шийдвэрлэхийн тулд би боловсролын байгууллагад 30 жил ажилласан ахмад багш Х.Мягмарсүрэнгийн зөвлөснөөр “Давтан унших арга”-ыг 2017 оноос хойш ангидаа хэрэгжүүлж, өөрийн арга зүй, ур чадварыг сайжруулж ирсэн.

- Ахмад багшийн зөвлөмж зөвлөгөөг авч, хамтарч ажилласнаар сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион явуулах, сурагчдын унших чадварт ахиц гаргах гол түлхэц болж өгсөн бөгөөд тэдний зөвлөмж зөвлөгөө нь бодитой, арга зүйгээ хэрэгжүүлж, үр дүнг нь тооцсон, олон жилийн судалгаатай, ажлын байран дээрээ хөгжих боломжийг олгодог зэрэг олон давуу талуудтай байдаг.
- Сургуулийн зүгээс зөв менежментийг боловсруулж, залуу багш нарыг ахмад багш нарт хариуцуулан өгч, цаашид “Сайн багш” болох эх суурийг нь тавьж өгдөг “Халамжлан хүмүүжүүлэгч” үйл ажиллагааг явуулсны үр дүнд залуу багш би сурагчдыг уншуулж сургах арга зүйг амжилттай хэрэгжүүлсэн.

Дэвшүүлж буй санаа

ЕБС-ийн байгууллагын менежментийг дараах 5 үе шаттайгаар харж болох юм.



- 1, 2 дугаар ангидаа зурган эх уншуулж сурагчдын зөв хурдан унших чадварыг хөгжүүлэх
- 3, 4 дүгээр ангидаа өөртөө унших, нийтээрээ унших, багшийг дуурайн унших, дамжуулан унших зэрэг оновчтой аргуудаас сонгон авч сургалтандаа тууштай
- Ахмад багш нарынхаа амжилтад хүрсэн арга зүйг судлан өөрийн арга зүйд нутагшуулж хэрэглэх
- Сургууль бүр байгууллагын менежментийг боловсруулахдаа ахмад багш нарын үүрэг оролцоо, нөлөөллийг тусган хамтарч ажиллах

Ном зүй

Адьяасүрэн,Ц. (2006). Сургалтын олон талт хөтөлбөр боловсруулах арга зүй. Улаанбаатар.
Эрдэнэчимэг,Ч. (2019) Боловсролын салбарт нийгмийн эргэх хариуцлагыг бэхжүүлэх нь. Улаанбаатар.
Насанбаяр,Б. (2018) Боловсрол судлал. Улаанбаатар хот
Ваанчиг,Ж. (1985) Сурган хүмүүжүүлэх тэргүүн туршлага дэвшилт арга барил. Улаанбаатар.
БШУЯ. (2019) Гадны туршлага боловсрол. Улаанбаатар хот.
БШУЯ. (2019) Боловсролын салбарт эргэх хариуцлагыг бий болгох нь.
БШУЯ. (2018) “Бага ангийн сурагчдын унших чадварыг хөгжүүлэх, үнэлэх зарим арга, хэрэгсэл” боловсролын чанарын шинэчлэл төсөл. Улаанбаатар хот.
МУБИС. (2018). Судалгааны ажлын арга зүй. Улаанбаатар хот.
Интернэт эх үүсвэр:
Sur,[www.http://Teacher. Sur, mn /](http://Teacher.Sur.mn/)
<http://www.google.mn /4411>
<http://www.slideshare.net/tudu9586/ss-48141625/>

МЭРГЭЖЛИЙН ӨСӨЛТӨД ТУРШЛАГАТАЙ БАГШИЙН ХАМТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НӨЛӨӨЛЛИЙГ СУДАЛЖ ДЭВШҮҮЛСЭН ХУВИЛБАР

Ө.Баянсан¹, Ж.Долгорсүрэн², Э.Ганцэцэг³, Б.Бямбадэлгэр⁴

Дундговь аймгийн ерөнхий боловсролын лаборатори

“Эрдмийн далай” цогцолбор сургууль

O.baysuk.BSN@gmail.com¹, dogooj@gmail.com², Eganaa378@gmail.com³,
byamba1004@gmail.com⁴

Оршил

Аж үйлдвэрийн IV хувьсгалтай холбоотойгоор ирээдүйд бидний хүүхдүүдийн 65 хувь нь шинээр бий болох ажлын байранд ажиллана. Мөн 2030 он гэхэд хөгжингүй орнуудын дунджаар ажлын байрны 30 хувь роботоор солигдоно. НҮБ-аас зохион байгуулсан “Хүн бүрт хүртээмжтэй, тэгш, насан туршдаа суралцах чанартай боловсрол” сэдэвт Дэлхийн боловсролын форумас Инчеоны тунхаглалын үзэл санаагаар 2030 он хүртэлх Дэлхийн боловсролын алсын хараа нь “Нэгдсэн зорилго, хүсэл эрмэлзэлтэй, хүн бүрт хүрсэн боловсролын хөтөлбөрийг боловсруулна хэмээн тодорхойлсон. Олон улсын чиг хандлага нь бие даан, бүтээлчээр суралцахуйд суралцах, мэдлэгт суурилсан тогтвортой хөгжлийг дэмжигч бүтээлч ирээдүйг төлөвшүүлэхийг зорьж байна.

Монгол улс нь урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний хөтөлбөр, хөгжлийн бодлого төлөвлөлт, багш мэргэжилтний тасралтгүй хөгжил тулгуур зорилтын хүрээнд 2020-2024 он хүртэл “Чадварлаг багш” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Дээрх нэр бүхий томоохон бичиг баримт, олон улсын тунхаглалаас гадна Монгол улсын боловсролын салбарыг хөгжүүлэх, багшийн хөгжлийг хангах (Чадварлаг багш хөтөлбөр гэх мэт) бодлогын чанартай эрх зүйн зохицуулалт бүхий бичиг баримтууд, тушаал, шийдвэрүүд гарч байна. Эдгээрийг анхан шатандаа хэрэгжүүлэгчид нь, түүний үр дүнг тодорхойлж, судлан шинжлэх, турших сайжруулагчид нь бүх шатны багш нар гэдэгтэй маргах хүн үгүй. Багш нар нь мэргэжлээ дээшлүүлэх, арга зүйгээ сайжруулах, шинэ зүйл суралцахдаа чадамжтай, туршлагатай багштай мэргэжлийн чиглэл, заах аргын нэгдлээр тасралтгүй хамтран ажилласны үр дүнд хөгжиж болох юм гэж үзэж байна.

Түлхүүр үг: өөрчлөлт; шийдэл; үр өгөөж.

Оршил

Судалгааны ажлын зорилго

Чадамжтай багшийн хамтын үйл ажиллагаан дахь нөлөөллийг судалж хамтран ажилласнаар багш нар хөгжиж үр дүнд хүрнэ.

Судалгааны ажлын зорилт

1. Багш нарын хамтын үйл ажиллагааг судлах
2. Багш бүрийн чадамж, нөлөөллийг судлах
3. Багш бүр чадамжтай туршлагатай багш нартай хамтран ажилласнаар ямар үр дүнд хүрэх

Дэвшүүлж буй асуудал

Өнөөгийн 6-12 дугаар ангийн сурагчид 2004-2010 оныхон бөгөөд digital generation (дижитал уугуул) гэж нэрлэгдэж байгаа хүүхдүүд байна.

2000-2005 он	2005 хойш
Үнэ цэн, үр ашигт суурилсан цаг үе	Холбоо хамаарлын цаг үе
Оюуны хүчинд суурилж, хүмүүстэй харилцах	Оюуны хүчинд суурилж, хамтран ажиллаж амьдрах
Оюун-Хүн	Оюун-Хамтын ажиллагаа

XXI зууны хүүхдүүдийн бүрдүүлэх ёстой чадамжийг дараах байдлаар буюу мэдэхэд суралцахуй, бүтээхэд суралцахуй, хамтдаа амьдрахад суралцахуй, оршихуйд суралцахуй гэсэн дөрвөн тулгуур агуулгыг ЮНЕСКО-с зарласан байна. Тиймээс багш бидэнд дээрх дөрвөн чадамжийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай. Дижитал уугуулууд гэж нэрлэгдэж буй шинэ мянганы хүүхдүүдийн сонирхлыг төрүүлж, хэрэгцээг хангахуйц, мэдлэг бүтээлгэх, хичээлийг бэлтгэж зохион байгуулах нь чухал юм. ЕБС-ийн багш нар дан ганцаараа өөрөө бие даан мэдлэг боловсролоо дээшлүүлэн хөгжинө гэдэг бол өрөөсгөл ойлголт юм. Тухайн багшийн оролцоо, хамтын ажиллагааг эрхэмлэн аливаа үйл ажиллагаанд оролцох оролцоогоо нэмэгдүүлэн, ажиллаж байхыг орчин үеийн боловсрол биднээс шаардаж байна. Хичээл сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад хөтөлбөр боловсруулах, төлөвлөгөө гаргах, ээлжит хичээл боловсруулах, нэгж бичих, хэрэглэгдэхүүн бэлтгэх, суралцагчдын төлөвшил хандлагад нөлөөлсөн үйл ажиллагаа, анги удирдах, тайлан бичих, дэвтэр шалгалтын материал засах, эцэг эх багш болон сурагчдад зориулсан сурагчийн сургууль цэцэрлэгийн хүрээнд болж буй мэдээлэл хяналтын платформ буюу <https://www.esis.edu.mn/> сайтад ажиллах, мэдээлэл харилцааны технологийн асуудлууд тулгамдаж байна.



Энэхүү тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхийн тулд багш нарын мэргэжлийн өсөлтөд ахмад багшийн зүгээс чиглүүлэн ажиллах явцдаа өөрийгөө хөгжүүлж, дижитал уугуулууд гэж нэрлэгдэж буй шинэ мянганы хүүхдүүдтэй хэрхэн ажиллах арга зүйд суралцах боломжуудыг туршин дээрх шийдлийг дэвшүүлж байна.

Судалгааны ажлын таамаглал

Дижитал хүүхдүүдтэй ажиллах болон хичээл сургалтын ажлыг хэрхэн богино хугацаанд үр дүнтэй хамтран ажиллах зэрэг асуудлуудыг шийдвэрлэхэд багш нар хувь нэмрээ оруулна. Үүнийг шийдвэрлэхийн тулд багш нар нь туршлагатай, чадамжтай багштай хамтран ажиллаж хичээл сургалтын үйл ажиллагааг зохион байгуулснаар дараах үр дүнд хүрнэ гэж таамаглаж байна. Үүнд:

- Орчин үеийн мэдээлэл технологи, техник хэрэгсэл дээр баг нартай хамтран ажиллах
- Ээлжит, нэгж хичээл, сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүнийг хамтран хийснээр сурлагын ахиц болон багш хөгжиж амжилт үр дүнд хүрэх гол арга зам
- Мэргэжлийн багш нар хамтран хөгжих боломжийг түгээн дэлгэрүүлэх
- Туршлагатай, чадамжтай олон жил ажилласан багштай хамтран ажиллах

Судалгааны арга зүй

Багш нарын хичээл сургалтын үйл ажиллагааг ажиглаж сонгон авсан сэдвийн хүрээнд асуулгыг нээлттэй болон хаалттай хэлбэрээр хослуулан боловсруулсан. Судалгааны боловсруулалтыг хийхдээ дараах аргачлалаар гүйцэтгэлээ.

- Судалгаанд мэдээлэл түүвэрлэх, эх сурвалж судлах аргыг сэдвийн судлагдсан байдлыг тогтоох, онолын хэсгийг боловсруулах
- Асуулгын аргаар багшийн хөгжлийн өсөлтөд ямар хүчин зүйлс нөлөөлж буйг тодруулах.
- Цахим орчинд мэдээллийн технологи ашиглан багш нар хамтарч, хэрхэн хөгжиж байгааг судлах
- Статистик боловсруулалтын аргыг цуглуулсан мэдээлэлд боловсруулалт хийх

Шинэлэг санаа



“Дуслыг хураавал далай

Дуулсныг хураавал эрдэм”

(өчүүхэн багаас их юм үүсдэг гэсэн санаа)

Далай мэт туршлагатай багшаас дусал дуслаар (дуслан загвар) зөвлөгөө авч хэрэгжүүлснээр тухайн багш туршлагатай манлайлагч удирдагч (Teacher leadership) багш болох боломж байгааг илрүүлэх нь шинэлэг тал болно.

Үндсэн хэсэг

Багшийн хөгжлийн чиг хандлага

Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 3.1.2.-т багшийн мэдлэг, арга зүй, ур чадвар, боловсролоо дээшлүүлэх тасралтгүй үйл явцыг багшийн хөгжил гэж тодорхойлсон байна. Багш хүн ажил, амьдралынхаа явцад өсөж хөгждөг бөгөөд сурган хүмүүжүүлэх

ухааны итгэл, үнэмшлийн болон туршлагын өвөрмөц тогтолцоог илэрхийлэгч юм. Багшийн хөгжил нь 2 талтай байна.

1. Багшийг хөгжүүлнэ
2. Багш өөрөө хөгжинө

Дээрх хоёр үйл явц харилцан уялдаатай хамтдаа явагдах юм. Нөгөө талаас багш өөрийгөө хөгжүүлэхийн тулд хүсэл эрмэлзэлтэй, мэргэжилдээ дуртай, эрэл хайгуул хийгч байх зэрэг нь чухал үүргийг гүйцэтгэх юм. Багшийг хөгжиж буй талаас нь дараах байдлаар ангилж үзсэн байдаг.

- *Хөгжих бололцоотой багш*: Нэгэнт багш мэргэжил эзэмшихсэн, эхний жилүүддээ ажиллаж байгаа залуу багш нар.
- *Хөгжиж буй багш*: Тухайн шинжлэх ухаан болон түүний дидактикийн онол, арга зүйг гүнзгийрүүлэн судалж мэргэшиж байгаа, ур чадвараа тасралтгүй дээшлүүлж өөрийгөө хөгжүүлэх тодорхой чиглэлтэй ажиллаж байгаа багш.
- *Хөгжсөн багш*: Энд хэнийг оруулах нь харьцангуй асуудал бөгөөд мэргэшил, мэдлэг, ур чадвараа төгс эзэмшсэн, нийгэм, төлөвшлийн өндөр түвшинд хүрсэн, судалгаа шинжилгээний арга зүйг сайн эзэмшсэн энэ чиглэлээрээ бусдад орчин үеийн шаардлагад нийцсэн онол, арга зүйн зөвлөгөө, мэдээлэл өгч чадах, цаашид улам хөгжин мэргэших төвшинд хүрсэн хүнийг оруулан авч үзэж болох юм.

Хөгжсөн багшийн загварыг дараах байдлаар томъёолж, багш бүр энэхүү загварт хүрэхийг зорьж болох юм.

1. Төлөвшлийн 7 чадвар
2. Арга зүй, эв дүйн 8 чадвар
3. Бүтээлч хандлагын 7 чадвар
4. Дидактик чадварын 7 чадвар
5. Хөгжлийн 4 чадвар

Чадамжтай багшийг илрүүлэн хамтын үйл ажиллагаан дахь нөлөөллийг судалж хамтран ажилласнаар багш нар хөгжиж үр дүнд хүрч болно.

Судалгааны хэсэг


Судалгааны шинэлэг тал

Багш нар нь бие биенээсээ хэрхэн суралцдаг, туршлагатай багшийн нөлөөллийг хамтран ажиллах явцдаа суралцаж багш хөгжих боломж байгааг судалж, өөрсдийн хэрэгжүүлсэн үйл ажиллагааны жишээн дээр судалсан нь шинэлэг тал болно.

Багш таны хувьд хөгжихөд дараах үйл ажиллагаануудын аль нь хамгийн их нөлөөлдөг вэ?

Нөлөөллийн судалгааны ерөнхий дүгнэлт: Судалгаанд хамрагдсан 364 багшаас авсан нөлөөллийн судалгаанаас харахад багш нар нь ихэвчлэн 60-70 хувь хамтран ажиллахдаа хөгждөг байгаа юм. Хамтран ажиллахдаа *агуулгын хувьд* ээлжит хичээл боловсруулахдаа, хэрэглэгдэхүүний хувьд тарааж өгөх материал бэлтгэх явцдаа, *арга зүйн хувьд* сургалтын идэвхтэй аргыг ашиглах явцдаа, *өөрийн хөгжлийн хувьд* хүүхэд нэг бүртэй ажиллах арга зүйгээ нэмэгдүүлэх явцдаа, *технологийн хувьд* цахим орчинд ажиллах явцдаа хамгийн ихээр хөгждөг ба бусдад нөлөөлж чаддаг гэж багш нар хариулсан байна.

Зураг 1. Чадамжийн түвшний өөрийн үнэлгээ



Судалгаанд хамрагдсан нийт 364 багш нарын 57.08 хувь төлөвшсөн, 30.18 хувь дундаж, 11.4 хувь нь хөгжиж буй гэж өөрсдийнхөө чадамжийг тодорхойлсон нь харагдаж байна. Тэгвэл 11.4 хувь 30.18 хувь байгаа багш нар 57.08 хувь байгаа багш нартай хамтран туршлага хуваалцан нэг нэгэндээ нөлөөлснөөр хөгжих боломж байгаа юм.

Туршиж хэрэгжүүлсэн байдал

Хүснэгт 1. Багш нар хамтран ажилласан байдлын үр дүн

№	Ажилласан чиглэл	Хэдэн жил	Хэдэн удаа	Хэдэн хүнтэй хамтарсан	Хэдэн хүн суусан
1	Хөтөлбөр боловсруулахад	2012 оноос 10	9	8	
2	Ээлжит хичээл боловсруулахад	2015 оноос 8	50	14	
3	Нэгж хичээл боловсруулахад	2019 оноос 3	2	4	
4	Гарын доорх материал ашиглан хэрэглэгдэхүүн бэлтгэх	2015 оноос	34	6	
5	Мэргэжлийн багш нарт зохион байгуулсан сургалт	2018 оноос 5	5	10	37
6	Мэргэжлийн багш нарт зохион байгуулсан сургалт	2018 оноос 5	3	8	89
7	Нэгдсэн		103	50	126

Дүгнэлт

Судалгаанд 4 дүүрэг, 8 аймгийн 364 багш хамрагдсан. Нийт оролцсон багш нарын байнга хамтран ажилладаг 18 хувь, 48 хувь нь ихэвчлэн, 19 хувь нь голдуу хамтран ажилладаг гэсэн хариулт өгч байгаагаас нийт багш нарын 85 хувь нь үйл ажиллагааны хамтын хэлбэрт шилжсэн гэж үзэж болохоор байна. Агуулгын хувьд: Хамтын ажиллагаа нь ихэвчлэн судалгаат хичээлээр дамжин илэрч байна гэдгийг нийт судалгаанд хамрагдсан багш нарын 45 хувь хариулт өгч 25 хувь нь ээлжит хичээл боловсруулахад хамтран ажилладаг гэсэн нь өнөөгийн багш нарын хөгжилд голлох нөлөөлөл үзүүлж байгаа нь 70 хувьтай байна. Хэрэглэгдэхүүний хувьд: Дараах төрлийн хэрэглэгдэхүүн бэлтгэхэд багш нар хамгийн ихээр хамтран ажиллаж байна гэж үзсэн. Үүнд: Тарааж өгөх материал бэлтгэх – 47 хувь, туршилтын хэрэглэгдэхүүн боловсруулахдаа гарын доорх материал ашиглах- 33 хувь, нийт 80 хувь нь эдгээр

хариултыг өгсөн байна. Арга зүйн хувьд: Идэвхтэй сургалтын арга—47 хувь, даалгавар төлөвлөлт—24 хувь гэсэн сонголтууд дээр нийтдээ 71 хувь нь хамтарч ажилладаг гэжээ. Өөрийн хөгжлийн хувьд: Хүүхэд нэг бүртэй ажиллах арга зүйгээ нэмэгдүүлэх - 41 хувь, онолын мэдлэг – 34 хувь нийт судалгаанд оролцогчдын 75 хувь нь энэ хариултыг сонгожээ. Технологийн хувьд: Цахим орчинд ажиллах – 64 хувь, программ ашиглах – 42 хувь гэсэн сонголтууд өгч байгаа нь цахим сургалт хүчтэй түрэн орж ирж буй өнөөгийн нөхцөл байдалтай холбон тайлбарлаж байна. Чадамжийн судалгааны нэгтгэл: Судалгаанд хамрагдсан нийт 364 багш нарын 57.08 хувь төлөвшсөн, 30.18 хувь дундаж, 11.4 хувь нь хөгжиж буй гэж өөрсдийнхөө чадамжийг тодорхойлсон байна. Тэгвэл 11.4 хувь, 30.18 хувь байгаа багш нар 57.08 хувь байгаа багш нартай хамтран туршлага хуваалцан нэг нэгэндээ нөлөөлснөөр хөгжих боломж байгаа юм.

“Дуслан загвар” дахь хамтын үйл ажиллагааны нөлөөллийг хэрэгжүүлэхэд дэмжлэг болохуйц давуу талуудыг дээрх үр дүнгээр харуулж байгаа юм.

2012 оноос хойш өнөөг хүртэл сургуулийн болон аймгийн хэмжээний мэргэжлийн багш нарт нийт 103 удаагийн сургалт, нэгж болон ээлжит хичээлийн боловсруулалт хийх, туршилтад болон үзүүлэх хичээл заах зэрэг олон үйл ажиллагааг багаар хамтран тасралтгүй зохион байгуулж байна. Үүнд давхардсан тоогоор 50 багштай хамтран ажилласан ба мөн өөрсдийн үйл ажиллагааны арга туршлагаа түгээн дэлгэрүүлэх, санал солилцох, хэлэлцүүлэг хийх, ажиглалт явуулах зорилгоор 126 багшийг хичээлдээ суулгасан тоон үзүүлэлт гарсан. Эдгээр нөлөөллийн үйл ажиллагааны үр дүнд аймгийн арга технологийн санд 6-р ангийн физикийн хичээлийн бүтэн жилийн 33 цагийн нэгжийн боловсруулалт, 8-р ангийн “Даралт” сэдвийн 13 цагийн нэгж, 9 дүгээр ангийн “Гүдгэр линзэнд үүсэх дүрсийг судлах” 1 цагийн бичлэгтэй хичээл зэргийг боловсруулан бүртгүүлсэн.

Дэлхийн том хичээл Тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний хэлэлцүүлэг 2021 арга хэмжээнд суурь боловсролын шилдэг 30 хичээлийн нэгд өөрсдийн боловсруулсан “Өдөр тутмын үр ашиггүй зарцуулалтаа хэрхэн багасгах вэ?” сэдэвт хичээлээр оролцож бүртгүүлсэн.

2018-2019 оны хичээлийн жилд Дундговь аймгийн 9 дүгээр ангиудын Чанарын үнэлгээний физикийн хичээлийн дундаж улс – 26 хувь, аймаг – 27 хувь, тухайн Эрдмийн далай цогцолбор сургуулийн дундаж 33.7 хувь байгаа нь улсын дунджаас 7.6 хувь -иар, аймгийн дунджаас 6.7 хувиар илүү үнэлэгдсэн дээрх хамтын үйл ажиллагаануудын нөлөөллийн эцсийн үр дүн гэж онцлон дүгнэж байна.

Дэвшүүлж буй санал

Улс орны болон орон нутгийн түвшинд

- Хүүхэд нэг бүртэй ажиллах арга зүйн чадамжаа нэмэгдүүлэх
- Багш бүр судалгаат хичээлийг үндсэн технологиор нь эзэмших
- Гарын доорх материал ашиглан тарааж өгөх материал бэлтгэх нь чухал
- Онолын мэдлэгээ дээшлүүлэх
- Цахим орчинд ажиллах, программ ашиглах

- Багшийн хөгжлийн шалгуурын ерөнхий стандарт гаргах (Жишээ нь: ментор багш болохын тулд сонирхсон чиглэлээрээ хэдэн удаагийн сургалт, ямар үнэлгээгээр үнэлэгдэх, үнэлгээгээ хэдэн удаа баталж байж авах зэрэг...)

Багш нарын түвшинд:

- Багш нар өөрийн чадварын нөхцөл байдлаа өөрсдөө үнэлэн тодорхойлж, үр дүнг өөрийн хөгжлийн төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлдэг байх
- Өдөр тутамд хэрэглэгддэг нэр томъёонуудыг маш сайн мэддэг байх (Жишээ нь: судалгаа авахад арга, арга зүй, амжилт, давуу тал гэх мэт үгүүдийг нэг утгаар ойлгож байна.)
- Багш нарын аливаа үйл ажиллагаанд оролцох хандлагаа өөрчлөх (Жишээ нь: судалгаанд хамрагдахдаа асуултыг ойлгох, англи кирилл хольж бичих, хариулт бичих зүйлд цэг тавьж үргэлжлүүлэх зэрэг, өөрийнх нь санал үзэл бодлоо үнэ цэнэтэй байна гэдгээ ойлгох)

Ном зүй

Ганбат,М. Амартайван,Ц. Алтангоо,О. Бурмаа,Б. Бат-Отгон,Б. Бавуудорж,Р. Үүрийнтуяа,Д. Батболд,Х. Зоригт,Г. Мөнхсайхан,Я. (2018). Багшийн ном X- XII.Улаанбаатар

Ганбат,М. Норжмаа,Г. Энэбиш,Ж. (2014). Шинжлэх ухаанч эрэл хайлтыг хичээлд хэрэглэх зөвлөмж. Эрдэм шинжилгээний хоёрдугаар бага хурлын эмхэтгэл. БСШУЯ, БМДИ, МХСН ТББ. Улаанбаатар.

Гажиддулам,Ч. Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй онол практикийн 5-р бага хурлын илтгэлийн дэлгэрэнгүй

Ганбат,М. Амартайван,Ц. Алтангоо,О. Бурмаа,Б. Бат-Отгон,Б. Бавуудорж,Р. Үүрийнтуяа,Д. Батболд, Х. Зоригт, Г. Мөнхсайхан, Я. (2018).Багшийн ном X- XII. Улаанбаатар

Болормаа Ж. БМД захирал <http://itpd.mn/article/394>

(2002). Бага дунд боловсролын тухай хууль. Улаанбаатар

(2019). Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль. Улаанбаатар

Байгальмаа,Ч. (2015). Боловсролын судалгааны арга зүй. Улаанбаатар

(2016). Бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөр. БСШУСЯ

Пүрэвдорж,Ч. Багшлахуйн менежмент. Улаанбаатар. 399-р тал

БСШСЯ. (2015). Суурь боловсролын цөм хөтөлбөр.

Тэгшжаргал,Н. (2009). Багаар ажиллах эрдэм.Улаанбаатар

www.google.com

www.itpd.mn

<http://ch.stat.eec.mn/>

Нарангэрэл,Ч. Оюунцэцэг,Н. Урансайхан,З. Баярмаа,Г. Сайнбилэг,Ш. Лхавгасүрэн,П. Отгонбаяр,Н. Батбилэг,Ж. (2007). Сорил тооцоогоор мэдлэг бүтээлгэх арга зүй – зөвлөмж I Улаанбаатар

ЗАЛУУ БАГШ НАРЫН ХӨГЖИЛД АХМАД БАГШ НАРЫН ОРОЛЦОО НӨЛӨӨЛӨХ НЬ

Б.Долгорсүрэн¹, Г.Цэндорж², Н.Оюунгэрэл³

Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын Ерөнхий боловсролын сургууль

dogoo0203@gmail.com¹, gtsee0202@gmail.com², n.oyungerel1402@gmail.com³

Хураангуй

Боловсролын шинэчлэлийн бодлого нь багш нарынхаа заах арга зүй, мэдлэг боловсролыг ажлын байранд тасралтгүй хөгжүүлэхэд, ахмад багш нарын оролцоо хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд чиглэж байна. Энэхүү чиглэлээр судалгааг 2021-2022 оны хичээлийн жилд 9 сараас 2 сар хүртэлх 5 сарын хугацаанд хийхдээ залуу багш нарын хичээл сургалтын үйл ажиллагаанд тулгарч буй бэрхшээлийг илрүүлэх, ахмад багш нартай хамтарч ажиллах боломжийг судлах, арга замыг тодорхойлох, хичээлүүдэд суух, сурагчдын мэдлэг эзэмшилт, ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулалт, гэрийн даалгаврыг сурагчдад бие даан хөгжих арга барилд суралцахад нөлөө болохоор чиглүүлэх боломжуудыг хамруулан гарааны судалгааг хийж, сайжруулах боломжийг судлан, туршин хэрэгжүүлэх үйл ажиллагааг ахмад багшийн оролцоотойгоор хамтран хийж хэрэгжүүлэх гэсэн санааг судалгааныхаа үр дүнд дэвшүүлж байна.

Түлхүүр үг: багшийн хөгжил; хамтын ажиллагаа; арга зүй.

Оршил

Судалгааны шинэлэг тал, зорьсон санаа

Бид энэхүү судалгаагаар залуу багш нараа шүүмжлэх гэсэнгүй, тэдэнд тулгарч буй бэрхшээлийг даван туулахад, ахмад багш нарын зүгээс хамтран ажиллах арга замыг хэрхэн яаж шийдэхийг бодит туршлага, судалгаанд үндэслэн хүргэхийг зорилоо. Сайн багшаас сайн шавь төрдөг гэдэг. Иймээс залуу багш нарыг хөгжүүлэхийн тулд тэдний өмнө тулгарч буй асуудлыг илрүүлэх, шийдвэрлэх арга замыг эрж хайх нь чухал асуудал юм. Уг асуудалд дүн шинжилгээ хийхийн тулд говийн бүсийн багш нарын төлөөллийг судалгаандаа хамруулсан үр дүнгээ танилцуулж байна. Судалгаанд говийн бүсийн сумдын 93 багш хамрагдсан.

Судалгааны зорилго: Залуу багш нарт сургалтын үйл ажиллагаа явуулахад тулгарч буй бэрхшээл, түүнийг ахмад багш нарын оролцоотойгоор шийдэх арга замыг тодорхойлох

Судалгааны зорилт

Багш нарын арга зүйд тулгарч буй бэрхшээлийг илрүүлэх

Залуу багш нартай хамтран ажиллахад ахмад багш нарын оролцоог нэмэгдүүлэх боломжийг судалж, туршилт хийж үр дүнг дүгнэх

Судалгааны арга:


Асуулгын арга, ярилцлагын арга, ажиглалтын арга, туршин судлах, нэгтгэн дүгнэх

Судалгааны хэсэг

Сайн багшаас сайн шавь төрдөг гэдэг. Иймээс залуу багш нарыг хөгжүүлэхийн тулд тэдний өмнө тулгарч буй асуудлыг илрүүлэх, шийдвэрлэх арга замыг эрж хайх нь чухал асуудал юм. Уг асуудалд дүн шинжилгээ хийхийн тулд говийн бүсийн багш нарын төлөөллийг судалгаандаа хамруулсан үр дүнгээ танилцуулж байна.

Судалгаа 1. Судалгаанд говийн бүсийн сумдын 93 багш хамрагдсан.

Зураг 1. Судалгаанд хамрагдсан багш нарын ажилласан жил



ажиллаж буй залуу багш нар бүрдүүлж байгаа нь боловсролын салбарт эрч хүчтэй шинэлэг сэтгэлгээтэй хойч үеийн залгамж халаа бэлтгэгдэж байгаа ч тэднийг арга зүй, ур чадварын хувьд туршлагажуулахад ахмад багш нар ихээхэн анхаарч ажиллах шаардлага бий болж байна. Ийм учраас ахмад багш нар залуу багш нартай хамтран ажиллах чиглэлээ боловсруулахын тулд тэдэнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлэхээр асуулга авсан.

Асуулт 1. Багш танд ажлын байранд өөрийгөө хөгжүүлэхэд ямар асуудал тулгарч байна гэсэн асуултад 1-20 жил ажиллаж байгаа багш нар хамрагдсан. Асуулгаас дүгнэхэд арга зүй дутмаг- 56, ажлын ачаалал их- 10, компьютер, принтерийн хүрэлцээ муу чанаргүй- 25, хүүхдүүдийн идэвх оролцоо тааруу-20, туршлага бага- 30, ахмад багш нарын зөвлөгөө маш их хэрэгтэй байна- 45, цахим орчны мэдлэгээ сайжруулах шаардлага гарч байна-11 гэсэн хариултуудыг өгсөн байна. Асуулга -1-ээс Залуу багш нарын хувьд арга зүй дутмаг бөгөөд ахмад багш нараас суралцах хүсэлтээ илэрхийлсэн нь хамгийн өндөр хувьтай байгаа нь багш нар хамтран ажиллах хэрэгцээг бий болгож байна (Зураг 2).

Зураг 2. Багшийн хөгжилд тулгарч буй бэрхшээлүүд, давхардсан тоогоор



Асуулт 2. Таны бодлоор, залуу багш нарын арга зүйг сайжруулахад тэдэнд тулгарч байгаа ямар асуудлууд байна вэ ? гэсэн асуулгад 21 жилээс дээш ажилласан 22 багш асуухад дараах хариултыг өгчээ.

- Заах арга зүй дутмаг- 16
- Өөрийгөө дайчлах чадвар- 10
- Хөтөлбөр боловсруулалт-12
- Онолын мэдлэг сул- 8
- Хүүхэдтэй ажиллах-12
- Хандлага, сэтгэлгээг өөрчлөх –14
- Дэвтэртэй ажиллах- 10
- Судалгаа хийх- 6
- Бусдаас асуух, суралцах-15

Асуулгын хариултаас дүгнэхэд ахмад багш нарын хувьд, залуу багш нарт арга зүй дутмаг, хандлагаа өөрчлөх, бусдаас суралцахад өөрийгөө дайчлах, бие даан хөгжих чадвараа нэмэгдүүлэх шаардлага байгааг олж харсан байна.

Асуулт 1 ба 2-ыг харьцуулахад залуу багш нарт заах арга зүй, бусдаас суралцах чадвар дутмаг байгаа нь хөгжих хэрэгцээ үүсэж байна. Иймээс багш бид хаана хаанаа анхаарч өөрсдийн боломж бололцоогоо ашиглан ажиллавал багш нар маань хөгжиж, цаашдаа сурагчид маань хөгжих боломж бүрэн байна. Мөн залуу багш нар ажлын туршлага бага байж болох ч, өөрийгөө хөгжүүлэхэд тэдний хичээл зүтгэлээс их зүйл шалтгаална.

Ингээд дээрх судалгаануудын дүгнэлтийг үндэслэн залуу багш нарын арга зүйг ахиулахад ахмад багш нарын оролцоог нэмэгдүүлэх зорилтоо биелүүлэхээр өөрийн сургуулийнхаа залуу багш нартай хамтран ажиллахаар болж, 1 сарын аян зарлаж, цаашдаа тогтмол хамтарч ажиллах, сургуулийн зүгээс чиглүүлэн ажиллахаар болсон.

Залуу ба ахмад багш нар хамтарч ажиллан судалгаа хийж, туршин хэрэгжүүлсэн ажлаасаа танилцуулж байна.

Судалгаа 2. Багш нарын хичээл төлөвлөлтөд тандалт хийсэн судалгаа (9 сард)

Залуу багш нарын жилийн төлөвлөлт, нэгж хичээл, ээлжит хичээлийн 17 цагийн хөтөлбөрт анализ хийж, багшийн хичээл төлөвлөлтийн чанар ямар түвшинд байгааг судалсан.

Жилийн төлөвлөлтөд шинжилгээ хийхэд:

- Зорилго зорилт тусгасан байдал- 52.9%,
- Агуулгын хуваарилалтыг хийсэн байдал нь 70.5%
- Жилийн үнэлгээ тусгасан байдал- 29.4% байсан. Эндээс харахад жилийн төлөвлөлтөд зорилго, зорилт, үнэлгээг маш бага , оновчтой бус тусгасан байна.

Нэгж хичээлийн төлөвлөлтөд шинжилгээ хийхэд:

- Зорилго зорилт тусгасан байдал- 73.3%,
- Нэгжийн агуулга, цаг төлөвлөлт, агуулгын залгамж холбоог гаргасан байдал 50%

- Нэгжийн үнэлгээ тусгасан байдал- 29.4%-тай байна. Эндээс харахад нэгжийн төлөвлөлтөд агуулгын залгамж холбоог сайн гаргасан боловч цаг төлөвлөлт, үнэлэх арга аргачлалыг хангалтгүй тусгасан байна.


Ээлжит хичээлийн төлөвлөлтөд шинжилгээ хийхэд:

- Зорилго зорилт тусгасан байдал- 70.5%
- Агуулгын хуваарилалт- 64.7%
- Арга зүй тусгасан байдал- 35.2%
- Хэрэглэгдэхүүний төлөвлөлт: 47%
- Үнэлгээгээ төлөвлөсөн байдал- 29.4%-тай байсан. Дүгнэлт хийхэд багш нар ээлжит хичээлийн төлөвлөлтөд зорилго зорилт, агуулгын хуваарилалтыг анхаарч, ямар арга зүйгээр хичээлээ заах, түүнийг дэмжсэн хэрэглэгдэхүүний шийдэл, үнэлгээг тусгах нь бага байсан.

Судалгаа 3: Залуу багш нарын хичээлд сууж хийсэн судалгаа (9 сард тандалтын судалгаа)

Судалгаанд өөрийн сургуулийн бага, дунд ангийн 17 залуу багш хамрагдсан (17 цагийн хичээл).

Зураг 3. Арга зүйн суурь үнэлгээ



Залуу багш нарын хичээлд сууж, доорх чиглэлээр анализ хийсэн тандалтыг графикаар харуулбал

Хичээлд суусан судалгаа, ээлжит хичээлийн төлөвлөлтөд хийсэн шинжилгээ хоёрыг харьцуулахад арга зүй, үнэлгээ, хэрэглэгдэхүүний шийдлийг боловсруулахад залуу багш нарын арга зүй дутмаг байгаа нь харагдаж байгаа учир ахмад багшийн оролцоог нэмэгдүүлэн хамтарч туршин ажиллахаар боллоо

Судалгаа 4. Математикийн 1 цагийн хичээлээр сурагчдын олж авсан мэдлэг эзэмшилтэд хийсэн гарааны судалгаа. Үүнд: 9 сард 1а ангийн 21 сурагч, 2а ангийн -23 сурагч, 3а ангийн 19 сурагч хамрагдсан. 1а ангийн “Нийлбэр олох” ээлжит хичээлийг заахад 66% тай байсан. 2а ангийн Математикийн “Багцлах буюу ижил нэмэгдэхүүнүүдийн нийлбэрийг үржвэрт шилжүүлэх” сэдэвт хичээлийг заахад сурагчдын 61.9% нь ойлгосон. 3а ангид “Арван мянга хүртэлх тоог унших, бичих сэдэвт хичээлийг заахад 57.8%-тай байсан. 1-3-р ангийн нийт хүүхдүүдийн гүйцэтгэл 53.9%-тай байна.

Тандалтын 3 судалгаанаас дүгнэхэд залуу багш нарын арга зүй, хүүхэдтэй ажиллах чадвар дутмаг, бэрхшээлтэй асуудлууд олон байгаа нь тэдний арга зүйг ахиулахад туршлагатай ахмад багш нарын оролцоог нэмэгдүүлж хамтран ажиллах шаардлага бий болж байна.

Туршин хэрэгжүүлсэн үйл ажиллагаа 1.

Багш нарын хичээлийн төлөвлөлтийг чанартай хийж сургах, арга зүйг ахиулахын тулд:

- Судлагдахуун бүрийн суралцахуйн удирдамж, зорилтыг уншиж, шинжлэх
- Агуулгын залгамж холбоонуудыг гаргах
- Үнэлэх арга аргачлалыг тодорхой болгох
- Хэрэглэгдэхүүний оновчтой байдлыг нэгж хичээл бүрээр төлөвлөн бэлтгэх
- Сургалтын идэвхтэй аргуудыг судлуулах зэрэгт чиглүүлж хамтран ажилласан.

Хичээл төлөвлөлтийг чанартай сайн хийлгэх талаар залуу багш нартайгаа хамтран 9 сард ажилласан үр дүн (Хүснэгт 1)

Сар		Хүснэгт 1: хамтын ажиллагааны үр дүн					
		Жилийн төлөвлөлт			Нэгжийн төлөвлөлт		
		Зорилго тусгасан байдал	Агуулгын хуваарилалт	Үнэлгээ	Зорилго тусгасан байдал	Агуулгын хуваарилалт	Үнэлгээ
9 сарын эцэст		88,2%	82,3%	64,7%	88,2%	73,5%	52,9%

Дүгнэлт хийхэд залуу багш нар жилийн болон нэгжийн төлөвлөлтөө хийх арга зүйд нь ахиц харагдаж байгааг ахмад багш нарын хамтын ажиллагааны ололттой тал гэж хэлж болно.

Туршин хэрэгжүүлсэн үйл ажиллагаа 2.

Бага боловсролын залуу багш нартайгаа ахмад багш нар хамтран 2-р ангид “Тэнцүү илэрхийлэл”, “Өгөгдөлтэй ажиллаж, зурган диаграмм байгуулах”, 3-р ангид “Ангилал” 1-р ангид “Тоо тоолол” сэдэвт хичээлүүдийг бэлтгэн заалгаж, хэлэлцүүлэг хийн арга зүйгээ сайжруулах санал зөвлөгөөг өгч ажиллахаас эхэлсэн. 9 сараас эхлэн Мягмар гараг бүрт залуу багш нартайгаа хамтран ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулах, арга зүйн зөвлөгөө өгөх, бусдаасаа суралцах ажлыг хийж, 10 сараас эхлэн өөрсдөөр нь ээлжит хичээлийн бэлтгэлийг хийлгэн хичээлд нь сууж зөвлөгөө өгч ажилласан.

Хүснэгт 2. Залуу багш нарын арга зүй гарч буй өөрчлөлт	
Багш бүр ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулахдаа хэрэгжүүлэн баримталсан алхмууд	Хичээл заах арга зүйд гарсан өөрчлөлт
Зорилго : -Хүүхдүүд юуг яаж хийхээ мэддэг болтол нь тодорхой томъёолох -Зорилгыг зөв томъёолохын тулд суралцахуйн удирдамжийг багш нараар судлуулах	- Зорилгоо биелүүлэхийн тулд сурах бичгээс хуулбарлах бус, суралцахуйн зорилтуудтай уялдуулан төлөвлөж байна

Агуулгын төлөвлөлт, залгамж холбоо:

-Ээлжит хичээл дээр багш ямар хэрэглэгдэхүүн хэрэглэж чиглүүлэх, яаж сэдэлжүүлэх, хэрхэн дэмжихээ төлөвлөнө.
-Агуулга нь өмнөх ба дараагийн хичээлийн агуулгатай хэрхэн холбогдож, байгааг тодруулж судлах


-Хичээлийг зөв сэдэлжүүлэхээс эхэлж, сурагчдаар шинэ мэдлэг бүтээлгэх үйлийг ямар асуултаар, яаж чиглүүлэн дэмжих арга зүйд суралцаж үр дүнд хүрч байгаа
-Агуулгын залгамж холбоог тодруулахаас гадна сурагчдын гэрийн даалгаврын гүйцэтгэлд судалгаа хийх
-Хийхгүй байгаа шалтгааныг олж илрүүлэн тэдэнтэй ганцаарчлан ажилласнаар хүүхдийн даалгавраа хийх идэвх сайжирсан.
-Багш хүүхэдтэйгээ тулж ажиллах, тэднийг ойлгох урамшуулах, дэмжих эв дүйтэй болсон.

Арга зүйн хувьд:

-Идэвхтэй сургалтын аргуудаас судалж хэрэглэх
Ахмад багш нарын хичээлд сууж туршлага судлах ажлуудыг хийснээр ахиц гарсан.


Математикийн хичээлд ТДХ аргыг үр дүнтэй хэрэглэж сурч байна
Асуудал дэвшүүлэн шийдвэрлэх, Нэрийн сугалааны арга, Тоглоомын аргууд, Аялангаа хөгжицгөөе, хүүхэд бүрт хүрч ажиллах зэрэг өөрсдийн сонирхсон олон аргуудаас туршин хамтран ажиллаж байна.

Туршин хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг тодорхойлох зорилгоор хийсэн судалгааны үр дүнг дараах зургаар харуулбал:



Багш нарын ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулах, хичээл заах арга зүйн үр дүнгийн судалгааны дараа багшийн заасан 1 цагийн хичээлээр сурагчдын эзэмшиж байгаа мэдлэг ойлголтын ахицад судалгаа хийв (Зураг 6).

Зураг 5. Мэдлэг ойлголтын ахицын судалгаа



Залуу багш нартай хамтран 5 сарын хугацаанд арга зүйг нь ахиулахаар ажилласан. Үүний үр дүнд хүүхдийн идэвх оролцоо нэмэгдэх, анхаарал төвлөрөх, залуу багш нарын хувьд арга зүйд ахиц гарснаар 1 цагийн хичээлээр сурагчдын эзэмшсэн мэдлэг ойлголтын дундаж 84.1% хүрсэн байгаа нь ахмад багш нартай хамтран ажилласны давуу тал байлаа.

Туршин хэрэгжүүлсэн үйл ажиллагаа 3.



Залуу багш нарыг бусад багш нарын хичээлд 7 хоног бүр 1 удаа суулгаж, тэмдэглэлд нь анализ хийсэн. Багш бүр хичээлийн явцыг товчхон тэмдэглэсэн байсан. Харин арга зүйн шинэлэг санааг олж харах тал нь хангалтгүй байлаа. Хичээлд суугаад тэмдэглэл хөтлөхдөө өөрийн үйл ажиллагаандаа хэрэг болохуйц арга зүйн санаануудыг олж харж тэмдэглэх, туршин хэрэгжүүлж, арга зүйгээ ахиулах талаар зөвлөгөө өгч, 10 цагийн хичээлд хамтран сууж, хичээл бүрээр хэлэлцүүлэг хийн тэмдэглэл дээр нь ярилцсанаар бүтээлч хандлага нь нэмэгдэж байгаа нь ажиглагдсан. Залуу багш нар бусад багшийн хичээлд сууж арга зүйн шинэлэг санааг олж харсан байдлыг гараа ба ахицаар харуулбал:

Өмнө нь (бэрхшээлтэй асуудал)	Хамтран ажилласны дараах ололттой тал
- Хичээл дээр хийгдэж буй үйл ажиллагааны дарааллыг товч бичих - Ихэнхдээ тэмдэглэлийг хийгээгүй он сар тавих, цөөхөн өгүүлбэр бичих - Юу бичих, арга зүйг олж харах талаар чадвар дутмаг байсан. - - Идэвхгүй байдал	- Хичээлээ хэрхэн сэдэлжүүлж байгаа - Хичээлийн алхмуудын дарааллыг ойлгох - Багш хүүхэд бүртэй хүрч ажиллах арга - Гаргасан алдааг тухай бүр нь засаж, самбарт тайлбарлах - Хичээлээ ямар арга зүйгээр явуулж байгааг тэмдэглэх - Сурагчдыг үнэлэх үнэлгээний хэлбэрүүдээс суралцах - Хичээлийн зорилгын биелэлтээ дүгнэн ярилцах - Хэрэглэгдэхүүнийг зөв сонгон хэрэглэх - Багш сурагчдын мэдэхгүй зүйлийг асуултаар зөв чиглүүлж байгаа - Самбар төлөвлөлтөө сайн хийх, түүн дээрээ дүгнэлтээ хийж байгаа - Гэрийн даалгаврын хэмжээг тохируулж, сонирхолтой хэлбэрээр өгч байгаа зэрэг арга зүйн санаануудыг олж харж, тэмдэглэж байгаа нь багш нарын арга зүйд тодорхой ахиц гарч байгаагийн илрэл юм.


9-өөс 2 сар хүртэлх хугацааны ажлын үр дүнд залуу багш нарын ажилдаа хандах хандлага өөрчлөгдөж, арга зүйн хувьд ахицтай байгаа нь хамтран ажиллаж чадвал алдаа оноогоо олж ухааран өөрийгөө хөгжүүлэх боломжийг нээж байна гэж үзсэн. Туршилтын дараах заагдсан ээлжит хичээлүүдийн самбар төлөвлөлтөөс харахад багш нарт арга зүйн ахиц гарч байгаа нь харагдаж байна.

Самбар төлөвлөлт

Зураг 6. Өмнөх самбар төлөвлөлт



Зураг 7. Туршин хэрэгжүүлсэн үйл ажиллагааны дараах самбар төлөвлөлт



1а

2а

3а

Судалгаа 5. Залуу багш нартай хамтран ажилласны дараа судалгааг доорх асуултаар авсан.

Ахмад багш нараас авсан арга зүйн зөвлөгөө, зөвлөмж, туршлагыг ажилдаа хэрхэн хэрэгжүүлж байна вэ?

Зураг 8. Ахмад багш нараас авсан арга зүйн зөвлөгөө, зөвлөмж, туршлагыг хэрэгжүүлж буй үр дүн (давхардсан тоогоор)



Залуу багш нар маань ахмад багш нарын зөвлөгөөнөөс санаа авч баяжуулан ашиглаж байгаа нь сайн талтай.

Судалгаа 6: Ахмад багш та, туршилтын хугацаанд залуу багш нартай ямар ямар чиглэлээр хамтран ажиллаж, зөвлөгөө өгсөн бэ? гэсэн асуултаар ярилцлагын судалгаа авахад

- Арга зүйн чиглэлээр
- Хөтөлбөр боловсруулалт
- Зөв бичих дүрэм, онолын мэдлэг
- Бодлого бодох аргачлал
- Хүүхэд бүртэй ажиллах
- Бусдаас суралцах, хамтарч ажиллах
- Хичээл зохион байгуулалт
- Бичиг баримт хөтлөх
- Цахим хичээл хамтран бэлтгэх
- Судалгаат хичээл зааж илтгэл бичих гэх мэт чиглэлээр хамтран ажиллаж зөвлөгөө өгсөн байна.

Дүгнэлт

Боловсролын салбарт ажиллаж байгаа багш нар, багшийн хөгжилд чухал нөлөөтэй зүйл нь хүүхэд хөгжүүлэх арга зүй болон хамтын ажиллагаа гэж үзсэн нь багшид сурагчдаар мэдлэг бүтээлгэснээр сурлагын чанарт ахиц гарах болно гэдгийг олж харсан байна.

Судалгааг 9 сараас 2 сар хүртэлх хугацаанд хийхдээ залуу багш нарын хичээл сургалтын үйл ажиллагаанд тулгарч буй бэрхшээлийг илрүүлэх, ахмад багш нартай хамтарч ажиллах боломжийг судлах, арга замыг тодорхойлох, хичээлүүдэд суух, сурагчдын мэдлэг эзэмшилт, ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулалт, гэрийн даалгаврыг сурагчдад бие даан хөгжих арга барилд суралцахад нөлөө болохоор чиглүүлэх боломжуудыг хамруулан гарааны судалгааг хийж, сайжруулах боломжийг судлан туршин хэрэгжүүлэх үйл ажиллагааг ахмад багшийн оролцоотойгоор хамтран хийж хэрэгжүүлсний дараа үр дүнгийн судалгааг хийсэн болно.

Багш арга зүйгээ ахиулснаар хичээлээ зохион байгуулах, хүүхэд бүртэй хүрч ажиллах, гаргасан алдаагаа дахин давтахгүй байхад анхаарах, хүүхдээ үнэлэх, бусдын хичээлээс өөрт туршлага болох шинэлэг санаануудыг олж харах зэрэг олон үйл ажиллагаа нь сайжрах давуу талтай байгаа нь хамтын ажиллагаанаас харагдсан. Гэхдээ залуу багш нарын арга зүйг сайжруулах үйл ажиллагаа нь богино хугацаанд их үр дүнд хүрэх ажил биш бөгөөд хугацаа шаардсан уйгагүй хөдөлмөр, хичээл зүтгэл, идэвх оролцоо, тухайн багшийн ажилдаа хандах хандлага зэргээс шалтгаалсан нарийн төвөгтэй үйл болох нь бидний туршин хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад харагдсан.

Багш бүр өөр өөрийн өвөрмөц онцлогтой учраас асуудлыг шийдвэрлэх, аливаад хандах хандлага нь ч өөр өөр байх биз. Гэхдээ л багш бүрийн өөрийгөө мэдрэх, нээн илрүүлэх идэвхтэй оролцоо л боловсролын шинэчлэлийн гол хүчин зүйл байх болно.

Залуу багш нарт зөвлөхөд харж чадвал хажууд чинь байгаа ахмад багш нарт арвин их туршлага байдгийг олж харж, арга зүйгээ ахиулан сайн багш болох боломж бүрэн байдаг шүү.

Ахмад багш нар залуу багш нарын техник технологитой ажиллах чадвараас суралцаж байсан нь хамтран ажиллахад эергээр нөлөөлж, тэдэнд итгэл нэмж, урам хайрлаж байсан.

Дэвшүүлж буй санаа

- Залуу багш нарын арга зүйг хөгжүүлэхэд ахмад багш нарын хамтын ажиллагааг сайжруулах ажлыг боловсролын байгууллагын шат бүрийн ажлын төлөвлөгөөнд тусгах
- Тодорхой нэг зүйлийг туршиж хэрэгжүүлснээр орхиж болохгүй, үргэлжлүүлэн үр дүнгээ үзэж өөрийн тогтсон арга зүйтэй болох
- Багшийн үйл ажиллагаа нь элдэв бичиг баримт бүрдүүлэх цаасны ажил руу илүүтэй чиглэх болж, хүүхэдтэй ажиллах бүтээлч хандлага багасаж байгаа юм биш биз гэсэн эргэлзээ ч төрж байна. Энэ нь боловсролын бодлогыг тогтвортой байлгахтай холбоотой юм.

Ном зүй

Итгэл,М. (2019). Бага боловсролын математикийн хичээлийн суралцахуйн зорилт

БСШУЯ, Дэлхийн банкнаас хэрэгжүүлж буй “Боловсролын чанарын шинэчлэл төслийн хүрээнд
“ Бага ангийн суралцагчдын математик чадварыг хөгжүүлэх арга зүй “ цахим сургалт

Багш боловсролын хөгжлийн шинэ чиг хандлага”

(2003). МУИС – ийн мэргэжлийн дидактикийн сургалт судалгааны төв. Улаанбаатар. 30х

Нарантуяа. Р. Бүтээлч багш түүнийг дэмжих, үнэлэх тухай асуудлууд.

Киёсаки,Р., Лектер,Ш. (2007). Баян болохын тулд “монополи” тогло. “Боловсрол судлал” сэтгүүл.
х63. Улаанбаатар: Соёмбо Принтинг.

Багшийн хөгжлийн өнөөгийн байдал, түүнийг өөрчлөх арга замууд”

Орнштейн,А. (2007). Сургалтын материал. “Боловсрол судлал” сэтгүүл. х35. Улаанбаатар:
Соёмбо Принтинг.

Н.Бэгз . Багш нарын мэргэжлийн ёс зүй ба нийгмийн үүрэг хариуцлагын асуудалд.

БШУЯ. (2021). ЕБС-ийн сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө.

Оюунцэцэг. Н. (2021). ХХI дүгээр зууны боловсролын чиг хандлага: Сургалтын орчныг хувирган
өөрчлөх асуудал.

ЗАЛУУ БАГШ НАРЫН ТӨЛӨВШИЛД АХМАД БАГШ НАРЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ

Бямбасүрэнгийн Оюунсүрэн

Нийслэлийн Налайх дүүргийн ерөнхий боловсролын

109 дүгээр сургууль

mglsisi38@gmail.com

Хураангуй

Миний хувьд мэргэжлээрээ 2 дахь жилдээ, мөн 2 дахь удаагаа ЭЕШ-д сурагчдыг бэлтгэн ажиллаж байгаа залуу багш. Залуу багш нарын хувьд шилжилтийн насны сурагчдад анх хичээл заахад ойлголтын зөрүү үүсэх, бие биенээ хүндлэхгүй байх, сургалтын үр дүн ахицгүй байх, цаашлаад шантрах, сэтгэлээр унах зэрэг асуудал үүсдэг. Энэхүү судалгааны ажлаар дээрх асуудлуудын үүсгэгч хүчин зүйлүүдийн нэг нь багш нарын бие хүний төлөвшил мөн гэдэг таамаглал дэвшүүлж, mentor - mentee (МЕТ хөтөлбөр)-г хэрэгжүүлснээр уг асуудал багасгах, боловсролын чанар дээшилнэ гэдгийг харуулахыг зорин сурагчид, залуу болон ахмад багш нараас А.Маслоуын хэрэгцээ тодорхойлох асуулгын судалгаа болон бусад холбоотой судалгаануудыг авсан.

Түлхүүр үгс: ахмад багш; бие хүн; төлөвшил; А.Маслоу.

Оршил

Боловсролын эцсийн зорилго бол мэдлэг чадвартай, төлөвшсөн иргэн (бие хүнийг)-ийг нийгэмд бүтээхэд оршино. Эрдэм мэдлэгээс гадна хүмүүжил төлөвшил нь сурган хүмүүжүүлэх үйлийн салшгүй хэсэг юм. Өнөөдөр мэдлэг, мэдээллийг хүмүүс бие даан судлах боломжтой хэдий ч хүмүүжлийг бие даан сурч олж авна гэдэг учир дутагдалтай. Бие хүнийг боловсрол олгох замаар төлөвшүүлдэг. Хүн өөрөө нийгмийн амьтан тул бусадтай харилцаж, нийгмийн харьцаанд орж байж бие хүний хөгжлийг хөгжүүлэх боломжтой. Үүнд багш болон сургуулийн орчин хамгийн чухал үүрэгтэй. Тиймээс улс орны ирээдүйг бэлтгэдэг багш нар минь бие хүний хөгжлийн төвшингийн хувьд ямар байгаа вэ? Багш бүр зөв төлөвшсөн иргэн болж чадсан уу? Багш нарын төлөвшлийг сайжруулах шаардлагатай юу? зэрэг асуултууд гарч ирж болох юм.

Залуу багш нарын бие хүний хөгжилд ахмад багш нарын үзүүлэх нөлөөллийг илрүүлж, түүнийг цаашид хэрэгжүүлэх боломжтой замуудыг олж тогтоох нь судалгааны үндэслэл болно.

Судалгааны ажлын зорилго

Залуу багш нарын ажлын байранд тулгарч буй асуудалд бие хүний төлөвшлийн хамаарлыг судлах, түүнийг шийдвэрлэхэд ахмад багш нарын оролцоог хэрхэн нэмэгдүүлж болохыг судлах.

Судалгааны ажлын зорилт:

- Боловсрол судлал болон бие хүний хөгжлийн тухай онолын мэдээллийг уншиж судлах
- Боловсрол судлал болон бие хүний хөгжлийн тухай баримт, материал цуглуулах
- Залуу багш нартай ярилцах
- Ярилцлагын үндсэнд судалгааны асуулт боловсруулж таамаг дэвшүүлэх
- Судалгаанд анализ хийн, нэгтгэн дүгнэх
- Асуудлыг шийдвэрлэхэд нөлөөлөх арга зам, өөрийн саналыг дэвшүүлэх

Судалгааны хамрах хүрээ

ЕБС залуу болон ахмад багш нар, ахлах ангийн сурагчид

Судалгааны арга: ярилцлага, асуулга, ажиглалт, нэгтгэн дүгнэх

Судалгааны ажлын ач холбогдол

Багшийн хөгжил, төлөвшилд нөлөөлөх хүчин зүйлсийг илрүүлэн сайжруулснаар боловсролын салбар, цаашлаад улс орны хөгжил, эдийн засагт эерэг өөрчлөлт гарна.

Судалгааны хэсэг

Олон улсын судалгаа: МУ 2015 оноос хүний хөгжлийн индексээрээ 189 орноос 99 дүгээр байранд, 2021 оны судалгаагаар 168 орноос 84 дүгээр байранд жагссан байна. Хувь хүний хөгжлийн индексээрээ 2015 оноос 2019 оныг хүртэл хугацаанд 0,001 оноогоор дээшилсэн үзүүлэлт байна. Хувь хүний хөгжилд боловсрол чухал нөлөөлөгч чухал хүчин зүйл нь мөн. Хэдийгээр сүүлийн жилүүдэд уг үзүүлэлт бага хэмжээгээр нэмэгдэж байгаа ч хувь хөгжлийн нэн өндөр орнуудаас 4 жилээр бага суралцаж, 4 дахин бага орлоготой байна. Насжилтын хувьд 40-өөс дээш дундажтай Европын орнууд хүний хөгжлийн индекс болон улс орны хөгжлийн хувьд өндөр үзүүлэлттэй байдаг байна. Тиймээс насжилт улс орны хөгжилд нөлөөлдөг, ахмад багш нарын оролцоо боловсролд мөн нөлөөлнө гэсэн санааг дэвшүүлсэн.

Зураг 1. Хүний хөгжлийн индексээр дэлхийд тэргүүлж буй улс орнууд

-	Rank	Country	HDI value (2019)
	1	Norway	0.957
	2	Ireland	0.955
	2	Switzerland	0.955
	4	Hong Kong, China (SAR)	0.949
	4	Iceland	0.949
	6	Germany	0.947
	7	Sweden	0.945
	8	Australia	0.944
	8	Netherlands	0.944
	10	Denmark	0.940

Зураг 2. Боловсролын салбарт тэргүүлж буй улс орнууд



А. Маслоу хэрэгцээний шатлал


2013 онд Сэтгэл судлалын үндэсний төвөөс монгол хүний сэтгэл зүйд хэрэгцээгээ хэрхэн тодорхойлдог талаар судалгаа авчээ. Судалгааны үр дүнд монголчуудын 75 хувь нь Маслоугийн шатлалын эсрэг хэрэгцээгээ тодорхойлдог аж. Энэ нь ойрын хэрэгцээг /шаардлагатай/ хангахаас илүүтэйгээр холын хэрэгцээнд санаа зовдог аж.

Зураг 3, 4. Монгол хүний сэтгэл зүйн судалгаа




Миний хувьд эхний жилдээ багшилж эхлэхэд сурагчидтай харилцах тал дээр туршлага дутмаг байсан. Ажлын байран дээр уг асуудал нэлээд тулгарч байсанг А.Маслоу-гийн хэрэгцээний шатлалтай холбоотой байж болзошгүй гэсэн таамаглал дэвшүүлсэн. Үүний дагуу ахлах ангийн сурагчид болон залуу багш нарын хэрэгцээг тодорхойлох судалгаа авсан. Судалгаагаар залуу багш болон сурагчдын хооронд харилцааны тал дээр гардаг асуудлын мөн чанарыг тодорхойлохыг зорьсон. Судалгааны дүнд 16-17 насны сурагчид болон залуу багш нарын хувьд нийгмийн хэрэгцээ, физиологийн хэрэгцээ болон өөрийгөө хүндэтгэх хэрэгцээг чухалчилдаг гэсэн судалгааны хариу гарсан байна. Үүн дээр үндэслэвэл багш болон сурагчид хоорондын харилцаан дээр үл ойлголцол гарах, аль аль нь өөрсдийгөө түрүүнд тавьдаг харилцаанаас үүдэлтэй зөрчилдөөн гарж магадгүй гэж судалгаан дээрээс дүгнэлээ.

Зураг 5. Ахлах ангийн сурагчид болон залуу багш нарын хэрэгцээний судалгаа



Зураг 6. Сурагчдын хэрэгцээний судалгаа (29 сурагч)




Зураг 7. Залуу багш нарын судалгаа (32 багш)




Харин Ахмад багш нар сурагчидтай харилцах тал дээр залуу багш нараас илүү туршлагатай нь ажиглагдсан гэдэг нь практик дээр ажиглагдсан тул ахмад багш нараас мөн хэрэгцээ тодорхойлох судалгаа авсан.

Зураг 8. Ахмад багш нарын хэрэгцээний судалгаа




Судалгааны дүнд ахмад багш нар суурь хэрэгцээг соёлын хэрэгцээнээс илүүд үздэг гэсэн судалгааны үр дүн гарсан байна. Энэ нь ахмад багш нар сурагчидтай харилцах арга зүйд залуу багш нараас илүү туршлагатай гэсэн дүгнэлтэд хүрч болохоор байна.




Нийслэлд багшилж буй 36 багшаас ажлын байранд тулгардаг асуудлуудын талаар судалгаа авч тэдгээрийг шийдвэрлэхэд ахмад багш нараас ямар асуудал дээр зөвлөгөө авах хүсэлтэй талаар судалгаа авлаа.

Зураг 9. Насжилтын эзлэх хувийн судалгаа



Зураг 10. Мэргэжлээрээ ажилласан жилийн судалгаа



Зураг 11 Ажлын байранд тулгардаг бэрхшээлүүдийг нэгтгэсэн нь:

Судалгааны үр дүн: Залуу багш нарын хувьд 50 хувиас дээш анги удирдах, сурагчидтай ажиллах арга зүйн тал дээр ахмад багш нараасаа зөвлөгөө авах хүсэлтэй гэсэн хариу гарсан байна.

Зураг 12 Ахмад багш нар эхний жилдээ ажиллаж байхад тулгарч байсан бэрхшээлүүдийн судалгаа



Зураг 12. Ахмад багшийн судалгаа



Судалгаанаас үзэхэд ахмад багш эхний жилдээ багшилж байхад тулгарч байсан бэрхшээл нь мөн сурагчидтай харилцах харилцаа байсан байна. Туршлага хуримтлуулж тухайн асуудлыг бүрэн шийдвэрлэхэд дунджаар 3 жилийг зарцуулсан байна. Тэгвэл залуу багш нар ахмад багшаас туршлага судалж, зөвлөгөө авсны дүнд уг хугацааг 1 жил хүртэл буулгаж болох боломжтой гэж харж байна.

Дүгнэлт

Боловсролын систем дэх сайжруулалтын хамгийн чухал хэсэг нь багшийн хөгжил, түүний суурь үзүүлэлт болох багшийн төлөвшил юм.

1. Ахмад багш нар мэргэжлээрээ ажиллах хүсэл эрмэлзэл өндөр байна.

Өөрийн сургуульд ажиллаж байсан 2 ахмад багшаас мэргэжлээрээ ажиллах боломжтой юу? гэсэн асуултын хүрээнд ярилцахад “тийм” гэж хариулсан. Энэ нь ахмад багш нар цаашдаа мэргэжлээрээ ажиллах хүсэлтэй болохыг харуулсан үр дүн юм.

2. Залуу багш болон сурагчдын харилцааны асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

А.Маслоугийн хэрэгцээний шатлалын онолын судалгааны үр дүнгээс харахад сурагчид болон залуу багш нар нь өөрийгөө хүндлүүлэх хэрэгцээг чухалчилж үздэг. Энэ нь залуу багш нар болон сурагчдын харилцаанд сөргөөр нөлөөлж, залуу багш нарын хувьд

сурагчидтай харьцах болон анги удирдах арга зүйд зөвлөгөө тусламж авах хэрэгцээ үүссэн гэсэн дүгнэлтэд хүрч байна.

3. Ахмад багш нарын оролцоог бий болгосноор хувь хүний хөгжлийн индексийг дээшлүүлэх боломжтой.

Монгол Улсын хувь хүний хөгжлийн индексийн үзүүлэлт нь хангалттай өссөн харагдахгүй байна. Хөгжлийн индексийн үзүүлэлтэд боловсролын нөлөөлөл их юм. Өөрөөр хэлбэл, залуу багш нь нийгэм дэх хувь хүн болохын хувьд түүнд хамаарах хувь хүний хөгжилд эерэг нөлөөг ахмад багш нар нь бодитоор үзүүлэх боломжтой юм.

Дэвшүүлэх санал

Ахмад багш нарын оролцоог залуу багш нарын сурагчидтай харьцах арга зүйд дэмжлэг үзүүлэхэд оролцуулах боломжтой гэж харж байна. Олон улс болон компаниудад сүүлийн үед өргөнөөр хэрэглэгдэж байгаа МЕТ хөтөлбөр буюу нэг талаас Mentor, нөгөө талаас Mentee хамтран тухайн салбартаа чадварлаг боловсон хүчин бэлтгэх хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн санааг дэвшүүлж байна. Энэхүү хөтөлбөрийг бизнесийн салбарт тэргүүлэх томоохон компаниуд ‘Cat’ болон ‘General Electric’, Монгол улсдаа банк, даатгалын салбар нэвтрүүлж ажиллаж эхлээд байна. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр:

- Боловсролын чанар тодорхой хэмжээнд дээшилнэ.
- Залуу багшийн төлөвшилд эергээр нөлөөлж хугацаа хэмнэнэ.
- Хувь хүний индексийн үзүүлэлт нэмэгдэнэ.
- Нийгэмд эерэг өөрчлөлт гарна гэж үзэж байна.

Ном зүй

Prosperity index ranking. /2021/ London Mongolia (Ranked 87th) :: Legatum Prosperity Index 2021, <https://mn.wikipedia.org/wiki/%D0%91%D0%BE%D0%BB%D0%BE%D0%B2%D1%81%D1%80%D0%BE%D0%BB>

Эрдэнэтуяа,Л. (2019). *Илтгэл биологи*. https://www.academia.edu/42917654/Илтгэл_биологи

Монцема. (2019). *Хүний хөгжлийн индексийн судалгаа*. Human development index Mongolia - Search (bing.com)

World population review website. (2022). *Хүний хөгжлийн олон улсын судалгаа*. Human Development Index (HDI) by Country 2022 (worldpopulationreview.com)

Батчимэг,П. (2006). *“Багшийн хөгжилд хувийн зохион байгуулалт нөлөөлөх нь”*

Санжжав,Д. (2000). *Сэтгэл судлалын ухааны тайлбар толь*. Улаанбаатар.

Louis Tay and Ed Diener. (2019). Universal needs and well being. https://academic.udayton.edu/jackbauer/Readings/595/Tay_Diener_11_needs_WB_world_copy.pdf?fbclid=IwAR10CIVHDee6nqATxL5qmQupOVtWai9zlpH-kXoetAmzZRBDVhKZ40S8qc

ЗАЛУУ БАГШ НАРЫН ЗААХ АРГА ЗҮЙД АХМАД БАГШИЙН ОРОЛЦОО НӨЛӨӨЛСӨН НЬ

Д.Энхээ¹, З.Хатантуяа², М.Энхмэнд³

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын ерөнхий боловсролын

3 дугаар сургууль

enkheee0429@gmail.com¹ hatantuya1124@gmail.com² m.enxmend005@gmail.com³

Хураангуй

Бид ахмад багш нараас заах арга зүйн зөвлөгөө авч, хамтран ажиллах нь залуу багшийн арга зүйд хэрхэн нөлөөлдөг болохыг судлан дүгнэх зорилгоор:

1. Залуу багш өөрийн заах арга зүйгээр ганцаарчлан явуулсан сургалтын үр дүнг гаргаж ахмад багшаасаа зөвлөгөө авсан.
2. Залуу болон ахмад багшийн заасан сургалтын үр дүнг харьцуулж, хамтран ажилласан.
3. Ахмад багшаас заавар зөвлөгөө авч, хамтран явуулсан сургалтын үр дүнг гаргасан.
4. Ахмад болон залуу багш нарын хамтын ажиллагааны давуу тал, үр дүнг сурагчдад гарсан чадвараар харьцуулж дүгнэлт хийсэн.

Үндэсний бичиг анхлан суралцаж буй сурагчдад “Титэмт үсгийг үсэгчлэн заах” аргаар сургалтаа явуулахад сурагчдын унших, бичих чадварт хоцрогдол их гарч, заавал ахин заах шаардлагатай болж хүүхдийг залхаах асуудал тулгарч байсан тул ахмад багшаасаа зөвлөгөө авч хамтран хичээлийг бэлдэж, заах арга зүйгээ өөрчлөн “титэмт үсгийг гийгүүлэгч амилуулах” аргаар сургалтыг явуулснаар сурагчдын мэдлэг чадварт төдийгүй хандлагад өөрчлөлт гарсан. Иймээс ахмад багш нартайгаа хамтран ажиллаж, тэдний заах арга зүйгээс суралцаж сургалтдаа хэрэгжүүлснээр багш өөрөө хөгжөөд зогсохгүй шавийн мэдлэг чадварт нөлөөлж байгааг тодорхой нэг сэдвээр туршилт сургалтаа явуулан, харьцуулалт гаргаж үзэхэд үр дүн нь илэрхий байлаа.

Түлхүүр үг:

Залуу багш - Багш мэргэжлийн ёс зүйг эзэмшсэн, ахмад багш нараас суралцаж өөрийгөө хөгжүүлдэг

Заах арга - Хэрхэн зааж сургах тухай онол үзлийн цогц

Ахмад багш - Мэргэжлээрээ он удаан жил тасралтгүй ажилласан өөрийн арга зүйтэй сурган хүмүүжүүлэгч

Оролцоо - Тухайн үйлд оролцож туслах, дэм болох байдал

Нөлөөлөл - Нөлөө үзүүлэх үйлийн үр дүн

Оршил

Боловсролыг эзэмших үндсэн зам буюу арга хэрэгсэл бол сургалт юм. Сургалтын явцад боловсролын зорилт шийдвэрлэгдэнэ. Сургалт бол багш, сурагчдын хамтарсан үйл ажиллагааны хэлбэр. Сургалтыг зохион явуулахад тухайн багшийн заах арга зүй чухал үүргийг гүйцэтгэнэ. Иймээс Монгол улсын “Боловсролын тухай хууль”- ийн 5 дугаар зүйл Боловсролын үндсэн зарчим “5.1.3. боловсрол эзэмшүүлэх арга, хэлбэр, суралцагчийн хэрэгцээ, хувийн болон хөгжлийн онцлогт нийцсэн олон хувилбартай, чөлөөтэй, нээлттэй байна” гэж заасан байдаг.

Багшийн ажил цаг наргүй, бас зогсолтгүй. Сурагчдынхаа өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд бидний санаачилга хамгаас чухал. Бид аливаа үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, тэр бүхэндээ дүгнэлт хийж, дараагийн ажлынхаа суурь болгож байх нь бидний үүрэг. Энэ бүхнийг цэгцтэй, үр дүнд хүргэх гол асуудал бол эхлээд багш өөрийгөө хөгжүүлэх явдал юм. Багш бидний юу хийх, улмаар хийж байгаа үйлдэл, хичээл сургалтын үйл ажиллагаа бүхнээ хааш нь чиглүүлэх нь суралцагчдаас шалтгаалдаг. Суралцагчийн тухайн үйл ажиллагаанд хандах хандлага эерэг байж аливаа зүйл амжилтад хүрдэг тул багш өөрийн сургалтад сурагчид маань хэрхэн хандаж байгааг мэдэж, тэднийг амжилттай суралцуулах арга замыг олж үйл ажиллагаагаа явуулах нь багш бидний зорилго болно.

Орчин үед нэг талаас нийгмийн амьдрал, нөгөөтэйгөөр хүүхдийн эрэлт хэрэгцээ, сонирхол өөрчлөгдөх болсон. Эдгээрийг багш байнга мэдэрч сурган хүмүүжүүлэх арга зүйгээ зохицуулан өөрчилж боловсронгуй болгох чадвартай байх нь чухал. Өөрчлөлт гэдэг нь нэг ёсондоо хөгжил юм.

Тэгвэл бид өнөөдөр хэрхэн өөрчлөгдөж өөрийн заах арга зүйдээ ямар ахиц гаргаснаар сурагчдад ямар нөлөөлөл үзүүлж болох талаар туршилт хийж “Үндэсний бичиг” хичээлийн “Титэмт үсэг” сэдвийг 2 өөр арга зүйгээр зааж харьцуулалт хийхэд ахмад багшаас заах арга зүйн зөвлөгөө авч, хамтран бэлтгэсэн “Гийгүүлэгч амилуулан заах” сургалтаар багшийн заах арга зүйд өөрчлөлт орсон төдийгүй суралцагчийн амжилтад нөлөөлсөн үр дүнг илрүүлэн энэхүү илтгэлийг бичлээ.

Судалгааны зорилго

Ахмад багш нараас заах арга зүйн зөвлөгөө авч, хамтран ажиллах нь залуу багшийн арга зүйд хэрхэн нөлөөлдөг болохыг судлан дүгнэх

Судалгааны зорилт

- Залуу багш өөрийн заах арга зүйгээр ганцаарчлан явуулсан сургалтын үр дүнг гаргах
- Залуу болон ахмад багшийн сургалтын үр дүнг харьцуулж, хамтран ажиллах
- Ахмад багшаас заавар зөвлөгөө авч, хамтран явуулсан сургалтын үр дүнг гаргах
- Ахмад болон залуу багш нарын хамтын ажиллагааны давуу тал, үр дүнг сурагчдад гарсан чадвараар харьцуулах

Сэдэв сонгосон үндэслэл

Ахмад багш нартай хамтран ажиллаж, тэдний заавар зөвлөгөөг сургалтдаа нэвтрүүлснээр залуу багш нарын арга зүй төдийгүй сурагчдын мэдлэг эзэмших чадварт дам нөлөөлөх боломжтой гэдгийг ойлгон “Залуу багш нарын заах арга зүйд ахмад багшийн оролцоо нөлөөлсөн нь” сэдвийг сонгон авсан

Судалгааны аргууд

Харьцуулалтын арга, ажиглалтын арга, ерөнхийлөн дүгнэх арга

Судалгааны ажлын шинэлэг тал

Ахмад болон залуу багш нарын хамтын ажиллагааны явцад залуу багшийн заах арга зүй төдийгүй, сургалтын явцад сурагчдын мэдлэг эзэмшилтэд өөрчлөлт гарч байгааг илрүүлсэн нь энэ судалгааны шинэлэг тал юм.

Судалгаа хийсэн талбар:

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2015, 2020, 2021 оны 6 дугаар ангийн сурагчид, МХБУЗ-ын багш нар

Судалгааны онолын үндэслэл

Багшийн хөгжил нь нийгмийн хөгжил, боловсролын шинэчлэл, сургалтын хөтөлбөрийн өөрчлөлт, хөгжилтэй шууд хамааралтайгаар тасралтгүй үргэлжлэх үйл явц юм.

Хонконг, Австрали, Япон, Англи, Индонез, Финланд, Шотланд, Итали, Малайз, Сингапур зэрэг улсын багшийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг харьцуулан судалсан судалгаанд багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжил (Continuing professional development)-ийг тогтолцоонд нь авч үзэж, багш өөрийн хөгжих хэрэгцээнд үндэслэн мэргэжил дээшлүүлэх олон талт үйл ажиллагаанд идэвхтэй оролцох замаар насан туршдаа суралцах, хөгжих үйл явц хэмээн томьёолсон байна.

Багш өөрийгөө хөгжүүлэхийн тулд мэргэжлийн хөгжлийн явцад “юуг, хэрхэн, хэзээ, хаана” өөрчлөн шинэчлэх вэ? гэдгийг судалж, оновчтой шийдлийг сонгон бүтээлчээр хэрэгжүүлэх хэрэгтэй. Сурахуйн аль нэг тохиромжтой онол баримтлалыг баримжаалан гадаад орчны таатай дэмжлэгт тулгуурлан, өөрийгөө үнэлэх, өөрийгөө хөгжүүлэх замаар үйл ажиллагаандаа эргэцүүлэл хийж, хөгжих боломж багш бүхэнд байна.

Иймээс багш нар мэргэжлийн практик үйл ажиллагаандаа шүүмжлэлтэй хандаж, заах арга зүйдээ илүү анхаарч, хажуудаа байгаа ахмад багш нартайгаа хамтран ажиллаж, тэдний олон жилийн туршлагаас суралцан, өөрийн арга барилтайгаа хослуулан, бүтээлчээр сэтгэж чадвал практик үйл ажиллагаанд ахиц өөрчлөлт гарч мэргэжлийн хувьд өсөх боломжтой юм.

Сургалтын арга гэдэг нь багшийн заах арга зүй, суралцагчийн сурах аргын нэгдэл юм. Өөрөөр хэлбэл нэг талаас сурагчдад мэдлэг, сурах арга барил эзэмшүүлэх, тэдэнд бие хүний эрхэм чанарыг төлөвшүүлэх, нийгэмшүүлэх зорилгоор гүйцэтгэж буй

багшийн үйлдлүүд, нөгөө талаас сурагч юмс үзэгдлийг сурч танин мэдэх зорилгоор хийж буй сэтгэхүйн олон янзын үйлдлүүд юм.

Тэгвэл сургалтыг чиглүүлэгч багш гэж хэн бэ? Энэ нь олон мэргэжлийн уулзварт тэдгээр чиглэлээр сурах арга барилд сурсан, санаачлагчтай, бүтээлч, тасралтгүй суралцан хөгжигч, соёлын өвийг уламжлагч юм (П.Батчимэг “багшийн хөгжилд хувийн зохион байгуулалт нөлөөлөх нь”) гэж тодорхойлсноос үзэхэд шавь нарынхаа хөгжил төлөвшилд ихээхэн хувь нэмэр оруулах мэргэжилтэн нь гарцаагүй багш мөн.

Хүн төрөлхтөнд хойч үеэ амьдрал, хөдөлмөрт бэлтгэж, өнгөрсөн үеэс хуримтлагдаж ирсэн үйлдвэрлэлийн арга, хөдөлмөрийн туршлага, оюун санааны баялгийг үеэс үед уламжлуулж, дамжуулахын зэрэгцээ тэдгээрийг арвижуулах, боловсруулах, хөгжүүлэх хэрэгцээ шаардлага зайлшгүй гарч ирдэг. Орчин үед энэ нь улам өргөн хүрээнд, тухайлбал зөвхөн хүүхдийг бус бас насанд хүрсэн хүмүүсийг сургах хүмүүжүүлэх утгатай болсон. Тэгвэл багш бид ч гэсэн насан туршдаа бие биенээсээ, ялангуяа ахмад багш нараасаа сурч хөгжиж байдаг. Багшийн хөгжил гэж багшийн мэдлэг, арга зүй, ур чадвар, боловсролоо дээшлүүлэх олон талт үйл ажиллагаа юм (“Багшийн хөгжлийг дэмжих тухай” хууль).


Судалгааны хэсэг

Судалгаа 1


Судалгааны зорилго: Залуу багш өөрийн заах арга зүйгээр “Титэмт үсэг” сэдвийг ганцаарчлан явуулсан сургалтын үр дүнг гаргах. /2020 он, 6-р ангийн 30 сурагч/

Үндэсний бичгийн “на, ма, ла” гийгүүлэгчийг заахдаа “а” үсгийн өмнө дуусал тавьж “на, нэ”, эвэр бичиж “ла, лэ” гэзэг бичиж “ма, мэ” гэж үсэгчлэн заасан.

Титэмт үсэг үсэгчлэн заасны дараа сурагчдын унших чадварыг дүгнэж үзвэл:



Титэмт үсэг үсэгчлэн заасны дараа сурагчдын бичих чадварыг дүгнэж үзвэл:



Судалгааны үр дүн


Хичээл заасан нийт сурагчдын 23.3% нь огт уншдаггүй, 56.7% нь багшийн тусламжтай уншдаг, 20% нь бие дааж шууд уншдаг болсон байлаа. Мөн огт бичдэггүй 16.7%, дуурайн бичдэг 30%, үеэ харж үг бичдэг 30%, галигаас бичдэг 23.3%, цээжээр шууд бичдэг сурагч байсангүй. Мэргэжлийн ахмад багш нараас асуухад огт уншдаггүй хүүхэд олон байна, шууд уншдаг хүүхэд заавал байх ёстой, тэгэхээр арга зүйгээ

жаахан өөрчлөөд үзэхэд сурагчдын амжилтад өөрчлөлт гарах магадлалтай гэсэн зөвлөгөө авсан.

Судалгаа 2

Судалгааны зорилго

Залуу болон ахмад багшийн заасан “Титэмт үсэг” сэдвийн сургалтын үр дүнг харьцуулж, хамтран ажиллах (2020 он, 6-р ангийн 30 сурагч; 2015 он, 6-р ангийн 30 сурагч).



Сургуулийнхаа МХБУЗ-ын багш Д.Энхээгийн (32дахь жилдээ ажиллаж байгаа) яг ижил “Титэмт үсэг” сэдвээр заасан сургалтын үр дүнг харьцуулалт хийж үзээд зөвлөгөө авч, хамтран ажилласан. Энэ хугацаанд нэгж болон ээлжит хөтөлбөр хэрхэн боловсруулах, хичээлээ хэрхэн төлөвлөх, сурагчдадаа ямар сэдвийг ямар аргаар хэрхэн заах зэрэг олон зүйл дээр багшаасаа зөвлөгөө авч, багш маань цахим болон танхимын хичээлд хамт орж сургалтын явцад тулгарсан асуудлуудыг засаж залруулж өгч байлаа. (Тухайлбал бидний судалгаандаа сонгосон “Титэмт үсэг” сэдвийг үсэгчлэн заах биш гийгүүлэгч амилуулж заах нь илүү үр дүнтэй ...гэх мэт).



Судалгаа 3.

Судалгааны зорилго

Ахмад багшаас заавар зөвлөгөө авч, “Титэмт үсэг” сэдвийг хамтран явуулсан сургалтын үр дүнг гаргах (6-р ангийн 41 сурагч, 2021 он).

Үндэсний бичгийн “на, нэ, ла, лэ, ма, мэ” долоон эгшиг, гурван гийгүүлэгч нь нийт арван үсгийн эхэнд дунд адагт хэрхэн бүтдэг зүй тогтлыг гийгүүлэгч амилуулах аргаар заасан.

Гийгүүлэгч амилах зүй тогтлоор титэмт үсэг заасны дараа сурагчдын унших чадварыг дүгнэж үзвэл:



Гийгүүлэгч амилуулж титэмт үсэг заасны дараа сурагчдын бичих чадварыг дүгнэж үзвэл:

Судалгааны үр дүн


Хичээл заасан нийт сурагчдын 17.1% нь огт уншдаггүй, 48.8% нь багшийн тусламжтай уншдаг, 34.1% нь бие дааж шууд уншдаг болсон байлаа. Мөн 9.8% огт бичдэггүй, 19.5% дуурын бичдэг, 17.1% үе харж үг бичдэг, 39% галигаас бичдэг, 14.4% цээжээр шууд бичдэг болсон байна. Эндээс үзэхэд “Гийгүүлэгч амилуулах” аргаар долоон эгшиг, гурван гийгүүлэгч нь нийт арван үсгийн эхэнд дунд адагт хэрхэн бүтдэг зүй тогтлыг заахад зөвхөн анхлан сурч байгаа хүүхэд маш хурдан хугацаанд шууд уншиж сурч байгаа үр дүнг мэдэрсэн төдийгүй зөв ойлгуулбал бусад үсгийг хүүхэд бие даан судлах ч боломжтой гэдгийг олж мэдлээ.

Судалгаа 4.

Судалгааны зорилго

Ахмад болон залуу багш нарын хамтын ажиллагааны давуу тал, үр дүнг сурагчдад гарсан чадвараар харьцуулах (6-р ангийн 30 сурагч, 2020 он; 6-р ангийн 41 сурагч, 2021 он).

4.1. Титэмт үсгийг үсэгчлэн болон гийгүүлэгчийг амилуулах зүй тогтлоор заасан үр дүнгийн харьцуулалт



Судалгааны үр дүн

Ахмад багш нартайгаа хамтран зөвлөлдсөний дагуу гийгүүлэгч амилуулах зүй тогтлоор сургалтаа явуулсан үр дүнгээ өөрийн үсэгчлэн заах аргаар явуулсан сургалттайгаа харьцуулж үзвэл:

Сурагчдын унших чадварт гарсан ахиц:

- огт уншдаггүй 23.3% - 17.1% = 6.2% буурсан, багшийн тусламжтай уншдаг 56.7% - 48.8% = 7.9% буурсан
- бие дааж шууд уншдаг 20% - 34.1% = 14.1% нэмэгдсэн,
- Сурагчдын бичих чадварт гарсан ахиц:
- огт бичдэггүй 16.7% - 9.8% = 6.9% буурсан, дуурайн бичдэг 30% - 19.5% = 10.5% буурсан
- үеэ харж үг бичдэг 30% - 17.1% = 12.9% буурсан, галигаас бичдэг 23.3% - 39% = 15.7% нэмэгдсэн
- цээжээр шууд бичдэг 0% - 14.4% шинээр нэмэгдсэн үр дүн гарч, ахмад багш нараасаа суралцан, тэдний заавар зөвлөгөөг хэрэгжүүлснээр бидний заах арга өөрчлөгдөж, улмаар сургалтад нөлөөлдөг гэдгийг баталлаа.

Дүгнэлт

Гарч буй бэрхшээл, давах арга зам:

<i>Тохиолдсон бэрхшээл</i>	<i>Давах арга зам</i>
Цахим сургалтын үед багштайгаа тулж ажиллах, тэр даруй асуулт асууж, ярилцах боломжгүй байсан. Цаг үеийн нөхцөл байдлаас хамааран ковидоор өвдсөн, ойрын хавьтал болсон хүүхдүүд танхимын сургалтаас хоцорч байсан	Ахмад зөвлөх багштайгаа видеокал , googl from ашиглан хичээлээ бэлдэж, багш маань цахим сургалтад хамт орсноор тулгамдсан асуудлыг сургалтын явцад шийдвэрлэж өгдөг болсон. Багштай хамтран зөвлөлдөж хоцрогдсон сурагчдыг тусгайлан авч мөн суралцсан шинэ арга зүйгээрээ сургалтыг явуулсан. Үсэг нүдлэх аргаа нэг ойлгосон хүүхэд дараагийн үсгээ ойлгоход хялбар болсон тул бусдаасаа хоцрох асуудал багассан.

Дэвшүүлсэн санаа

Багшийн гол хөдөлмөр бол сургалт, сургалтыг чанартай явуулахын тулд цаг ямагт өөрийгөө хөгжүүлж, заах арга зүйгээ баяжуулж байх ёстой. Энэ нь эрж хайгаад байх зүйл биш харин дэргэдэх ахмад багш нараасаа суралцаж, хамтран ажиллахад л хангалттай юм. Бидний заах арга зүй ямар байна суралцагчийн мэдлэг, чадвар, хандлага мөн тийм байна. Залуу багш бүхэн халамжлан хүмүүжүүлэгч ахмад багштай байвал ажиллах эрч хүч, урам зориг нэмэгдэж, бид өөрсдөө дараагийн үедээ уламжлуулан үлдээх заах арга зүйн арвин их туршлагатай болох юм байна гэж үзлээ. Иймээс ахмад багш нартайгаа хамтран ажиллаж, багшид байвал зохих олон чадварын цуглуулга байгаарай гэсэн санааг илэрхийлэн залуу багш нараа уриалж байна.

Ерөнхий дүгнэлт

Техник технологи хөгжсөн өнөө үед багш өөрийн мэдлэг боловсролоо хөгжүүлэх бүрэн боломжтой хэдий ч, дан ганцаараа заах арга зүйгээ дээшлүүлж шавьдаа мэдлэг боловсрол олгоход арга зүйн хувьд дутмаг байгааг олж мэдлээ. Үндэсний бичиг анхлан суралцаж буй сурагчдад “Титэмт үсгийг үсэгчлэн заах” аргаар сургалтаа явуулахад сурагчдын унших, бичих чадварт хоцрогдол их гарч, заавал ахин заах шаардлагатай болж хүүхдийг залхаах асуудал тулгарч байсан. Яавал хоцрогдолгүй суралцуулах вэ? гэдэг талаар ахмад багшаасаа зөвлөгөө авч хамтран хичээлийг бэлдэж, заах арга

зүйгээ өөрчлөн “Гийгүүлэгч амилуулах” аргаар сургалтыг явуулснаар сурагчдын мэдлэг чадварт төдийгүй хандлагад өөрчлөлт гарсан. Иймээс ахмад багш нартайгаа хамтран ажиллаж, тэдний заах арга зүйгээс суралцаж сургалтдаа хэрэгжүүлснээр багш өөрөө хөгжөөд зогсохгүй шавийн маань мэдлэг чадварт хэрхэн нөлөөлж байгааг тодорхой нэг сэдэв дээр туршилт сургалтаа явуулан, харьцуулалт гаргаж үзэхэд илэрхий байлаа.

Залуу багш нар ахмад багшаасаа суралцсанаар:

Багшийн хувьд: Заах арга сайжирна, ажлын туршлага сууна, шинэ арга барил эзэмшинэ, өөрийн сайн ба сул талыг мэдэрнэ, өөрт өвлөсөн арга туршлагыг бусдад түгээн дэлгэрүүлж зөвлөгч болно.

Сурагчийн хувьд: Хандлага, мэдлэг, чадварт дам нөлөөлнө, хичээлд идэвхтэй оролцоно, багштай харилцахдаа энгийн чөлөөтэй болно, хөгжих, бие даан суралцах чадвар нь нэмэгдэнэ.

Нэг багшийн зөвхөн нэг сэдэв заах туршлагыг хэрэгжүүлж, харьцуулалт хийж үзэхэд залуу багшийн заах арга зүй, сурлагын амжилтад үр дүн гарч байгаа юм чинь цаашид бид хэдэн багшийн хэдэн арга зүйгээс суралцахад ямар их амжилт үр дүн гарах нь тодорхой байна.

Ном зүй

Ариунболд, Ү. (1999). “Уншлагын сурах бичиг”. Улаанбаатар

(1999). “Багшийн хөгжлийн өнөөгийн байдал, түүнийг өөрчлөх арга замууд”. Улаанбаатар

Бэгз, Н. (2012). “*Багш, удирдах ажилтны мэргэжлийн ёс зүй, нийгмийн шаардлага ба бодит байдал*”. Улаанбаатар

Оюун, Ч., Чинзориг, Л., Долгорсүрэн, М. (2014). *Амжилттай сайн сургалтыг хэрхэн зохион байгуулах*. Улаанбаатар

(2019). “Үндэсний бичиг” 6-р ангийн сурах бичиг. Улаанбаатар

<https://legalinfo.mn/mn/detail/9020>

http://ulambayarb.blogspot.com/2015/10/blog-post_44.html

<http://ulambayarb.blogspot.com/2015/10/blog-post.html>

<http://unjiitechnology.blogspot.com/2016/03/blog-post.html>

<http://www.google.com/>

<http://www.wvu.edu.com/>

МЭНТОР & МЭНТИ НАР ХАМТДАА ХӨГЖИХ НЬ

Б.Энхжаргал¹

Нийслэлийн Сонгино Хайрхан дүүргийн
ерөнхий боловсролын 67 дугаар сургууль

90445811a@gmail.com¹

Хураангуй

Дэлхий дахины цар тахалтай холбоотойгоор сүүлийн 3 жил багш мэргэжлээр суралцан төгсөж ажлын байран дээр гарч байгаа залуу багш нараа туршлагатай багш нар угтан авч хөгжүүлэн арга туршлагаа заан зөвлөж багшаар багш бэлдэх зайлшгүй шаардлага үүсээд байна.

Энэхүү судалгаагаар ментор багштай байх хэрэгцээ шаардлагыг тодруулж цаашид **ментор** багштай болох бөгөөд тэднээс суралцах хүсэлтэй багш нараа (**менти**) Ментор багштай холбон **Менторшип** харилцааг идэвхжүүлэх юм.

67 дугаар сургууль нь Менторшип хөтөлбөрийг 2020 онд Гадаад хэлний Секцийн хүрээнд 2021-2022 онд НУЗАН-ийн хүрээнд 2 жилийн турш зохион байгуулж Мэнти багш нар Ментор багшаа сонгон хамтран менторшип хөтөлбөртөө оролцож үр дүнгээ тооцуулаад байна.


Түлхүүр үг

1. **Ментор**- зөвлөх, дасгалжуулагч, зааварлагч, зөвлөн туслагч, сургагч багш
2. Ментор гэдэг бол өөрөөс чинь илүү чамд байгаа боломж, авъяасыг олж хараад, тэр бүхнээ зөв ашиглахад тусалж чиглүүлж өгдөг хүн билээ.
3. **Мэнти**- дагалдан сурагч багш
4. **Менторшип**- зөвлөх багш болон дагалдан багш нарын хамтын үйл ажиллагаа
5. Мэнти бол онгоцны нисгэгч, харин ментор бол хоёрдугаар нисгэгч бөгөөд зорьсон газартаа хүрэхэд нь хажуунаас нь туслах л үүрэгтэй хэмээн зүйрлэжээ.

Оршил

Багшийн хөгжил гэдэг нь тухайн нийгэм, соёл бусад багш нар сурагч, эцэг эх, олон нийт, мэргэжлийн орчинд орж, өдөр тутам харилцаж, хамтран ажиллаж байгаа хувь хүний өөрөө хөгжих үйл явц юм. Мөн өөрөөр багш мэргэжлийн болон сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх зүйн мэдлэг, арга барил, ур чадвар, үзэл бодол, харилцаа хандлага, сэтгэлгээ зэргээ бие даан ухамсартай өөрчлөн сайжруулах чиглэлтэй үйлдлүүдийг хийх явдал юм. Багшийн хөгжлийн үйл явц нь тэдний өөрсдийнх нь идэвх оролцоо, санаачилга, хүсэл тэмүүлэлд тулгуурладаг.

Багшлах ажилд дадах, тасралтгүй суралцах загварын үе³



Багш ажлын байрандаа тасралтгүй хөгжих нь, 2015

Судалгааны хэрэгцээ шаардлага

Хүнийг Байгал ба Нийгмийн бүтээгдэхүүн гэж үзвэл нийгмийн бүтээгдэхүүний эхийг тавигч нь багш юм. Багш хүний үндсэн ажил:

Сурагчдад мэдлэг, чадвар, амьдрах ухаан, төлөвшил олгож өв тэгш иргэн болгон төлөвшүүлэх юм. Иймд багш:

- Мэдлэгтэй байх
- Бэлтгэлтэй байх
- Аргатай байх харилцаа хандлага зөв байх

Харин бичиг баримт нь: сурган хүмүүжүүлэх тэмдэглэл, Журнал, Хичээлийн бэлтгэл, Хөтөлбөр, Хэрэглэгдэхүүн,

Хувийн хэрэг, Судалгаатай байх хэрэгтэй гэж үздэг бөгөөд дээрх чадваруудтай багшийг ажлын байран дээр чадвар туршлагатай багш нар практик дээр бэлдэх бүрэн боломжтой байдаг.

Багшийн ажилд орж байгаа шинэ төгсөгч залуу багш нар нь онолын мэдлэг арвин хэдий ч практик туршлага бага тул туршлагатай туулж өнгөрүүлсэн амжилт уналтыг мэддэг зөвлөх багш нар нь тэднийг удирдаж хөрсөн дээрээ буулгаж сайжруулан сайн багш болох жигүүрийг ургуулдаг.

Тиймээс өндөр мэдлэг боловсролтой, хөрвөх чадвартай, өөрийгөө хөгжүүлэх арга технологийг эзэмшсэн, багшийн ажилдаа дур сонирхолтой, хүүхдэд хайртай, хөгжсөн,

жинхэнэ сайн багш болох суурийг нь зөвлөн чиглүүлэх арвин туршлагатай багш нараар удирдуулан ажлын байран дээрх сайн багшийг бэлдэх зайлшгүй хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Судалгааны арга

- Анкет судалгаа авах
- Судалгааны явцад ажиглалт хийх
- Статистик боловсруулалт хийх
- Харьцуулалтын арга
- Нэгтгэн дүгнэх арга (Энэхүү судалгаа нь ЕБС-ийн багш нараас авсан бөгөөд 272 багш судалгаанд хамрагдсан ч бүх багш нарыг бүрэн төлөөлөх боломжгүй юм).

Судалгааны зорилго

Багш ажлын байран дээр ахмад багш болон туршлагатай багш нараасаа илүү их суралцаж хөгжиж байдаг тул судалгаагаараа халамжлагч багштай байх хэрэгцээ шаардлагыг тодруулж цаашид Зөвлөн туслах халамжлагч багш буюу сургуулийн мэнтон багштай болох бөгөөд тэднээс суралцаж байгаа залуу багш болон суралцах хүсэлтэй багш нараа (мэнти) мэнтон багштай холбон тэдний залгамж холбоог сайжруулан хамтдаа хөгжих нь чухал юм.

Халамжлагч багштай байх хэрэгцээ шаардлагыг тодруулж цаашид Зөвлөн туслах халамжлагч багш буюу сургуулийн мэнтон багштай болох бөгөөд тэднээс суралцаж байгаа залуу багш болон суралцах хүсэлтэй багш нараа (мэнти) Мэнтон багштай холбон тэдний залгамж холбоог сайжруулан хамтдаа хөгжих нь судалгааны зорилго болно.

Судалгааны зорилт

- ЕБС-ийн багш нараас асуулгын аргаар судалгаа авах
- Үр дүнд дүн шинжилгээ хийх
- Мэнти багш болох хүсэлтэй багш нарыг тодруулах
- Мэнтон багш болох хүсэлтэй багш нарыг илрүүлэх
- Судалгаагаа нэгтгэн дүгнэх, харьцуулах

Дэвшүүлж буй санаа

Багш ажлын байрандаа хөгжих нь илүү их боломжтой гэж үзсэн бөгөөд ажил дээр хөгжихөд: Ахмад багш залуу үеэсээ техник технологи болон хувь хүний ур чадваруудаас нь суралцаж мэнти нартаа өөрийн багшийн ажлын туршлага мэдлэг чадвараас зөвлөн сургаж хамтран зорилгоо тодорхойлон түүндээ хүрэх арга замуудыг сонгож залуу багшдаа өөрийн ур чадваруудаа өвлүүлэн үлдээх хамтдаа бүтээдэг сурч хөгждөг Мэнтон, Мэнти багш нартай болж Мэнтоншип харилцааг идэвхжүүлэх юм.

1. Сургуулийн хэмжээнд Мэнтон багштай болох
2. Анхны жил (1-5) ажиллаж байгаа багш нарыг мэнти болгох
3. Мэнтон, Мэнти нар нь сайн дурын үндсэн дээр бүрэлдэх бөгөөд цаашид өөрийн өсөж хөгжих чиглэлийн өөрт тохирсон багшаа сонгох
4. Мэнтоншип үйл ажиллагааг төсөл болгон үнэлж дүгнэн урамшуулах
5. Жил бүр Мэнтон, мэнти нарыг шалгаруулж үйл ажиллагааг тогтмол явуулах.

Хүснэгт 1. Мэнтормшип хөтөлбөр

Агуулга	Мэнторм	Мэнти
1.Хөтөлбөрийн зорилгоо тодорхойлох	Хэнд би яаг юуг өгч чадах вэ? Тодорхойлох	Хөтөлбөрт оролцсоноор юуг сурах вэ?
2.Мэнтормоо бэлдэх	Сургуулийн хэмжээнд мэнтормоо илрүүлэх	Юуг сурах чиглэлээ өгөх сурах зүйлээ тодорхойлох
3.Төлөвлөгөө боловсруулах (өөрийн сургуульд тохируулах)	Мэнторм өөрийн чиг үүргийг мэдэх мэнтигээсээ суралцах хамтрах (хэнд юуг, яаж)	Мэнти өөрийн чиг үүргээ тодорхой болгох
4. Тэгш эрхтэй оролцох	Мэнторм бол халамжлагч биш хамтран хөгжүүлэгч	Мэнти өөрийн үүргээ ухамсарлах авах өгөх хуулиар
5.Үйл явцыг үнэлэх, дүгнэх	Зорилгодоо хүрч чадаж байгаа эсэх нэгжээр үнэлэх	Зорилгодоо хүрсэн бол нэгж бүрээр үнэлүүлэх
6. Үр дүнг бусадтай хуваалцах	Үр дүнгээ бусдад танилцуулах, түгээн дэлгэрүүлэх	Сурсан зүйлээ бататгах, өөрийн болгох

Мэнтормшип хөтөлбөрийн үйл ажиллагаа (2020 он)

2020 онд тус хөтөлбөрийг гадаад хэлний секц судалж өөрийн сургууль дээр секцийн хүрээнд зохион байгуулсан. Тус хөтөлбөрт 11 багш хамрагдсан бөгөөд анхны жил ажиллаж байгаа - 2 багш, 3-5 жил ажилласан – 3 багш, 8 жил ажилласан-2, 20-30 жил ажилласан 4 багш хамтран Мэнторм болон Мэнти багш болон мэнтормшип үйл ажиллагааг цахим сургалттай холбогдуулан цахим сургалт зохион байгуулах арга зүйн сургалтыг залуу багш нар зохион байгуулж ахмад багш нар амжилттай суралцаж хичээл сургалтдаа хэрэглэсэн. Хөтөлбөр боловсруулах болон бичиг баримт хөтлөлтөд туршлагатай багш нар сургалт зохион байгуулснаар Англи хэлний 6- 12 ангийн ээлжит нэгж тогтолцоог тухайн хугацаанд жишиг загвар гарган түүнийхээ дагуу хөтөлбөрөө цахим болгож жил бүр нэмэлт сайжруулан, баяжуулж ажиллаж байгаа нь багш бүр хичээлийн шинэ жилд өөр ангид хичээл заах тохиолдолд шинээр бичиг баримт хөтлөлт болон боловсруулалтад харьцангуй бага цаг зарцуулж сурагчдынхаа сурлага амжилтад анхаарах цаг илүү их гарч байгаа нь энэхүү хөтөлбөрийн маань үр шим юм.

Мэнтормшип хөтөлбөрийн үйл ажиллагаа (2021-2022 он)

Мэнтормшип хөтөлбөрийн сургалт хариуцсан Мэнторм багш нарын баг. Тус багууд нь туршлагад суурилсан өөрийн арга туршлагаудыг түгээн дэлгэрүүлж багш нарынхаа тал бүрийн авьяас чадварыг нээн илрүүлж хөгжүүлэх чиглэлтэй НУЗАН-ийн нэрэмжит мэнтормшип хөтөлбөр нь 45 хоногт сургалтаа багтаан явуулж суусан мэнти багш нараа буцаан үнэлж дүгнэх арга хэмжээг хариуцдаг.

Мэнторм болон мэнти нар 9 хүнтэй 5 багт хуваагдан бүхий л үйл ажиллагаанд багаар оролцдог (тус багууд нь нэг секц биш өөр секцүүдийг нэгтгсэн бөгөөд багш нарын хамтын ажиллагаа илүү бүтээлч байж эерэг уур амьсгал бүрдүүлж бие биенээ шинээр таньж мэднэ хамтарч чаддаг).

Мэнтормшип хөтөлбөрийн үйл ажиллагаа

2021-2022 онд НУЗАН хүрээнд зохион байгуулсан бөгөөд Багшлах арга зүй, бичиг баримт хөтлөлт, хөтөлбөр боловсруулалт, анги даалт, харилцаа хандлага, цагийн менежмент, багштай холбоотой хууль тогтоомж судлах зэрэг маш олон талын үйл ажиллагааг Мэнторм болон Мэнти багш нарынхаа хүрээнд зохион байгуулж амжилттай хэрэгжиж байна.

Хөтөлбөрийн давуу тал

Мэнти

- Чадвараа хөгжүүлэх (Багш хүнд байх чадварууд)
- Өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлдэг
- Харилцааны чадвар сайжирдаг
- Мэдээллийн эх сурвалжийг шүүлтүүртэй хүлээж авдаг болох
- Мэргэжлийн болон албан харилцааг хувийн харилцаанаас ялгаж сурах

Мэнторм

- Идэвхтэй сонсох чадварыг бэхжүүлдэг
- Өөрийгөө үнэлэх мэдрэмжийг нэмэгдүүлдэг
- Ажлын үр өгөөж нэмэгддэг
- Багшлах явцдаа сэтгэл хангалуун байх нь нэмэгддэг.
- Мэнторын харилцах өгөх чадварыг нэмэгдүүлдэг.
- Ажил мэргэжлийнхээ төлөөх зорилго, хариуцлагын нэмэлт мэдрэмжийг бий болгодог

Байгууллагын давуу тал

- Манлайллын тогтвортой хөгжлийг хангах авъяас чадварыг хөгжүүлэх зорилгодоо хүрэхэд тусалдаг.
- Манлайлал ажилтнууддаа хөрөнгө оруулахад бэлэн байгаа гэдгийг сургуулийн хэмжээнд хэмжээнд хүн бүрт мэдэгдэнэ
- Авъяас чадварыг олж авах хүчин чармайлтыг сайжруулна. Шинээр ажилд орсон хүмүүс тухайн байгууллагын карьер хөгжүүлэх боломжуудыг мэддэг болох
- Ажилтныг тогтвор суурьшилтай байлгахад дэмжлэг үзүүлж, улмаар эргэлтийн хувь хэмжээг бууруулахад хүргэдэг.
- Ганцаарчилсан харилцан үйлчлэлийн замаар сургалтын зардлыг бууруулахад хүргэдэг.
- Төрөлхийн манлайллын хүчийг ашигладаг эерэг өөрчлөлтүүд гардаг

Дүгнэлт

Судалгаанд оролцсон нийт багш нарын хариултнаас дүгнэхэд багш нарт эхний жилүүдэд:

- Хичээл сургалт зохион байгуулах,
- Ээлжит нэгж хичээл зохион байгуулах,
- Хичээл зааж байгаа сурагчидтай харилцах,
- Хөтөлбөр төлөвлөгөө боловсруулах,
- Бичиг баримт хөтлөх,

- Анги удирдах,
- Багш нарын тогтмол оролцдог тэмцээн уралдаанд өөрийгөө бэлтгэх гэх мэтэд олон бэрхшээл тулгардаг бөгөөд эдгээрийг шийдвэрлэхэд заавал зөвлөн туслах удирдан чиглүүлэх Мэнтор багштай байх хэрэгцээ үүсэж байна. Иймээс цаашид Мэнтор багшаа сонгосон мэнти нар урт болон богино хугацааны зорилгоо тодорхойлон түүндээ алхам алхамаар хүрэх зорилтуудаа гаргаж хамтдаа үнэлж дүгнэж сайжруулж байвал залуу үеийхэн ахмад үеийхэнтэйгээ илүү ойрхон байж сайн багшийн тоо нэмэгдэн гэдэгт итгэлтэй байна.
- 20-30 насны залуу багш 20 хувийг эзэлж байгаа бөгөөд туршлагатай багш нар маань “асуувал хариулдаг” гэсэн хэлбэрээр тэдэнд тусалж байна.
- 60 хувь нь туршлагатай багш нараасаа суралцаж бэрхшээл тулгарвал тэднээс тусламж авдаг.
- 60.5% нь зөвлөх багш хэрэгтэй байсан ч халамжлан хүмүүжүүлэгч багшгүй гэсэн бөгөөд байсан бол би одоо байгаагаасаа илүү амжилттай байх байсан гэжээ.
- Бичиг баримт хөтлөх болон анги удирдах арга зүйн зөвлөгөө 67.3% нь түгээн дэлгэрүүлэх боломжтой гэсэн бол залуу багш нар Хичээл заах арга барил, харилцааны тал дээр суралцах хүсэлтэй байна.
- 60.5% халамжлан хүмүүжүүлэгч байж гарын шавь бэлдэх боломжтой гэсэн бөгөөд түүнтэй тэнцэх хэмжээний багш нар халамжлагч багшгүй бөгөөд цаашид халамжлан хүмүүжүүлэгч багштай болох хүсэлтэй байна.

Хэрэв багш өөрийн үйл ажиллагаандаа өөрөө дүн шинжилгээ хийж суралцах үйлийг хамтран явуулж чадвал алдаа оноо, амжилт бүтээлийнхээ мөн чанарыг ухааран мэдэх боломж бүрдэж энэ нь өөрийгөө хөгжүүлэх гол хүчин зүйл нь болох бизээ. Суралцах үйлийн гол утга нь сургахад бус харин сурах үйлийг сурагчтайгаа хамтран явуулж “багш сурагч хоёр хичээл рүү хамтдаа” гэсэн зарчмыг хэрэгжүүлэхэд оршиж байгаа бөгөөд ингэсэн нөхцөлд багшийн тасралтгүй суралцах хэрэгцээ үүснэ. Харин багш ажлын байран дээрээ тасралтгүй хөгжихийн тулд туршлагатай багш нартайгаа байнга нийгмийн идэвхтэй харилцааг үүсгэх, бусад багш нараас суралцах буюу тухайн институт дотроо, институт хооронд өөрийн туршлагаас хуваалцах ажлыг тасралтгүй явуулах, сүүлийн үеийн мэдээллээр байнга өөрийгөө цэнэглэж улмаар өөрийгөө идэвхжүүлэн ажил ихтэй ачаалалтай үед ч эрч хүчээр дүүрэн байх ёстой болов уу хэмээн дүгнэж байна.

Ментороор дамжуулж олон хүн ажилтад хүрч, менторшипээр дамжуулж олон олон бизнес, байгууллага, цаашлаад улс орон хөгжиж байна. Ментор гэдэг нь заавал алдартай, гоц ухаантай, насаар ахмад, дүү ер нь ямар ч байх албагүй. Харин тухайн сэдвээрээ хуваалцаж болох туршлагатай байх нь гол билээ. Ментортой болсноор тэдний алдаанаас бас амжилтаас суралцах том боломж гардаг. Өөрөөр хэлбэл тэдний туршлагаас суралцан өөрийн замаа “товчлох” боломжтой гэсэн үг. Амжилтад хүрсэн маш олон хүн өөрийн гэсэн ментор буюу чиглүүлэгчтэй байдаг.

Миний бие анхны жил ээлжит нэгж хичээл болон тогтолцоог ойлгох гэж 2 сар зарцуулсан бөгөөд өөрийн аргаар бичсэн хөтөлбөрөө батлуулахдаа салгалж хөлс гарч маш их сандардаг байсан. Жилийн дараа анхны жилийн сургалтад сууснаар миний 10 сар будилж ойлгосон хөтөлбөрийг минь 80 минутад тайлбарлаж буцаагаад 40 минутад ээлжит хөтөлбөр бичүүлж сургаж байсан нь бидний хэлдгээр оройтсон

борооны араас цув нөмрөхтэй адил байсан юм. Хэрвээ энэ сургалт намар болдог бол би бүгдийг нь алдаа мадаггүй хийж чадах байсан гэсэн бодол төрж байлаа.

Цаашид олон залуу багш нарт дээрх шиг бэрхшээл үүсэх боломжтой тул зөвлөн туслах чиглүүлэгч багшийг сургууль секцийн хэмжээнд Мэнтор багшаа тодруулж Мэнти нар орж ирэхэд бэлэн байж Мэнторшипийн хөтөлбөртэй болж олон сайн багш нарыг бэлдэж мянга мянган хүүхдийг эрдмийн оргилд хүргэнэ гэдэг итгэлтэй байна.

Ном зүй

(2007). Багшийн хөгжил түүнийг үнэлэн дэмжих асуудлууд. Улаанбаатар

Жадамба,Б., Батсуурь,Ц., Пүрэв-Очир,Б., Пүрэвдорж,Д. (2005). “Багш боловсролын ирээдүй”. Улаанбаатар

Ичинхорлоо,Ш. (2004). *Багшийн ном*. Улаанбаатар

МУЗГ. (2007). Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө. Улаанбаатар.

<https://unread.today/c/2086>

<https://oneminute.mn/2517>

<https://student.num.edu.mn/wp-content/uploads/2021/08/Mabuchi-setquul.pdf>

<https://www.facebook.com/MissEarthMongolia>

<http://mentors.mn/tsast> 159

АХМАД БАГШ НАРЫН ҮНДЭСНИЙ БИЧИГ ЗААХ АРГА БАГШИЙН МЭРГЭЖЛИЙН ӨСӨЛТӨД НӨЛӨӨЛӨХ НЬ

Э.Уранцэцэг¹, Б.Болор-Амгалан², Х.Ганди³

Сүхбаатар аймгийн Ерөнхий боловсролын

Лаборатори 1 дүгээр сургууль

Urantsetseg1616@gmail.com¹, boloramgalan77@gmail.com², gandi94111221@gmail.com³

Хураангуй

Монгол бичиг (Үндэсний бичиггүй бол даяарчлалын энэ эрин цагт монгол үндэстэн ялгаран оршихын баталгаа, эртний түүх, өв соёлоо уламжлан авч хөгжүүлэхийн үндэс, дэлхийн үсэг бичгийн соёлд Монголчуудын оруулсан хувь нэмрийг хойч үеийнхэнд хэвээр уламжлуулах түүхэн хариуцлага, амин чухал асуудлын нэг юм.²⁴ Үндэсний бичгийн мэргэжлийн багш нар 5-н жил кирилл бичигт суралцсан, өөр бичиг үсэгт дадсан онцлогтой хүүхдэд тус хичээлийг амжилттай зааж, сургахын тулд өмнөө тулгарсан бэрхшээлийг зөв илрүүлж, түүнийгээ даван туулах, өөрийн гэсэн арга зүйгээ олохын тулд шилдэг болон туршлагажсан багш нараас суралцах боломж бидэнд байна. Багш хүн тасралтгүй суралцахын үлгэр жишээ, үнэт баялаг бол ахмад багш нар юм.

“Learning never stops” буюу “Суралцахаа хэзээ ч бүү зогсоо” ЮНЕСКО

Түлхүүр үг: үндэсний бичгийн хичээл; ахмад багш; сурагчдын ахиц; арга аргачлал; туршлага; өсөлт хөгжил.

Оршил

1995-2005 онд анх “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр 1”, 2008-2015 онд “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр 2”-ийг тус тус хэрэгжүүлснээр ерөнхий боловсролын сургуулийн VI-IX ангид монгол бичгийн хичээлийг судалж, иргэний болон боловсролын баримт бичгийг кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн үйлдэх, ном, сурах бичиг зохиох, хөрвүүлэх, түүх, соёлын бүтээлийг нийтийн хүртээл болгох зэрэг үр дүн бий болсон байна. Мөн УИХ-с 2015 онд баталсан Монгол хэлний тухай хуулийн 11 дүгээр зүйлд Монгол Улсын Засгийн газрын хүлээх үүргийг тодорхойлохдоо “Монгол хэл, бичиг үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, хамгаалах, хөгжүүлэх, үндэсний бичгийн хэрэглээнд албан ёсоор шилжих дунд болон урт хугацааны үндэсний хөтөлбөр, дүрэм, журам, үндсэн чиглэл боловсруулж хэрэгжүүлэх” гэж заажээ...

Судалгааны ажлын хэрэгцээ, шаардлага

1. Үндэсний бичгийг зөвхөн сурагчдад зааж сургах төдийгүй өнөөгийн сургалт, хэрэглээний нөхцөл байдалд хийсэн шинжилгээний дүнгээр цаашид монгол

²⁴ Чулуунбор.Ш (2010). Монгол бичгийн зарим хүнд сэдвийн заах арга, шалгах сорил, 5-р тал

бичгийн сургалтыг дээд боловсрол, мэргэжлийн боловсрол, насан туршийн боловсролын салбарт эрчимжүүлэх, сургалтын чанарыг сайжруулах, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, стандарт дүрэм, журмыг шинэчлэн батлах, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, үүрэг оролцоог нэмэгдүүлэх, уялдуулах нь зүйтэй гэж үзсэн байна.²⁵

2. УИХ-аас 2015 онд баталсан Монгол хэлний тухай хуулийн 7.2-т “Энэ хуулийн 11.1.2-т заасан үндэсний бичгийн хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна” гэж, 24.2-т “Энэ хуулийн 7.2 дахь хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө”²⁶ гэж тус тус заасан байна.
3. Хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс “Төрийн албан хаагчийн мэдлэг тодорхойлох судалгааг 160 мянган алба хаагчаас авч МУ-ын Ерөнхийлөгч, БШУ-ны сайд, Соёлын сайд болон албаны хүмүүст танилцуулсан. Үүнд 56.3% нь 2025 оноос хос бичгээр албан хэргээ хөтлөхөд бэлэн гэж хариулжээ.
4. Үндэсний бичгийг заан, сургах их үүрэг хүлээсэн мэргэжлийн багш нарт тулгарах бэрхшээл олон байдгийг судалгаагаар илрүүлэхэд үндэсний бичгээ заах сонирхол их байдаг боловч ихэнх залуу багш нар өөрийн гэсэн арга зүйгээ олоогүй байгаа зэрэг бэрхшээлийг ахмад багш нарын заавар зөвлөмж, хамтын ажиллагаагаар даван туулах гарц шийдэл болж байна.

Зорилго:

Үндэсний бичиг заах арга зүйд тулгарч буй бэрхшээлийг тодорхойлон, түүнийг ахмад багш нарын туршлага арга зүйд тулгуурлан оновчтой шийдвэрлэх.

Зорилт:

- Үндэсний бичгийн хэрэгжилт, үе шатыг судлах
- Ахмад болон шилдэг багш нарын заах арга, туршлагыг судлах
- Үндэсний бичгийн хичээл зааж буй багш нар болон сурагчдад тулгарч буй бэрхшээлтэй асуудлыг судалгаагаар илрүүлэх
- Асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, хэрэгжүүлэх

Хүснэгт 1. Судалгааны арга

1. Баримт бичгийн судалгаа хийх арга	Сургалтын хөтөлбөр болон үндэсний бичгийн заах арга бүхий ном хэвлэлийг уншиж судлан багш нарын шилдэг арга барилыг судалсан.
2. Жишиж харьцуулах арга	Кирилл бичигтэнд үндэсний бичиг заах арга, кирилл бичиггүй хүүхдэд үндэсний бичиг заах аргыг жишиж харьцуулах аргаар судалсан
3. Асуулгын арга	Асуулга судалгаанд түүврийн аргаар 167 сурагч, 115 иргэн, төрийн албан хаагчид, мэргэжлийн 42 багш хамрагдлаа.
4. Түүврийн арга	
5. Ажиглалтын арга	6, 7, 12-р ангиудын үндэсний бичгийн хичээл болон сурагчдын ахиц амжилтад ажиглалтын аргыг ашигласан.
6. Фокус бүлгийн ярилцлагын арга	Ахмад багш болон шилдэг багш нарын туршлагыг судлах үүднээс сургуулийн орчинд, гэрээр, утсаар ярилцлага хийсэн. Үүнд Баруун-

²⁵ Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III

²⁶ Монгол хэлний тухай хууль 2015

	Урт сумын 3, Баяндэлгэр сумын 1, Түмэнцогт сумын 2, Улаанбаатар хотын 2 багш хамрагдлаа.
7. Ангилан бүлэглэх арга	Үндэсний бичгийн тухай гарсан эрх зүйн баримтууд, заах арга зүйн шилдэг туршлагуудыг судалж илрүүлэхэд ангилан бүлэглэх аргыг түлхүү ашигласан.
8. Туршилтын арга	Кирилл бичигтэнд үндэсний бичиг заах арга зүйг 6, 7, 12-р ангиудад хэрэгжүүлж, туршилтын аргыг хэрэглэсэн.
9. Математик статистик боловсруулалт	Нийт судалгаануудад энэхүү аргыг хэрэглэсэн ба түүн дотроос хувийн жин олох (процентлох), График, диаграмм зохиох аргуудыг түлхүү ашигласан.
10. Ерөнхийлөн дүгнэх арга	Судалгаа бүрийн төгсгөлд болон дүгнэлт хэсэгт ерөнхийлөн дүгнэх аргыг хэрэглэсэн.

Судалгааны хэсэг

Үндэсний бичгийн сургалт ба үр дүн

Үндэсний бичгийн сургалтын үе шат ба онцлог

Үндэсний бичиг заах асуудал нь 1986-1987 оны хичээлийн жилээс ЕБС-д 7,8-р ангиудад, 1991-1992 оны хичээлийн жилээс 1-р ангийн монгол бичгийн сургалтыг орон даяар эхлэхэд кирилл бичиг заадаг бага ангийн багш нараа орон нутаг нь 14-30 хоногийн түр сургалтаар бэлтгээд шууд багшлуулж байв. 1998-1999 оны хичээлийн жилээс 3-р ангиас зааж эхэлснээр ЕБС-д үндэсний бичгээр суурь боловсрол олгох үндэс тавигдаж стандарт батлагдав.²⁷...

Ахмад багш нарын үндэсний бичиг заах арга, туршлага

Зураг 1. Үндэсний бичгийн ахмад багш нар



Сүхбаатар аймгийн гурван ахмад багшийн туршлагаас судалж, харьцуулж, хэрэгжүүлэв.

Монгол улсын гавьяат багш БТА Ш.Чулуунборын туршлагаас дүгнэхэд үндэсний бичгийг нэгэнт бичиг үсэг сурчихсан кирилл бичигтэй хүүхдэд заахад хуучин аргыг шинэчлэхээс өөр аргагүй гэж үзэн дараах 7-н зүйлийг онцлов. Үүнд:

1. Цагаан толгойн үсгүүдийг богино хугацаанд багцлан заах


²⁷ Ш.Чулуунбор Монгол бичиг заах аргын зарим асуудал 2002. 15-р тал

- Утгатай утгагүй олон үе цээжлүүлж цаг барахгүй, үзсэн үсгүүдийн хүрээнд унших бичих үе бэлтгэх
- Сурагчдын урьд нь олж авсан хэлний мэдлэгт тулгуурлан заах
- Үндэсний бичгийн онцлог, зарчим, дүрмээр сургах
- Уламжлалт заах аргыг шинэчилж ашиглахын хамт шинэ дэвшилтэт аргыг хэрэглэх
- Нэг хэлийг тэмдэглэж байгаа 2 бичгийн адил ба ялгаатай талыг харьцуулан жиших. Ийм хэрэгцээ үүсэж байна.
- Уйдаахгүй богино хугацаанд хурдавчилж, эрчимтэй сургах

Кирилл бичигтэнд үндэсний бичиг заах аргыг туршиж хэрэгжүүлэх нь

Кирилл бичигтэнд үндэсний бичиг заахад учрах бэрхшээл түүнийг давах арга зам.


Судалгаа 1: Монгол хэл, уран зохиолын мэргэжлийн багш нараас авсан судалгаанд аймгийн хэмжээний 42 багш хамрагдав.




Мэргэжлийн багш нар хэдийгээр гурван судлагдахуун хариуцаж, заадаг ч монгол хэл, уран зохиолоосоо илүүтэй үндэсний бичгээ заах сонирхолтой байдаг. Тэдэнд тулгардаг бэрхшээлийн нэг нь залуу багш нар өөрийн гэсэн оновчтой заах арга зүйгээ олоогүй байдаг нь бидний анхаарлыг татлаа. Өөрт тулгарч буй бэрхшээлээ даван туулахын тулд хамт ажиллаж буй мэргэжлийн багш нар болон үе тэнгийн багш нараасаа туслалцаа авдаг бол ахмад багшаас туслалцаа авдаггүй байна.

Судалгаа 2

Зураг 2. Үндэсний бичиг хэр чухал хичээл болох, мэргэжлийн багш нарын хариулт



Зураг 3. Үндэсний хичээлд хэр дуртай, сурагчдын хариулт



Судалгаанд түүврийн аргаар 167 сурагч хамрагдав. Судалгааг дүгнэхэд сурагчид үндэсний бичгийн хичээлд дур сонирхолтой, чухал хичээл гэж үздэг бөгөөд тус хичээлдээ сайн биш байгаа нь олон шалтгаантай ч багшийн заах арга тохиромжгүй гэж 4.2% нь хариулж байна.

Судалгааны мөрөөр хийж хэрэгжүүлсэн ажлууд:

“Ахмадын туршлага-Амжилтын эх” нэртэй төслийг хэрэгжүүлэн дараах үйл ажиллагаануудыг зохион байгууллаа.

Үндэсний бичиг анхлан үзэж байгаа 6 дугаар анги, дунд анги, ахлах ангиас тус бүр нэгийг сонгон авч Ш.Чулуунбор багшийн туршлага, арга зүйг туршин хэрэгжүүллээ.

Зураг 4. Туршилтын ангиуд, нэгж хичээлийн төлөвлөлтийн QR код



Туршилтын 6,7-р ангид заасан үндэсний бичгийн интерактив хичээлийг сургуулийн нэгдсэн moodle sols системд байршуулж, туршив. <https://sb-lab1.eschool.mn/course/view.php?id=327¬ifieditingon=1>

1. Сурагчдын түвшинд тохирсон үнэлгээний даалгавар боловсруулж moodle sols системд байршуулан туршиж байна. <https://sblab1.eschool.mn/mod/hvp/view.php?id=1620>

ба анги, 76 анги, 12 дугаар ангийн сонгоны үндэсний бичгийн хичээлээр эхний оношилгоог 9 дүгээр сард, эцсийн оношилгоог 12 дугаар сард авч харьцуулалт хийхэд ба анги 14.2%, 76 анги 12%, 12 сонгон 22%-иар тус тус ахисан байна

2. Үндэсний бичиг эхлэн суралцаж буй 6 дугаар анги болон дунд ангийн сурагчдад зориулсан гарын авлага, үндэсний бичиг зааж эхэлж буй мэргэжлийн багш нарт зориулсан зөвлөмжийг боловсруулан туршиж, аймгийн хэмжээнд түгээн дэлгэрүүлж ажиллав.

Тус товхимол, гарын авлагыг сонирхсон сурагч, багш нар QR кодоор орж харах, ашиглах боломжтой байдлаар боловсруулав.

Зураг 5. Багш сурагчдын гарын авлага, товхимол



Хүснэгт 2 Сурагч, багшид гарсан үр дүн

Сурагчийн гарын авлагыг боловсруулан хэрэгжүүлснээр:	Багшийн зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлснээр:
- Сурагчид сонирхолтой байдлаар дасгал ажиллаж, хичээлийн улам их сонирхох болсон. - Хөнгөнөөс хүнд рүү чиглэсэн дасгалыг ажиллахад сурагчдад бэрхшээл бага байсан. - Гарын авлагатай ажиллахад мэдэхгүй зүйлээ лавлаж харах боломжтой байгаа нь сурагчдын ахицад нөлөөлж байна.	- Залуу багш нар зөвлөмжийг судалж, өөрийн гэсэн арга зүйг олоход дөхөм болсон. - Зарим багш нар өөрийн гэсэн арга зүйг олж, туршиж байна. - Ахмад багш нарт хуримтлуулсан туршлага, нөөц боломж байгааг бусдад түгээсэн. - Боловсролын газрын мэргэжилтэнтэй хамтран ажиллаж аймгийн мэргэжлийн багш нартаа түгээн дэлгэрүүлэв.

Дэвшүүлэх асуудал

- Сурагчид төдийгүй, иргэд, төрийн албан хаагчид үндэсний бичгийг сурах сонирхол маш их байна. 2025 оноос эхлэн улс орон даяар хос бичигтэн болоход мэргэжлийн багш нарыг бэлтгэх шаардлагатай.
- Өөрийн арга зүйг олоогүй багш нар олон байгаа нь судалгаанаас харагдаж байгаа бөгөөд ахмад багш нарын шилдэг арга зүйг судалж, заах арга зүйгээ сайжруулах.
- Үндэсний бичгийн хэрэглээг төр засгийн бодлогын түвшинд нэмэгдүүлэх.
- Сурах орчин, хэрэгцээг бүрдүүлэх. Сургуулийн түвшинд Үндэсний бичгийн кабинетыг төсөл хөтөлбөрөөр дэмжиж чанарыг сайжруулах.
- Ахмад багш нарын арга зүйн зөвлөлийг судлагдахуун бүрээр байгуулж эргэх холбоотой ажиллах.
- Шинэ үеийн сурагчид буюу Z үеийнхний онцлогт тохируулан уламжлалаа хадгалахаас гадна цахим орчинд тэдний сонирхолд нийцүүлэн хичээл, сургалтаа зохион байгуулах олон арга байгааг эрэлхийлэх.

Дүгнэлт

Суралцахуйд гарсан өөрчлөлт:

- Хичээлийг сурагч бүрийн түвшинд тохируулж зааснаар сурагчид үндэсний бичгийн хичээлд илүү сонирхолтой болсон.
- Багш тохиромжтой арга зүйгээ олж, хэрэгжүүлж эхэлснээр сурагчдын үндэсний бичиг бие даан суралцах үйлд дэмжлэг болсон.

Багшлахуйд гарсан өөрчлөлт:

- Багш бүр судлаач байх үүргээ ухамсарлаж, багшлахуйдаа шинэчлэл хийн өөрийн гэсэн арга зүйгээ олж авч байна.
- Ахмад багш нарын туршлагаас зөвхөн арга зүйгээс гадна хандлага, ёс зүй, ангитай ажиллах арга барилаас суралцаж болохыг олж харсан.

Нэг бичигт дадсан хүүхэд нөгөө бичгийг сурахад дөхөмтэй тал байхаас гадна хүндрэлтэй тал нь илүү байдаг учир хичээлийн цаг дээр нэмэлтээр давтлага хийх, багшаас уйгагүй, тасралтгүй үйл ажиллагааг шаардаж байна.

Кирилл бичигтэнд үндэсний бичиг заах арга туршлагыг 6а, 7б, 12б ангийн ЭЕШ өгөх сурагчдад туршин хэрэгжүүлснээр дунджаар 16%-иар ахисан бөгөөд энэхүү арга

туршлагаа бусад ангиудад хэрэгжүүлэн ажиллаж байна. Залуу багш нарын ихэнх нь үндэсний бичгийг заах тогтсон арга зүй эзэмшээгүй учраас хүүхдийг сургахад бэрхшээл үүсдэг. Тиймээс ахмад багш нарын туршлага, арга зүйг судлан эзэмшиж, сургалтын үйл ажиллагаандаа туршин хэрэгжүүлэх нь хамгийн оновчтой шийдэл юм.

Ном зүй

- Аюурзана,Г. (2010). *Цэцэн мэргэний нэвтэрхий толь*. Улаанбаатар
- БСШУЯ. (2015). Суурь боловсролын цөм хөтөлбөр. Улаанбаатар
- БСШУЯ. (2016). Бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөр. Улаанбаатар
- БСШУЯ. (2019). Суурь боловсролын сайжруулсан хөтөлбөр. Улаанбаатар
- БСШУЯ. (2019). Бүрэн дунд боловсролын сайжруулсан хөтөлбөр. Улаанбаатар
- БШУЯ, Боловсролын хүрээлэн. (2021). Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт. (Танхимын ба цахим хичээл) Асуудал, шийдэл. Цэцэрлэг, ЕБС-ийн багш, удирдах ажилтны эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Улаанбаатар
- БМДИ. (2020). Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын гарын авлага-1. Улаанбаатар
- (2015). Боловсролын хэмжил зүйн тулгамдсан асуудал, шийдэл, арга зам. 105-106-р тал. Улаанбаатар
- БШУА. (2013). Боловсрол судлал сэтгүүл. Дугаар/2014.04 102-р тал. Улаанбаатар
- Ичинхорлоо,Ш. (2010). Орчин үеийн хичээлийн тухай өгүүлэх нь. Улаанбаатар
- Ичинхорлоо,Ш. (2012). Судалгааны ажлын үндэс. Улаанбаатар
- Ичинхорлоо,Ш. (2011). Сургалтын зарим үзэл, онол. Улаанбаатар
- Ичинхорлоо,Ш. (2011). Сургалтын арга зүйн шинэчлэл. Улаанбаатар
- МУБИС. (2018). Судалгааны ажлын арга зүй. Улаанбаатар
- МУБИС. (2018). Эрдэм шинжилгээний бичиг. Дугаар 4. 96-97-р тал. Улаанбаатар.
- МАБХ. (2010). *Туршлагаас туршлагажих боломж*. Улаанбаатар
- Нарангэрэл, Н. нар. (2019). Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь. Улаанбаатар
- (2020). Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих арга зүйн зөвлөмж. Улаанбаатар
- Уранцэцэг,Э., Баттогт,Э. (2021). Сургалтын хөтөлбөрийн хэрэгжүүлэхэд багш нарын хамтын ажиллагаа чухал болох нь. Илтгэл. 2020-2021
- Цэвэл,Я. (1966). Монгол хэлний товч тайлбар толь. Улаанбаатар
- Чулуунбор,Ш. (2002). Монгол бичиг заах аргын зарим асуудал. Улаанбаатар
- Чулуунбор,Ш. (2010). Монгол бичгийн зарим хүнд сэдвийн заах арга, шалгах сорил. Улаанбаатар
- Цахим эх сурвалж:*
- <https://www.montsame.mn/mn/read/224500>
- <https://www.polit.mn/a/91598>

АХМАД БОЛОН ЗАЛУУ БАГШ НАР БИЕ БИЕНЭЭСЭЭ СУРАЛЦАЖ ТАСРАЛТГҮЙ ХӨГЖИХ НЬ

Ж.Мөнхбаяр¹, Ц.Энхтуяа²

Төв аймгийн Зуунмод сумын

“Хүмүүн” цогцолбор лаборатори сургууль

munkhbayar8mvh@medle.mn¹, enkhtuya88201704@gmail.com²

Оршил

Улс орны хөгжил хүний хөгжилтэй, хүний хөгжил нь боловсролын хөгжилтэй, боловсролын хөгжил нь багшийн хөгжилтэй шууд холбоотой. Багшийн хөгжил гэж багшийн мэдлэг, арга зүй, ур чадвар, боловсролоо дээшлүүлэх тасралтгүй үйл явцыг хэлнэ (“Багшийн хөгжлийг дэмжих тухай” хууль 3.1.2).

Багшийн ажлын байрандаа тасралтгүй хөгжих олон хүчин зүйл байдгийг Linda Evans “Oxford Review of Education” сэтгүүлд тэмдэглэсэн байдаг ба үүнд мэргэжил нэгтгүүдийн үйл ажиллагааг онцолсон байдаг. Мөн Удирдлагын академийн захирал Д.Сүрэнчимэг “Хэнтэй олон удаа харилцаж байна, хүн түүнтэй төстэй болдог” гэж хэлсэн байдгийг үндэс болгон залуу багш ажлын байрандаа тасралтгүй хөгжихөд хамтарч ажиллаж байгаа ахмад багшийн нөлөө чухал гэж үзэн тухайн сэдвийг сонголоо.

Түлхүүр үг: залуу багш; ахмад багшийн харилцан нөлөөлөл.

Судалгааны зорилго

ЕБС-д ажиллаж байгаа ахмад багш болон залуу багш нар бие биеийнхээ хөгжилд хэрхэн нөлөөлж байгааг судалж, цаашид багшийн хөгжилд ахмад багш нарын оролцоог нэмэгдүүлэх санааг дэвшүүлэх

Онолын хэсэг

Багш яагаад хөгжих шаардлагатай вэ?

1. Чанартай сургалт, үр өгөөжтэй мэдлэг, чадвар олгох
2. Суралцагчдыг хөгжүүлэх, чадваржуулах, өрсөлдөх чадвартай иргэн бий болгох

Багшийн хөгжилд нөлөөлөх гол хүчин зүйл нь:

- Хөгжих таатай боломж –орчин буюу хамт олон
- Бусадтай мэдлэг туршлагаа хуваалцах ёс зүй, хандлага
- Өөрөө өөрчлөгдөх, хөгжих хүсэл тэмүүлэл

Эрдэмтэн судлаачдын судалгаанаас үзэхэд багш хөгжих явцад дараах үр дүнгүүд гарч байдаг.


- Суралцагчдад гарч буй мэдлэг, чадвар, төлөвшлийн хувьд өөрчлөгдөх,
- Хүүхдийн оролцоо өргөжиж, сэтгэл ханамж дээшилж, үр дүн нэмэгдэх,
- Багшлах арга барил, ур чадвар, эв дүй, туршлагатай болох,

Ажлын байрандаа бүтээлчээр тасралтгүй хөгжиж онолын мэдлэг, үзэл хандлага, ажлын арга барилаа шинэчлэн сайжруулахдаа суралцагчийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх нь хамгийн чухал.

Судалгааны хэрэгцээ, шаардлага

Монголын багш нар 1990 оноос хойш сургалтын чанарыг дээшлүүлэхийн тулд арга зүйгээ дээшлүүлсээр байгаа ч шинэ арга зүйг бүрэн эзэмшиж, хөгжилд хүрч сургалтын чанарт бодит ахиц гарсан уу? 1990 онд ажиллаж байсан залуу багш одоо 30 жил ажилласан ахмад багш болсон байна. Тэгвэл 30 жил ажилласан багшийн хуримтлуулсан туршлага одоогийн залуу багш нарт маш их хэрэгтэй байна. Тиймээс ахмад багш нарын арга зүй туршлага залуу багш нарт хэрхэн нөлөөлж байгааг судлах хэрэгцээ шаардлага байна гэж үзэж байна. Энэхүү хэрэгцээ шаардлагыг тодорхой болгох үүднээс ахмад болон залуу багш, одоо суралцаж байгаа сурагчдын онцлог болон гол ялгааг энд өгүүлэх нь зүйтэй болов уу.

Зураг 1. Ахмад багш, залуу багш, сурагчдын ялгаа




Судалгааны хэсэг

Судалгаа 1. Зорилго

Ахмад, залуу багш нарын хамтын үйл ажиллагаа, бие биедээ нөлөөлөх нөлөөллийг илрүүлэх зорилгоор асуулгын болон ярилцлагын аргаар 36 багшаас судалгаа авлаа.

Асуулга 1

Та боловсролын байгууллагад хэдэн жил ажилласан бэ?
36 responses




Асуулга 2

Багшийн ажлын сэтгэл ханамж
36 responses




Асуулга 3

1. Ахмад багш нар залуу багш нараас юу суралцдаг вэ?




Асуулга 4

2. Залуу багш нар ахмад багш нараасаа юу суралцдаг вэ?



Асуулга 5

Танд мэргэжлийн талаас туслалцаа авахад хэнд хандах шаардлага тулгардаг вэ?



Асуулга 6-1, Асуулга 6-2




Судалгаа 1-ийн дүгнэлт

- Залуу багш нар заах арга зүй, мэргэжлийн мэдлэг чадвараа ахмад багш нараас суралцдаг.
- Ахмад багш нар залуу багш нараас МХХТ-той ажиллах болон шинэлэг арга зүйг суралцдаг байна. (Асуулга 3, 4)
- Багш нар ижил мэргэжлийн багш нартай хамтран мэргэжил, арга зүйн хувьд хөгжих хүсэлтэй. (Асуулга 5)
- Ахмад багш нар залуу багш нарын хүсэж байгаа хүлээлтэд хүрэхүйц нөлөөг үзүүлж, үлгэрлэн ажиллах, харин залуу багш нар ахмад багш нарын сургамжийг сонсон мэргэжилдээ дурлаж ажиллах

Судалгаа 2

Судалгаа 1-ийн дүгнэлтэд үндэслэн үйл ажиллагаандаа эргэцүүлэл, дүгнэлт хийж мэргэжил нэгт багш нартайгаа хэрхэн хамтарч ажиллаж багшийн хөгжилдөө ахиц, амжилт гаргасан бэ гэдгээ судлахыг зорилоо. Миний хувьд 8 дахь жилдээ ажиллаж байгаа математикийн багш. Манай сургуулийн хувьд 125 багштай бөгөөд хамтарч ажилладаг математикийн секцийн 6 багш байдаг.



1.Сурагчдын мэдлэг, чадварыг ахиулан хичээл заах арга зүйгээ сайжруулахад хэрхэн хамтарч ажиллан үр дүнд хүрсэн бэ?

Баримт-1

№	Сурагчийн нэр	Танхим				Цахим				Хангалттай судалсан агуулга																					
		Тоо тоолох	Зэрэг	Рационал тооны үйлдэл	Харьцаа ба пропорц	Сэтгүүл	Сэтгүүл	Хайгууль өмнө оро	Параллель тасалгаа	Алгебрын алгуури	Солбицол өмнө	Алгебрын бүтэц	Олон өмнө	Бүтэц, дүрс, хувиар	Холцон бодлого	Олон өмнө	Бүтэц, дүрс, хувиар	Урвалын тасалгаа	Тасалгаа	Тоонолын үйлдэл ба дүрс	Шулуны өмнө	Батсан өмнө	Кадат функц	Магдал	Програмын гадаргуу	Магдал	Арифметикийн дүрс	Бүтэц, дүрс, хувиар			
1	Мендүүлгэрэх	1	0	1	2	0	2	1	1	0	0	0	0	0	0	1	1	0	0	0	0	0	0	0	0	0	1	0	1	1	
2	Удвалдцарх	1	1	1	0	2	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
3	Эрдэнэбулган	0	0	0	0	2	0	0	0	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	
4	Энхий	0	1	1	0	2	2	0	1	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	
21	Амжиргал	0	1	1	0	0	2	1	1	1	0	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	
22	Нэмжамжир	1	0	0	0	2	0	1	0	0	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	
23	Ганзориг	0	0	1	2	2	2	0	0	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	
24	Цэдлэв	1	1	1	0	2	2	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
25	Хүснэ	0	1	1	2	0	2	0	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	
26	Функц	0	0	0	0	2	0	0	1	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	
27	Барсболд	1	1	1	2	0	0	1	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	
28	Огноо	0	1	0	0	2	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	
29	Юмжирмаа	1	1	1	2	0	0	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
		29	29	29	58	58	58	29	29	29	29	29	29	29	29	29	29	29	29	29	29	29	29	29	29	29	29	29	29	29	29
		15	15	20	26	26	30	12	19	14	12	13	4	9	10	12	9	9	11	11	4	4	4	4	10	27	27	42	19	20	20
		52	52	69	45	45	52	41	66	49	45	45	14	31	17	21	31	31	38	38	38	14	14	7	34	31	93	72	66	69	69
		52.4				49.4				20.7				28.2				75													

Танхим

Алгебрийн илэрхийлэл ба бутархай

Харьцаа ба пропорц

Цахим

Геометр ба хэмжигдэхүүн

Тэгшитгэл% тэнцэтгэл биш

Функц ба график

Хангалттай судалсан

Дараалал

Магдал статистик


Хоцрогдлыг арилгахад анхаарах нь:

- Богино хугацаанд чанартай гүйцэтгэж, тухайн сарын, улирлын, жилийн төлөвлөгөөт шинэ агуулгад хүрэх
- Тухайн агуулгын хоцрогдлыг арилгахад шаардагдах урд мэдлэг, чадварыг сайн сэргээн сануулж, сонирхлыг нь төрүүлэх
- Хүүхдүүдийн сэтгэл зүй, хандлагыг зөв төлөвшүүлэх
- Агуулга нэгжийн хоорондын холбоог барих

Дээрх хоцрогдсон агуулгыг сурагчдад хурдан хугацаанд ойлгуулах, чадваржуулахад

- Процентийн уусмал, хайлшийн бодлогыг бодох аргачлал, сурагчдад ойлгуулах арга зүй
- Хөнгөнөөс хүндрүүлэх замаар бие даан суралцах арга барилд сургаж байгааг өөрийн үйл ажиллагаандаа тусгаж ажиллахыг зорьсон.

Баримт 2. Сурагчдын мэдлэг, чадварт гарсан ахиц, амжилт



Баримт 3

40%-ын 200 г давсны уусмал дөр хэдэн грамм ус нэмж хийвэл 20%-ын давсны уусмал болох вэ?

$$\frac{200 - 100\%}{x - 40\%} = \frac{200 - 40x}{100x} = 80\%$$

$$\frac{200 - 100\%}{80\% - 40\%} = \frac{200 - 40x}{100x} = 80\%$$

$$80\% - 40\% = 40\%$$

$$80\% - 40\% = 40\%$$


$$x = 200\text{ г (үзвэр үс)}$$





200г — 300г = 200г + 300г

20% — 40% = x%

$$200 \times 20 + 300 \times 40 = x \times (200 + 300)$$





Тэргүүлэх болон ахмад багш нар Ж.Мөнхбаяр, Д.Анхбаяр, 5 дугаар сургуулийн математикийн багш Төмөрчөдөр, Э.Өнөржаргал багш нартайгаа хамтран “Вектор” нэгж хичээлээр сэдвийн цахим хичээл заасан.

боловсруулалт хийж

Заах арга зүй, бодлого бодох аргачлал, даалгаврын шинжилгээ, хүүхэд хөгжүүлэх, төлөвшүүлэх, үнэлгээ нь сурагчдад сайшаал мөн шийтгэл болдог.

Баримт 4. Ахмад багш нарын ангийн сурагчидтайгаа ажиллах арга барилд дараах ажиглалт хийж өөрийн үйл ажиллагаандаа тусгаж байна.

Ахмад багш нараасаа сурагчдыг хөгжүүлэх талаарх ур чадварыг өөрийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллаж байна. Тухайлбал:

Ж.Мөнхбаяр - Ангийн сурагчид нь бусдын алдааг давтахгүй байхад байнга суралцдаг

Д.Шинэзул - Ангийн хүүхдүүд нь багш болон бусад хүмүүстэй зөв сайхан мэндэлж сурсан

С.Гэрэлтуяа- Эцэг эхийн үйл ажиллагааг урамшуулах замаар тэдний оролцоог сайжруулан нягт холбоотой ажилласнаар хүүхдийн сурлага, хүмүүжилд ахиц гардаг.

Г.Энхцэцэг-Эцэг эхчүүдийн тусламжтайгаар сурагчдын сургалтын орчинг сайжруулах арга туршлага

Г.Өсөхжаргал-Суралцагчдад өгсөн үүрэг даалгавраа заавал эргэж хянан үр дүнг тооцдог



Массаар нь хөгжүүлэхдээ багш зөвхөн чиглүүлэх бус хамтдаа хөгждөг. /Ц. Жидээ/



- Урлаг, спортын тэргүүний анги
- Цахимын үед 100% хамруулж чадсан.
- Бусдыг хүндлэх, харилцах харилцаанд эерэг өөрчлөлт гарч байсан.
- Сурлагын чанарт ахиц гарч байсан.

Дүгнэлт

Залуу багш нарын хувьд:

1. Ахмад болон туршлагатай багш нарын үйл ажиллагаанаас суралцаж мэргэжлийн онол, арга зүйгээ дээшлүүлэн хөгжих
2. Мэргэжилдээ дуртай байж ахмад багш нарын үгийг сонсож, авах гээхийн ухаанд суралцан, мэдэхгүй зүйлээ асууж сурахаас эмээхгүй байх
- 3.Өөрөө сайн багш болсноор дараагийн шинэ залуу багш нарыгаа илүү сайн багш болох, тэдэнд дэмжлэг үзүүлдэг ахмад багш болохын тулд одооноос өөрийгөө хөгжүүлэх, сэтгэлгээгээ шинэчлэх, шинийг эрэлхийлэх, арга зүйгээ сайжруулах

Ахмад багш нарын хувьд:

1. Техник технологийн дэвшлийн өөрчлөлт шинэчлэлтэд залуу багш нартай хамтран хурдацтай суралцах
2. Залуу багш нарынхаа үлгэр, дуурайлал болж ажиллах, эергээр нөлөөлөх
- 3.Залуу багш нарт мэдсэн, сурсан бүхий л зүйлээ өвлүүлэх, хойч үеийн чадварлаг багшийг бэлтгэх шаардлагатай байна.

Дэвшүүлж буй санал

Сургуулийн түвшинд:

- Ахмад багш нарын нэрэмжит цагтай болж долоо хоногт нэг удаа багш хөгжлийн цагаар ахмад багшаар яриа зөвлөгөө өгүүлэх
- Хамтын судалгааны багийг бүрдүүлэх (Багш нарын хөгжлийн хэрэгцээ шаардлагыг судалж, түүн дээрээ тулгуурлан үйл ажиллагаа зохион байгуулах)

Орон нутгийн түвшинд:

- Аймгийн хэмжээнд ажиллаж буй шилдэг туршлагатай, ахмад багш нарын туршлагыг залуу багш нарт түгээх ажлыг зохион байгуулах

Үндэсний түвшинд (БМИД):

- ЕБС-ийн ахмад багш нар залуу багш нарт дэмжлэг үзүүлж ажиллах талаар нэгдсэн чиглэл өгч ажиллах

“БАГШИЙН БАГШ” ХӨТӨЛБӨР НЬ ЗАЛУУ БАГШИЙН МЭРГЭЖЛИЙН ӨСӨЛТӨД НӨЛӨӨЛӨХ НЬ

Б.Энхмаа¹, Б.Мөнхтуул², Б.Баянмөнх³

Увс аймгийн Улаангом сумын ерөнхий боловсролын

6 дугаар сургууль

Emaenhmaa044@gmail.com¹, 0825tuul@gmail.com², bayanmunkh99627883gmail.com³

Хураангуй

“Та бид өнөө үеийн уугуул иргэдийн цаг хугацаанд зочлон ирсэн суугуулууд билээ.”²⁸ Хөгжлийг түүчээлэгч багш бид цаг үеэсээ хоцрохгүйг эрхэм болгож, мэргэжлийн хувьд цаг ямагт өсөж хөгжих шаардлага тулгараад байна. Иймд багш ээлжит хичээлийн төлөвлөлтөө чанартай бэлтгэн, өөрийн арга зүйгээ хөгжүүлэхэд анхаарснаар ямар үр дүнд хүрэх боломж байгааг судлан туршиж.

Түлхүүр үг: “Багшийн багш” хөтөлбөр; зөвлөгч багш; чадварлаг багш.

Оршил

Судалгааны шинэлэг тал

“Багшийн багш” хөтөлбөр хэрэгжүүлснээр зөвлөгч (ментор) багшийн үйл ажиллагааг туршин хэрэгжүүлэх.

Судалгааны дэвшүүлж буй асуудал

Багш ээлжит хичээлийн төлөвлөлтөө чанартай төлөвлөх явцдаа өөрийн мэдлэг, арга зүйгээ хөгжүүлж, хичээл үйл ажиллагааг хүүхдийн хөгжил төлөвшил рүү чиглүүлэх нь багшийн ажлын байрын тасралтгүй хөгжил мөн бөгөөд баг хамт олны оролцоог нэмэгдүүлэх нь хамгийн оновчтой бөгөөд бүтээлч үйл ажиллагаа юм.

Судалгааны зорилго

Багш ажлын байртаа зөвлөгч (ментор) багшийн дэмжлэгтэйгээр мэргэжил, арга зүйн хувьд өсөж хөгжих боломжийг судлах, турших, хэрэгжүүлэх.

Судалгааны зорилт

- Тандалт судалгаа авах
- Судалгааны дагуу гол асуудлыг дэвшүүлэх
- Дэвшүүлсэн асуудалд гаргалгааг олох

²⁸ Бид бол өнөө үеийн зет, альфа үеийн хүмүүсийн цаг хугацаанд ирсэн зочид билээ. ЕБ-н багш нарын ихэнх нь gen x, millennial үеийнхэн байна. Иймд бид цаг үедээ нийцэх, дасан зохицож, шинэ үеийн нөхцөл байдалд суралцах хэрэгцээ үүсээд байна.

Б.Сүрэнчимэг. (2022). Үе хоорондын ялгаа багшийн хөгжил. Улаанбаатар.

- Гаргалгааг бодитоор туршин хэрэгжүүлэх
- Үр дүнг тооцох

Судалгааны арга:

- Google forms ашиглан судалгаа авах.
- Туршилт хийх. Ээлжит хичээлийн А загварыг Б загвартай харьцуулах.
- SPSS 28 программ ашиглан үр дүнг шинжлэх

Судлагдсан байдал

Менторын үүсэл хөгжлийн түүх эрт үеэс улбаатай ба өнөө үед хүчээ авч буй хувь хүний хөгжлийн чухал нэгэн үйл ажиллагаа юм. Менторын тухай цөөнгүй бүтээл, гарын авлага, материалуудаас БШУЯ-аас гаргасан “Ментороос менторуудад зориулав” гарын авлагыг энэхүү илтгэлдээ ашиглав. Сүүлийн гурван жилийн хугацаанд бид сургууль дээрээ “Багшийн багш” хөтөлбөрөөрөө дамжуулж менторын үйл ажиллагааг туршиж байна.


Судалгааны хамрах хүрээ

Сорил судалгаанд Баянгол, Сүхбаатар дүүрэг, Увс, Ховд, Өмнөговь, Говь Алтай, Завхан, Сэлэнгэ, Орхон зэрэг нийт 8 аймаг, 2 дүүргийн 132 багш хамрагдав. Судалгаанд аль болох өргөн хүрээг хамруулж, бүс бүрээс багшийн төлөөлөл оролцуулахыг зорив. Туршилт судалгаанд Увс аймгийн Ерөнхий боловсролын 6 сургуулийн 55 багш хамрагдлаа.

Үндэслэл

Дөрвөн жил суралцсан мэргэжлээрээ дөчин жил амьдрах үе ард хоцроод байна. Иймд багшийн тасралтгүй хөгжлийг чухалчилсан цөөнгүй баримт бичгүүдэд боловсруулагджээ.

Зураг 1. Багшийн хөгжлийн талаарх баримт бичгүүд



Үндсэн хэсэг

Багшийн мэргэжлийн өсөлт гэж юу вэ?: “Өсөлт” гэдэг үгийн утгыг монгол хэлний тайлбар толиос үзвэл торнилт, томролт, бойжилт, хөгжилт гэсэн утгыг илэрхийлэх бөгөөд ерөнхийдөө дээшлэх, томрох хэмээх утгыг агуулах аж (Я.Цэвэл, 2021, хуудас 651).

Тэгвэл багш бид мэргэжлийн хувьд дээшлэх, ахихын тулд юунд илүү анхаарал хандуулах шаардлагатай вэ? Яаж багш та бид цаг наргүй ажлынхаа хажуугаар тасралтгүй хөгжлийг өөртөө бий болгох вэ? Эдгээр асуултад хариулт эрэлхийлж, энэхүү илтгэлээ бичлээ.

Сорил судалгаа зорилго: Багш нарын хувьд яг мэргэжлийн өсөлт гэдэгт юуг хамааруулж ойлгодог болохыг тодорхойлох. Багшийн мэргэжлийн өсөлтөд хамаарах зүйлсийн дарааллыг олж тогтоох.

Сорил судалгааны дүгнэлт

Судалгаанд оролцсон багш нарын ихэнх нь “багшийн мэргэжлийн өсөлтөд хамгийн чухалд тооцогдох чадвар бол хичээл заах арга барил” юм гэж үзжээ.

Асуудал - Заах арга барил -29% !! Үүнийг шийдэх шийдлийг дараах байдлаар томъёолов.

- Онолын мэдлэг -20%
- МХХТ хэрэглэх чадвар– 21%
- Бичиг баримт боловсруулах чадвар -15%
- Багшийн ёс зүй -15% зэргийг дурджээ.

Ээлжит хичээлийн хөтөлбөр сайжруулах

Багшийн хичээл заах арга барил нь багш хичээлдээ хэрэглэж буй арга зүй технологи ба ээлжит хичээлийн төлөвлөлтөөс шууд хамаарна. Багш ээлжит хичээлийн төлөвлөлтөд анхаарснаар 40 минутыг үр дүнтэй өнгөрүүлж чаддаг.

“Багшийн багш” хөтөлбөр буюу Ментор багш

Хөтөлбөрийн зорилго: Багш ажлын байртаа тасралтгүй өсөж хөгжих боломж, нөхцөлийг судлах, турших, үр дүнг тодорхойлох юм.

Товчхондоо бусдад зөвлөн туслах чадвар, зөв хандлагатай²⁹ багш нар маань, бусдаас суралцах чин хүсэлтэй залуу багштай хамтран нэг баг болж бие биенээ мэргэжил арга зүйн хувьд дэмжиж ажиллах юм. Иймд, илтгэлдээ Вальдорфийн сурган хүмүүжүүлэх онолыг эх үндэс болгов. Уг онолоор хүмүүс бие биесийнхээ бие махбод ба сэтгэл санаанд явагдах хөгжилд үзүүлэх нөлөөллийг чухалчилдаг.(<http://www.buuvei.mn/>)

“Залуу багш - зөвлөгч багш (ментор багш)” хамтран нэг баг болсноор хамтын хэрэгцээ, сонирхол, зорилго, үнэт зүйл, үйл ажиллагааны арга барилын талаар нэгдмэл нэг ойлголт, нэг итгэл үнэмшилтэй болж хамтын зорилго, ижил үр дүнгийн

²⁹ Сэтгэл судлалын шинжлэх ухаанаар: “Хувь хүний үзэл бодол зорилго үйл ажиллагаанд илрэн гарч буй эерэг болон сөрөг үйлдэл, үзэгдлийг хандлага гэнэ. Энэ нь хувь хүний үйлдэлд түр болон урт хугацаагаар илэрч болно. Урт хугацааны туршид илрэх байдал нь тогтсон хандлага юм. Энэ нь хувь хүний өөрийн үйл ажиллагааг зохицуулан явуулах үйл ажиллагааны ойрын болон хэтийн чиг баримжааг тогтоон тодорхойлох бүх төрлийн бодит байдал болон нөхцөл байдалд эрэмбэ дэс дараатай, тодорхой чиг зорилготой хандах тогтвортой хандлага юм” Д.Санжжав., С. Энхболд. (2000). Сэтгэл судлалын ухааны тайлбар толь. 138-р тал

төлөө бие биенээ дэмжиж нэг зүгт хардаг. “Харилцагч бүр өөрийгөө нөгөө хүнтэй харьцуулан жишиж, тухайн хүний *толинд* өөрийгөө тольдох үйл явц байнга өрнөж байдаг.” (Алгаа.П., Алтанцэцэг.Д., нар, 2013). Ингэж эергээр нэг нэгэндээ нөлөөлөх нь хөгжлийн үндэс юм. “Багш нар ажлын байртаа хөгжих боломжийг ашиглах хүсэл сонирхол байгаа боловч хэрхэн ажиллах арга барилаа олохгүй, төвлөрүүлэн зохион байгуулсан сургалтад алдаг оног оролцож сертификат олж авах төдийгөөр хязгаарлагдаж байна.” (Ч. Пүрэвдорж, 2014, хууд 400). Өөрөөр хэлбэл энэхүү хөтөлбөр маань менторингийн үйл ажиллагаа, зорилго чиглэлтэй нийцэж байгаа юм. “Менторинг нь илүү туршлагатай болон арай бага туршлагатай хувь хүмүүсийн хоорондох бие биенээ харилцан хөгжүүлэх харилцаа” юм хэмээн судлаач Коллин тодорхойлжээ. (Ментороос менторуудад, 2018).

Хүн бүхнийг анхнаасаа мэддэг, чаддаг төрнө гэж үгүй. Бүгд л уйгагүй суралцаар одоогийн өөрийгөө бүтээдэг билээ. Иймд өөрийн мэдэхгүй, чадахгүй байгаагаас ичих, эмээх, хойш суух хэрэггүй. Харин ч бусдаас асууж, сурч мэдэж байгаа хүн хамгийн зөв замаа олсон хүн байдаг.

Багшийн багш хөтөлбөр хэрэгжүүлсэн нь: Энэхүү хөтөлбөр маань дараах үндсэн хоёр чиглэлд шинэ төгсөж ирсэн залуу багш нараа хөгжүүлэхээр зорив.

Хөтөлбөрийг сайжруулах чиглэлээр: “Багшийн багш” хөтөлбөр нь залуу багшийн хичээл заах арга барилд түлхүү анхаарч, өдөр бүр хөтөлбөр сайжруулалт хийж ажилласнаар, БШУЯ хэрэгжүүлж буй “Чадварлаг багш” хөтөлбөртэй зорилго, үйл ажиллагаа, үр дүнгийн хувьд нягт уялдаж байна. Хөтөлбөрийн хүрээнд ээлжит хичээлийн загварт өөрчлөлт хийснээр залуу багш өөрийн хичээлийн үе шат бүрт үр дүнгээ тооцсон, шинэ зүйлд суралцсан бүтээлч үйл ажиллагаанд суралцаж байна.

Хөтөлбөр сайжруулах А туршилт:

Хүснэгт 1: Бидний өмнө нь хийж ирсэн ээлжит хичээлийн төлөвлөлт загвар

Хичээлийн үе шат	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа
Сэдэлжүүлэлт		
Шинэ мэдлэг бүтээх		
Бататгах		
Дүгнэлт		

-А туршилтаар багш ээлжит хичээлийн хөтөлбөрөө сурагчийн үйл ажиллагаа, багшийн үйл ажиллагаа гэсэн үндсэн хоёр чиглэлээр төлөвлөж ирсэн түгээмэл загвараар хийх.

- Залуу багшийн хичээлд зөвлөн чиглүүлэгч багш сууж, үе шат бүрт

дүгнэлт хийж, анхаарах зүйлс нь дээр зөвлөгөө өгөв.

Хөтөлбөр сайжруулах эхний алхамд дараах асуудлууд тулгарсан.

Хичээл бүрийн дараах хэлэлцүүлгээр багшийн анхаарч, сайжруулах зүйлс доривтой багасахгүй. Багш өмнө гаргасан алдаагаа давтсаар байв.

Багш хичээл заах явцдаа онолын алдаа зөрүү гаргах байдал цөөнгүй байлаа.

Иймд залуу багш нарынхаа онолын мэдлэг чадвар, бүтээлч чадварыг дээшлүүлэх хэрэгцээ шаардлага үүссэн ба үүнийг бид ээлжит хичээлийн хөтөлбөрийн загвартаа өөрчлөлт хийх замаар шийдвэрлэв.

Хөтөлбөр сайжруулах Б туршилт:

2021-2022 оны хичээлийн жилээс Аймгийн хэмжээнд нэгдсэн журмаар туршигдаж буй ээлжит хичээлийн хөтөлбөрийн загвараар хичээл төлөвлөлтөө хийж эхэлсэн. Туршин хэрэгжүүлснээр, залуу багш нарт дараах үр дүнгүүд гарсан (5 сарын хугацаанд туршив).

Хичээлийн үе шат	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа	Үе шат бүрийн хүрэх үр дүн
Сэдэлжүүлэлт			
Шинэ мэдлэг бүтээх			
Бататгах			
Дүгнэлт			

Хавсралт 2: Туршин хэрэгжүүлж буй ээлжит хичээлийн төлөвлөлт загвар

Хичээлийн үе шат	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа	Үе шат бүрийн хүрэх үр дүн
Сэдэлжүүлэлт			
Шинэ мэдлэг бүтээх			
Бататгах			
Дүгнэлт			

Б загвар боловсруулсан арга зам:

- 1.Багш ээлжит хичээлийн төлөвлөлт хийхдээ хичээлийн үе шат бүрийн ард хүрэх үр дүнгээ тодорхой заадаг.
- 2.Ээлжит хичээлийн төлөвлөлтөө гараар бичдэг.

Б загвараар ээлжит хичээлийн хөтөлбөрөө тэмдэглэсний үр дүн:

- Багшийн онолын мэдлэг ахисан. Аливаад эрэл хайгуул хийх, бүтээлч, шинжлэх ухаанч хандах чадвар өссөн.
- Самбар төлөвлөлт эрс дээшилсэн. Самбарт хичээлийн агуулгыг маш цэгцтэй тэмдэглэх болсон.
- Хичээлийн үе шат бүрийн үр дүнгээ нарийн тооцоолсноор 40 минутыг бүтээлч өнгөрүүлдэг болсон.
- Үүнийг дагаад сурагчдын хичээлийн идэвх ахисан. Сурлагын чанарт ч эергээр нөлөөлсөн.

Ээлжит хичээлийн хөтөлбөр сайжруулсан Б туршилтын үр дүн, багшид үзүүлсэн нөлөөллийн SPSS программаар дүгнэхэд: Найдвартай байдал нь факторын олон хэмжилтийн хувьсагчдын хоорондох нийцэмжийн түвшинг үнэлэх явдал буюу хэмжилтийн дотоод тогтвортой байдлыг илэрхийлдэг. Дотоод нийцтэй байдал нь Кронбах альфа-ийн утга 0.9-өөс их байвал маш сайн бөгөөд 0.7-оос багагүй байвал хүлээн зөвшөөрөгддөг (Blunch, 2008). (Навчаа, Ц., Түмэнбаяр, Д., 2017 он)

Reliability Statistics		
Cronbach's Alpha	Cronbach's Alpha Based on Standardized Items	N of Items
.693	.693	2

Б загвараар ээлжит хичээлээ төлөвлөж заах болсноор өдөр тутмын хичээлийн чанар ахисан эсэх:

Кронбах альфа утга 0.693 байгаа нь боломжийн буюу багшийн өдөр тутмын хичээлийн чанар ахисан нь батлагдаж байна.

Багшийн онолын мэдлэг дээшилсэн эсэх

Reliability Statistics		
Cronbach's Alpha	Cronbach's Alpha Based on Standardized Items	N of Items
.873	.874	2

Кронбах альфа утга нь 0.873 буюу ойролцоогоор 0.9 байгаа нь ээлжит хичээлийн хөтөлбөрөө Б загвараар бичиж, зузаан дэвтэрт гараар тэмдэглэж, сурах бичгээс өөр эх сурвалжаас агуулгаа баяжуулсан нь багшийн онолын мэдлэг дээшилсэн болохыг

баталж байна.

Нэгэнт зорилго уялдсан учир өөрсдийнхөө тус бүрийн үүргийг ухамсарлаж хөгжиж, хөгжүүлэхийг эрхэм болгож нэгэн баг болж ажиллах явцдаа ахмад үеийн багш нар маань ч гэсэн залуу багш нараасаа их зүйл сурч мэдэж байна. Ингэж харилцан бие биеэ хөгжүүлж хамтран, ажиллаж чадаж буй маань бидний ажил зайлшгүй шаардлагатай байсныг баталж байна. Үүний баталгаа болгож доорх судалгааг та бүхэнд хүргэхэд:

Total Variance Explained						
Component	Initial Eigenvalues			Extraction Sums of Squared Loadings		
	Total	% of Variance	Cumulative %	Total	% of Variance	Cumulative %
1	1.531	76.531	76.531	1.531	76.531	76.531
2	.469	23.469	100.000			

Extraction Method: Principal Component Analysis.


Туршилтад хамрагдсан багш нарын (1) маань хөтөлбөр боловсруулах чадвар болон онолын мэдлэг 76.531% ахисан гэсэн үр дүн гарсан бол, хамрагдаагүй (2) багш нарт хамаарлын утга гараагүй. Энэ нь бусад багш ч гэсэн ээлжит хичээлээ Б загвараар бичиж өөрсдийгөө хөгжүүлэх шаардлагатай нь харагдаж байна.

2. Багшийн арга зүйг хөгжүүлэх чиглэлээр: “Багшийн багш” хөтөлбөрийн хүрээнд сургуулийнхаа нийт багш нарын хичээл заах ур чадварыг ахиулах зорилгоор жил бүр “Нэг багш – Нэг арга зүй” боловсруулах үйл ажиллагааг зохион явуулдаг. Арга зүй-технологи гэдэг нь багш өөрийн хичээл практикт жижиг гэлтгүй туршин хэрэглэж буй үйл ажиллагаа юм. Үүнээс заавал том зүйл хүсэх хэрэггүй. Жижиг гэлтгүй хичээл,

сургалтдаа хэрэглэж буй хүүхдэд сурах, хөгжих сэдэл \motivator\³⁰ өгч буй тэр зүйлийг бүгдийг нь хамааруулж үздэг. линк

Багш өөрийн өдөр тутмын хичээлд туршин хэрэгжүүлэх арга зүйгээ боловсруулахдаа арга зүй технологи боловсруулах 5 дарааллыг баримтлах ёстой. Ингэснээр таны туршин хэрэгжүүлж буй арга зүй илүү үр дүнтэй, бүтээлч болно. (Арга зүй технологи эмхэтгэл, 2019)

Хавсралт 3: Арга зүй технологи боловсруулах дараалал:



Correlations			
		[Арга зүй]	[Ур чадвар]
сургалтын технологитой болсноор аны арга зүй өссөн үү?	Pearson Correlation	1	.964**
	Sig. (2-tailed)		.000
	N	18	18
аны сурагчидтай харилцах эв дүй, ур чадвар ахисан уу?	Pearson Correlation	.964**	1
	Sig. (2-tailed)	.000	
	N	18	18

. Correlation is significant at the 0.01 level (2-tailed).

Энэ 2 асуултын хоорондын харилцан хамаарлын түвшин **0.964** байгаа нь маш чухал ач холбогдолтой гэсэн үр дүн гарлаа.

Reliability Statistics		
Cronbach's Alpha	Cronbach's Alpha Based on Standardized Items	N of Items
.981	.982	2

Кронбах альфа утга 0.981 байгаа нь “Нэг багш – Нэг арга зүй” үйл ажиллагааны үр дүнд залуу баш нарын маань арга зүй, ур чадвар дээшилсэн болохыг баталж байна.

Арга зүй технологи боловсруулж хэрэгжүүлэх ач холбогдол:

- Багшийн арга зүй ур чадвар дээшилнэ.
- Судалгааны ажил хийж сурах эхлэл болно.
- Сурагчдыг сонирхолтой байдлаар хөгжүүлнэ.
- Сурагчдыг сурах арга барилд сургана.
- Агуулга эзэмшилтийн хувь нэмэгдэнэ.

³⁰ Хөгжил, дэвшлийн төлөөх үйлд сэдэлжүүлэн, өдөөгч/motivator/ үйл явдал юм. Б.Батаа <https://www.facebook.com/photo/?fbid>

- Батламж авснаараа мэргэжлийн зэрэг авах, ахиулахад нөлөөлнө.

Арга зүй технологийн уралдаан зохион явуулаад үр дүнд нь, багш бүрийн туршин хэрэгжүүлсэн аргуудыг эмхтгэл болгон хэвлэдэг. Одоогоор багш нарынхаа туршин хэрэгжүүлсэн арга зүйг бусдад түгээх зорилгоор хоёр эмхтгэл хэвлүүлж, туршлагаа түгээн дэлгэрүүлээд байна.

Багшийн багш хөтөлбөр хэрэгжүүлсний давуу тал:

- Практикт түшиглэсэн учир илүү бодитой, үр дүнтэй байдаг.
- Ажлын талбарт явагддаг учир тусгай цаг гаргах шаардлагагүй.
- Туршлага судлах ментор бэлэн байдаг.
- Ажлын хамтрагчтай болсон мэт сэтгэлзүйн эерэг орчин үүсдэг.
- Алдаа, оноогоо цаг алдалгүй мэдэх боломжтой.
- Ажлын байртаа, тасралтгүй шинж чанартайгаар өөрийгөө хөгжүүлдэг.
- Үүрэг хариуцлагаа ойлгох, ухамсарлах үзэл дээшилдэг.



Зураг 1: Арга зүй технологи эмхэтгэл 2019 он

Багшийн багш хөтөлбөр хэрэгжсэн 3 жилийн үр дүнг боловсруулж дүгнэхэд:

Communalities		
	Initial	Extraction
Багшийн багш хөтөлбөр хэрэгжсэнээр залуу багш нарын хичээл заах арга барил сайжирсан уу?	1.000	.866
Багшийн багш хөтөлбөр хэрэгжсэнээр залуу багш нар өөрийн гэсэн арга зүй технологитой болж чадсан уу?	1.000	.872
Залуу багш нар зөвлөн чиглүүлэгч багштай хамтран ажилласан нь тэдний мэргэжлийн өсөлтөнд эерэгээр нөлөөлсөн үү?	1.000	.853
Extraction Method: Principal Component Analysis.		

1. Б загвараар хөтөлбөрөө төлөвлөснөөр залуу багш нарын заах арга барил 86.6% сайжирсан.
2. “Нэг багш- Нэг арга” зүй үйл ажиллагааг хэрэгжүүлснээр залуу багш нарын 87.2 хувь нь өөрсдийн гэсэн гаршсан арга зүйтэй болж чадсан.

3. Зөвлөн чиглүүлэгч багштай хамтарч ажилласан нь залуу багш нарын 85.3%-д мэргэжлийн өсөлт хөгжилд нь эерэг нөлөө үзүүлж чаджээ.

Reliability Statistics			
Cronbach's Alpha	Cronbach's Alpha Based on Standardized Items	N of Items	
.920	.921	3	

Судалгааны үр дүн:

Өмнөх судалгааны үр дүнд фактор батлах шинжилгээ хийхэд Кронбах альфа утга нь 0.9-өөс их буюу үр дүнтэй хөтөлбөр болсон нь батлагдаж байна.

Дүгнэлт

Нийгэм цаг үеэ дагаад багш бид тасралтгүй хөгжих хэрэгцээ шаардлага үүсээд байна. Үүнийг шийдвэрлэх арга зам, гарц байна уу? Үгүй юу? Эсвэл бид гарцаа хаагаад зогсоод байна уу?

Үзүүр хүрвэл уяа хүрдэг...Бид аливааг бүтээлчээр харж чадвал хөгжлийн гарц, таны хажууд байна. Судалгааны үр дүнгээс харахад багш ээлжит хичээлийн үе шат бүрийн хүрэх үр дүнгээ тооцоолсноор, хичээлийн чанар сайжирч, багшийн онолын мэдлэг, арга зүй сайжирдаг нь батлагдаж байна. Бидний хэрэгжүүлж буй “Багшийн багш” хөтөлбөр нь залуу багшийг мэргэжлийн хувьд өсөж өндийхөд түлхэц болсон үр дүнтэй хөтөлбөр болсон батлагдаж байна.

Түгээн дэлгэрүүлэлт

Энэхүү үйл ажиллагаагаа “Багшийн багш” фэйсбүүк гүрпээр дамжуулан 150 гаруй хүнд үйл ажиллагаагаа мэдээлээд байна. Манай сургуулийн зүгээс эдгээр арга туршлагуудаа Увс аймгийн Тэс, Завхан, Бөхмөрөн, Наранбулаг зэрэг дөрвөн сумын 6 сургуулийн нийт 190 багшид түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа хийгээд байна.

Алсын хараа

“Багшийн багш” хөтөлбөр багшийн ажлын байр дахь тасралтгүй хөгжилд цөөнгүй үр дүнг өгч буй учир цаашдаа үе шаттайгаар, өргөн хүрээг хамрах, бүтээлч ажлуудыг зохион байгуулахаар төлөвлөөд байна. Үүнд:

1. Цаашид залуу багш нарынхаа анги удирдалт, асран хамгаалагчидтай ажиллах арга зүйг хөгжүүлэх.
2. Сурагчидтай харилцах эв дүй ур чадварыг өсгөх.
3. Шилдэг арга зүйг бусдад түгээх зорилгоор жил бүр аймгийнхаа залуу багш нарын дунд “Нэг багш- Нэг арга” зүй уралдааныг явуулах... гэх мэт ажлуудыг үе шаттай явуулахаар төлөвлөөд байна

Ном зүй

Алгаа,П., Алтанцэцэг,Д., нар. (2013). *Мэргэжлийн сэтгэл зүй*. Улаанбаатар

Биньээ,А. (2000). *Арга зүйд суралцахуй II*. Улаанбаатар

(2019). *“Арга зүй технологи” эмхтгэл*. Улаанбаатар

Цэвэл,Я. (1966). *Монгол хэлний тайлбар толь*

Пүрэвдорж,Ч. (2014). *Багшлахуйн менежмент*. Улаанбаатар

(2021). *Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын лекц*. Улаанбаатар

Жавзан,Б. (2013). *Боловсрол судлалын үндэс* Улаанбаатар

Лхагважав, Б. (2011). *“Сургалтын технологийн шинэчлэл”*. Улаанбаатар

Ичинхорлоо,Ш. (2013). *Сургалтын арга онол ба хэрэглээ*. Улаанбаатар

Ичинхорлоо,Ш. (2009). *Сургалтын арга зүйн шинэчлэл*. Улаанбаатар.

Навчаа,Ц., Түмэнбаяр,Д. (2017). *Технологи хүлээн авах хэмжилтийн загварын фактор сорих шинжилгээ*. Боловсрол судлал. Улаанбаатар

(2018). *“Ментороос менторуудад зориулав.” гарын авлага*. Улаанбаатар

(2020). *“2019-2020 оны Улсын сурган хүмүүжүүлэх илтгэлийн уралдааны эмхэтгэл”*. Улаанбаатар

Интернэт эх сурвалжууд:

<https://www.facebook.com/MinistryofEdu/videos/492292979277032>

<http://www.buuvei.mn/?q=%D2%AF%D0%B7%D1%8D%D0%BB-%D0%B1%D0%B0%D1%80%D0%B8%D0%BC%D1%82%D0%BB%D0%B0%D0%BB-%D0%B1%D0%BE%D0%B4%D0%BB%D0%BE%D0%B3%D0%BE/%D0%B2%D0%B0%D0%B%D1%8C%D0%B4%D0%BE%D1%80%D1%84%D0%B8%D0%B9%D0%BD-%D1%81%D1%83%D1%80%D0%B3%D0%B0%D0%BD-%D1%85%D2%AF%D0%BC%D2%AF%D2%AF%D0%B6%D2%AF%D2%AF%D0%BB%D1%8D%D1%85-%D1%83%D1%85%D0%B0%D0%B0%D0%BD>

<https://sdg.1212.mn/>

<https://www.facebook.com/photo/?fbid=5135037279889049&set=a.515670485159108>

“ХАВРУТА” АРГЫГ ХЭРЭГЖҮҮЛСЭН НЬ

Д.Уранцэцэг¹, Б.Золзаяа², Л.Цэрэнханд³

Нийслэлийн Хан-Уул дүүргийн ерөнхий боловсролын

52 дугаар сургууль

urantsetseg521@gmail.com¹, zoloo.b52@gmail.com², 2020school.52@gmail.com³

Хураангуй

Багшийн хөгжил гэж багшийн мэдлэг, арга зүй, ур чадвар, боловсролоо дээшлүүлэх тасралтгүй үйл явцыг хэлнэ (Багшийн хөгжлийг дэмжих тухай” хууль 3.1.). Багш нь мэргэжил, хувь хүний ур чадвар болон мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаанд оролцож насан туршидаа суралцан хөгждөг. Багш өөрийгөө хөгжүүлэхийн тулд “юуг, хэрхэн, хэзээ, хаана өөрчлөн шинэчлэх вэ?” гэдгийг судалж, оновчтой шийдлийг сонгон бүтээлчээр хэрэгжүүлэх хэрэгтэй.

Багш ажлын байран дээрээ байгууллагын бодлого, шинэлэг үйл ажиллагаагаар хөгжих боломжтой юм. Сургуулийн өөрийн үнэлгээгээр тулгамдаж буй асуудлаа илрүүлэн, шийдвэрлэх үйл явцад багш хөгжих нь тодорхой.

Багшийн мэргэжлийн зэрэг нь багш, ажилтны албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлж, үр дүнд хүрч мэргэжил, ур чадварын өсөлт, хөгжлийг илэрхийлдэг. Багшийн ажилласан жил, мэргэжлийн зэргээс үл шалтгаалан үе үеийн багш нар хамтран ажиллаж, харилцан суралцаж хөгжиж байна.

Энэхүү илтгэлдээ “Хаврута” аргыг нэвтрүүлэн, багш нарын хамтын ажиллагаагаар тулгамдаж буй асуудлаа хэрхэн шийдвэрлэсэн, түүний үр дүнд багш нар хамтдаа хөгжих боломж, санал дүгнэлтийг тусгалаа. Энэ арга нь уламжлал шинэчлэлийн цогц үйл ажиллагаа бөгөөд ахмад болон залуу багш нарын хамтын үйл ажиллагааны нэгдэл юм.

Уламжлал шинэчлэл, технологийн, багшлахуйн агуулгын мэдлэг, технологийн агуулгын мэдлэг, технологийн багшлахуйн мэдлэгийг “Хаврута” аргаар ахмад, дунд, залуу үеийн багш нарын хамтын үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлэхийг зорилоо.

Түлхүүр үг: Хаврута; тулгамдаж буй асуудал; асуултын шинжилгээ; хариултын шинжилгээ; багшийн хөгжил; сургуулийн өөрийн үнэлгээ; мэдлэг чадварын сорил.

Оршил

Нийгмийн хөгжлийн өөрчлөлтийн явцад үүссэн шинэ хэрэгцээ шаардлагыг боловсролын байгууллага өөрийн үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх нь зайлшгүй чухал болсон.

Багшийн хөгжлийг дэмжих хуульд “Багшийн хөгжил” гэж багшийн мэдлэг, арга зүй, ур чадвар, боловсролоо дээшлүүлэх тасралтгүй үйл явц гэж тодорхойлсон. (“Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль” 3.1.2.

Байгууллагын “Өөрийн үнэлгээ”-ний үр дүнд үндэслэн Еврей үндэстний боловсролын нууц асууж, харилцан ярилцах, дүн шинжилгээ хийх болон бүтээлч чадвар гайхалтай хөгждөг “Хаврута” аргыг Х, Y, Z үеийн багш нарын хамтын үйл ажиллагаагаар хэрэгжүүлсэн.

Үндсэн хэсэг

Судалгааны зорилго

Багш удирдлагын хамтын ажиллагаагаар “Хаврута” аргад тулгуурлан багш хөгжих боломжийг илрүүлэх

Судалгааны зорилт

- Сургуулийн өөрийн үнэлгээний дүгнэлтээс тулгамдсан асуудлыг илрүүлэх
- Багшийн хөгжилд шаардлагатай дэмжлэг, хэрэгцээг илрүүлэх
- Багшийн хөгжлийг дэмжих боломж, үр дүнг дүгнэх

Судалгаанд ашигласан арга

Асуулга, ганцаарчилсан ярилцлага, WMS аргачлал, баримтын шинжилгээ

Судалгааны таамаглал

Сургуулийн өөрийн үнэлгээнээс тулгамдаж буй асуудлыг илрүүлэн “Хаврута” аргыг сургалтын үйл ажиллагаанд хэрэглэснээр ахмад, дунд, залуу үеийн багш нарын хамтын ажиллагааны үр дүнд асуултыг төлөвлөх, асуултын чанар сайжирч арга зүйн талаас багш хөгжинө.

Судалгааны ажлын шинэлэг тал

“Хаврута” аргыг сургалтын үйл ажиллагаанд хэрэглэж залуу, дунд, ахмад үеийн багш нарын хамтын ажиллагаагаар багш хөгжих боломжийг судалснаараа бусдад түгээн дэлгэрүүлэх шинэлэг арга болно гэж үзлээ.

Судлагдсан байдал

“Хаврута” нь Араб хэлэнд “найз, хамтрагч”, Еврей хэлэнд “баг, бүлэг” гэсэн язгуур утгыг илтгэх ба “хамтрагчаасаа асууж ярилцан мэтгэлцэх” гэсэн утгатай арга юм.

Монгол улсын хэмжээнд судлагдсан байдлыг судлахад сурагч төвтэй суралцахуйг дэмждэг сургалтын аргуудын нэг хэлбэр болох нь харагдлаа.

“Хэрвээ сурагчид нь ямар ч зүйл асуухгүй зөвхөн сонсоод л байвал тоть шувууг сургаж байгаатай ялгаагүй” (Е-сод боловсрол Льюс Шайло 18 тал) гэж Еврейчүүд хүүхдүүдээ сургадаг.

“Талмуд” хэмээх Еврейчүүдийн түүх гүн ухаан, ёс зүйн сударт “Асуулт асуух явцад хувь хүний бие даасан сэтгэлгээ, бүтээлч оюун санааны тогтолцоо бүрэлдэн хөгждөг” гэж бичсэн байдаг.

Хүүхдээ Израйль улсад боловсрол эзэмшүүлсэн Конгүг их сургуулийн багш Рю Тэ Ён “Еврей хүмүүсийн хэл ярианы боловсрол, арга барил бусдаас өөр” нь “Хаврута” аргын үр дүн гэжээ.

Онолын хэсэг

Багшийн хөгжил нь багш мэдлэг арга зүй ур чадвараа дээшлүүлэх, тасралтгүй хөгжих үйл явц юм. (Багшийн хөгжлийг дэмжих хууль 3.2.1)

Багшлах ажилд дадах тасралтгүй суралцах, хөгжих үе шатыг Германы эрдэмтэн Сандер дараах байдлаар ангилсан байна. (Ч.Пүрэвдорж Багшлахуйн менежмент хуудас 405 “ Багшлах ажилд дадах тасралтгүй хөгжил загвар”) Үүнд:

- 1-3 жил ажиллаж байгаа багшийн хувьд: Орчиндоо дасан зохицох
- 4-6 жил ажиллаж байгаа багшийн хувьд: Байр сууриа олох
- 7-18 жил ажиллаж байгаа багшийн хувьд: Эргэцүүлэх, идэвхжих, турших
- 19-30 жилийн хувьд: Хуучнаа хадгалж үлдэх
- 31-40 жилийн хувьд: Хэт чөлөөтэй болох

Багшлах ажилд дадах, тасралтгүй суралцах үе шатаас харахад:

- 70% -ийг Эргэцүүлэх, идэвхжих, турших Ү үеийнхэн (1977-1997 он)
- 30%-ийг Хуучнаа хадгалж үлдэх Х үеийнхэн (1965-1976) эзэлж байна.

“Үе хоорондын ялгаа багшийн ажилд” удирдлагын академийн захирал Д.Сүрэнчимэгийн лекцэндээ: сургуулийн удирдах албан тушаалтнууд (захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, ЗАН ахлагч) дийлэнх нь Х үеийнхэн бөгөөд үе хоорондын шилжилтийн нөлөөлөл байдаг хэмээн дурдсан байна. Энэ нь залуу багш нар удирдах албан тушаалтан, ахмад үеийн багш нараас эзэмшсэн мэдлэг чадвар, арга барилыг нь сурч хөгждөг гэсэн үг юм.

Багш арга зүйн талаасаа хөгжихөд сурагч төвтэй сургалтыг хэрэгжүүлэх нь чухал юм. Сурагч төвтэй сургалтаар:

- Бие дааж бүтээлчээр сэтгэх,
- Бүтээлчээр сэтгэн, өөрт хэрэгтэй мэдлэг, чадварыг мэдээллийн эх үүсвэрээс эрж хайх,
- Нээлттэй, ардчилсан байх, өөрийн хэрэгцээг илэрхийлэх,
- Судлах хичээлийнхээ хөтөлбөрийг өөрөө сонгох,
- Сурах үйл ажиллагаа нь бие даасан байх зэрэг олон бололцоог нээж өгөхөд багшийн хамтын үйл ажиллагаа чухал.

Еврей сурган хүмүүжүүлэгч, багш судлаач, зохиолч, доктор Орит Кентийн тодорхойлсноор “Хаврута” аргын үндсэн гурван шат нь:

- Сонсох, ярих
- Бодох, анхаарлаа төвлөрүүлэх
- Дэмжих, нэгнээ сорих

Хаврута сургалтын давуу тал нь:

- Дүн шинжилгээ хийх, учир шалтгааныг олох
- Суралцах чадвар илүү өндөр
- Хамтрагчдаа учир шалтгаанаа тайлбарлах, сонсох, мэтгэлцэх
- Хамтрагчийнхаа санаа бодлыг асууж, хурцалж цоо шинэ ойлголттой болгодог.

Хамрах хүрээ

- Багшийн хөгжилд шаардлагатай дэмжлэг, хэрэгцээ, шаардлагыг илрүүлэх судалгаа-52 дугаар сургуулийн 131 багшаас асуулгын аргаар
- Сургуулийн өөрийн үнэлгээний дүгнэлтээс тулгамдсан асуудлыг илрүүлэх судалгааг WMS аргачлалд тулгуурлан 144 багшаас асуулгын аргаар
- “Хаврута” аргыг 1867 сурагчид 136 багш хэрэгжүүлсэн үр дүн, үйл ажиллагааны ажиглалт

Туршилтын хугацаа

- 2020-2021 оны хичээлийн жилд “Хаврута” аргыг турших
- 2021-2022 оны хичээлийн жилд засан сайжруулах

Туршилтын зорилго

Цахим ба танхимын сургалтын явцад суралцагч бие биенээсээ асуулт асуух, багшаас асуулт асуух, багш сурагчаас асуулт асуух чадвар, харилцан ярилцах чадвар сул байгаа нь сургалтын менежерүүд, багш нарын ярилцлага, ээлжит хичээлийн төлөвлөлтөөс ажиглагдсан. Иймээс багш арга зүйн тал дээр сурагчийн асууж буй асуултыг задлан шинжлэх, бүтээлч үйл ажиллагаанд хөтлөхөд “Хаврута” арга хэрэглэснээр гарч буй үр дүнг харьцуулан дүгнэхэд чиглэсэн.

Туршин хэрэгжүүлсэн байдал :

“Хаврута” аргыг турших үйл ажиллагааг PDCA мөчлөгт тулгуурлан хэрэгжүүлсэн. Үүнд:

Төлөвлөх (Plan)

1. Сургуулийн өөрийн үнэлгээг WML аргачлалд тулгуурлан тулгамдаж буй асуудлаа илрүүлэх
2. Багшийн хөгжилд нөлөөлөх хүчин зүйлийг судалгаагаар илрүүлэх
3. “Хаврута” аргын талаарх сургалтыг багш нарт танилцуулах
4. “Хаврута” аргыг нэвтрүүлэх үйл ажиллагааны төлөвлөлтийн схем гаргаж, хугацааг товлон (Асуух өдөр-Пүрэв гариг, Хаврута судалгааны эсээг багш бүр бичих, Хаврута МЧС)
5. “Хаврута МЧС” (мэдлэг чадварын сорил) зохион байгуулалт, арга аргачлал, дүгнэх үзүүлэлт, үр дүнгийн хэлэлцүүлэг хийх хугацааг багш нар, заах аргын нэгдэл, секцийн ахлагч нарын хэлэлцүүлгээр хэлэлцэн батлах
6. Багш нарын багийг ахмад, дунд, залуу үеийн мэргэжлийн холимог баг үүсгэж зөвлөх багш, багийн ахлагчийг томилон үүрэгжүүлэх
7. Удирдлага, багш нар “Хаврута”-д хамрагдах суралцагч, эцэг эх асран хамгаалагчдад мэдээлэл өгч хамтран ажиллах
8. Үр дүнг тооцож хэлэлцэн сайжруулах

Хэрэгжүүлэх шат (Do)

Сургуулийн өөрийн үнэлгээг WML аргачлалд тулгуурлан зохион байгуулж тулгамдаж буй асуудлаа илрүүлсэн.

Судалгааны хэсэг

Сургуулийн менежментийн оношилгоо

Сургуулийн өөрийн үнэлгээнд шинжилгээ хийсэн нь:

Хүснэгт 1. Сургуулийн өөрийн үнэлгээнд хамрагдсан байдал

	Судалгаанд хамрагдсан	Хамрагдсан тоо	Эрэгтэй	Эмэгтэй
1	Захирал	1		1
2	Сургалтын менежер	4		4
3	Нийгмийн ажилтан	3	1	2
4	Багш	136	23	113
	Нийт	144	24	120

Улсад ажилласан жилийн дундаж 14.6, тус сургуульд ажилласан жилийн дундаж 7.7 байна.

“Төрийн өмчийн ЕБС-иудын менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх нь” төсөлд хамрагдаж сургуулийн менежмент ямар түвшинд байгааг *оношлох*, цаашид менежментийн аль чиглэлд, юуг анхаарах шаардлагатайг тодорхойлох зорилгоор сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтнууд, багш нараар өөрийн үнэлгээг хийлгэлээ.


Уг оношлох үнэлгээг хөгжиж буй орны сургуулийн менежментийг үнэлэхэд зориулан сайжруулж боловсруулсан WMS аргачлалыг ашиглан хийв.

Судалгааны асуулга нь менежментийн дараах 6 үндсэн чиглэлийг үнэлэх, байнга хэвшүүлсэн байвал зохих 36 үйл ажиллагааг 1-5 оноогоор үнэлэх шаталсан хариулт бүхий боломжит асуултуудаас бүрдсэн болно.

1. Алсын хараа, эрхэм зорилгоо тодорхойлдог байдал
2. Зорилго, зорилтоо тодорхойлдог байдал
3. Сургалтын хөтөлбөр, хэрэгжилт, сайжруулалтын менежмент
4. Гүйцэтгэлийн менежмент
5. Хүний нөөцийн менежмент
6. Сайн туршлагыг нэвтрүүлэх менежмент

Чиглэл тус бүрийн дундаж оноо болон нийт 6 чиглэлээр өгсөн үнэлгээний голч, дундаж үнэлгээ, хувийг зургаар харуулбал:

Зураг 1. Менежментийн 6 чиглэлийн үр дүн



Зургаас үзэхэд хамгийн өндөр оноотой үзүүлэлт нь 5 дугаар чиглэл (Хүний нөөцийн менежмент)-ийн “Багшийн орон тоог албан ёсоор хэн шийддэг вэ?” асуултад 4.21 буюу 4 дүгээр түвшний хариулт болж байна.

Хамгийн бага оноотой үзүүлэлт нь 6 дугаар чиглэл буюу (Сайн туршлагыг нэвтрүүлэх менежмент)-ийн “Шинэ арга туршлагыг хэрэгжүүлж буй үйл явц үр, дүнг хэрхэн нягталж, баталгаажуулдаг вэ?” асуултад 2.6 буюу 2 дугаар түвшний хариулт байна. Бусад үзүүлэлтээр сургуулийн менежмент 2, 3 дугаар түвшинд байна гэж

үнэлсэн байна. Одоогийн байдлаар 5 дугаар түвшинд гэж үнэлэгдсэн үзүүлэлт хараахан алга байна.

Дүгнэлт

Судалгаанд оролцсон багш нарын улсад болон тухайн байгууллагад ажилласан жилийн дундаж 7.7 байгаа нь сургуулийнхаа менежментийг бодитой үнэлэх хэмжээний туршлага баримжаатай болсон гэж үзэх боломжтой юм.

Сургуулийн менежментийн үндсэн 6 чиглэлийн үнэлгээний дунджийг харахад бүх чиглэлд 2, 3 дугаар түвшинд үйл ажиллагаа хэвшиж, тогтмолжоогүй, албан бус шинжтэй байгааг илтгэнэ.

Багшийн хөгжилд шаардлагатай дэмжлэг, хэрэгцээ, шаардлагыг илрүүлэх судалгаа түүний үр дүн

Судалгаанд 131 багш хамрагдав. Багшийн хөгжилд дараах хүчин зүйлс чухал нөлөөтэй хэмээн судалгаанд оролцогчид үзжээ. Судалгааны асуулга нь дараах 6 асуултаас бүрдсэн. Үүнд:

- Удирдлагын манлайлал, чиглүүлэг чухал эсэх- 64.1% (84 багш)
- Хамт олны уур амьсгал чухал эсэх – 44.3 % (58 багш)
- Багшийн өөрийн итгэл үнэмшил, ёс зүй, харилцаа хандлага, санал санаачилга- 81% (106)
- Ахмад багш нарын мэдлэг туршлага, заавар, зөвлөгөө – 35.9% (47 багш)
- Мэргэжил дээшлүүлэх сургалт- 35% (36 багш)
- Сургуулийн материаллаг орчин, ажиллах нөхцөл боломжоор хангасан байдал- 32.8% (43 багш)

Хүснэгт 2: Багшийн хөгжилд шаардлагатай дэмжлэг, хэрэгцээг илрүүлэх


Асуулт	чухал нөлөөтэй		заримдаа		ямар ч нөлөөлөлгүй	
	эзлэх хувь	б/тоо	эзлэх хувь	б/тоо	эзлэх хувь	б/тоо
Удирдлагын манлайлал, чиглүүлэг чухал эсэх	64.1%	84	35.9%	47	0	0
Хамт олны уур амьсгал чухал эсэх	44.3%	58	55.7%	73	0	0
Багшийн өөрийн итгэл үнэмшил, ёс зүй, харилцаа хандлага, санал санаачилга	81.0%	106	19%	25	0	0
Ахмад багш нарын мэдлэг туршлага, зөвлөгөө	35.9%	47	64.1%	84	0	0
Мэргэжил дээшлүүлэх сургалт	35.0%	36	65%	95	0	0
Сургуулийн материаллаг орчин, ажиллах нөхцөл боломжоор хангасан байдал	32.8%	43	67.2%	88	0	0

Дээрх судалгаанаас дүгнэхэд: Багшийн хөгжилд удирдлагын нөлөө, чиглүүлэг, багшийн өөрийнх нь идэвх санаачилга чухал болох нь харагдаж байна.

“Хаврута” аргыг туршин хэрэгжүүлсэн байдал

“Асуух өдөр” үйл ажиллагааг Пүрэв гараг бүр 2 сарын хугацаатай зохион байгуулж, багш суралцагчдын асуултад хариулж, асуултын хэлбэрт дүгнэлт хийсэн.

Асуух өдөр үйл ажиллагааны дүгнэлт үр дүн



“Хаврута” судалгааны эсээ түүний үр дүн

Асуух өдрийн үйл ажиллагааны үр дүнг илэрхийлэх “Хаврута” судалгааны эсээ 136 багш бичиж хэлэлцүүлэг зохион байгуулсан.

- Багш нарын асуултын шинжилгээ хийх суурь мэдээлэл – 85.2% боловсруулсан, асуудал,
- Асуух өдөр үйл ажиллагааны талаар асуудал дэвшүүлсэн 61.7%, баримт нотолгоо гаргасан 38.3% эсээг бичсэн.
- Багш нарын санал асуулгаас аливаа зүйлийг олон талаас нь харж чадсан, эрэл хайгуул хийсэн, бусад багш нарын бичсэнээс өөрийн олж хараагүй өнцгийг харж, санаа авч үйл ажиллагаандаа шингээж ажилласан бусдын саналд үнэлэлт, дүгнэлт хийх, аливаа асуудлыг шинжлэх ухаан болоод өөрийн үзэл бодлоор харьцуулж сурсан, бичихийн тулд судалгаа хийж, ном уншсан, өөрийн хийж буй зүйлээ дүгнэсэн, эргэцүүлсэн гэсэн нээлттэй хариултыг өгсөн.
- Нийт багш нарын 95.5% нь Асуух өдөр-“Хаврута” үйл ажиллагааг үр дүнтэй гэж үзсэн.
- Аливаа үйлийг олон талаас харж, санал дүгнэлт өгсөн, эрэл хайгуул хийсэн, нэг хэвийн арга барилаар хичээл заахаа больсон, хүүхдийн асууж буй асуултыг ажиглах, хариулт өгөхийн тулд судалж байгаа нь сурагчдад шинжлэн судлах арга барилыг эзэмшүүлэхийн зэрэгцээ хүүхдийг бие даан, бүтээлчээр сэтгэхэд эерэг нөлөө үзүүлж байна.

“Хаврута-МЧС шалгалтын үр дүн

“Хаврута – МЧС” –ыг зохион байгуулан ахмад, дунд, залуу үеийн багш нарын баг асуулт, хариултын шинжилгээг судлагдахуун тус бүрээр хийн үр дүнгийн хэлэлцүүлэг зохион байгуулсан.

- Дунд ахлах ангийн 1867 суралцагч
- Багш нарын 8 баг нийт 87 багш
- 1 багийн багш нарын хувьд 1-10 жил ажилласан 47%
- 11-ээс дээш жил ажилласан багш 53%

- Зэрэгтэй багш 56% тус тус эзэлж байна.

Багш нарын багийн хэлэлцүүлгээс дүгнэхэд: Хэлэлцүүлэгт

- Багийн ахлагч 1-2 жил ажилласан залуу, багийн зөвлөх багш, тэргүүлэх зэрэгтэй 15-аас дээш жил ажилласан багш томилсон нь багийн бүх гишүүдэд асуултыг задлан шинжлэхэд туслах, харилцан мэтгэлцэхэд чиглүүлэх үүрэг гүйцэтгэж байгаа нь үр дүнтэй байлаа.
- Залуу багш нар (1-10 жил) олон жил ажилласан, мэргэжлийн зэрэгтэй багш нараас Блум таксономын түвшнээр асуулт, хариултыг ангилах, дүгнэх, үйл ажиллагааг дүгнэж суралцсан.
- Ахмад багш нарын хувьд залуу багш нараас үйл ажиллагааны үр дүнг нэгтгэх, илтгэхдээ техник, программ дээр ажиллахад суралцсан.
- Хамрагдсан багш нарын дунд явуулсан асуулга судалгааны үр дүнд:
- Багш багшаасаа суралцсан - 92%
- Хамтран ажилласан - 95.4%
- Багийн үйл ажиллагаанд үүрэгтэй оролцож сурсан – 98.2% дүгнэсэн.

Үр дүнг тооцох шат (*Check*)

Цахим ба танхимын сургалтын үед багшийн бэлтгэсэн ээлжит хичээлийн төлөвлөлтөд багш суралцагчдаас асуух асуулт бага тусгагдсан бөгөөд багш төвтэй сургалт зонхилсон, суралцагчаас асууж буй асуулт ихэвчлэн хаалттай асуулт байгааг хичээл ажиглалтаас болон ХУД-ийн сургалтын менежерүүдийн ганцаарчилсан ярилцлагаас дүгнэсэн.

2020-2021 оны хичээлийн жилд “Хаврута” арга хэрэгжүүлснээр багш удирдлагын баг хамтран:

1. Зохион байгуулалтын схем
2. Бүлэг тус бүрийн судлах сэдэв
3. Сорил төлөвлөлтийн загвар
4. Сурагч төвтэй сургалтын арга “Хаврута арга”
5. Асуулт, хариултыг дүгнэх загварыг тус тус боловсруулсан.
6. Асуултыг эрэмбэлэн ялгаж дүгнэхэд /Блумээр/- 67 багш /68.4% суралцсан.

Давуу тал нь:

- Эцэг эхийн оролцоо, хамтын үйл ажиллагаа- 82,6%
- АУБ-ийн үүрэг оролцоо-100%
- Мэргэжлийн багшийн үүрэг оролцоо-94%
- Суралцагч - Багийн оролцоо-100%

“Үр дүнгүй” гэж үзсэн хариулт 4 байгаа нь орос хэлний хичээлийн хувьд үр дүнгүй байсан (хүүхдүүдийн хэлний түвшингээс шалтгаалаад хөрвүүлж ярих, асуух чадвар сул байсан).

Хаврута арга нь асуудал шийдвэрлэх арга, төсөлд суурилсан сургалтын аргын хосолсон хэлбэр болж харагдаж байна. Хаврута арга нь:

1. Төлөвлөх (тодорхой сэдэв)
2. Асуулт болон боломжит шийдлүүдийг шинжлэх ухааны үндэслэлтэй илэрхийлэх

3. Хянах, зөвлөх
4. Хуваарилах
5. Үнэлэх
6. Дүгнэх гэсэн алхам дарааллаар хэрэгжинэ.

Багш нар асуултыг хэрхэн шинжилж байгааг судалсан судалгаа түүний үр дүн

2021-2022 оны хичээлийн жилд багш нарын асуултыг хэрхэн шинжилж байгааг 117 багшийг хамруулан судлахад мэргэжлийн зэрэггүй залуу багш нарын хувьд:

- Задлан шинжлэх түвшний асуулт 79.3%
- Үнэлэх түвшний асуулт 58.6% нь
- Хэрэглэх түвшний асуулт 41,4%
- Ойлгох түвшний асуулт 37.9% нь
- Сэргээн санах түвшний асуулт 34,5% нь зэрэгтэй багш нараас илүү ялгаж дүгнэсэн байна.

Судалгааны үр дүнгээс харахад багшийн хамтын үйл ажиллагаа бүхий шинэ шинэлэг “Хаврута” арга нь багшийн арга зүйн хөгжилд нөлөөлөхүйц үйл ажиллагаа болсон нь тодорхой байна.

Түвшин	Зөв хариулсан багшийн тоо	Хувь	Зөв хариулсан багшийн тоо	Хувь	Зөв хариулсан багшийн тоо	Хувь
	Зөвлөх	Тэргүүлэх 31 багш	Заах аргач 31 багш		Зэрэггүй, залуу 54 багш	
Сэргээн санах	5	20.6 %	4	13.8%	10	34.5%
Ойлгох	4	13.8%	4	13.8%	11	37.9%
Хэрэглэх	4	13.8%	6	20.7%	12	41.4%
Задлан шинжлэх	15	51.7%	9	31.1%	23	79.3%
Үнэлэх	12	41.4%	15	51.7%	17	58.6%
Бүтээх	12	41.4%	5	17.2%	6	20.7%

Сайжруулах шат (Action)

- “Хаврута” МЧС-ын сэдвийг судлагдахуун бүрийн агуулгын интеграцийг харгалзан тодорхойлох.
- Багш бүр судлагдахууны тус бүрийн агуулгыг судлан хэлэлцүүлэгт бэлтгэн оролцох
- Бага боловсролын багш, сурагчдыг хамруулах, нас сэтгэхүйн онцлогт тохирсон арга аргачлалыг боловсруулахад анхаарна.

Түгээн дэлгэрүүлсэн байдал:

- Ховд аймгийн БСУГ-ын дарга болон ерөнхий боловсролын 13 сумын 15 багшид
- СХД-ийн “Хөгжил” цогцолбор сургуулийн бага боловсролын 65 багшид
- Нийслэлийн гадаад хэлний багш нарын “Зөвлөлдөх” багийн 64 багшид

Ерөнхий дүгнэлт

1. Судалгааны үр дүнгээс харахад сургуулийн өөрийн үнэлгээгээр “Шинэ арга туршлагыг хэрэгжүүлж буй үйл явц үр, дүнг хэрхэн нягталж, баталгаажуулдаг вэ?” гэсэн асуултад буюу 2 дугаар түвшний хариулт, харин сургуулийн менежментийн үндсэн 6 чиглэлийн үнэлгээний дундажийг харахад бүх чиглэлд 2, 3 дугаар түвшинд буюу тухайн чиглэлд үйл ажиллагаа хэвшиж, тогтмолжоогүй байгааг

илтгэж байсан. Тиймээс тулгамдаж буй асуудлын нэг болох суралцагчдын асуулт асуух, асуултад хариулах чадварыг удирдлагын уян хатан бодлого, багшийн манлайлал, эрх мэдлийн төвлөрлийг сааруулах, шилжүүлэх замаар менежментийн шинэлэг аргачлалыг туршин шийдвэрлэсэн. Уг туршилтын үр дүнгээс харахад:

- Багш удирдлагын хамтын үйл ажиллагаа
- Удирдлага гэдэг албан тушаал талаас эрх мэдлээ өөртөө төвлөрүүлэх биш түүнийг шилжүүлэн, асуудлыг хамтдаа шийддэг гарц, шийдлийг олж хардаг болсон.
- Шинэ, шинэлэг санаагаар хэвшмэл байдал болон нэр томьёо, аргыг баяжуулах, хэрэгжүүлэх, үр дүнг тооцох нь багшийн хөгжих бас нэгэн гарц гэдгийг илрүүлсэн.

Дээрх үр дүнгээс залуу болон ахмад багш нарын хамтын үйл ажиллагааг нэмэгдүүлэх, түүгээр дамжуулан арга зүйн талаас хөгжих боломжийг дэмжих, шинэлэг Хаврута үйл ажиллагааг зохион байгуулсан.

2. Хаврута үйл ажиллагааг шат дараалалтай зохион байгуулахад дараах үр дүнгүүд гарсан.Үүнд:

- Эерэг харилцаа хамаарал: Багийн гишүүн бүр нэгдсэн зорилгыг биелүүлэхийн төлөө бие биетэйгээ холбоо хамааралтай болохоо мэдэрсэн.
- Хувийн үүрэг хариуцлага: Зорилгоо биелүүлэхийн тулд гишүүн бүр үүргээ ойлгосон.
- Нүүр тулсан харилцаа: Цаашдын тасралтгүй хөгжлийг хангах ярилцлага, хэлэлцүүлэг хийсэн.
- Нийгмийн харилцааны чадвар: Эерэг, бүтээлч, нөхцөл байдалд дасан зохицох чадварт суралцсан.
- Боловсруулалт: Хамтын ажиллагаанд үнэлгээ дүгнэлт өгөх, үр дүнг тооцох, улам боловсронгуй болгох зэргээр удирдлагын зүгээс гүйцэтгэлийн менежментийг хэрэгжүүлсэн.
- Багш нар арга зүйн тал дээр хамтран ажиллах, асуулт төлөвлөх, асуултыг шинжлэх үйлд суралцагчийг хөтлөх үйлд суралцсан.

Төсөлд суурилсан арга, Асуудал шийдвэрлэх арга, Хаврута аргад суурилсан хичээлийг төлөвлөн заах алхам нь үр дүнтэй болох нь туршилт судалгаанаас харагдаж байна.

Цаашид тогтвортой байдлыг хангах талд гүйцэтгэлийн тогтмол менежментийг хэрэгжүүлж, хамтын үйл ажиллагаагаар багшийг дэмжин хөгжүүлэх боломжтой юм. Энэ талаарх нэр томьёо, нэршлийг нэг шийдэлд хүргэн тодорхойлох боломжгүй байгаа тул дараах байдлаар тодорхойлж байна.

Санал

- Багш, удирдлага хамтын үйл ажиллагааг тогтмолжуулах
- Сургуулийн өөрийн үнэлгээг жил тутамд хийж хэвших
- Гүйцэтгэлийн тогтмол менежментийг удирдлагын зүгээс баримтлах
- Эрх мэдлээ шилжүүлэн асуудлыг хамтаар шийдүүлэх
- Нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн шинэлэг үйл ажиллагааг зохион байгуулах
- Үйл ажиллагаа бүрийн хэрэгжүүлэх арга аргачлалыг багш нартай хамтран боловсруулах
- Хэлэлцүүлэг, асуумж судалгаагаар сайжруулалт хийх

- Үйл ажиллагаа болгон уялдаа холбоотой байх
- Бодлого боловсруулах түвшинд СӨБ болон гэр бүлийн хүрээнд хүүхэдтэйгээ ярилцаж “Хаврута” аргыг хэрэгжүүлэх
- Хамтран суралцахуйн үндсэн 5 элементэд тулгуурлан шинэлэг үйл ажиллагааг гүйцэтгэлийн тогтмол менежментэд суурилан хэрэгжүүлснээр багш тасралтгүй хөгжих нэг боломж юм.

Номзүй

- Пүрэвдорж, Ч. (2013). “Багшлахуйн менежмент” хоёр дахь хэвлэл. Улаанбаатар
- Гэрэлмаа, А. (2013). “Хамтран суралцахуй” харилцан идэвхтэй сургалтын гарын авлага. Улаанбаатар
- БМДИ. (2021). “ЕБС-ийн сурагчдын хичээл, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах төлөвлөгөөг хэрэгжүүлэх сургалт, үйл ажиллагааны удирдамж. Улаанбаатар
- Өнөржаргал, Ц. (2016). “Удирдахуйн ухаан”. Улаанбаатар
- (2021). ЕБС-ийн сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө А/190 тушаал. Улаанбаатар
- Жамц, Л. “Ерөнхий сэтгэл судлал”. Дөрөв дэх хэвлэл. Улаанбаатар
- Батболд, Д. (2017). “Багшлахад учир бий”. Улаанбаатар
- Оюун, Ц., Түмэндэмбэрэл, Д. (2005). “Багшийн хөгжил”. Улаанбаатар
- Смарт Грийн Партнерс., (2017). “Еврей хүмүүсийн боловсрол болон амжилтын нууц”. Улаанбаатар
- Льюс Шайло. (2012). “Е-сод боловсрол”. Улаанбаатар
- Галбадрах, Б. (2019). “Боловсролын байгууллагын хөгжил”. Улаанбаатар
- Бүжинлхам, Д. (2019). “Цойлогсод”. Улаанбаатар
- БМДИ. (2018). “Үндсэн сургалтын гарын авлага”. Улаанбаатар
- “Бага, дунд боловсролын тухай хууль”
- “Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль”
- (2021). ЕБС-ийн сурагчдын хичээл, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах төлөвлөгөөг хэрэгжүүлэх сургалтын үйл ажиллагааны удирдамж. Улаанбаатар
- Боловсролын хүрээлэн. (2021). Цэцэрлэг, ЕБС-ийн багш, удирдах ажилтны эрдэм шинжлгээний хурал. Улаанбаатар
- Боловсролын хүрээлэн. (2019). *Эрдэм шинжилгээний бичиг*. Дугаар 24. Улаанбаатар
- БШУЯ, БХ. (2018). “Боловсролын хөгжил”. Улаанбаатар
- МБСХ. (2020). Боловсрол судлал. Улаанбаатар
- МБСХ. (2018). Боловсрол судлал. Улаанбаатар
- Сүрэнчимэг, Д. (2022). “Үе хоорондын ялгаа багшийн ажилд” лекц. Улаанбаатар

ЗАЛУУ БАГШ НАРЫН ХАРИЛЦАА ХАНДЛАГАД ЭЭРЭГ НӨЛӨӨ ҮЗҮҮЛЭХЭД АХМАД БАГШ НАРЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ

Б.Оюунбилэг¹, Ц.Сүрэнхорлоо², Б.Цэрэндолгор³, Ц.Нямзаяа⁴

Ховд аймгийн Жаргалант сумын ерөнхий боловсролын

2 дугаар сургууль

Buyanulziiyounbileg@gmail.com¹, Surenhorloo25@gmail.com²,

tseegii8746@gmail.com³, tsnyamzaya7@gmail.com⁴,

Хураангуй

Энэхүү илтгэлд сургалтын байгууллагын үйл ажиллагааг хэрэгжүүлэгч, суралцагчдад мэдлэг, ур чадвар эзэмшүүлэн зөв харилцаа хандлага төлөвшүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэгч гол субъект болсон багш нарын харилцаа хандлагын асуудлыг судлан өөрийн сургуулийн залуу багш нарын үйл ажиллагаанд илэрдэг зарим анхаарвал зохих асуудлыг хөндөн тавьж шийдвэрлэх арга замыг эрэлхийлэн бодит ажлуудыг ахмад багш нартай хамтран туршиж үр дүнг боловсруулсан туршлагаа түгээн дэлгэрүүлэх талаар судлан өгүүлсэн болно.

Түлхүүр үг: багш; харилцаа хандлага; эерэг нөлөөлөл; ахмад багш; шүүлтүүргүй мэдээлэл; зүрх сэтгэлийн боловсрол; амьд харилцаа; үлгэр дуурайлал.

Оршил

Монголчууд эрт дээр цагаас бичиг, номтой, эрдэм, мэдлэгтэй хүнийг “Номын багш” хэмээн хүндэтгэдэг эртний сайхан уламжлалтай. Номын багшаа “Гучин цагаан үсэг заасан ачтан” хэмээн дээдэлсээр иржээ. Өөрөөр хэлбэл, “Багш бол өсвөр залуу үеийнхэнд ажил амьдралдаа хэрэгтэй мэдлэг чадвар туршлага олж авахад нь туслах, тэдний иргэн-бие хүн болж төлөвших, нийгэмших процессийг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах мэдлэг ур чадвар бүхий бие хүн. Шавь хүний ямар нэг эрхэм чанарыг эзэмших, алдаа дутагдлаас салахаас эхлээд аливаа сайн сайханд хүрэх нь гагцхүү гэгээрлийн багшаас хамаардаг. Боловсролын салбарын тулах багана нь ур чадвартай боловсон хүчин юм.

Сэдэв сонгосон үндэслэл

Мэдээлэл технологийн болон даяарчлалын эрин зуунд шилжин орж байгаа өнөө үед дэлхийн түвшний боловсрол эзэмшсэн иргэнийг бэлтгэхэд багш хүний үүрэг, хариуцлага их юм. Суралцагч бүрийг өөртөө итгэлтэй, эрсдэлгүй сурч, амьдрах, бүтээлч иргэн болгон төлөвшүүлэх үндсэн үйл ажиллагаа нь багш биднээс шалтгаалдаг. Цахим орчноос сурагчид маань мэдээллийг ямар ч шүүлтүүргүйгээр хүлээн авч байгаа бөгөөд нэн ялангуяа цар тахлын өнөө үед дэлгэцийн хамаарал “донтолт”-ын түвшинд хүрч гэр бүл найз нөхдийн хүрээнд дэх амьд харилцааны орон

зай үгүйлэгдэж байгаа тул хүүхэд багачуудад зүрх сэтгэлийн боловсрол олгох хамгийн чухал үүргийг багш бид гүйцэтгэх зайлшгүй шаардлага үүсэж байна. Иймээс хүүхдүүдтэй амьд харилцаа үүсгэхэд багш өөрөө эерэг харилцаа хандлагатай зөв үлгэр дуурайлалтай байх ёстой.

Зорилго: Ахмад багш нарын оролцоотойгоор залуу багш нарын харилцаа хандлагад гарах эерэг үр дүнг нэмэгдүүлэх боломжийг судлан, туршиж, түгээн дэлгэрүүлэх

Зорилт:

- Багш нарын харилцаа хандлагын талаар судлах
- Ахмад багш нарын оролцоотой эерэг хандлагыг нэмэгдүүлэх арга замыг турших
- Үр дүн боловсруулан түгээн дэлгэрүүлэх санал дүгнэлт боловсруулах

Судалгааны шинэлэг тал

Залуу багш нар олон төрлийн сургалтад хамрагддаг ч тэдний харилцаа хандлагад эергээр нөлөөлөх чухал арга замуудын нэг нь зөв үлгэр дуурайлал, зөв чиглүүлж зөвлөн туслах амьд харилцаа байдгийг ахмад үе ба залуу үеийн хамтарсан үйл ажиллагаагаар туршиж үр дүнг харьцуулан судалснаараа шинэлэг юм. Түүнчлэн энэхүү үйл ажиллагаанд гавьяаны амралтад гарсан багш нар, одоо ажиллаж буй ахмад багш нар, багшаас өөр мэргэжлийн ахмад үеийг хамруулж чадсанаараа онцлог байлаа.

Судалгааны арга:

- Тоо баримт цуглуулах арга
- Бичиг баримт судлах арга
- Ажиглалтын арга
- Харьцуулалтын арга
- SWOT шинжилгээний арга
- Хэлэлцүүлгийн арга
- Анализ, синтезийн арга

Онолын хэсэг

Харилцаа гэдэг нь хүмүүс хоорондоо харилцан ойлголцох. Мэдээлэл дамжуулах, хамтран ажиллахаар холбоо тогтоох юм. Харилцаа хандлага хоёр нягт холбоотой бөгөөд харилцааны явцад хандлага бий болдог. Сэтгэл судлаач Карол Двек таны амжилтыг оюун ухаан биш хандлага тодорхойлдог гэдгийг судалж баталжээ. [3.197т]

Сэтгэл судлаач И.И.Чернокозов багшийн ёс зүйн асуудлыг дорвитой судалж, дараах хэм хэмжээнээс бүрддэг гэж үзжээ.

- Хүүхдийг хүндлэн, хүндэтгэх шаардлага хоёрыг хослуулсан.
- Хүүхдийг зөв хайрлах, анхаарал тавих
- Хүүхдийнхээ дотоод ертөнц биеэ авч явах байдлыг үргэлж судалж байх.
- Хүүхдийн боломж үзэл бодол, авьяас билэгт үргэлж анхаарч өөдрөг хандах.
- Биеэ эзэмдэж, тэвчээртэй байх, хүүхдийн алдаа дутагдалд тэвчээртэй байж засаж залруулж байх.
- Хэзээ ч хүүхдийг доромжилж гомдоож болохгүй.
- Хүүхдэд элэгсэг, найрсаг хандах.

- Үнэнч шударга зарчимч байх.
- Ямагт хүүхдэд зөв үлгэр дуурайлал үзүүлэх, биеэ зөв авч явах гэсэн байдаг. Тэгвэл дээрх эдгээр зүйлүүдийг багш хүн төгс эзэмшиж, сурагчдад үлгэр дуурайлал болох ёстой [9.49т]

Багш хүн хүүхдэд сурах хүсэл тэмүүлэл мөрөөдлөө биелүүлэхэд нь тусалдаг урам зориг өгдөг чиглүүлдэг харилцааны менежер байх ёстой. Хүүхэд өөрийгөө үнэлүүлэх магтуулах дүгнүүлэх дуртай. Хүүхдийг хамт олон дотны хүнийх нь дэргэд гомдоох муулах үнэ цэнэгүй болгохгүй байх нөгөө талаар хэт өөрийгөө магтах онгирох бардам зан гаргах зэрэг сэтгэл зүйн процессыг нь мэдэрч баярлах гутрах сэтгэл хөдлөлийг нь анзаарч харилцаан дээр нь анхаарах хэрэгтэй. Иймд: Багш бол сэтгэл зүйн зөвлөгч байх ёстой.

Багш сурагчидтайгаа харилцахдаа баримтлах зарчим:

- Шийдэмгий байх
- Хичээл заахдаа аль болох суухгүй байх
- Сурагчдын эерэг хөдөлгөөн, хандлага, зан араншинг дэмжих
- Сурагчдад ангидаа өөрийн бодол санаагаа зохих төвшинд илэрхийлэх ярих, ярилцах, чөлөөтэй байх боломж олгох
- Ангидаа багш өөрөө үүрэг хариуцлагатай байх
- Сурагчдыг өөр шигээ байлгах гэж оролдохгүй байх
- Сурагчдыг хамт олных нь өмнө шүүмжлэхгүй байх
- Сурагчдад зүрх сэтгэлийн боловсрол хүн байх ухааныг олгох дээрх зарчмуудыг баримтлан ажиллах хэрэгтэй [5.25т]

Судалгаа туршилтын хэсэг

Багш нарын харилцаа, хандлагын өнөөгийн байдлыг Жаргалант сумын ЕБ-ын 2 дугаар сургуулийн жишээн дээр дараах байдлаар судлан туршлаа. Бидний судалгаанд 2 дугаар сургуулийн нийгмийн ухааны 15 багш, байгалийн ухааны 18 багш, бага боловсролын 15 багш нийт 48 багш буюу багш нарын 73.8 хувь, ахмад багш нарын төлөөлөл 26 багш, 9-12 дугаар ангийн 45 сурагч хамрагдсан.

Асуулгын арга

1. Сурагчдаас авсан судалгаа

“Та багш нарыг ямар байгаасай гэж хүсдэг вэ?” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 88.9 хувь нь бидний зүрх сэтгэлийг ойлгодог байгаасай, 25.4 хувь нь ялгаварладаггүй байх, 77.6 хувь нь биднийг сайн сонсдог, 42.5 хувь нь илэн далангүй ярилцдаг, 65.5 хувь нь цаг баримталдаг, 80.8 хувь нь найз шиг дотно харилцаатай, 78.9 хувь нь урам өгч дэмждэг 35.5 хувь нь нээлттэй байх, 28.5 хувь нь үлгэр дуурайлалтай байгаасай гэж хариулсан байна.

Судалгаанаас харахад нийт сурагчид маань багш нараасаа эерэг харилцаа хандлагыг хүсдэг болох нь харагдаж байна.

2.Залуу багш нараас авсан судалгаа

“Багшийн ажлыг хийхэд танд ямар бэрхшээл тулгардаг вэ?” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 12.5% нь эцэг эхчүүд болон зарим сурагчид биднийг багш гэж тоодоггүй, 40% аливаа ажлыг бие даан зохион байгуулахад туршлага дутдаг, 56% заах арга зүйн дэмжлэг, 34% баримт бичиг боловсруулах тал дээр учир дутагдалтай байдаг, 78% хүүхэдтэй ажиллах эв дүйгээ олдоггүй, 56% зарим үед төлөвлөсөн ажлаа хугацаанд нь амжуулж чаддаггүй, 8% ахмад багш нарын дарамт гэж хариулсан байна.

Дээрх судалгаанаас дүгнэхэд залуу багш нарын хувьд мэргэжил арга зүйн дэмжлэг туслалцаанаас гадна харилцаа хандлагын эерэг нөлөөлөл, эерэг үлгэр дуурайлалд суралцах асуудал чухал болох нь харагдаж байна.

3.Ахмад багш нараас авсан судалгаа

“Та залуу багш нарыг харилцаа хандлагын ямар тал дээрээ анхаараасай гэж боддог вэ?” гэсэн асуултад ажлын хурд ажлын гүйцэтгэл, багаар ажиллах чадвар, цагийн зохион байгуулалт, бичиг хэргийн эмх цэгц хөтлөлт, зөв бичгийн дүрмийн алдаа, хүндэтгэх хүндлэх ёс, багшийн үлгэр дуурайлал, хувийн зохион байгуулалт ба сахилга бат гэх мэт асуудлыг онцолсон байна.

Зураг 1. Ахмад багш нарын хариулт



Сурагчид, залуу багш нар, ахмад багш нараас авсан судалгаануудаас үзэхэд асуулга бүрийн өндөр үзүүлэлт нь багшийн харилцаа хандлагатай холбоотой асуудлуудад огтлолцож байсан. Иймээс залуу багш нарыг мэргэжил арга зүйн тал дээрээ анхаарахаас гадна харилцаа хандлагын тал дээр илүү анхаарахыг чухалчилсан байна.

Хэлэлцүүлгийн арга

Дээрх судалгаанаас үндэслэн ахмад багш нар залуу багш нарын харилцаа хандлагад эергээр нөлөөлж чадах болов уу гэсэн асуудал дэвшүүлэн

нээлттэй хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Эергээр нөлөөлнө.

Нотолгоо 2017 онд “Олон нийтийн оролцоот сургууль” үйл ажиллагааны хүрээнд ахмад багш нарын “Эрдмийн оргил” холбооны идэвхжсэн 15 багштай түншлэлийн гэрээ байгуулан урьж ажиллуулсан.

Ажлын чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт гаргах зорилгоор судалгаа авсан бөгөөд манай сургууль дээр баг болон ажиллах Ховд аймгийн нэрийн хуудас болсон ахмад багш нарын багаас та бүхэнд чиглэсэн ямар ямар үйл ажиллагааг зохион байгуулаасай хэмээн хүсэж байна вэ? гэсэн асуултад багш нарын дийлэнх хувь нь арга зүй, хүүхдийн хүмүүжил төлөвшил, анги удирдах эв дүй, сургалтын хоцрогдлыг арилгах арга зам, эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх тал дээр хэрхэн анхаарах талаар сургалт заавар зөвлөгөө авахыг хүссэн байсан.

Багш нарын санал хүсэлтийг үндэслэн үйл ажиллагааны төлөвлөлт гарган 2017-2021 оны хооронд 10 төрлийн 26 ажлыг хамтран зохион байгуулсан. Жишээлбэл:

- “Мөрөөдлөө биелүүлэх арга зам”
“Аравтын бутархайг хэрхэн заах нь”
“Бага ангид математикийн хичээлд хялбар аргуудыг хэрэглэх нь”
“Процентын тухай” сэдвүүдээр ахмад багш нар сайн хичээл заав (цаг төлөвлөлт, багшийн үлгэрлэл).
- Ахмад болон залуу багш нар хамтран Охид, хөвгүүдийн чуулганыг амжилттай зохион байгууллаа (ажлын гүйцэтгэл, ажлын санаачилга).
- “Ухаалаг хэрэглээ, зөв хэмнэлт” төслийг ахмад багш нартай хамтран хэрэгжүүлж сургуулийн усны алдагдлыг бууруулж, цэвэр усны хэрэгцээг хангалаа (багаар ажиллах чадвар, бичиг баримт боловсруулалт).

Ахмад залуу үеийн хамтарсан үйл ажиллагаануудаас багшийн харилцаа хандлагатай холбоотой дараах эерэг хандлагууд бий болсон.

1. Сайн хичээл
 - Цагийн менежмент
 - Төлөвлөлт
 - Багш сурагчийн харилцаа
 - Сурагчийг урамшуулах, үнэлэх үйл явц
 - Бичиг баримт хөтлөлт
2. Хөвгүүдийн чуулган
 - Багаар ажиллах чадвар
 - Бие биенээ хүндлэх, хүндэтгэх ёс
 - Ажлын гүйцэтгэл
 - Биеэ авч явах байдал
3. Ухаалаг хэрэглээ зөв хэмнэлт
 - Эмх цэгцтэй зөв ярих чадвар
 - Бусдыг сонсож, сайн талыг олж харах

Хүснэгт 1. Ахмад багш нартай хамтран ажиллахад хийсэн SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
Цагийн менежмент - Цаг барьдаг, цагийн юмыг цагт нь хийдэг аливаа ажлыг хойш тавьдаггүй Ажлын төлөвлөлт - Ажлыг жил, сар, 7 хоногоор төлөвлөж хийдэг. Энэ нь конспект бичдэгтэй холбоотой байж магад. Ажлын байрны ёс зүй - хувцаслалт, чимэг зүүлт биеэ авч явах байдал гэх мэт Удирдах удирдуулах ёс - Удирдах албан тушаалтан болон ахмад үедээ хүндэтгэлтэй хандаж зөвлөгөө авах Ажлын гүйцэтгэлийг 100% хийдэг байдал, эхэлсэн ажлаа дуустал тултал хийдэг аливаа юмыг хийхдээ дутуу орхидоггүй. Эхлэх хугацаандаа яг эхлээд дуусгах хугацаанаасаа өмнө дуусгадаг.	Асуудалд шүүмжлэлтэй хандаж сөрөг талыг нь түрүүлж олж хардаг байж магад. Энэ нь тэд сурагчдыг үнэлэхдээ алдаа төд онц, муу гэж үнэлдэг байсан ажлын онцлогтой холбоотой байх магадлалтай. Хүний алдааг олны нүдэн дээр шууд хэлдэг – Тухайн соц нийгмийн удирдлагын арга барилтай холбоотой. Компьютер тоног төхөөрөмжийн мэдлэг тааруу

Арга туршлагатай олон жил ажилласан ахмад багш нартай хамтран ажиллаж тэднээс суралцах, тэдгээр багш нартай ямар нэгэн үйл ажиллагааг гар бие оролцон зохион байгуулж хамтран дүгнэх нь илүү амьд, бодит үр дүнгээ шууд өгдөг болохыг харуулж байлаа. Залуу багш нар олон төрлийн сургалтад хамрагддаг ч тэдний харилцаа хандлагад эергээр нөлөөлөх нь *зөв үлгэр дуурайлал, зөв чиглүүлж зөвлөн туслах амьд харилцаа* байдгийг ахмад үе ба залуу үеийн хамтарсан үйл ажиллагаа нотолж чадлаа.

Дүгнэлт

- Залуу багш нарын хувьд харилцаа хандлагын тал дээр анхаармаар зарим асуудлууд ажиглагдаж байна.
- Олон жил ажилласан ахмад багш нартай залуу багш нарыг хамтатган зөвлөн тусалж ажиллах
- Бодит үйл ажиллагааг хамтран зохион байгуулах
- Ахмад багш нар болон залуу багш нарын хамтын үйл ажиллагааг үнэлж тодорхой хэмжээний урамшуулал олговол зүйтэй

Санал зөвлөмж

Сургуулийн хэмжээнд:

- Тэдний хамтын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслэл, цахим ертөнцөд сурталчлан түгээн дэлгэрүүлэх.
- Зөвхөн багш гэлтгүй бусад мэргэжлийн ахмадуудтай хамтран ажиллах оролцоог нэмэгдүүлэх.

Үндэсний хэмжээнд:

- Цаашид ахмад болон залуу багш нарын хамтын үйл ажиллагааг илүү үр дүнтэй болгохын тулд боловсролын бүхий л шатны байгууллагын бодлогын хүрээнд албажуулах арга хэмжээ авах
- Ахмад багш нарыг идэвхжүүлэх, урамшуулах тогтолцоог судлах. Тухайлбал, сургуулийн төсөвт зөвлөн туслах арга хэмжээний зардал, түүнийг бүрдүүлэх арга замыг тодорхой зааж өгөх

Ном зүй

Жадамба,Б. (2010). Үйлийн явцдаа суралцаж хүншихүй. Улаанбаатар

Батсайхан,Б., Дэлгэрсайхан,М. (2015). Байгууллагын сэтгэл судлал. Улаанбаатар: Соёмбо принтинг

Жан Каяа. (2009). Багшид өгөх зөвлөгөө. Улаанбаатар

Ичинхорлоо,Ш. (2006). Багшийн хөгжил. Улаанбаатар

Мягмар,О. (2011). Судлаач багшийн гарын авлага. Улаанбаатар

Пүрэвдорж,Ч. (2013). Багшлахуйн менежмент. Улаанбаатар

Шатар,Ц. (2011). Багшлах урлаг. Улаанбаатар

Энхжаргал,Л. (2008). Багшлахад суралцахуй. Улаанбаатар

Эрдэнэцэцэг,С. (2010). Багш боловсролын үндэс. Улаанбаатар

Эрдэнэчулуун,Д. (2006). Удирдах арга барилын сэтгэл зүйн үндэс. Улаанбаатар

Монцамэ. (2019). Өвлөх эрдэм. Хөвсгөл

“Сурган хүмүүжүүлэх сэтгүүл”

ЗАЛУУ БАГШ НАР РДСА ЗАГВАРААР ӨӨРИЙГӨӨ ХӨГЖҮҮЛЭХЭД АХМАД БАГШ НАРЫН ОРОЛЦОО

Б. Өлзийхишиг¹, Л. Болор², Х. Сетергүл³

Нийслэлийн Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын

53 дугаар сургууль

Ulziihishigb@gmail.com¹, bolorlamzav1234@gmail.com², kh.setergul@gmail.com³

Хураангуй

Нийслэл болон хөдөө орон нутгийн залуу багш нараас ахмад багш нартайгаа хэрхэн хамтран ажиллаж буй болон өөрийгөө хэрхэн хөгжүүлж байгаа талаар судалж, өөрийгөө хөгжүүлэхэд ямар, ямар саад бэрхшээлүүд тулгарч буй талаар судалсан. Судалгааны үр дүнд заах арга зүй, багшийн бичиг баримт хөтлөлт, хөтөлбөр төлөвлөгөө боловсруулах, бодлого бодох болон онолын мэдлэг гэх мэт бэрхшээл үүсдэг нь харагдсан. Иймээс эдгээр асуудал бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэх боломж байгааг судлахаар ахмад болон залуу багш нартай ярилцлага хийж түүний үр дүнг нэгтгэн санал дэвшүүлсэн. Түүнчлэн залуу багш нарын өөрийгөө хөгжүүлэх үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх “Залуу багшийн хөгжлийн дэвтэр”-ийг боловсруулсан. Энэхүү дэвтрийн агуулгын дагуу багшийн бичиг баримт хөтлөлт, багшийн мэргэжил дээшлүүлэх болон үндсэн сургалтын тайлангууд, өөрийгөө хөгжүүлэх дадлуудыг тогтмол хэрэгжүүлж явах нь багшийн хөгжилд чухал хувь нэмэр оруулах боломжтой гэж үзсэн.

Түлхүүр үгс: залуу багш нар; мэргэжлийн өсөлт хөгжил; өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөө.

Оршил

Монгол улсын боловсролын хөгжлийн гол хөдөлгөгч хүч нь болох залуу багш бид бүхэн тогтмол өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх хэрэгцээ шаардлага бий болсоор байна. Иймээс залуу багш нарын мэргэжлийн өсөлтөд тулгардаг асуудал бэрхшээл, хэрэгцээ шаардлагуудыг судалж, залуу багш нарын мэргэжлийн өсөлтөд ахмад туршлагатай багш нар хэрхэн туслан дэмжих боломжууд байгааг эрж хайх үүднээс энэхүү сэдвийг сонгон авсан.

Судалгааны зорилго

Залуу багшийн мэргэжлийн өсөлтөд нөлөөлөх ахмад туршлагатай багш нарын оролцоо мөн залуу багш нар багшлахуйн үйл явцдаа хэрхэн өөрийгөө хөгжүүлэх боломжтойг судлах.

Практик ач холбогдол

Залуу багш нарийн мэргэжлийн өсөлтөнд ахмад туршлагатай багш нарын оролцоо маш чухал үүрэгтэй болохыг мөн залуу багш өөрийгөө хэрхэн хөгжүүлэх боломжууд байгааг илрүүлэн гаргаж ирсэн судалгааны үр дүнд бүтээсэн “Залуу багшийн хөгжлийн

дэвтэр”-ийг залуу багш нар өөрийгөө хөгжүүлэх үйл ажиллагаандаа авч хэрэглэх боломжтой юм.

Онолын хэсэг

1. Хөгжил гэж юу вэ?

Нийгмийн тогтолцооны бүхий л шатны байгуулал хандлага ба бодлогын түвшинд ахиц дэвшил гаргахад чиглэсэн хөдөлгөөнийг хөгжил хэмээн ойлгож болохыг судлаачид авч үздэг байна. Хөгжил нь:

- Хүний хөгжил
- Нийгмийн хөгжил
- Эдийн засгийн хөгжил
- Тогтвортой хөгжил

2. Хүний хөгжил гэж юу вэ?

Хүний хөгжлийн 3 айн хүрээнд хувь хүний итгэл үнэмшил, сэдэл, эрмэлзэл, ойлголцол, эв дүй, дадал, зан төлөв, хандлага туршлага зэрэгт гарч буй эерэг өөрчлөлт. Өөрөөр хэлбэл, хувь хүний цогц чадамжид гарч буй эерэг өөрчлөлт³¹ гэж үздэг байна.

3. Багшийн хөгжил гэж юу вэ?

Багшийн хөгжил гэж багшийн мэдлэг, арга зүй, ур чадвар, боловсролоо дээшлүүлэх тасралтгүй үйл явцыг хэлнэ³². Багшийн хөгжил нь нийгмийн хөгжил, боловсролын шинэчлэл, сургалтын хөтөлбөрийн өөрчлөлт, хөгжилтэй шууд хамааралтайгаар тасралтгүй үргэлжлэх үйл явц хэмээн үздэг байна.

“Багшийн хөгжлийг дэмжих хууль” батлагдсанаар багшийн оролцоо, багшийн хөгжлийг нэмэгдүүлэх эрх зүйн орчин бүрдсэн учир залуу багш нар ахмад туршлагатай багш нартай хамтран тулгамдсан асуудлаа шийдэх боломж бүрдсэн байна. Багш нар дараах арга замуудаар өөрийгөө хөгжүүлэх боломжууд байна.

Зураг 1. Боловсролын яамны харьяа байгууллагуудаас зохион байгуулж буй сургалт



- Сургуулийн багш нар эсвэл ЗАН-ын хамт олноосоо гэх мэт арга замуудаар багш өөрийгөө хөгжүүлэх олон боломжууд байгаа юм.
- Өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах

³¹ Сүрэнчимэг.Д. (2019). Багшийн хөгжил сэтгүүл. Дугаар 7. 10-р тал


³² Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 3.1.2.

Дээрх арга замуудаар хөгжихөд залуу багшийн өөрийн хичээл зүтгэл маш чухал үүрэгтэй юм. Иймээс багш нар өөрт тулгарч буй асуудал, бэрхшээлээ тодорхойлон бичээд өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулж түүний үндсэн дээр ямар сургалтанд хамрагдах, сургуулийн багш нар эсвэл ЗАН-ын хамт олноосоо дэмжлэг авах юм.

Залуу багш нар PDCA загвараар хөгжих нь

Бид өдөр бүр ямар нэгэн үйлдэл хийхдээ шийдвэр гаргадаг. Заримдаа буруу шийдвэр гаргаснаар алдаа гаргаж түүндээ харамсдаг. Учир нь бид ирээдүйд юу тохиолдож болохыг урьдчилан харж чадахгүй. Гэхдээ бид бүхэн аливаа эрсдэлийг тунгаан бодож, үүсэх асуудал бэрхшээлээс сэргийлэх боломжтой. Тухайлбал, залуу багш нар онолын мэдлэг тааруу шалтгаанаас болж хичээл сургалтын үйл ажиллагаагаа явуулж чадахгүй бэрхшээл тулгарахаас сэргийлж оюутан байх хугацаандаа эсвэл ажиллаж байх үедээ ээлжит хичээл бүрийнхээ өмнө бэлтгэлтэй байхаа төлөвлөсөн үед түүнийхээ дараа арга хэмжээ авч асуудал үүсэхгүй юм.

Иймээс залуу багш нар одоогийн түвшингээ тодорхойлж сургалтын үйл ажиллагаа явуулахад өөрт тулгамдаж буй асуудал бэрхшээлээ тодорхойлон бичиж, түүний үндсэн дээр энэхүү бэрхшээлүүдээ хэрхэн шийдвэрлэх арга зам байгааг төлөвлөх нь зүйтэй. Мөн одоо ямар түвшинд байгаагаа цаашид ямар түвшинд очихоо төлөвлөн бичсэнээр залуу багш бид бүхэнд хөгжих боломжууд бүрэн бий. Ийнхүү хөгжихөд туслах олон арга зам, загварууд байдаг. Тухайлбал, PDCA циклийн талаар дэлгэрүүлэн авч үзье.



PDCA” нь үр дүнтэй ажиллах арга юм. Энэ арга нь дөрвөн үе шаттай бөгөөд тэдгээр үе шатуудыг давтах байдлаар үйл ажиллагаагаа сайжруулж, ажлыг тогтвортой үргэлжлүүлэх боломжтой.

Plan:Төлөвлөгөө; Do: Хэрэгжүүлэлт; Check : Хяналт; Action: Сайжруулалт.

Дээрх дөрвөн үе шатны эхний үсгүүдийг нийлүүлж “PDCA” гэж нэрлэдэг. Уг аргыг Уолтер Эндрью Шеварт анх санал болгосон бөгөөд чанарын менежментийн хүрээнд ашиглагддаг. PDCA аргын дагуу чанарын сайжруулалт хийхдээ сайн төлөвлөгөө (P) болон үйл ажиллагаанаас эхэлбэл илүү үр дүнтэй байдаг. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх (гүйцэтгэл D), үр дүнг шалгах (C), үр дүнгийн шалтгааныг ойлгох, үйл явцыг сайжруулахын тулд (A) арга хэмжээ авах гэсэн тойрог хэлбэрээр үргэлжлүүлсээр илүү өндөр стандарт, илүү чанартай ажлын гүйцэтгэлийг бий болгодог.

Энэхүү загварын дагуу залуу багш нар өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлснээр хүрсэн үр дүнгээ үнэлэх, үр дүнгээ илүү сайжруулахын тулд хэрхэн сайжруулах боломжууд байгааг тодорхойлох юм. Ингэснээр өөрийн гаргасан алдаа нь дээрээ ажиллаж сурах боломжтой гэж бид үзэж байна. Өөрөөр хэлбэл өөрийн зорилгоо биелүүлэх төлөвлөгөөгөө бичээд үр дүнд хүрч чадаагүй бол орхих бус яагаад

үр дүндээ хүрч чадаагүй шалтгаанаа илрүүлэх түүний үндсэн дээр сайжруулаад дахин төлөвлөөд хийх гэсэн цикл хэлбэрээр залуу багш өөрийгөө хөгжүүлэх юм.

Судалгааны дүн

Хамрах хүрээ: НЕБ-н сургуулиудын залуу багш нараас

Судалгааны арга зүй:

- Нээлттэй ба хаалттай асуулгын арга (Залуу багш нарийн мэргэжлийн өсөлттэй холбоотой асуудал, бэрхшээлийг эрж хайх).
- Ярилцлагын арга (Асуулгаар тодорхой илэрч гарч ирээгүй асуудлыг залуу багш нартай ярилцах).
- Ажиглалтын арга болон баримт шинжилгээний арга (Асуулгын үр дүнд илэрч гарч ирсэн саад бэрхшээлүүдийг хэрхэн шийдвэрлэж болох арга замыг эрж хайх, олсон арга замаа туршиж үзэх).

Залуу багш нар өөрийгөө хэрхэн хөгжүүлж байгааг сургуулийнхаа залуу багш нараас бичгээр, бусад сургуулиудын багш нараас онлайн хэлбэрээр судалгаа авч үр дүнг боловсруулсан

Судалгааны 1-р хэсгийн үр дүнгээс харахад залуу багш нарт:

- Заах арга зүйн талаар
- Багшийн бичиг баримтын хөтлөлт
- Хөтөлбөр төлөвлөгөө боловсруулах
- Бодлого бодох болон онолын мэдлэг гэсэн бэрхшээлүүд тулгардаг байна.

Дээр буй асуудлуудаас хамгийн олон залуу багш нарын санал ирүүлсэн заах арга зүйн талаарх бэрхшээлийг хэрхэн шийдэж болох боломж байгааг бид судалж үзэхийн тулд сургуулийнхаа ахмад туршлагатай багш нарын хичээлд сууж үзсэн.

Энэхүү ажлын үр дүнгээс харвал залуу багш нар өөрийн заах арга зүйгээ хөгжүүлэхийн тулд олон багш нарын хичээлд сууснаар багш бүрийн онцлог заах аргын талаар шинэ санаа авч багшлахуйн үйлдээ хэрэгжүүлэх боломж байгааг илрүүлсэн. БЗД-ийн химийн сургагч багш нар мэргэжил нэгт болон залуу багш нарт мэргэжлийн ур чадвараа хөгжүүлэх олон боломжуудыг олгосныг бид бүхэн мэдэх билээ. Жишээ нь:

- Долоо хоног бүр багш нар цахим хичээл бэлтгэж хэлэлцүүлэг өрнүүлэх
- Долоо хоног бүр багш нарын санал асуулгаар нэг сэдэв сонгож онолын болон заах арга зүйн сургалт явуулж байсан нь залуу багш нарын хөгжилд маш чухал нөлөө үзүүлсэн.

Эдгээр ажлын үр дүнгээс харахад залуу багш нарын мэргэжлийн өсөлтөд ахмад туршлагатай багш нарын оролцоо маш чухал нөлөө үзүүлдэг байна. Мөн залуу багш нарийн мэргэжлийн өсөлтөд нөлөөлөх гол 2 хүчин зүйл байдаг нь харагдаж байна. Үүнд:

- Багшийн мэргэжлийн бэлтгэл
- Залуу багш нарын багшлах үеийн мэргэжлийн өсөлт

Санал

Багш бэлтгэх:

- Багш бэлтгэдэг их дээд сургуулиуд дадлага хийлгэхдээ ээлжит болон нэгж хичээлийн төлөвлөлт хэрхэн хийх мөн багшийн болон ангийн журнал хэрхэн бичих талаарх дадлагын үр дүнгээ илүү сайжруулах.
- Багш мэргэжлээр суралцаж буй оюутнууд багшлахуйн үйлийн талаар судалж, шинийг эрэлхийлэн хайдаг байх.
- Багш мэргэжлээр суралцаж буй оюутнууд өөрийгөө тогтмол хөгжүүлж онолын мэдлэгээ дээшлүүлэх.

Багшлах үед:

Залуу багш нар өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулж дараах арга замуудыг хэрэгжүүлж болох юм. Үүнд:

- Дүүргийн хэмжээнд: Залуу багш нар өөрсдийн багшлахуйд тулгарч буй бэрхшээлүүдээ БЗД-ийн ахмад туршлагатай багш нартаа уламжлан сургалт авах.
- Сургуулийн хэмжээнд: Ахмад багш нараасаа улиралд 1 удаа багшийн бичиг баримт хэрхэн зөв хөтлөх талаар эсвэл онол арга зүйн сургалт авах.
- Ахмад багш нарын хичээлд суух, хавтас бичиг баримттай танилцах боломж олгох
- Ахмад багш залуу багш нарын хичээлд сууж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх
- Ахмад багш болон залуу багшийн харилцаа хандлагыг сайжруулах ажлыг төлөвлөх, арга зүйгээр хангах
- Ахмад багш болон залуу багш хамтран хийх ажил зохион явуулах

Дүгнэлт

Хүний нийгэм үүссэн цагаас эхлээд л бид хамтран амьдрах хэрэгцээ шаардлага үүссэн. Үүнтэй адил залуу багш нар бид бүхэн ч гэсэн ахмад туршлагатай багш нараасаа үргэлж суралцаж, дэмжлэг зөвлөгөө авч байдаг нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Тиймээс залуу багш нарын мэргэжлийн өсөлтөд нөлөөлөх ахмад туршлагатай багшийн оролцоог нэмэгдүүлэхэд нэг талаас залуу багш нар, нөгөө талаас багшийн хөгжил хариуцсан байгууллагуудын хамтын ажиллагаа нөлөөлөх юм байна. Багш нар цаг үргэлж бие биенээсээ суралцаж байдаг.

Орчин үед нийгмийн өөрчлөлт хөгжлөө дагаад боловсролын салбар тэр дундаа сурагчдын сурах арга барил өөрчлөгдсөөр байна. Тиймээс багш бид бүхэн өдөр бүр тасралтгүй хөгжих шаардлага тулгарч байна. Залуу багш бид бүхэн “Залуу багшийн өөрийн хөгжлийн төлөвлөгөө” боловсруулан PDCA циклийн дагуу өөрийн хөгжих үйл ажиллагаандаа анализ хийж ахмад туршлагатай багш нартайгаа хамтран ажиллах шаардлагатай ажээ. Иймээс энэхүү хэрэгцээ шаардлагад тулгуурлан “Залуу багшийн хөгжлийн дэвтэр”-ийг боловсруулсан.

АХМАД БАГШИЙН АРГА ЗҮЙ БОЛОН САМБАР ТӨЛӨВЛӨЛТ

Л.Эрдэнэбаатар¹, Х.Даваалхам², Л.Даваасүрэн³, Ё.Отгонтуяа⁴

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын

лаборатори 23 дугаар сургууль

baatar0112@gmail.com¹, khdaagii2@gmail.com²,

davaasuren.lkhagva@gmail.com³, yootgontuya@gmail.com⁴

Хураангуй

Ээлжит хичээлийн үр өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд самбар төлөвлөлтийн судалгаа, туршилт хийлээ. Нэгдүгээр судалгаанд 399 багшийг хамруулж, самбар ашиглалтын хэрэгцээ шаардлагыг тодруулахад ахмад багш нар залуу багш нараас илүү самбар зохион байгуулалт сайн байсан. Үүнд тулгуурлан хоёрдугаар судалгааг 6 ахмад багшаас зөвлөгөө авч хийсэн. Гуравдугаар судалгаанд 3 багш зөвлөгөө өгч, самбар ашиглалтаа 5 удаа сайжруулан төлөвлөж, хичээл заасан ба ахиц нь сурагчдын дэвтэр хөтлөлтөөс тод ажиглагдсан. Иймээс багш ээлжит хичээл бүрийн самбар төлөвлөлтөө сайн хийснээр сурагчдын мэдлэг чадвар хандлагад ахиц гарч, багш сурагч хамтдаа тасралтгүй хөгжих боломж бүрддэгийг ахмад багш нараасаа суралцах ёстой гэж дүгнэв.

Түлхүүр үг: самбар төлөвлөлт; ахмад багш; залуу багш; суралцахуй.

Оршил

Багшийн хувьд хичээл сургалтын гол хэрэглэгдэхүүн болох самбарт хичээлээ хэрхэн төлөвлөж буулгах нь хичээлийн хамгийн чухал үйл явцын нэг юм. Хичээлийн онцлогоос хамааран багш бүр харилцан адилгүй самбар ашигладаг. Иймд залуу багш бид эмх цэгцтэй, төлөвлөлттэй самбар ашиглалтын талаар ахмад болон туршлагатай багш нараас суралцаж, өөрийн сурган хүмүүжүүлэх арга барил, багшлах үйл явцдаа хэрэглэх нь өнөөгийн тулгамдсан асуудлын нэг болж байна. Энэ нь сурагчдад системтэй, цэгцтэй мэдлэг эзэмшихэд, цаашлаад сурах арга барилыг өөртөө төлөвшүүлэхэд нөлөөлөх боломжийг судлахаар энэхүү судалгааг хийсэн болно. Үүнээс шалтгаалан ахмад багш нарын самбар төлөвлөх туршлага суралцах зорилгоор энэхүү судалгааг хийлээ.

Судалгааны ажлын зорилго

Ээлжит хичээлийн үйл явцыг самбарт эмх цэгцтэй, товч тодорхой тусгаснаар багш сурагчийн хамтын үйл ажиллагаа сайжирч, мэдлэг бүтээснээр сурлагын чанар ахих боломжийг судална.

Судалгааны ажлын зорилт

- Самбарын бичиглэлийг сайжруулснаар сурлагын чанарт нөлөөлөх боломжийг судлах

- Хичээлийн бэлтгэл судалгаанд самбараа сайн төлөвлөснөөр сурагчдын сурлагын чанарт ахиц гарахыг ажиглах
 - Хоцрогдож байгаа сурагчдаа самбарт тогтмол ажиллуулснаар тухайн сурагчийн хичээлд хандах хандлага өөрчлөгдөж болохыг нотлох
 - Багшийн заах арга барил, ажлын амжилтад чанарын ахиц гарах боломжийг судлах
- Судалгааны арга зүй*

Судалгааны ажлын нэгдүгээр бүлгийг бичихэд баримт материал цуглуулах, харьцуулан жиших аргыг, хоёрдугаар бүлгийг бичихэд судалгааны арга, ажиглалтын арга, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх аргыг хэрэглэсэн.

Онолын хэсэг

Суралцахуйн сэтгэл зүйн үндэс нь өөртөө итгэх итгэл, өөрөөрөө бахархах, өөдрөг сэтгэл төрүүлэх, шинийг сурах хүсэл тэмүүлэл бий болох бол сургах хүмүүжүүлэх үндэс нь зөв дадал хэвшилд сургах, бүтээлч байх, хариуцлагатай байх зан төлөвийг төлөвшүүлэх, аливаа зүйлд хандах хандлагыг эергээр хөгжүүлэх явдал чухал байдаг байна.

Самбар төлөвлөлт гэдэг нь багшийн урьдчилан бэлтгэсэн цахим хичээлийн үзүүлэнгүүд болон хичээлийн явцад багш, хүүхдүүдийн самбарт хийсэн бичиглэлийг самбарт хэрхэн буулгахыг багш өөртөө зураглан төлөвлөхийг хэлнэ.

Ингэхэд яагаад заавал самбарыг төлөвлөх ёстой вэ?

Хэрвээ сургалтаар хүүхдийн өмнөх төсөөлөлд мэдрэгдэхүйц өөрчлөлт гараагүй бол бид хичээлээрээ бүтээлч иргэн төлөвшүүлэх эрхэм үүргээ биелүүлээгүй байна гэсэн үг.

Сурагчид гарсан чанарын өөрчлөлт буюу мэдлэг эзэмшилтийг *үнэлэх шалгуур* нь сурагчдын дэвтэрт бичиж тэмдэглэсэн байдал, бусдад өөрийгөө илэрхийлж буй байдал, бодлогын бодолтыг бичгээр илэрхийлж буй байдлаар илэрдэг. Цаашлаад сурагч тухайн зүйлийг сонирхох явдал юм. Сонирхол гэдэг бол хүн тухайн зүйлийг өнгөц гүнзгий, их бага ямар нэгэн хэмжээгээр мэдэрч эхэлж байгаагийн илрэл юм. [1]

Ахмад багш нарын туршлага

- Төлөвшил - багшийн хөгжил – бүтээлч ажиллагааны үе шат нь ажилд орсноос тэтгэвэрт гарах бүх хугацаа бөгөөд өөрийн гэсэн төрхтэй, бүтээлчээр ажилладаг, тасралтгүй хөгждөг буюу хөгжсөн багш болж төлөвшсөнөөр боловсролын хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулдаг хөдөлмөрийн он жилүүд юм. [18] Багш нарын мэргэжил дээшлүүлсэн байдал гэсэн судалгааны 71 хувь нь ажлын байран дээрээ хөгждөг [19]
- Багшлах эхний 1-2 жил орчимд ахмад туршлагатай багш нар хамтран ажиллаж туслах, багшийн ажлын олон талт байдлыг танин мэдэж, бэрхшээлийг даван туулахад нь арга барилаасаа өвлүүлэх, дамжуулах. Дараагийн 3-5 жил буюу 30 хүртэл насныхан өөрийн сонирхдог чиглэлээрээ шинэ зүйл оролдож хийх хүсэлтэй, өөрийн эргэлзсэн зүйлд эрэл хайгуул хийж, санаачилгатайгаар ажиллаж эхэлдэг ба аливаа өөрчлөлт болон шинэ зүйлд дасан зохицох чадвартай байдаг учир энэ үед хамтран ажиллах

- 30-40 насныхан нь тодорхой арга барилтай болчихсон, албан тушаал аж амьдралаа өөд татах гэсэн хоёрдмол зорилготой болсон байдаг учир бие даасан сургалтаар хөгжих, залуу багш нарт туслах хүсэл сонирхлыг нь төрүүлэх, 40-50 насны багш нар дадлага туршлага сайтай, аливаад шүүмжлэлтэй ханддаг, ямар нэг чиглэлээр мэргэшсэн байдаг тул тэд сайн зөвлөгч, удирдагч хамтрагч байж чаддаг бол 50 – иас дээш насныхан ажилдаа чин сэтгэлээсээ дуртай байх боловч шинээр сэтгэх, өөрийгөө өөрчлөхөд хүндрэлтэй болсон байдаг тул тэд сайн зөвлөн туслагч байж чаддаг [20].

Судалгааны хэсэг

Нэгдүгээр судалгаа нь хотын 55 , хөдөө орон нутгийн 6 сургуулийн нийт 399 багш нар оролцсон. Судалгаа авсан хэлбэр нь задгай болон битүү хариулттай асуултаар googleform ашиглан авсан. Боловсруулалтыг SPSS22 болон excel ашиглан хийлээ. (Диаграмм 1-6) багш нарын хувийн мэдээлэл, диаграмм 7-8 самбар ашиглалтын хэрэгцээ шаардлагыг тодруулсан. (Хүснэгт 1-5, график 1-5)-д багш нарын хариултыг хамааруулж харуулсан байна.

Дүгнэлт: Дараах судалгаанаас багш нарт хичээл заахад самбар төлөвлөлт маш чухал. Мөн бүх багш нарт ч байнга хичээлээ самбартаа бүрэн багтаан орж чаддаггүй. Тийм учраас энэ талаар үлгэр жишээ авч суралцах шаардлага үүсч байна. Судалгаанд ахмад багш нар самбарт хичээлээ багтаан заадаг 30 багш байгаа нь нийт ахимаг настай багш нарын 65.2%-ийг эзэлж байна. Иймээс ахмад багш нараас туршлага судлан самбар төлөвлөлт суралцах боломжтой байж болно.

Хоёрдугаар судалгааг 23 дугаар сургуульд ажиллаж буй ахмад туршлагатай 6 багшаас авсан. Судалгаа авсан хэлбэр нь ярилцлагын арга ашигласан. Судалгааг авсан программ нь аудио бичлэг хийж, excel дээр боловсруулсан.

Дүгнэлт 1. Самбарыг сайн төлөвлөснөөр хичээлийг эмх цэгцтэй сурагчид мэдлэг бүтээхэд онцгой үүрэг гүйцэтгэдэг гэдэг нь харагдлаа. Ахмад багш нарын зөвлөснөөр самбар төлөвлөхдөө дараах зүйлс дээр анхаарах: Эмх цэгцтэй, баруун дээд булангаас зүүн доод булан руу чиглэсэн байх, хичээлийн гол агуулгыг бүрэн дүүрэн багтаасан байх, самбарт дармал болон бичмэл үсгийг хольж бичихгүй байх, шаардлагатай чухал хэсгүүдийг тодруулсан байх зэрэгт анхаарч, самбар төлөвлөхдөө тусгаж авахаар олон зүйлийг сурлаа. Өөр багш энэ хичээлийг яг тэр төлөвлөлтөөр дахин туршиж амжилттай заасан нь хичээлийг сайн төлөвлөлөө гэж ахмад багш нар дүгнэлээ. Цаашид хичээл төлөвлөхдөө үүнийг анхаарч ажиллана.

Самбар төлөвлөлт хийхэд ахмад багш нарын зөвлөгөө

	Д.Хандмаа, Л.Эрдэнэбаатар, Ё. Отгонтуяа Самбарт зөв, цэгцтэй том, тодорхой бичих хэрэгтэй сурагчид дагаад адилхан цэвэрхэн цэгцтэй бичдэг болно.
	Ё. Отгонтуяа, Д.Хандмаа - Онолын мэдлэг сайн байх - Өөрсдөөр нь мэдлэг бүтээлгэх - Эхний ангид орсон хичээлээ сайжруулаад, дараа дараагийн ангид илүү сайнаар хичээлээ заадаг байгаасай.
	Д.Хандмаа, Б.Батчимэг - Хялбараас гүнзгий рүү чиглэсэн дараалалтай - Мэдлэг бүтээх үе шатаар ахиулсан байвал самбар цэгцтэй байна.
	Д.Хандмаа, Б.Батчимэг Бусдаас санаа авч, өөртөө анализ хийдэг байх. Жишээ нь. Япон багш нарын самбар төлөвлөлт үнэхээр сайн байдаг.
	С.Ариунаа, Б.Батчимэг Хичээл хоорондын уялдаа, сурагчдын нас сэтгэхүйн онцлогт тааруулж самбартаа бичих, зурах аргаа сонгох

Дүгнэлт 2. Сургуулийнхаа ахмад болон зөвлөх, тэргүүлэх зэрэгтэй багш нартай сургалтын явцад баримталдаг гол зарчим, багшлах арга зүй болон сургалтын явцад самбар төлөвлөлтийн ач холбогдлын талаар ярилцлаа. 23 дугаар сургуулийн монгол хэлний зөвлөх багш 2, бага ангийн зөвлөх багш 1, байгалийн ухааны тэргүүлэх зэрэгтэй 2 багштай ярилцсан.

Тэдний олон жил ажилласан туршлагаас дүгнэхэд бага анги болон байгалийн ухааны хичээлээр “хичээл сургалтын үйл ажиллагааг алхамчилж, алхам бүрт асуулт бэлтгэх, үйл ажиллагаатай уялдуулан самбар ашиглалтыг төлөвлөх, сайжруулах, ажиглалтын үр дүнг тусган хичээлийн хөтөлбөр болон самбар ашиглалтыг сайжруулах нь зайлшгүй чухал байна³ –хэмээн дүгнэлээ.

Гуравдугаар судалгааг 23 дугаар сургуульд ажиллаж буй ахмад туршлагатай 3 багш нараас зөвлөгөө авч туршилт хийсэн. Туршилт хийсэн хэлбэр нь хичээлийг зааж самбар ашигласан. Судалгааг авсан программ нь видео бичлэг хийсэн.



Ерөнхий дүгнэлт

Багш нар ээлжит хичээлийн бэлтгэл судалгаандаа самбар төлөвлөлтөө тусгаснаар үзсэнээр багшийн ээлжит хичээлийн төлөвлөгөө нь тодорхой харагдаж юуг сайжруулах ёстойгоо олж харах боломж нээгдэхээс гадна сурагчид самбарын бичиглэлийг харан дэвтэртээ эмх цэгцтэй тэмдэглэж авах тухайн хичээлийнхээ талаар цогц мэдээллийг тархиндаа цэгцтэй кодлон буулгаж байна. Ингэснээр системтэй мэдлэгийг өөртөө бүтээж, тэдний санаанаас гарахгүй санаж байх нь багш бидний дараа дараагийн мэдлэгийг эзэмшүүлэхэд тулгуур нь болж сурлагын чанарт илүү ахиц гарах боломжтой юм гэсэн дүгнэлтэд хүрлээ.

- Өдөр бүрийн үзсэн хичээлээ багшийн самбарт бичсэн зураглалаар төсөөлж эргэж санана гэдэг нь сурлагын хоцрогдол үүсэхгүй байх хөшүүрэг юм.
- ХХI зууны боловсролын чухал шалгуурын нэг болох бичиг үсгийн чадвар, мэдээллийг боловсруулах чадвартай болох төдийгүй өөр бусад зүйлд хандах хандлага эергээр төлөвшиж бүтээлч сэтгэлгээ нь хөгжинө.
- Багш нэг янзаар самбараа төлөвлөх бус боловсролын шинэчлэлд зохицон тасралтгүй сайжруулахаас гадна ээлжит хичээл бүрийн онцлогтоо тохируулан өөрийн ажлын гол хэрэглэгдэхүүн болох самбартаа хичээлээ хэрхэн буулгахаа дотроо зураглан байнга төлөвлөж байх нь зүйтэй юм байна.
- Багш ээлжит хичээл бүрээ төлөвлөж самбарт буулгаснаар сурагчдын мэдлэг чадвар хандлагад алхам алхмаар ахиц гарч, багш сурагч хоёр хамтдаа тасралтгүй хөгжих боломжийг тасралтгүй бүрдүүлнэ.

Санал

Хичээлийн бэлтгэл судалгаанд самбар ашиглалтыг зөв төлөвлөх нь сурагчийн сурлагын чанар ахих боломжтой байгаа учраас багш нарын дунд “Самбараа төлөвлөлттэйгөөр ашиглая”, залуу багш нарын дунд “Ахмад багш нараасаа суралцъя” гэх мэт аяныг зохион байгуулж цаашид ээлжит хичээлийн бэлтгэлдээ самбар төлөвлөлтөө чухалчлан тусгаж байхыг багш нартаа уриалж байна.

Ном зүй

Батсуурь,Ц., Жадамба,Б. (2005). Багш боловсролын хөгжлийн орчин үеийн чиг хандлага, үзэл баримтлалын асуудал. Сэтгэл судлал СХУ-ы эмхэтгэл. х54-63.

Бурмаа,Б., Нэргүй,Н., Нямгэрэл,Ч. (2001). Суралцахуй – концепцийн өөрчлөлт. Чанартай боловсрол-хөгжлийн баталгаа. Багш нарын бага хурал. Улаанбаатар.

Жадамбаа,Н. (2016). Багш нарыг хөгжүүлэх тухай зарим асуудал. Сэтгэл судлал, СХУ-ы эмхэтгэл, х.77-83

Наранчимэг,С. (2001). Бүтээлч сэтгэлгээний үзэл санааг хэрэгжүүлэх арга зүй. Чанартай боловсрол-хөгжлийн баталгаа. Багш нарын бага хурал. Улаанбаатар.

Наранцэцэг,Б. (2001). Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх сургалт, түүний үр дүн, цаашдын зорилт.

～ 板書づくり ～ 発行日 平成31年2月 編集 白井市教育委員会 教育支援課 発行 白井市教育委員会

Накамүра Кооичи (2010) “Асуудал Шийдвэрлэхэд Чиглэсэн Математикийн Хичээлийн Самбар Ашиглалт “Туршлагатай Багшийн Самбар Ашиглалтын Практикт Тулгуурлан Үзэх Нь” Математикийн Боловсрол Мэйжи Тошо Хк, Рр.4-5.

Отгончимэг, Ж. Багшийн хөгжил. Сэтгэл судлал СХУ-ы эмхэтгэл. х.257-260

Сүгияма Ёшишигэ. Суралцахуйн Аргыг Сайжруулах (3) Асуух Асуулт. Самбар ашиглалтыг сайжруулах нь”

Төмөр, Д. (2003). Тулгуур дохионы сургалт. Улаанбаатар.

Тунгаамал Төв” Тбб. (2018). Боловсролын үндэсний хөтөлбөрүүд, сургуулийн үйлчилгээний орчны стандартын хэрэгжилтэд хийсэн хөндлөнгийн үнэлгээний тайлан”.

Уранбилэг, Р., Отгонжаргал, Д. Бямбасүрэн, Л. (2013). Хичээлийн бэлтгэл судалгаанд самбар ашиглалтыг зөв төлөвлөснөөр сурагчдын сурлагын чанар ахих боломжууд.

Хишигт, Я. (2001). Сургалт хүмүүний мэдрэмжтэй шүтэлцэх тухай асуудалд” илтгэл “чанартай боловсрол-хөгжлийн баталгаа. Багш нарын бага хурал. Улаанбаатар.

“Шинжлэх Хичээлийн Нэгэн Жишээ” Илтгэл. Багшлах Урлаг Сэтгүүл 2016/3

Булган Хишиг Өдөр сумын сургууль хичээлийн судалгаа “Самбар ашиглалтыг сайжруулах нь” илтгэл

Cogent Education The Lived-Through Experience Of The Senior Teacher: A Closer Look At A Middle Management And Leadership Position In Bahraini Public Schools 2015 Nina Lutfi Abdul Razzak

Цахим линк

<http://www.e-shiroi.jp/center/kenkyu/bansyo.pdf>

<https://schoolweek.co.uk/age-is-no-barrier-to-teachers-ability-finds-long-awaited-working-longer-review/>

<https://www.facebook.com/%D0%A5%D0%B0%D0%BC%D1%82%D0%B4%D0%B0%D0%B0-%D0%91%D0%BE%D0%B4%D0%BB%D0%BE%D0%B3%D0%BE-%D0%91%D0%BE%D0%B4%D0%BE%D1%86%D0%B3%D0%BE%D0%BE%D1%91-115038633957065/photos/pcb.282641997196727/282641553863438>

АХМАД БАГШИЙН ДЭМЖЛЭГЭЭР ТУРШИЛТАТ ХИЧЭЭЛИЙН АЖЛЫН ХУУДСЫГ САЙЖРУУЛАХ БОЛОМЖ

О.Мөнхгэрэл¹, А.Батгэрэл², С.Нямсүрэн³, Э.Азжаргал⁴

Дорнод аймгийн Ерөнхий боловсролын

“Хан-Уул” цогцолбор сургууль

Munkhgerel1123@gmail.com¹, batgerel.altangerel0707@gmail.com²,

su.nyamaa@gmail.com³, azjargal0802a@gmail.com⁴,

Хураангуй

Бид бүхэн туршилтат хичээлийг хэрхэн үр дүнтэй болгохын сацуу бага боловсрол суурь боловсрол гэсэн уялдаа холбоог илүү бэхжүүлэхийг зорин ажиллалаа.

Сурагчид бага ангиасаа эхлэн шинжлэн судлах арга барилыг хүн ба орчин, хүн ба байгаль хичээлүүдээр эзэмшиж эхэлдэг. Тэгвэл туршилтат хичээлүүд нь зүгээр нэг хийсвэр зүйл яриад байх биш амьдрал ахуйд ойрхон туршилт судалгааг байгалийн ухааны хичээлд шигтгэж өгөх, түүнийг сонирхон судалж, үр дүнг тооцох чадварт сургах ажлын хуудас, туршилтын заавар боловсруулж, сурагчдын чадварыг бага ангиас нь дэмжих нь зүйтэй юм.

Энэхүү туршилт-үйл ажиллагааг ээлжит хичээлд зөв төлөвлөж, ажлын хуудсыг хүүхдийн чадварт тулгуурлан боловсруулж, үр дүнг тооцох хэрэгцээ байгааг манай судлаач багш нар олж харсан. Бага ангийн “Сурагчийн туслах” ялгаатай даалгавраар, дунд ахлах ангид “Ажлын хуудас”-ыг боловсруулан ээлжит хичээлд шигтгэн төлөвлөхөд ахмад багш нарын дэмжлэгийг авч, хамтран ажиллаж, арга зүйд суралцах дэмжлэг хэрэгтэй болсон.

Түлхүүр үг: химийн хичээл; сорил туршилт; арга аргачлал; арга зүй; сурагчдын идэвх; туршилтын заавар; үр дүн; арга барил; сурлагын хоцрогдол.

Оршил

Аливаа сургалтын хөтөлбөрийг боловсруулахад багш (сургагч)-ийн дидактик шийдэл чухал хэдий ч тухайн хөтөлбөрийг бүтээлчээр хэрэгжүүлэхэд суралцагч (сургалтад оролцогч)-ийн сэдэл тэмүүлэл, хэрэгцээ, санаачилга ч эн тэнцүү ач холбогдолтой гэдэгтэй та лав санал нийлэх биз ээ.

Химийн хичээл нь шинжлэх ухааны суурь ойлголтуудын талаар мэддэг болохоос илүүтэй сурах арга барил, судлан шинжлэх ур чадварыг хөгжүүлэхэд илүү чиглэх юм. (БСШУЯ, Бүрэн дунд боловсролын хөтөлбөр. 2019) Харин бага ангийн байгалийн ухааны хичээл нь шинжлэн судлах замаар сурах арга барил эзэмшүүлэхэд чиглэдэг.

Туршилтат хичээл өөрөө туршилт, лаборатори дээр түшиглэн шинжлэн судлах арга барил эзэмшдэг судлагдахуун юм. 2-3 жилийн өмнө туршилтын багаж, хэрэгсэл дутмаг учир сурагчдын хичээлд оролцох оролцоо идэвхгүй байсан. Сургууль бүрт үе шаттайгаар лаборатори, кабинетуудыг нийлүүлсэн боловч хүүхэд бүр туршилтын багаж хэрэгслийг хэрэглэх чадваргүй байсан. Гэтэл сүүлийн 2 жилд онцгой нөхцөл

байдал үүсч, хүүхэд бүр танхимын болон танхимын бус хэлбэрээр суралцах *цахим шилжилт* хийсэн нь хичээлийг хэрхэн сонирхолтойгоор зохион явуулах хэрэгцээ байгааг судлах, турших, үр дүнг тооцох, нэвтрүүлэх нь анхны үндэслэлээр бид виртуал лабораторийг 2 жил туршин хэрэгжүүлж, үр дүнг тооцсон.

Иймээс сурагчдыг бие даан суралцахад танхимд ч зайнаас ч тэр ажлын хуудас хэрхэн дэмжлэг болж байгаа илрүүлэх, ашиглах арга зүйг сайжруулах явцдаа шинжлэх ухаанч арга барилыг дэмжих нь зүйтэй гэж үзэж дээрх сэдвийг сонгон авсан.

Хан-Уул цогцолбор сургуулийн хувьд 20015 оноос эхлэн байгалийн ухааны хичээлээр “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил” БСШУЯ, ЖАЙКА-ийн хамтарсан төсөлд сонгогдон хичээлийн судалгааг сум, аймаг, үндэсний хэмжээнд туршин түгээн дэлгэрүүлэхэд ашигласан ажлын хуудас боловсруулах, хэрэглэх, үр дүнг тооцох арвин туршлагатай ахмад багшийн зөвлөмж, зөвлөгөө, хамтын ажиллагаа байгаа нь судалгааны ажлыг боловсруулах дэмжлэг болсон.

Судалгааны хэрэгцээ, шаардлага

Сурагчид бага ангиасаа эхлэн шинжлэн судлах арга барилыг хүн ба орчин, хүн ба байгаль хичээлүүдээр эзэмшиж эхэлдэг. Тэгвэл туршилтат хичээлүүд нь зүгээр нэг хийсвэр зүйл яриад байх биш амьдрал ахуйд ойрхон туршилт судалгааг байгалийн ухааны хичээлд шигтгэж өгөх, түүнийг сонирхон судалж, үр дүнг тооцох чадварт сургах ажлын хуудас, туршилтын заавар боловсруулж, сурагчдын чадварыг бага ангиас нь дэмжих нь зүйтэй юм.

Энэхүү туршилт-үйл ажиллагааг ээлжит хичээлд зөв төлөвлөж, ажлын хуудсыг хүүхдийн чадварт тулгуурлан боловсруулж, үр дүнг тооцох хэрэгцээ байгааг манай судлаач багш нар олж харсан. Бага ангийн “Сурагчийн туслах” ялгаатай даалгавраар, дунд ахлах ангид “Ажлын хуудас”-ыг боловсруулан ээлжит хичээлд шигтгэн төлөвлөхөд ахмад багш нарын дэмжлэгийг авч, хамтран ажиллаж, арга зүйд суралцах дэмжлэг хэрэгтэй болсон.

Дэвшүүлж буй асуудал

Залуу багш-дунд үе-ахмад гэсэн холбоог уялдаа холбоотой болгож ажилласнаар гарах үр дүн нь хэмжээлшгүй юм. Багш цаг хугацааг хэмнэн арга зүй, ажлын туршлагаа ахиулах боломж нээгдэж байна. Мөн ахмад багш өөрсдийн туршлагад тулгуурлан өөрсдийн мэдлэг чадвараа залуу, дунд үеийн багш нараараа дамжуулан түгээх боломж бүрдэж байна.

Судалгааны зорилго:

Ахмад багшийн туршлагад тулгуурлан туршилтат хичээлийн ажлын хуудсыг сайжруулах боломжийг судлах, боловсруулан хэрэгжүүлж, үр дүнг тооцох

Судалгааны зорилт

- Ахмад багшийн дэмжлэг, оролцоо ямар байсан, ямар байгааг, хамтран ажиллах боломжийг судлах
- Ажлын хуудсыг цуглуулан, төрөлжүүлэн, бүлэглэх, шинжлэх, нэгтгэх

- Ахмад багш нартай хамтран үйл ажиллагааг зохион байгуулж, үр дүнг тооцох, ажиглах, дүгнэх

Судалгааны арга зүй

Судалгааны ажлын багажаар асуулга, ярилцлагын асуултын аргыг сонгож, фокус бүлгийн ярилцлагаар өнөөгийн байдал, багш мэргэжлийн өсөлтөд үзүүлэх үр дүнг тооцсон.

Судалгаанд хот, хөдөөгийн 20 гаруй сургуулийн байгалийн ухааны 98 багш, бага ангийн 42 багш, лаборатори сургуулийн 51 багшийг оролцуулж, асуулга, анкетын аргаар авч өгөгдөл цуглуулж, задлан шинжилж үр дүнг тооцсон бөгөөд химийн хичээл судалдаг ЕБ-ын сургуулийн дунд ангийн 200 сурагчаас асуулга авсан (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан багш, сурагчдын статистик мэдээ

Байршлаар:	Хот	Аймаг	Сум	Баг, тосгон
Хамрагдсан тоо	42	98	45	4
Насаар:	20-30	30-40	40-50	50-иас дээш, ахмад
Хамрагдсан тоо	48	85	32	26
Ажилласан жилээр:	1-5	6-10	11-20	20-иос дээш
Хамрагдсан тоо	42	25	92	30
Мэргэжлийн зэргээр:	Зэрэггүй	Заах аргач	Тэргүүлэх	Зөвлөх
Хамрагдсан тоо	25	81	76	9
Сурагчид	6 анги	7 анги	8 анги	9 анги
Хамрагдсан тоо		72	48	80

Судалгааны багаас багшийн мэргэжлийн өсөлтөд ахмад багшийн оролцоо, дэмжлэг ямар байгаа, багш нарт ямар хэрэгцээ байгаа, хамтран ажилласан байдал зэргийг судлахаар хаалттай асуулттай, задгай хариулттай асуулгыг 191 багшид илгээснээс 188 асуулга буцаж ирснээс огт хариулаагүй болон дутуу, хангалтгүй хариулттай асуулгыг хасаж, эцсийн байдлаар 171 асуулгыг ашиглав.


Судалгаат хичээлд оролцсон сурагчдын ахиц, амжилт, ажлын хуудас хөтлөх чадварыг тооцох зорилгоор 200 асуулга илгээснээс 181 асуулга ирсний 25 нь хангалтгүй хариулттай байсан учир 156 асуулгыг судалгаанд ашиглав. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Төлөвлөсөн санал асуулгын тоо

Оролцогчид	Төлөвлөсөн санал асуулга	Ирүүлсэн тоо	Судалгаанд ашигласан санал
Багш	191	188 /98%/	171 /89%/
Сурагч	200	181 /90%/	156 /78%/

Судалгааны хэсэг

Зураг 1. Сургуулийнхаа ахмад багш, тэтгэвэрт гарсан багш нартай хамтран ажилладаг эсэх



Багш нараас авсан судалгаанаас үзэхэд багш нарын 67% нь ажлын байран дээрээ ахмад багштай, 30% нь тэтгэвэрт гарсан ахмад багштай хамтран ажилладаг боловч хамтран ажилладаггүй гэж 2.4%, 32.4% нь хариулсан байгаа нь өнөөгийн багш нар ахмад багш нарыг төдийлөн ойшоодоггүй нь харагдаж байна.

Хүснэгт 3. Ажиллаж байгаа ахмад багш нартай хамтран ажилладаг чиглэл

хичээлийн судалгаа зохион байгуулах	5
нэг болон ээлжит хичээл боловсруулах	3
хүүхэд бүрийн ахиц, амжилтыг нэмэгдүүлэх	16
даалгавар боловсруулан шинжлэх	6
уралдаан, олимпиадад оролцох	6
хүүхэд бүрийг төлөвшүүлэх	16
авьяасыг хөгжүүлэх	8
арга зүй, ур чадвараа хөгжүүлэх	17
судалгааны ажил боловсруулах	4
эцэг эхтэй ажиллах	14

Багш нар ажлын байранд дээрээ хөгжихөд ахмад багш нартай хамтарч ажиллаж, тэдний арга зүй, туршлагаас суралцах нь илүү үр дүнтэй гэж 100 хувь хариулсан. Мөн хөтөлбөр төлөвлөгөө боловсруулах, судалгаат хичээл үйл ажиллагаа явуулах зэрэгт хамтарч ажилладаг гэж хариулсан байна.

Хүснэгт 4. Тэтгэвэрт гарсан багшийн үзүүлсэн дэмжлэгийн чиглэл

аймгийн хэмжээнд манлайлсан	10
үндэсний хэмжээнд манлайлсан	1
сургуулийн хэмжээнд манлайлсан	7
судлагдахууны хэмжээнд манлайлсан	2
гарын авлага эмхэтгэсэн	9
ном, хэвлэл гаргасан	5
даалгаврын сан боловсруулсан	8
арга зүй, туршлагаа түгээсэн	19
сурагчид амжилт гаргасан	16

Зураг 2. Тэтгэвэрт гарсан багштай хамтран ажилласнаар гарсан амжилт, бүтээл



Ахмад багш нараасаа суралцсан багш нарын 62% арга зүй, ур чадвараа хөгжүүлж, 59% нь туршлагаа түгээн дэлгэрүүлсэн байна. Ахмад багш нартай хамтран ажиллахад багш нарын бусдаас суралцах, сайн сонсогч байх, хариуцлагатай зарчимч, цаг хугацаандаа ажлаа хийж хэвших, багшлах арга зүй, хүүхэд хөгжүүлэх чадвар, эцэг эхтэй ажиллах зэргийг ахмад багш нарын туршлагыг өнөөгийн арга барилтай хослуулсан хэрэгжүүлсэн гэж хариулсан сайн тал байсан боловч, ахмад багштай хамтарч ажиллаж үзээгүй, ахмад багш нар санаачилгатай байх хэрэгтэй гэж хариулсан багш нар байсан нь сургууль бүр, нэгж бүр дээр боловсролын салбарын маш том капитал болох ахмад багш нартай харилцан адилгүй ажилладаг юм болов уу гэсэн харамсал төрж байсан.

Зураг 3. Багш нарын сэтгэлгээний хандлага



Туршин хэрэгжүүлж, үр дүнг тооцсон байдал

Үйл ажиллагаа 1. Бага ангийн ЗАН-ийн хамт олны ахмад багшийн дэмжлэг оролцоог авч ажилласан туршлага

Хоцрогдолтой байгаа сурагчдын чадварыг нэмэгдүүлэхээр “Ялгаатай даалгаврын сан” буюу “Миний туслах” гарын авлагыг сэргээн санах, задлан шинжлэх, чадвар гэсэн 3


түвшний ажлын хуудсыг боловсруулан гарын авлага болгосон нь эцэг эх, сурагчдад ойлгомжтой, хөнгөнөөс хүнд рүү чиглэсэн хэрэглэгдэхүүн болж чадсан. Бага ангийн сурагчдын гүйцэтгэлийн түвшин 2-18 хувиар ахисан.

Үйл ажиллагаа 2. Байгалийн ухааны ЗАН-ийн багш нарын ахмад багшийн дэмжлэг, оролцоог авч ажилласан туршлага

Хичээлийг төлөвлөхдөө ажлын хуудсыг хүүхэд бүрийг чадваржуулах, туршилтын заавартайгаар төлөвлөн хэрэгжүүлсэн. Жил бүр хичээлийг зааж туршихдаа, ажлын хуудсыг засан сайжруулан хэрэглэж, цаашид сайжруулах санаагаа олж харж, хүүхэд бүр хэрэглэхэд ойлгомжтой болгож чадсан.

6-9 дүгээр ангийн 278-306 /2015 оны хичээлийн жилээс 2020 оны хичээлийн жилийн хооронд суралцаж байсан сурагчдын тоо/ сурагчдын туршилтат хичээлийн ажлын хуудас ашигласан байдал, гүйцэтгэлийг нэгтгэж үзэхэд 2015 оноос ахисан байдалтай харагдаж байна (Зураг 4).

Зураг 4. Сурагчдын ажлын хуудасны гүйцэтгэлийн өсөлт



Хүснэгт 5. Ахмад багшийн дэмжлэг оролцоо

Хичээлийн жил	Зөвлөгөө, зөвлөмж	Үр дүн
2016-2017 оны хичээлийн жил	Сурах бичгийн туршилтын зааврын дагуу дасгалыг гүйцэтгүүлж, хүүхдийн үр дүнг нэгтгэж, анализ хийх арга зүй	Энэ үед сурагчид туршилтын зааврыг сайн ойлгохгүй туршилт амжилтгүй болдог байсан.
2017-2018 оны хичээлийн жил	Туршилтын аргачлалыг дэвтэрт тэмдэглүүлэх нь зүйтэй, ингэснээс сурагчид гэртээ давтаж, эргэж харах боломж бүрдэнэ.	Энэ үед хичээл цагтаа багтахгүй туршилтыг бүрэн явуулах боломжгүй байсан.
2018-2019 оны хичээлийн жил	Туршилтын зааврыг сурагч бүрд тарааж өгснөөр хүүхэд ганцаарчилсан хийж, туршиж, үр дүнд хүрэх боломж бүрдэнэ.	ТӨМ-ийг үрэгдүүлснээр Үр дүнг тооцох, нэгтгэн дүгнэх боломжгүй байсан.
2019-2020 оны хичээлийн жил	Туршилтын заавар, ажлын хуудсыг эмхэтгэж сурагчдын гарын авлага болгон хэрэглэх, туршилтын үр дүнг хэрхэн зөв тэмдэглэснийг анхаарна.	өмнөх бэрхшээлүүд үгүй болж Туршилт цагтаа багтдаг болсон Сурагчдын явц, үйл ажиллагааны үр дүнг тооцох боломжтой болсон Багш чиглүүлэгчийн үүрэг гүйцэтгэдэг болсон

		Мэдлэгийг сэргээн санах боломж бүрдсэн.
2020-2021 оны хичээлийн жил	Бүлэг сэдэв бүрийн туршилтын заавар болон ажлын хуудсыг эмхэтгэн ном хэлбэрт оруулснаар хүүхэд бүр аль даалгаврын гүйцэтгэл сайн байх, аль даалгавар, алхам дээр анхаарахаар байгааг хянана. Цахимын үед сурагчдад гарын авлагыг хэвлэж өгөх, гэртээ хийсэн даалгаврын ололттой, анхаарах зүйл юу байгааг багш эргэх холбоотой үзэж, үнгэлгээ өгнө.	Орон нутгийн бусад аймгийн багш нарт түгээн дэлгэрүүлсэн Мэргэжлийн бусад багш нар хэрэглэх боломж бүрдсэн. Сурагчид гарын авлагаа ашиглахад хялбар болсон. Цахимаар туршилт явуулахад үзүүлэх туршилт учраас сурагчид хүлээх авах нь тааруу байсан. Мөн интернэтийн холболт салах зэрэг хүндрэл бэрхшээл байсан

Ахмад багшаас суралцсан туршлага

Багш нар	Ээлжит хичээлийн бэлтгэл	Хүүхэдтэй ажиллах арга барил	Ажлын хуудас, даалгавар боловсруулах
Бага ангийн багш нар	Ээлжит хичээлийн бэлтгэхдээ ажлын хуудсыг өөрөө туршиж, үр дүнг урьдчилан байх	Хүүхдэд ойлгомжтой дасгал даалгавар төлөвлөж, сурагчдаар хийлгэх ажлын хуудсыг боловсруулах	Хөнгөнөөс хүнд рүү чиглэсэн цөөн даалгавар төлөвлөх, сурагчдын ялгаатай байдлыг харгалзах
Байгалийн ухааны багш нар	Туршилтат бэлтгэлийг хангаж, аргачлал, аюулгүй байдлыг тооцоолох, 5е алхмаар хичээлийг төлөвлөх нь чухал.	Оролцох, шинжлэн судлах, тайлбарлах, нарийвчлах, үнэлэх алхам тус бүрт хүүхдийн бие даах арга барилыг ажлын хуудсаар дэмжиж, үр дүнг өөрсдөөр яриулах	5е-ийн загвараар хичээл төлөвлөхөд ажлын хуудас алхам бүрээ дагаад сайжирч байсан.

Дүгнэлт

Туршилтат хичээлийн арга зүй, туршлагыг хамтран хэрэгжүүлснээр сурагчид бага ангиасаа сорил туршилт явуулах алхмыг зөв дадал болгон хэрэгжүүлснээр ажлын хуудас ашиглах чадвар нэмэгдэж, химийн бодис урвалжтай ажиллах, сорил туршилт хийхдээ аюулгүй ажиллагаагаа хангаж чадаж байгаа нь судалгааны явцад хийсэн үнэлгээнээс харагдаж байна.

Цөм хөтөлбөр 2014 оноос хэрэгжиж эхэлсэн үеэс хөтөлбөрийн үр дүнг тооцох зорилгоор нэгж хичээлийг чанартай төлөвлөх, ажлын хуудсыг сайжруулах хичээлийн судалгааг 19 удаа зохион байгуулж, туршиж хэрэгжүүлснээр сурагчдын сурах арга барил, шинжлэн судлах чадварыг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан нь цөм хөтөлбөр өөрөө багш, сурагчийн хэрэгцээг хангасан сайн хөтөлбөр болсон гэсэн дүгнэлтэд хүргэсэн. Сургалтын хөтөлбөр ойр ойрхон өөрчлөгдөөд байх нь багшийн хөгжилд төдийлөн үр дүнгүй юм. Иймд багшийн хөгжлийг сайн байлгахын тулд хөтөлбөр дээр илүү сайн ажиллах нь чухал юм.

Багшийн хөгжлийг хангах бас нэг гол үндэс нь ахмад багш нарын туршлагыг судалж, багшийн багш байх ур чадварыг нь уламжлан хөгжүүлбэл ахмад багш нар бол боловсролын салбарын маш том капитал мөн гэдгийг энэхүү судалгаагаар баталж чадсан.

Багш бүр сорил туршилттай хичээлийг ажлын хуудсанд тулгуурлан чанартай явуулснаар өөрөө хөгжихөөс гадна сурагчдын шинжлэн судлах, багаар хамтарч ажиллах, төлөвлөгөө гаргах зэрэг чадварууд ахиж, туршилтат хичээлийг сонирхон судлах сурагчдын тоо нэмэгдэж байна.

Ном зүй

Анна,Г. (2018). Ажлын хуудас сайн ба муу.

Ahmad Mohamad. (2019). Virtual laboratory chemistry application youtube (2020) https://www.youtube.com/watch?v=YLC_GGNJnLE

Амартайван,Ц., Наранцогт,Ц. нар. (2019). *Байгалийн ухаан VI*. Улаанбаатар: Бест колор

Ариунжаргал,А., Байгалтөгс,С. (2017). *Цахим сургалтыг их дээд сургуулийн сургалтад нийцүүлэх нь*.

http://mmt.edu.mn/static/upload/old_paper/2017/2017-04-26_154410.526787.pdf

Батдулам,С. (2015). *Магистрын судалгааны ажлыг хэрхэн гүйцэтгэх вэ?*: Улаанбаатар хот: Admon.

Батшагай,Б., Уранчимэг,Т. (2020). Инженерийн сургуулийн боловсролд зориулсан виртуал лаборатори хөгжүүлэлт.

<http://imdt.pub.ac.mn/uploads/papers/1560237669b15-10.pdf>

Батхишиг,Ж., Байгалмаа,Д., Батчимэг,Ө. нар. (2016) “*Сурагчдын өмнөх төсөөлөлд тулгуурлан химийн урвалыг судлах арга зүйд сургах нь*” сэдэвт илтгэл

Баярмаа,Г., Наранцогт,Н., Сайнбилэг,Ш., (2015). *Багшийн ном*. Улаанбаатар: Офсет

БСШУЯ. (2019). Бага боловсролын сургалтын хөтөлбөр. Улаанбаатар: Офсет.

БСШУЯ. (2019). Суурь боловсролын цөм хөтөлбөр. Улаанбаатар: Колорфул.

БСШУСС-ын 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн А/43 тушаал, Боловсролын хүрээлэнгийн захирлын 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн А/03 тушаал)

Оюунцэцэг,Н. Сарангэрэл,Д. нар. (2019). *Хими VII сурах бичиг*. Улаанбаатар: Офсет

МЭРГЭЖЛИЙН БАГШИЙН ӨСӨЛТӨД АХМАД БАГШ НАРЫН ОРОЛЦОО

“Харилцан суралцаж, хамтдаа хөгжье”

Ц.Алтанчимэг¹, Б.Лоопилмаа², Х.Сайжирмаа³

Архангай аймгийн Батцэнгэл сумын ерөнхий боловсролын сургууль

Altanchimeg629@gmail.com¹, loopilmaabadam@gmail.com², saijirmaa1028@gmail.com³

Хураангуй

Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхийн үндэс нь “Хөгжсөн багш” юм гэж бид үздэг бөгөөд гол хүчин зүйл нь багш ажлын байрандаа хамтаар хөгжих бодлого боловсруулах, түүнийгээ хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Өнөөгийн боловсролын байгууллагад тулгамдаж буй асуудлын нэг нь сурагчдын хичээлийн хоцрогдол бөгөөд үүнийг нөхөх, сурагчдын нийгэм сэтгэл зүйн хэвийн байдлыг хангах, харилцаа хандлага, хүмүүжил төлөвшлийн асуудалд дэмжлэг үзүүлэхэд ахмад багш, эцэг эхтэй хамтран ажиллах боломжийг судлан турших, үр дүнг түгээн дэлгэрүүлэх явдал юм.

Сурагч нэг бүрийн түвшинг оношлон судлах, хичээлийн хоцрогдлыг нөхөхөд мэргэжлийн багш, ахмад багш нар, эцэг эхчүүд хамтран ажилласнаар тодорхой хэмжээний сурлагын ахиц амжилт гарч, багш нар ажлын байрандаа хамтран хөгжиж, арга зүй, туршлагаа солилцож, судлан шинжлэх аргад суралцах зэрэг давуу талууд гарсан байна.

Түлхүүр үг: суралцагч; судалгаа; ахмад багш; арга зүй; туршлага солилцох; хамтын ажиллагаа; чанар; үр дүн; сайн туршлага.

Оршил

Дэлхийн монгол иргэнийг хөгжүүлэх гэгээлэг үйлсэд өөрөө манлайлан, бусадтай хамтран ажиллах нь бидний үүрэг бас хариуцлага болсон (Цэрмаагийн Аюуш).

Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхийн үндэс нь “Хөгжсөн багш” юм гэж бид үздэг бөгөөд гол хүчин зүйл нь ажлын байрандаа хамтаар хөгжих бодлого боловсруулах, бодлого хэрэгжих тогтолцоог буй болгох явдал мөн гэж судалгааны ажлын явцад харлаа.

Боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлалын гол санаануудын нэг нь “Сургуулийн бие даасан байдал”-ыг хангах явдал юм. Энэхүү агуулга, үзэл санааны хүрээнд сургууль бүр багшийг ажлын байранд нь хөгжүүлэх бодлого боловсруулах, хэрэгжих тогтолцоог буй болгох замаар хөгжлийг бий болгож амжилт үр дүнд хүрч байгаа жишээ, практикийг харуулж байна.

Цар тахлаас шалтгаалан хичээл сургалтын үйл ажиллагаа тасалдсантай холбоотойгоор сурагчдын дунд хичээлийн хоцрогдол ихээр үүссэн нь багш сурагчид, эцэг эх, асран хамгаалагчдын хувьд тулгамдсан асуудал болоод байна. Иймээс бид

ахмад дунд залуу үеийн багш нарын хамтын ажиллагааг эрхэмлэн дээдэлж сурагчдаа хичээлийн хоцрогдолгүй болгохоор зорин ажиллаж байна.

Сэдэв сонгосон үндэслэл

Манай суманд 2020 оны 11 сарын 27-д цар тахлын анхны тохиолдол бүртгэгдэж, хичээл сургалтын үйл ажиллагааг зогсоож улаан түвшинд шилжсэн. Мөн 33 долоо хоног хичээллэхээс 8 долоо хоног хичээллэж, 25 долоо хоногийн хичээлийг цахим ба теле хичээлээр хичээллэсэн. Нийт цар тахалтай 2 жилийн хугацаанд сурагчид 66 долоо хоног танхимаар хичээллэх байснаас ердөө 25 долоо хоногийг танхимаар хичээллэж үлдсэн 41 долоо хоногийн хичээл сургалтын үйл ажиллагааг теле хичээл болон зайн сургалтаар үзсэн байна. Хөдөө орон нутгийн алслагдсан сум суурингийн болон малчдын хүүхдүүд теле хичээл, цахим хичээл үзэх боломжгүй учраас хичээлийн агуулгын хоцрогдол ихээр үүссэн байна.

Хүснэгт 1: 2019 оны 1-р улирлын үнэлгээг 2021 оны сургуульд суурилсан үнэлгээнд харьцуулсан анализ

Судлагдахуун	2019 оны 1-р улирлын хөндлөнгийн үнэлгээ				Сургуульд суурилсан үнэлгээ				Мөрүү	Дундаж
	Анги	Авах оноо	Авсан оноо	Гүйцэтгэл	Анги	Авах оноо	Авсан оноо	Гүйцэтгэл		
Гадаад хэл нэгдсэн дүн	19	7295	4237	58.1	16	3804	1590	41.8	- 16.3	49.9
Газарзүй нэгдсэн дүн	8	3130	1925	61.5	7	4250	2065	48.6	- 12.9	55.0
Монгол хэл, үндэсний бичиг, уран зохиол	11	18748	12645	67.4	11	7710	3907	50.7	- 16.8	59.1
Технологи нэгдсэн дүн	11	2522	2064.7	81.9	9	4400	2668	60.6	- 21.2	71.3
Математик нэгдсэн дүн	11	3420	2132	62.3	11	6745	3062	45.4	- 16.9	53.9
НТМ, ТМ нэгдсэн дүн	19	5210	2913	55.9	16	8390	3687	43.9	- 12.0	49.9
Физик нэгдсэн дүн	11	3148	1932.5	61.4	9	4600	1901	41.3	- 20.1	51.4
Биологи нэгдсэн дүн	11	4320	2543	58.9	9	5070	2309.7	45.6	- 13.3	52.2
Эрүүл мэнд нэгдсэн	11	2500	2041.4	81.7	11	3300	1641	49.7	- 31.9	65.7
Биеийн тамир нэгдсэн	11	3920	3385	86.4	11	5377	2595	48.3	- 38.1	67.3
Дуу хөгжим нэгдсэн	8	2795	1963	70.2	8	3662	1212.5	33.1	- 37.1	51.7
	131	57008	37782	66.3	118	57308	26638	46.5	- 19.8	56.4

Энэ анализаас харахад: Архангай аймгийн Батцэнгэл сумын ЕБС-ийн сурагчдын сургуульд суурилсан үнэлгээг хорио цээрийн өмнөх үеийн сурлагын чанартай харьцуулахад 19.8%-иар буурсан нь харагдаж байна.

Энэ хоцрогдлыг нөхөхөд дан ганц мэргэжлийн багш нарын ажлын ачаалал ихээр үүсэж байгаа учир ахмад багш нар, эцэг эхийн туслалцаа дэмжлэг авах шаардлага гарч ирсэн.

Сайдын хэлснээр: “Ахмад багш гэдэг бол боловсролын салбарын капитал. Энэ капиталын үр өгөөжийг хүртэх ёстой. Боловсролын салбар өөрийнхөө бий болгосон капиталын үр шимийг үзэж чадахгүй байна. Тухайн ахмад багш хөдөлмөрлөх бололцоотой гэвэл ур чадварыг нь ашиглая” гэсэн санаачилга гаргалаа.

Мөн сайдын А/190 тушаалыг тус тус үндэслэн ахмад багш нартай хамтран ажиллаж сурагчдын хоцрогдлыг арилгах цогц төлөвлөгөө боловсруулан ажиллаж үр дүнд хүрэхээр сонгосон болно.

Энэ хоцрогдлыг нөхөх, суралцахуйн суурь чадвараа бататгах нь цаашид сайн суралцах үндэс суурь нь болж өгдөг учраас энэ асуудлыг шийдвэрлэх зорилгоор сэдвийг сонгосон үндэслэл болно.

Судалгааны хэрэгцээ, шаардлага

Сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгахаас гадна сурагчдын нийгэм сэтгэл зүйн хэвийн байдлыг хангах, харилцаа хандлага, хүмүүжил төлөвшлийн асуудалд дэмжлэг үзүүлэхийн тулд ахмад багш нарын оролцоо дэмжлэг хэрэгтэй байна.

Тус сургуулийн дунд бага ангийн 150 сурагчдад түүврийн аргаар нийгэм, сэтгэл зүйн байдал, бухимдал, амьдралын хэв маяг, дадал хэвшил гэх мэт сэтгэл зүйн судалгаа авч үзэхэд сурагчдын 50% нь хичээлийн хоцрогдол үүссэн гэсэн айдатай, 30% нь ганцаардаж, уйтгарладаг, 20% орчим нь амьдралын хэв маяг дэглэм өөрчлөгдсөн гэсэн хариултыг өгсөн байна. Иймд сурагчдад сэтгэл зүйн дэмжлэг өгөх, хүмүүжлийн эерэг аргыг хичээл сургалтандаа сонгон хэрэглэх шаардлага үүсэж байна.

Судалгааны зорилго

Ахмад багш нарын оролцоо дэмжлэгтэйгээр сурагчдын хичээлийн хоцрогдлыг нөхөн, багш ажлын байрандаа хамтран ажиллаж, тасралтгүй хөгжих боломжийг судлан туршиж, үр дүнг түгээн дэлгэрүүлнэ.

Судалгааны зорилт

- Ахмад багш, эцэг эх, асран хамгаалагчаас судалгаа авч, үр дүнг боловсруулах
- Судалгааны үр дүнг онолын үүднээс батлан дүгнэх
- Агуулгын суурь судалгааг гаргаж, сурагчдын хоцрогдлын түвшинг оношлон, агуулгын хоцрогдлыг тооцон гаргах
- Сурагчдын хичээлийн хоцрогдлыг нөхөхөд ахмад багш нарын дэмжлэгийг авч хамтран ажиллаж, үр дүнг тооцон сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх

Онолын хэсэг

Бусадтай хамтран насан туршдаа хөгжих чадвартай, тухайн мэдлэг, чадвар хандлагыг өөрөө бие даан хөгжүүлдэг байх гэж чадварлаг багш хөтөлбөрт тусгасан байна.

Багш яагаад тасралтгүй хөгжих ёстой вэ?

Хүний хөгжил нь чухамдаа түүний өөрийнх нь бүтээлч сэтгэлгээ, бүтээлч үйл, хандлага, итгэл үнэмшил, онол- арга зүйн мэдлэг, чадварын үр дүнд явагддаг үйл явц учир багшийн хувьд ажлын байрандаа орчин үеийн шинжлэх ухааны ололт амжилт, нийгмийн болон суралцагчийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагатай уялдуулан өөрийнхөө онолын мэдлэг, үзэл хандлага, ажлын арга барилаа шинэчлэн сайжруулах үйл явц тасралтгүй байх ёстой.

“Багшийн хөгжлийг дэмжих хууль” батлагдсанаар багшийн оролцоо, манлайллаа нэмэгдүүлэх эрх зүйн орчин бүрдсэн учир мэргэжлийн болон сонирхлын баг, хамтлагаар ажиллах замаар тулгамдсан асуудал, бэрхшээл, шийдэл, арга зам, туршлагаа харилцан ярилцаж, хамтран ажиллах боломж бидэнд байна.

Сурагчдын хичээл, сурлагын хоцрогдлыг арилгах, суралцахуйг дэмжихэд талуудын үүрэг оролцоо, тэдгээрийн үйл ажиллагааны уялдаа холбоотой байхыг чухалчилж байна. Энэ үйл ажиллагааны төвд сурагчдын өөрсдийн хүчин чармайлт байх бөгөөд багш нар, эцэг эхийн дэмжлэг гол үүрэгтэй байна.

Дэлхий нийтийг хамарсан цар тахал энэ үед боловсролын салбарт ажиллаж байгаа бидний ажлын хэв шинж, амьдралд нөлөөлж боловсролын салбарын хандлага үзэл баримтлалд мөн сурах, сургах үйл ажиллагаанд өөрчлөлт авчирч технологийн шинэчлэлд эрчимтэй нэвтэрч ирээдүй нь тодорхойгүй хурдтай цаг үед *багш бид нар тасралтгүй хөгжих, хөгжил шаардлагатай болж байна.*

Цар тахлын энэ үед “ Монголын боловсролын нэр нүүр болсон ахмад багш нар маань тусалж, дэмжье гээд саналаа хэлж байгаад талархаж байна. Та бүхний туслалцаа бидэнд ус, агаар мэт хэрэгтэй. Ахмад, дунд, залуу үеийн уялдаа холбоо байж ажил урагшилдаг. Иймд бид салбарын 100 жилийн ой болон боловсролын салбарын шинэчлэлийг та бүхний оролцоотойгоор хийнэ гэж сайдынхаа хэлсэн ёсоор багш бид нар ч гэсэн ахмад багш нарынхаа тэргүүн туршлага, арга зүйд тулгуурлан өөрсдийгөө хөгжүүлэн суралцсаар байх болно.

Судалгааны хэсэг

Архангай аймгийн Батцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын теле хичээл болон цахим хичээлд хамрагдсан судалгаанд үндэслэн 2 жилийн хичээлийн агуулгын хоцрогдлын судалгааг гаргаж, хоцрогдлыг ямар арга замаар нөхөх аргыг судлан тогтоож үр дүнг тооцсон. Хичээлийн хоцрогдлыг оношлохдоо дараах зүйлсийг баримталсан байна.

- Ямар хичээл дээр хэдэн сэдвийн хоцрогдолтойг тодорхойлох
- Хичээлийн хоцрогдолтой хүүхдийг сэтгэл зүйн дарамтгүй байлгах
- Хоцрогдолтой гэж үзэж байвал тухайн хүүхэдтэй харилцах харилцаа, хандлагаа өөрчлөх
- Би чадна гэсэн өөртөө итгэх итгэл үнэмшлийг төрүүлэх
- Хичээлийн хоцрогдолтой хүүхэд бүрийн оюун ухаан, сэтгэл зүй,мэдлэг хүлээж авах онцлогт тохирсон арга зүй, хөтөлбөр системийг баримтлан хичээллэх

Теле хичээлийн судалгаа

Зураг 1. Теле хичээлийн үзсэн байдал ангиар



Тус сургуулийн теле хичээл үзсэн судалгаанаас харахад сурагчдын 60-70% нь теле хичээлээ үзээгүй байгаа бөгөөд энэ нь хоцрогдол үүсэх шалтгаан болж байна. Энэ хоцрогдлыг арилгахад багш нар илүү цагаар ажиллах хэрэгтэй болж байна.

Багшийн нэг өдрийн ажлын цагийн зураглал, тооцоолол:

$19 \times 35 = 665$ цаг (Багшийн хичээл заах цаг)

$665 + 604$ (2 жилийн хугацаанд теле хичээл үзэж судлаагүй цаг) $= 1269$ цаг

$1269 / 35 = 36$ цаг (долоо хоногт зарцуулах цаг)

$36 / 5 = 7.2$ цаг (1 өдөрт хоцрогдол нөхөхөд зарцуулна.)



Энэ тооцооллоос харахад багш өдөрт 16-17 цагийг хичээл сургалтын үйл ажиллагаа болон хоцрогдол нөхөхөд зарцуулахаар харагдаж байна. Энэ нь багшийн ажлын ачааллыг нэмэгдүүлж байгаа учир ахмад багш нарын дэмжлэг туслалцааг авах хэрэгцээ бий болж байна.

Ахмад багш нар, эцэг эх, асран хамгаалагчдаас судалгаа авч ерөнхийлөн дүгнэхэд:

- Сүүлийн 2 жилийн теле хичээл болон цахим хичээлийн хамрагдалтын судалгаагаар манай сургуулийн сурагчид (амьдралын нөхцөл бололцоо, алслагдсан хөдөө орон нутагт амьдардаг, цар тахлын улаан түвшинд удаан байсан...) хангалтгүй хамрагдсан нь хичээлийн хоцрогдол үүсэх томоохон шалтгаан болсон байна.
- Сурагчдыг зөв оношлож, хоцрогдлын түвшинг тогтоож, хоцрогдсон агуулгын судалгааг гаргаснаар цаашид ажиллах арга зам тодорхой болно
- Сурагч нэг бүрийн хичээлийн хоцрогдсон агуулгыг гаргаж дүгнэлт хийн, сурагчдыг хөгжүүлэн, сурлагын чанарт ахиц амжилт үзүүлнэ.
- Сурагчдын хоцрогдлыг нөхөхөд багшийн нэг өдрийн ажлын цагийн ачаалал ихээр нэмэгдэж байгаа учир ахмад багш нарын дэмжлэг туслалцаа хэрэгтэй байна.
- Хоцрогдсон агуулгыг тодорхой болгосноор ахмад багш нар хүүхдийг хөгжүүлэх, багш нартай хамтран ажиллах ажлын төлөвлөгөө тодорхой болно.
- Ахмад багш нар багш нартай хамтран ажиллах, халамжлан хүмүүжүүлэгч багшаар ажиллах сонирхолтой байна

- Ахмад багш нар боловсролын салбартаа ажиллаж, өнөөгийн тулгамдаж буй асуудал болох сурагчдын хоцрогдлыг арилгахад дэмжлэг, тусалцаа үзүүлэх боломжтой
- Ахмад багш нараас арга зүйн зөвлөгөө авах, туршлага солилцох уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулж байх
- Эцэг эх, асран хамгаалагчид багш нартай хамтран ажиллах нь үр дүнтэй байна гэсэн санааг илэрхийлсэн байна.
- Сурагчдын хүмүүжил төлөвшилд эерэг арга хэрэглэх, сэтгэл зүйн дэмжлэг хэрэгтэй байна.
- Сургуулийн зүгээс багш, ахмад багш, эцэг эхийг дэмжин хамтран ажиллах хэрэгтэй байна.

“Багш нарын мэргэжлийн өсөлтөд ахмад багш нарын оролцоог нэмэгдүүлэх” илтгэлийн хүрээнд хийж буй ажлын төлөвлөгөө

Судалгааны зорилго

Сурагчдын хичээлийн хоцрогдлыг арилгахад ахмад багш нартай хамтран ажиллах, багш ажлын байрандаа тасралтгүй хөгжихөд оршино.

Судалгааны хамрах хүрээ

Сурагчид, эцэг эхчүүд, мэргэжлийн болон ахмад багш нар

Судалгааны хугацаа: 2021.09.25-аас эхэлнэ

Хүснэгт 2. Хийгдэж буй ажлууд

д/д	ХИЙГДЭХ АЖЛУУД	ХУГАЦАА	АГУУЛГА	ТАЙЛБАР
1.	Ахмад, дунд, залуу үеийн багш нарын уулзалт зохион байгуулах	2021.09.25	Зн үеийн багш нар уулзаж, сурагчидтай хэрхэн ажиллах мөн цаашид хамтран ажиллах төлөвлөгөөг боловсруулах	Сурагчдын хичээлийн хоцрогдлыг нөхөхөд ахмад багш нар дэмжлэг үзүүлэхээр болов
2.	Ахмад багш, багш нар, эцэг эх, сурагчдын уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах	2021.10.12	Ахмад багш нар эцэг эх сурагчидтай уулзаж, сурагчидтай хэрхэн ажиллах мөн цаашид хамтран ажиллах төлөвлөгөөг боловсруулах	Эцэг эх сурагчдаас гарсан гарсан туршлага арга зүйд суурилан хамтран ажиллах
3.	Ахмад багш нарын тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх	2021.10.18	Ахмад багш нарын тэргүүн туршлагыг цахимаар багш нар болон олон нийтэд таниулах	Ахмад багш зөвлөж байна (facebook) группыг байнга ажиллуулж үйл ажиллагааг сурталчилж байна.
4.	“Ахмад багш нарын оролцоог нэмэгдүүлэх”	Жилийн турш	Ахмад багш нарын оролцоог нэмэгдүүлэх ажлыг тасралтгүй зохион байгуулах	ЗАН-ийн ажлын төлөвлөгөөнд тусгах (Хавсралт 5)

3.	"Хамтдаа хөгжье"	Жилийн турш	Ахмад багш нарын өрөөтэй болох	Ахмад багш нар сурагчдын арилгах сонирхлоор хөгжүүлэх, туслах ажиллуулах
5.	Сурагчдад "Зөв бичих дүрэм"-ийн гарын авлага боловсруулан өгөх, сурагчдаар бие эцэг эхтэйгээ хамтран ажиллах\	Жилийн турш гарын авлагаа ашиглах	Монгол хэлний зөв бичих дүрэм, цээжээр бичих эх, унших сэдэв, нүдлэн тогтоох үг бүхий зурагт гарын авлага бэлтгэх \ цахим ном бэлтгэх\	Ахмад багш нарын зөвлөгөө зааврын дагуу мэргэжлийн багш нар бэлтгэх

Ахмад багш нарын уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулав

Ахмад багш нараас туршлага, арга зүй зөвлөгөө, сурагчдын хоцрогдлыг нөхөхөд дэмжлэг туслалцаа авах зорилгоор "Ахмад, дунд, залуу үеийн багш нарын уулзалт" уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт 8 ахмад багш нараас гадна одоо ажиллаж байгаа дунд болон залуу үеийн 12 багш хамрагдан дараах асуудлын талаар ярилцсан байна.Үүнд:

- Өнөө үеийн боловсролын чиглэл, онцлог, давуу тал
- Сургуулийн тулгамдсан асуудал болох сурагчдын сурлагын хоцрогдлын судалгааг танилцуулах, сурагчдын хоцрогдлыг арилгахад оруулах санал
- Ахмад багш нарын сурагчидтайгаа ажиллаж байсан тэргүүн туршлага

Уулзалт хэлэлцүүлгээс гарсан үр дүн:

Ахмад дунд залуу үеийн багш нарын уулзалт хэлэлцүүлгээс дараах үйл ажиллагааг хамтран хийхээр боллоо.

1. Сүүлийн хоёр жил коронавируст халдвараас болоод хичээл сургалтын үйл ажиллагаа тасалдаж, танхим цахим хосолсон хэлбэрээр явагдаж, сурагчдын хувьд хичээлийн хоцрогдол ихээр үүссэн байна. Энэ бүгдээс гарахын тулд ахмад багш нар дэмжлэг туслалцаа үзүүлэн ур чадвараа ашиглан хамтран ажиллахаар боллоо.
2. Хэлэлцүүлгээс ахмад багш нар залуу багш нарыг халамжлан хүмүүжүүлэн, арга зүйн зөвлөгөө өгч байхаар боллоо. Үүнд математикийн багш Д.Чойдогжамц, газарзүй, түүх нийгмийн ухааны багш Я.Балжид, Бага ангийн багш Д.Алтанзул, Б.Цэндсүрэн, технологийн багш П.Гантулга оролцож байна.
3. Ахмад багш нар өөрийн давуу тал, сонирхлоо ашиглан сурагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор шатар даам, оёдол хатгамлын сонирхлын бүлэг хичээллүүлэхээр болов.
4. Мөн энэ үйл ажиллагаандаа эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллахаар болсон байна.

Сурагчдын эцэг эх, асран хамгаалагчидтай хийсэн хэлэлцүүлэг

Сурагчдын сурлагын хоцрогдол, хүмүүжил төлөвшил, сэтгэл зүйн өөрчлөлт түүнийг хэрхэн эерэг аргаар дэмжлэг үзүүлэх талаар ахмад багш, мэргэжлийн багш, сэтгэл зүйч, эцэг эх, асран хамгаалагч нарын хамтарсан хэлэлцүүлгийг хийсэн байна. Хэлэлцүүлэгт 6-12-р ангийн сурагчдын 215 эцэг эх, асран хамгаалагчид, мэргэжлийн 31 багш, ахмад багш нар дээрх сэдвээр ярилцав. Хэлэлцүүлгээс гарсан саналуудаас харахад сурагчдын хичээлийн хоцрогдлыг нөхөх суралцахуйн суурь чадваруудыг сайжруулах, хүмүүжил харилцаа хандлагын эерэг байдлыг бий болгоход эцэг эх, багш, сурагчийн хамтын ажиллагаа чухал байна.

Ахмад багш нарын туршлага арга зүйг цахимаар олон нийтэд түгээн дэлгэрүүлэв

“Ахмад багш зөвлөж байна” гэсэн цахим буланг ажиллуулж, багш нарын багшлах арга зүй, хүүхдүүдтэй ажиллах эв дүй, хичээл төлөвлөлт, тэргүүн туршлага зэргийг түгээн дэлгэрүүлэх зорилготой бичлэгийг хийж цахимаар олон нийтийн хүртээл болгосон байна.

“Хамтдаа хөгжье” ахмад багш нарын өрөө

Ахмад багш нарын оролцоог нэмэгдүүлэх, залуу багш нарт арга зүйн зөвлөгөө өгөх, сурагчдын хоцрогдлыг арилгах, сонирхлын бүлгээр нь сургалт явуулах, ахмад багш нартаа сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор танхимын үйл ажиллагааг тасралтгүй явуулж байна.

Сурагчидтай ажилласан байдал

Сурагчдын хичээлийн хоцрогдол, биеэ даан ажиллах чадварыг нэмэгдүүлэх, дэмжлэг болох, суралцахуйн суурь чадварыг сайжруулах, нийгэм сэтгэл зүйн эерэг хандлага бий болгох зорилгоор түвшин бүрт тохирсон нэмэлт давтлага даалгаврыг өгч, хамтран ажиллаж байна.

Тарааж өгөх материал, дасгал даалгавар бэлтгэсэн байдал

Ахмад багш нартай хамтран сурагчдын хоцрогдлын оношлогоонд үндэслэн сурагч нэг бүрийн түвшинд тохирсон *ялгаатай* даалгавар, тарааж өгөх материал, цахим даалгавруудыг боловсруулан өгч хүүхэд нэг бүрийн хоцрогдлыг нөхөж, сурлагын чанарыг ахиулахаар ажиллаж байна. Даалгавар, тарааж өгөх материал, гарын авлагыг дараах шалгуурт нийцүүлэн боловсруулав. Үүнд:

- Нас сэтгэхүйн онцлогт тохирсон
- Сурагчдад ачаалал, хэт их дарамт болохоор биш
- Сонирхол татахуйц
- Бие даан гүйцэтгэж болохуйц
- Сурагчдын түвшинд тохирсон
- Дахин ашиглагдаж болохуйц
- Даалгаврын олон хэлбэрээр
- Хүүхэд бүрт хүрэлцэхүйц олон тоогоор гэх мэт шаардлагыг хангаж боловсруулж өгсөн байна.

“Монгол хэлний зөв бичих дүрмийн гарын авлага”

Сурагчдад бие даан ажиллах ном, гарын авлагыг ойлгомжтой, хялбар сонирхолтой байдлаар хийж өгөх нь зүйтэй гэсэн ахмад багш нарын туршлага зөвлөгөөний дагуу номыг гарын авлага болгон гаргаж, цахимаар болон цаасаар сурагчдын хүртээл болгосон байна. Зөв бичих дүрэм, дасгал даалгавар, цээж бичгийн эхүүдийг багтаасан бөгөөд сурагчид бие даан ажиллах боломжтой ажээ. Мөн эцэг эхчүүд хэрэглэхэд тохиромжтой байхаар бэлтгэсэн.

Дүгнэлт

Сүүлийн 2 жилийн хугацаанд хичээл сургалтын үйл ажиллагаа тасалдсантай холбоотойгоор Архангай аймгийн Батцэнгэл сумын ЕБС-ийн 11 бүлгийн 323 сурагчийг оношлон судалж, гарааны үнэлгээг авахад сурагчдын сурлагын чанар муудаж, хоцрогдол үүссэн байсан бөгөөд түүнтэй холбоотойгоор хичээл бүрийн агуулгын судалгааг мэргэжлийн багш нар нэгтгэн гаргаж, танхим, теле, цахим сургалтад хамрагдаж чадаагүй болон хичээлийн хоцрогдолд орсон сурагч нэг бүрийг судлан оношилж, үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 8 ахмад багш, мэргэжлийн 26 багш, 158 эцэг эхтэй хамтран ажиллаж, 8 ахмад багш 7хоногт 2-3 цагийн давтлагыг 1-5 дугаар ангийн 15 сурагч, 6-8 дугаар ангийн 28 сурагч, ахлах ангийн 9 сурагчдад өгч байгаа бөгөөд мэргэжлийн багш нар өдөр бүр 2-3 дугаар ангид 3-4 цагийн нэмэлт давтлагыг хичээлийн бус цагаар тогтмол хийснээр сурагчдын сурлагын ахиц амжилт нь 52% болж, 6%-иар ахисан үзүүлэлттэй байна.

Ахмад багш нарын оролцоог нэмэгдүүлэх, туршлага арга зүйгээс суралцах, сэтгэл санаагаар дэмжих, хамтран ажиллах нөхцөл бололцоогоор хангаж өгөх зорилгоор

“Хамтдаа хөгжье” ахмад багшийн өрөөг байгуулсан бөгөөд энэ өрөөнд ахмад багш нар сурагчдад давтлага өгөх, залуу багш нарт арга зүйн зөвлөгөө өгөх, өөрийн давуу талыг ашиглан багш сурагчдыг хөгжүүлэх ажлуудыг тасралтгүй явуулж байгаа нь багш ажлын байрандаа хөгжих давуу тал болж байна.

Мөн ахмад багш нарыг сургуулийн үйл ажиллагаанд татан оролцуулах, ахмад, дунд, залуу үеийн багш нарын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор ЗАН-ийн ажлын төлөвлөгөөнд тодорхой ажлуудыг тусган өгснөөр багш нар мэргэжил арга зүйн хувьд өсөн хөгжих нэгэн боломж болж байна.

Ахмад багш нар нь халамжлан хүмүүжүүлэгч багшаар ажиллах, сурагчдын хоцрогдлыг арилгахад дэмжлэг үзүүлж байгаа зэрэг нь багш нарын ажлын ачааллыг бууруулах, сэтгэл зүйн таатай байдлыг нэмэгдүүлэхэд эергээр нөлөө үзүүлж байгаа билээ. Иймээс ахмад багш нарт тодорхой хэмжээний урамшуулал олгох, ажиллах нөхцөл боломжоор хангах, цаашид ахмад багш нараа дэмжсэн төрийн бодлого хэрэгтэй байна.

Ном зүй

“Багшийн хөгжил” сэтгүүл 2020, 2021 оны дугаар

МУБШУ-ны сайдын А/190 тогтоол

Чадварлаг багш хөтөлбөр

Багшийн хөгжил мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын гарын авлага-1

БСШУЯ. (2014). Дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр. Улаанбаатар

БСШУЯ. (2014). Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр. Улаанбаатар

Чимгээ,Б., Оюун,Д., Алтанцэцэг,Д. (2014). Монгол хэлний гарын авлага. Улаанбаатар: Мөнхийн үсэг.

Март,Ц. (2017). *Эх дээр ажиллах жишиг даалгавар, дасгал*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.

Оюунцэцэг,Ш., Мөнгөнцэцэг,Б., Олзвой, Л., Оюун,Ц., Туул,Ц. (2015). Монгол хэл YI анги. Улаанбаатар:Мөнхийн үсэг

Гантуул,А., Батболд,Г., Дэнсмаа,Ж., Чойсүрэн,Э. (2015). Зөв бичих чадвар IV анги. Улаанбаатар: Мөнхийн үсэг.

Түвшинбаяр,Д. нар. (2015). Монгол хэл VI анги. Улаанбаатар

Батчимэг,Т.нар. (2015). Монгол хэл VIII анги. Улаанбаатар: Мөнхийн үсэг.

ЕБС-ийн сурагчдын хичээл, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах төлөвлөгөөг хэрэгжүүлэх сургалт, үйл ажиллагааны удирдамж

Дамдинсүрэн,Ц. (1983). *Монгол хэлний зөв бичих дүрэм*.

Эрдэнэсан,Д. (2012). “ *Монгол хэлний эх өгүүлбэр задлал*. Улаанбаатар: Соёмбо принтинг.